



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**
/2022 оны байдлаар/

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**
/2022 оны байдлаар/

Монгол Улсын Их Хурлын ээлжит 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Засгийн газар нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн, Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд оролцсон Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тулгуурлан нам, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналуудад үндэслэн 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулахдаа халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг амжилттай даван туулж, хүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, бүс ба орон нутгийг хөгжүүлэх, өмнөх Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгой анхаарч, дараах зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа дэвшүүллээ.

**НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН
ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО**

1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.1. “Ковид-19” халдварт цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих дараах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ:

1.1.1.1. хүүхдийн мөнгөн тэтгэмжийн цар тахлын үеийн нэмэгдлийг 2020 оныг дуустал үргэлжлүүлэн олгоно.

Биелэлт: Цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор 18 хүртэлх насны хүүхэд бүрд олгож буй хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж 2020 оныг дуустал 1.2 сая хүүхдэд сар бүр 100 мянган төгрөг, 2022 оныг дуустал 18 хүртэлх насны 1.2 сая хүүхдэд сар бүр 100 мянган төгрөг олгосон. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид нийт 2021 онд 1,455.2 тэрбум төгрөг, 2022 онд 1,461.7 тэрбум төгрөгийг тус тус зарцуулав.

1.1.1.2. нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг 2020 оны 10 дугаар сараас хойш хэсэгчлэн үргэлжлүүлнэ.

Биелэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт болон хөнгөлөлтийг гурван үе шаттай хэрэгжүүлж байна. Үүнд, 1) 2020 оны 4 дүгээр сарын 1-нээс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл аж ахуйн нэгж даатгуулагчийг шимтгэл төлөхөөс бүрэн чөлөөлж төрөөс нөхөн төлсөн. 2) 2020 оны 10 дугаар сарын 1-нээс 2020 оны 12 дугаар сарын 31-ийг дуустал хугацаанд ажил олгогч болон даатгуулагч (сайн дурын даатгуулагч мөн нэгэн адил) тус бүр 5 хувь шимтгэл төлөх, үлдэх хувийг төрөөс нөхөн төлсөн. 3) 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл ажил олгогч болон даатгуулагч (сайн дурын даатгуулагч мөн нэгэн адил) тус бүр 8.5 хувь шимтгэл төлөх, үлдэх хувийг төрөөс нөхөн төлөв.

1.1.1.3.жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх арга хэмжээг 2020 оныг дуустал үргэлжлүүлнэ.

Биелэлт: УИХ-аар 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан 2020 оны төсвийн тодотголд жилийн 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийг 6 сарын хугацаанд Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн.

1.1.1.4.түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжийн түрээсийн орлогод 2020 оныг дуустал татварын хөнгөлөлтийг үргэлжлүүлэн үзүүлнэ.

Биелэлт: 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь гэрээ болон Татварын ерөнхий хуулийн 28.5-д зааснаар төлбөрийн баримтаар нотлогдсон тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлсэн. 2020 онд 3,514 татвар төлөгчийн 2,300.0 сая төгрөг, 2021 онд 4,164 татвар төлөгчийн 1,100.0 сая төгрөгийн хөнгөлөлт эдлүүлсэн байна.

1.1.1.5.аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт: Ажлын байранд Ковид 19 цар тахал гарахаас урьдчилан сэргийлэх асуудлаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг БНТУ-ын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн үйлчилгээний яамны харьяа Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий газар, Туркийн Хамтын ажиллагааны зохицуулах агентлагтай хамтран 2020 оны 8 дугаар сарын 31-9 дүгээр сарын 4-ны өдөр зохион байгууллаа. Нийт 5 өдрийн 20 цагийн зайн сургалтаар Туркийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн үйлчилгээний яам, түүний харьяа Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий газрын холбогдох мэргэжилтнүүд Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хүрээнд ажлын байранд авч хэрэгжүүлэх ерөнхий арга хэмжээ, үйлдвэрлэл, үйлчилгээний 18 салбар, чиглэл тус бүрээр ажлын байрыг коронавирусын дэгдэлтээс хамгаалахад анхаарах асуудлаар мэдээлэл хийсэн. Үүнд: барилга, уул уурхай, хүнд үйлдвэрлэл, тээвэр, газар тариалан, хүнс, үсчин, гоо сайхан, банк, дуудлагын төв, нийтийн ахуйн үйлчилгээ, зочид буудал, шүдний эмнэлэг зэрэг 18 чиглэлээр Турк улс өөрийн туршлага, сургамждаа тулгуурлан боловсруулсан мэдээлэл, арга аргачлалаасаа хувалцлаа. Дээрх арга хэмжээтэй холбогдуулан “Ажлын байранд Ковид-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэх шалгах хуудасны загвар”-ыг баталсан.

1.1.2.“Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ:

1.1.2.1.цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс 2020 онд шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног

төхөөрөмж, эм, халдваргүйтгэлийн бодис худалдан авах зардалд, тусгаарлах байранд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдийн байр, хоолны мөнгө, төрийн холбогдох байгууллагуудын албан хаагчдад урамшуулал, халдварын тусгаарлалтын зардалд 50.9 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан байна.

Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн төсвийг нэмэгдүүлж 2021 оны төсөвт 100.0 тэрбум төгрөг батлуулсан. Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс 2021 онд шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эм, халдваргүйжүүлэх бодис худалдан авах зардал, тусгаарлах байранд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын байр, хоолны мөнгө, төрийн холбогдох байгууллагуудын албан хаагчдад урамшуулал, тусгаарлалтын зардалд нийт 64.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

1.1.2.2. цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ.

Биелэлт: Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, эмнэлгүүдийн бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх, илүү цагийн хөлс, урамшуулал, дэмжлэг олгоход 2021 онд нийт 309.46 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны 67/А/268, А/387/99 дүгээр хамтарсан тушаалуудыг тус тус баталж, нийт 360.5 тэрбум төгрөгийг зарцуулсан.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад шаардлагатай эх үүсвэрийг олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудтай хамтран нийт 111.7 сая ам.долларыг шийдвэрлэв. Үүнд:

1. Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсад КОВИД-19-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл”-ийн 50.7 сая ам.доллар;

2. Монгол Улс, Азийн хөгжлийн банкт 19.0 сая ам.долларын Зээлийн хэлэлцээр;

3. Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкт (АДБХОБ) 21.0 сая ам.долларын Зээлийн хэлэлцээр;

4. Монгол Улс, Япон Улсын Засгийн газартай байгуулсан 21.0 сая ам.долларын буцалтгүй тусламж.

1.1.2.3. сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна.

Биелэлт: 2020 онд Монгол Улсын хэмжээнд дархлаажуулалтад хамрагдвал зохих 6 сартайгаас 13 насны нийт 352924 хүүхэд байсан ба нийт хүүхдийн 96.6 хувь нь буюу 340968 хүүхэд дархлаажуулалтад хамрагдсан. Дархлаажуулалтын хувь нийслэлд 96.2 хувьтай байсан бол орон нутагт 98 хувьтай хамрагдсан байна.

2021 онд нийт 360,600 тун вакциныг томуугийн вакцинжуулалтад хэрэглэх бэлтгэл ажлыг хангасан бөгөөд дархлаажуулалтыг эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 2-11 насны 235,678 хүүхдийг 2021 оны байдлаар улирлын томуугийн вакцинд хамруулсан. Энэ нь нийт хамрагдвал зохих хүүхдийн 98.6 хувийг эзэлж байна.

1.1.2.4. Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилчдад олгох цалин, урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: 2020 онд коронавирусийн халдварын голомтод ажилласан халдварт өвчин судлалын үндэсний төвийн эмнэлгийн ажилтнуудын цалин, урамшуулал, дэмжлэгт нийт 4.845.5 сая төгрөг, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд нийт 663.8 сая төгрөг олгосон бол 2021 оны байдлаар 8.3 тэрбум төгрөг, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 1.2 тэрбум төгрөгийг олгоод байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод болон гамшгийн үед дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн ажилтанд олгох нэг удаагийн санхүүгийн дэмжлэгийг ХӨСҮТ-ийн 1,596 (давхардсан тоогоор) албан хаагчдад 7 удаагийн шийдвэрээр 2.8 тэрбум төгрөг, ЗӨСҮТ-ийн 249 (давхардсан тоогоор) албан хаагчдад 3 удаагийн шийдвэрээр 415.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

2020 оны 3 сараас хойш бэлэн байдалд, тусгаарлан ажиглах байр, халдварын голомтод ажилласан эмч ажиллагсад 9 дүгээр сараас эхлэн тус дэмжлэгийг олгож эхэлсэн. 2020 онд нийт 773 эмч, эрүүл мэндийн ажилтнуудад 1.0-5.0 сая төгрөгийн нийт 2.1 тэрбум төгрөгийг олгосон.

1.1.2.5.Хүн амыг коронавирусийн эсрэг вакцинд хамруулна.

Биелэлт: Их Британийн Оксфордын их сургууль бүтээж, БНЭУ-д үйлдвэрлэсэн AstraZeneca вакцинаас 150,000 тунг манай улс 2021 оны 2 дугаар сарын 22-нд хүлээн авсан. Уг вакцинд ДЭМБ-аас нийтэд хэрэглэх зөвшөөрлийг олгосон юм. Энэхүү вакцины анхны тунг Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 2 дугаар сарын 23-нд Улсын хоёрдугаар төв эмнэлэг дээр очиж, 11:30 цагт хийлгэснээр вакцинжуулалт эхэллээ.

Улсын хэмжээнд **2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар** нийт хүн амын коронавируст халдварын эсрэг вакцины **нэгдүгээр тунд 2,268,377 хүн буюу 69.7 хувь, хоёрдугаар тунд 2,168,827 хүн буюу 66.7 хувь, гуравдугаар тунд 979,390 мянган иргэн** хамрагдсан байна.

1.1.2.6.Коронавируст халдвар (COVID-19)-тай холбоотой хийгдэх судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээн авна.

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/620 тушаалаар Коронавируст халдвар (COVID-19)-ын судалгааг зохион байгуулах, удирдах ажлын хэсэг, судалгааны тэргүүлэх 10 чиглэлийг боловсруулж баталсан. 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар судалгааны ажлын үр дүнгийн даалгавар танилцуулгыг батлуулж судалгааны ажлууд эхэлсэн. Судалгааны ажлын санхүүжилтийг 2021 оны төсвийн тодотголоор 2.4 тэрбум төгрөгийг баталсан. “КОВИД-19 вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа”, “КОВИД-19 эсрэг вакцины гурав дахь сэргээх тунгийн дараах дархлааны хариу урвал болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг судлах нь”, “Монгол Улсад КОВИД-19 цар тахал үүсгэсэн SARS-CoV-2 вирүсийн геномын шинжийг судалсан судалгаа”-ны дүн гарсан. 2022 оны 11 дүгээр сард судалгааны ажлын үр дүнг хүлээн авч, хэвлүүлсэн.

1.1.3.Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана:

1.1.3.1.хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.

Биелэлт: Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс дараах байдлаар бүрдүүлж ажилласан байна. Үүнд:

1.Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан 50,166,400 төгрөгийн үнэ бүхий 3,200 ширхэг моксифлоксациныг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгов.

2.Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр”-ийн хүрээнд Коронавирусын халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсад эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслэл нийлүүлэх Төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд 1,791,815,400 төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг унтуулгын аппарат болон дагалдах хэрэгслийг хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.

3.Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 17,008,368 төгрөгийн үнэ бүхий суурилуулах 6 ширхэг эмнэлгийн зориулалт бүхий хөргөгч, 57,036,754 төгрөгийн үнэ бүхий эм болон эмнэлгийн хэрэгсэл, 1,799,583,040 төгрөгийн үнэ бүхий эх, нярайн тусламж үйлчилгээнд ашиглагдах эмнэлгийн тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгөв.

4.НҮБ-ын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд 85,950,000 төгрөгийн үнэ бүхий 6,000 ширхэг нэг удаагийн халатыг хүлээн авч нөөцөд авах тухай тушаал гаргав.

1.1.3.2.шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна.

Биелэлт: Дорноговь, Орхон 2 аймагт шинээр Зоонозын өвчин судлалын төв, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорнод, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сүхбаатар, Өмнөговь аймагт2, Ховд, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл зэрэг 10 аймагт хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулахаар тооцоо судалгааг хийсэн. Зоонозын өвчин судлалын төв хоёрыг байгуулахад 550.0 сая төгрөг, тандалтын 1 нэгж байгуулахад 1.2 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоог хийсэн. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хилийн нэвтрэх цэгийн тандалтыг сайжруулах үүднээс Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хадны нутаг дэвсгэрт орших “Гашуун сухайт” хилийн боомтод нүүрс экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагын жолооч, ажилчдын молекул биологийн шинжилгээ хийх, тохиолдлын тандалт судалгаа хийх зорилгоор 2021 оны 9 дүгээр сарын 26-наас ХӨСҮТ-ийн баг томилогдон 14 хоногийн давтамжтай солигдон ажиллаж байна. 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Чингис хаан агаарын боомт, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Увс аймгийн Боршоо, Өмнөговь аймгийн Гашуунсухайт автозамын боомтуудад коронавируст халдварын идэвхтэй тандалт хийж байна.

1.1.3.3.шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна.

Биелэлт: Коронавируст халдварын нөхцөл байдлын хэвлэлийн хурлыг (өдөр бүрийн 11:00 цаг) 219 удаа зохион байгуулж, 30 телевиз 50 сайтаар дамжуулсан. Мөн ЭМЯ-ны фейсбүүк хуудсаар шууд дамжуулахад давхардсан тоогоор 33,712,188 хүн хандалт хийж, 19,898 хүн мэдээллийг хуваалцсан байна. Коронавируст халдвараас сэргийлэх 31 төрлийн инфографик, 70 удаагийн мэргэжилийн эмчийн зөвлөмж, 26 видео, шторк, 28 төрлийн зөвлөмж (текст) бэлтгэн Эрүүл мэндийн яамны фэйсбүүк хуудсанд байршуулан 22,944,731 иргэдэд мэдээлэл хүргэж, 201,056 гаруй хүн хуваалцсан байна.

1.1.3.4.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулна.

Биелэлт: Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ)-ийн эзэмшлийн газрын баруун хойд хэсэгт 0.58 га. талбай бүхий Улаанбаатар хотын төв цэгээс 10 км зайд, Сонгинохайрхан, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сонсголонгийн замын дагуу газарт шинэчлэн барьж, ашиглалтад оруулж, агуулахын тоног төхөөрөмжөөр хангав.

1.1.3.5.өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна.

Биелэлт: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн XIX.1.53-д Өвчтөний хяналт, зохицуулалтын төвийн барилга (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)-ын ажил 3.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр батлагдаж, худалдан авах ажиллагааг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр зарласан. Барилгыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн хашаанд барихаар төлөвлөж байна.

1.1.3.6.шинэ коронавирусийн халдварыг тодорхойлох оношлуурыг дотооддоо бүтээн, туршиж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

Биелэлт: Шинэ коронавирусийн SARS-COVID-19 халдварыг шүлснээс илрүүлэх АШУҮИС-ийн эрдэмтдийн бүтээсэн ПГУ/PCR оношлуурыг 2021 оны 03 дугаар сараас оношилгоонд нэвтрүүлсэн. Коронавируст халдварыг шүлсэнд тодорхойлох 1.3 тэрбум төгрөгний 200 мянган ширхэг түргэвчилсэн оношлуурыг худалдан авч, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан ашиглаж байна.

1.1.3.7.аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийг РТ-ПЦР төхөөрөмжөөр хангана.

Биелэлт: 2022 оны байдлаар нийслэлийн 8 дүүрэг, 21 аймаг, нийт 29 SARS CoV-2 вирусыг илрүүлэх шинжилгээг хийх молекул биологийн лабораторийг шинээр байгуулан лабораторийн чадавхийг бэхжүүлэн ажилласан. Үүнд: УНТЭ, УХТЭ, ЭХЭМҮТ, ЦТЭ, АШУҮИС болон Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Багануур, Хан-Уул, Налайх дүүргийн ЭМТ, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Хэнтий, Завхан аймгуудын Нэгдсэн эмнэлэг, Өвөрхангай, Өмнөговь аймгийн БОЭТ, Өмнөговь аймгийн Цагаан хад боомт дахь лабораториуд хамаарна.Мөн Дархан-Уул, Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн лабораторит PCR аппарат, нуклейн хүчил ялгагч аппаратыг шинээр нэмж суурилуулан, хүчин чадлыг нэмэгдүүлэв.

2022 онд Люксембургийн Их Гүнт Улсын санхүүжилтээр “Цар тахлын үед эхийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах” төслийг хэрэгжүүлж, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Өргөө, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт молекул биологийн шинжилгээ хийх иж бүрэн лабораторийг байгуулсан. Төслийн хүрээнд 109,726.76 ам.долларын үнэ бүхий 22 нэр төрлийн молекул биологийн оношилгооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүдийг лабораторийн стандарт тавилгын хамт хүлээлгэн өгөв.

1.1.4.“Ковид-19” халдварт вирусийн оношилгоо, эмчилгээнд зориулж импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг

гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2020 оныг дуустал үргэлжлүүлэн чөлөөлнө.

Биелэлт: Засгийн газрын 2020 оны 132 дугаар тогтоолоор Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор хугацаанд импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн бөгөөд Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолын 13-т Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор 2021 оныг дуусталх хугацаанд импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж байна.

1.1.5.Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Хөгжлийн банкны үйл ажиллагааг шинэчлэн өөрчилж, экспортын орлогыг нэмэгдүүлэх, эксим банкны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр болов. Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогыг боловсруулан УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны хуралдаанаар батлуулаад байна. Уг бодлогод экспортыг дэмжих хүрээнд экспортын гол хязгаарлагч хүчин зүйл болоод байгаа хилийн боомтуудыг хөгжүүлэх, боомтын нэвтрэх хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлэх, аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд экспортын чиглэлийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг дэмжих чиглэлээр арга хэмжээнүүдийг тусгасан. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлснээр дунд хугацаанд экспортыг 14 тэрбум ам.долларт хүргэж, урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ.

Уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д 2022 оны 1 дүгээр сарын 5-нд өргөн мэдүүлсэн. Худалдааны тухай хуулийн төслийн урьдчилсан тандан судалгааны ажлыг эхлүүлээд байна.

Экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоол батлав, тогтоолын хүрээнд нүүрсний экспортыг бодитоор нэмэгдүүлэх, экспортын дэд бүтцийг цахим болгох чиглэлээр төрийн өмчит компаниудад үүрэг даалгавар өгсөн. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 385 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 6 сарын хугацаатай онцгой дэглэм тогтоогоод байна. Онцгой дэглэм тогтоосноос хойш нүүрс экспортыг 2 дахин, нүүрс тээврийг 4 дахин нэмэгдүүлэн борлуулалтын орлогыг 500 орчим сая ам.доллараар өсгөж “Эрдэнэс Тавантолгой” ХК байгуулагдсанаас хойш хамгийн өндөр түвшинд буюу 1.1 тэрбум ам.долларт хүргэлээ.

1.1.6.Нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд “Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Ковид-19 цар тахлын улмаас манай улсын эрдэс бүтээгдэхүүний экспорт буурч тасалдах нөхцөл үүссэнтэй холбоотойгоор Засгийн газраас шат дараатай арга хэмжээ авсаны нэг нь Монгол, Хятадын "Ногоон гарц" журам бөгөөд энэхүү түр журмын хүрээнд нүүрс тээврийн жолооч нарыг Хятадын талд хонуулах арга хэмжээг авч эхэлсний дүнд 2020 оны 9 дүгээр сараас өдөрт дунджаар 1800 орчим тээврийн хэрэгсэл хил

нэвтэрч эхэлсэн. Ингэснээр 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2.1 тэрбум ам.долларын 28.6 сая тн чулуун нүүрс экспортлоод байна.

Засгийн газрын 2021.07.02-ны өдрийн 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Энэ хүрээнд Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, терминалын үйл ажиллагааг 2021.11.08-ны өдрөөс эхлүүлэн өдөрт 100 тээврийн хэрэгслээр экспорт хийж эхэлсэн. 2021 оны 12 дугаар сарын байдлаар 16.1 сая тн нүүрс, 1,282.5 мян.тн зэсийн баяжмал 7,106.2 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 644.7 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна.

2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 22,559.4 мян.тн нүүрс, 1,189.1 мян.тн зэсийн баяжмал, 3,824.4 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 118.0 мян.тн цайрын баяжмал, 283.1 мян.тн хайлуур жоншны баяжмал, 16.9 тонн алт экспортод тус тус гаргаад байна. Нүүрс 125.3%, зэсийн баяжмал 98%, төмрийн хүдэр, баяжмал 73.6%, цайрын баяжмал 118.0%, хайлуур жоншны баяжмал 43.6%, алт 84.5%-ийн экспортын гүйцэтгэлтэй байна.

1.1.7.Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад чиглэсэн дэмжлэг, тусалцааг нэмэгдүүлэх чиглэлээр хөгжлийн түнш улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллана.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлэх “Эрүүл мэндийн аюулгүй байдлыг бэхжүүлэх хөтөлбөр – Дэд хөтөлбөр 1”-ийн Зээлийн хэлэлцээрийгцар тахлын эдийн засаг, төсөв, эмзэг бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зарцуулах зорилгоор 2021.04.01-ний өдөр байгуулсан бөгөөд хэлэлцээрийн хүрээнд 100.0 сая ам. долларын төсвийн дэмжлэгийн санхүүжилтийг 2021.04.13-ны өдөр Төрийн санд хүлээн авсан. Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлт”-ийн гэрээг 2021 оны тавдугаар сарын 10-ны өдөр байгуулсан бөгөөд 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон батлуулсан. “Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлт”-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас 170 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн нэмэлт эх үүсвэрийг авч ашиглах бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрээр хүүхдийн мөнгө хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих, нийгмийн халамжийн хөтөлбөр, арга хэмжээг зорилтот бүлэгт чиглүүлэх, давхардлыг арилгах, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эдийн засаг, төсөвт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтийг дэмжих, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх юм.

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл”-ийн хүрээнд улсын төсвөөс олгосон хүүхдийн мөнгөний нөхөн санхүүжилтэд 2020 онд 60.7 тэрбум, 2021 онд 119.5 тэрбум, 2022 онд 82.6 тэрбум төгрөгийг олгоод байна.

1.1.8.Гадаад улсад байгаа иргэнээ татан авах ажлыг эрчимжүүлнэ.

Биелэлт: Эх орондоо ирэх хүсэлтэй иргэдээ гадаадаас бүрэн татан авч, 2021 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн агаарын хилээ нээж, тусгай үүргийн нислэгийг ердийн нислэгт шилжүүлсэн. Цар тахал эхэлсэн хугацаанаас хойш буюу 2020.02.01-2021.05.31-ний

хооронд агаарын замаар 183 нислэг үйлдэж 29 543, Монгол-Хятадын боомтоор 4301, Монгол-Оросын боомтоор 2516, нийт 36 360 Монгол иргэдээ эх оронд нь ирүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дэлхийн 91 улсаас агаарын замаар 106 удаагийн нислэг үйлдэж 20,582, Монгол Улс –БНХАУ-ын боомтоор 4,210, Монгол Улс-ОХУ-ын боомтоор 2,392, нийт 27,184 Монгол Улсын иргэнээ зохион байгуулалттайгаар татан авсан байна.

2021 оны байдлаар хилийн чанадад байгаа “Монгол Улсын иргэдэд туслах сан”-гаас 56 өргөдөл, хүсэлтэд 188,8 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна. Тус санд УОК-оос төвлөрүүлсэн 300 сая төгрөгөөс энэ онд 280 иргэнд тусгаарлах байрны зардал болон санхүүгийн бусад дэмжлэг үзүүлэхэд нийт 120,2 сая төгрөгийн тусламжийг (нислэгийн тийз, тусгаарлалтын зардал, бичиг баримтын төлбөр зэрэг) үзүүлсэн байна.

1.1.9.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээг авна.

Биелэлт: Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах чиглэлийн дагуу 2021 онд ЭМДЕГ-ын арилжааны банкинд байршиж байсан 333.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийг Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүллээ. Тухайлбал, Худалдаа хөгжлийн банкнаас 120.0 тэрбум төгрөг, Хас банкнаас 20.0 тэрбум төгрөг, Хаан банкнаас 92.0 тэрбум төгрөг, Төрийн банкнаас 27.0 тэрбум төгрөг, Капитал банкнаас 10.0 тэрбум төгрөг, Голомт банкнаас 40.0 тэрбум төгрөг, ҮХО-ын банкнаас 24.8 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүллээ. Түүнчлэн Прокурорын байгууллагуудын барьцаа хөрөнгийн 13 дансны 726.4 сая төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн.

Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А122/А-172 тоот тушаалаар “Засгийн газрын болон төсвийн байгууллагын банканд нээх, хаах, тайлагнах журам” батлуулсан. Засгийн газрын болон төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгийг эрсдэлд оруулахгүй байх үүднээс тус журамд Монголбанкнаас тогтоосон банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, гадаад валютын зохистой харьцаа, заавал байлгах нөөцийн шаардлагын үзүүлэлтийг сүүлийн 6 сар тасралтгүй хангасан байх, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг сүүлийн 6 сар тасралтгүй хангасан байх, засаглалын үнэлгээгээр 65 ба түүнээс дээш онооны үнэлгээтэй байх, банканд байршиж буй Монгол Улсын Засгийн газрын болон төсвийн байгууллагын банк дах өглөг, харилцах, хадгаламжийн дансны нийт мөнгөн хөрөнгө нь тухайн улирлын банкны нийт активын 30 хувиас хэтрэхгүй байх зарчмыг баримтална гэсэн зохицуулалтуудыг шинээр оруулж өгсөн.

1.1.10.Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаанаас нь өмнө төлүүлэх, хямдруулан худалдах, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанканд шилжүүлэх зэргээр Засгийн газрын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэй Засгийн газрын тусгай сан, компани, банк, санхүүгийн байгууллагуудад олгогдсон Засгийн газрын бүх төрлийн авлагыг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын санхүүгийн тайлангийн “Үнэт цаас”- хэсэгт бүртгэгддэг хөрөнгүүд болон Төрийн өмчит компаниудад оруулсан хөрөнгийн талаар

холбогдох мэдээллийг цуглуулан, тухайн байгууллагуудад оруулсан хувь эзэмшлийн талаарх мэдээллүүдийг нэгтгэх ажлыг хийж байна.

Засгийн газрын эх үүсвэрээр олгосон ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны үлдэгдэл болох 275.4 тэрбум төгрөгийг Сангийн яам болон Монголбанк хооронд байгуулсан 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 295; 0521/607 дугаартай гэрээгээр Засгийн газраас Монголбанкинд 2031 онд төлөх хуваарьтай "Сайн хувьцаа" арга хэмжээний хүрээнд гаргасан үнэт цаасны төлбөр болох 374.0 тэрбум төгрөгөөс 277.4 тэрбум төгрөгийг хугацаанаас нь өмнө суутган тооцож, Монголбанкинд эзэмших эрхийг шилжүүлсэн болно. Өглөг авлагын дүнг хооронд нь хаах замаар Засгийн газрын өрийн үзүүлэлтийг сайжруулсан.

Засгийн газраас орон сууцны хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлсэн эх үүсвэрийн Төрийн банк дахь чөлөөт үлдэгдлийг буцаан төвлөрүүлэхээр ажиллаж, Сангийн яамны Төрийн банкнаас авах нийт зээлийн авлага 54.3 тэрбум төгрөг болон Төрийн банкны зээлдэгчдээс авах авлага 39.3 тэрбум төгрөгийн зөрүү болох 15.0 тэрбум төгрөгийн чөлөөт үлдэгдлийг 2020 онд Төрийн банкаар төлүүлэхээр тохиролцож, бүрэн төвлөрүүлсэн болно.

Засгийн газрын бондын хөрөнгөөр дамжуулан зээлийн хөрөнгийн санхүүжилтийн эргэн төлөлтийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаар 2020 онд ЖДҮХС-гаас 8,647.8 сая төгрөг төлөхөөс 6,200.0 сая төгрөг төлж гүйцэтгэл 72.1 хувь, ХААДС-гаас 11,053.8 сая төгрөг төлөхөөс 2,500.0 сая төгрөг төлж, гүйцэтгэл 22.6 хувьтай гарсан. Мөн Мал хамгаалах сангаар дамжуулан өвс, тэжээл авсан 40,000.0 сая төгрөгийн зээлээс 2020 онд 1,280.7 сая төгрөгийг төлж, уг зээлийн 66.8 хувь буюу 26,736.9 сая төгрөгийн зээлийг барагдуулсан байна.

Улсын төсөв, Засгийн газрын дотоод үнэт цаасны эх үүсвэр, гадаад хөнгөлөлттэй зээлээс Засгийн газрын тусгай сан, төрийн өмчит хуулийн этгээдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон өр авлагыг барагдуулах хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 498.0 тэрбум төгрөгийн өр авлагыг барагдуулаад байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан Засгийн газрын бондын төлбөрт 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 4,5 тэрбум төгрөгийг төлж үлдсэн 10 тэрбум төгрөгийг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр бүрэн төлж барагдуулав.

Анод болон Зоос банкнуудаас авах Засгийн газрын авлагыг шүүхээр шийдвэрлүүлж, авлагыг хаалгах талаар ажиллаж байна.

1.1.11.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцагчдад сургалтын амжилттай нь уялдуулан 100 хүртэл хувийн тэтгэлэг олгоно.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн "Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай" 13 дугаар тогтоолыг баталж, дараах өөрчлөлтийг нэмсэн. Үүнд: Засгийн газрын 2014 оны "Журам, чиглэл шинэчлэн батлах тухай" 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам"-ын "4.1.9-д "Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр дээд боловсролын дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтын 501-ээс дээш оноо авсан бол хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь; суралцагч 2.5-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувийг, 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд 100 хувь" хөнгөлнө гэж шийдвэрлэсэн. 2020 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагад "сувилахуйн хөтөлбөр"-өөр 2946 оюутан суралцаж байна. 2020 оны улсын төсөвт сувилагч мэргэжлээр суралцагчдад сурлагын онооноос хамааруулж олгох тэтгэлэгт зориулж 5.9 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Журамд заасан шаардлага хангасан 843 оюутанд сурлагын амжилттай нь уялдуулан 625.1 сая төгрөгийн

тэтгэлэг олгосон бол 2021 онд 1417 оюутанд 1.8 тэрбум төгрөг, 2022 онд 2480 оюутанд 3.1 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

1.1.12.Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж, бэлтгэнэ. Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр, хувилбаруудыг судалж, бэлтгэнэ.

Биелэлт: Үндэсний хэмжээнд цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх, түүгээр дамжуулан бүх нийтэд зориулсан цахим контент боловсруулах, сургалтад ашиглах зорилгоор MEDLE.mn платформыг 2021 оны 6 дугаар сараас эхлэн хөгжүүлж байна. Энэ платформд 1-12 дугаар ангийн 419 хичээл байршиж, 1.0 сая иргэн хандсан статистик гарсан байна. Танхимын сургалт зайн, цахим хэлбэрт шилжсэн 2 жилийн хугацаанд боловсрол, сургалтын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчим баримтлан 5,756 теле хичээл, 104 интерактив хичээл, 2,775 цахим хичээл, 50 цахим контент, радио болон аудио 30 хичээлийг тус тус бэлтгэн тэгш, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор дохионы хэл, тува, казах хэлний орчуулгатайгаар телевиз, радиогоор дамжуулан хүргэх ажлыг телевизүүдийн холбоо, хувийн хэвшил болон олон улсын байгууллага (Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан)-тай хамтран зохион байгууллаа. Цар тахлын үед төгсөх ангийн сурагчдад зориулсан онлайн сургалтын талбарыг үүсгэн цахим хичээлийг улсын хэмжээнд X-XII ангид хичээл зааж байгаа шилдэг 602 багш удирдаж, хот, хөдөөгийн сургуулийн ахлах ангийн 30.1 мянган сурагч онлайн хичээлд хамрагдсан байна. Цахим контент бэлтгэх, цахим хичээлийн санг бүрдүүлэх, баяжуулах, сургалтад мэдээллийн технологийг бүрэн ашиглах, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын бэлэн байдлыг хангах зорилгоор улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 21 аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын 45 сургуульд цахим контент бүтээх бичил студи байгуулсан.

2022 онд MEDLE.mn цахим санд 2590 контентийг нэмж байршуулсан бөгөөд 5196 контент боловсруулалт, хяналтын шатанд байна. Тус платформд 147 цахим сурах бичиг, 4140 теле хичээл, 6-12 дугаар ангийн математик, физик, хими, биологийн хичээлд ашиглах 805 виртуаль лаборатори, эрүүл мэнд, замын хөдөлгөөний чиглэлээр 152 контент, суралцагчдад зориулсан 85 Microsoft 365 цахим хичээл, контент боловсруулах арга зүйн зөвлөмж, насан туршийн боловсрол, цахим ур чадварын 413 контент, хоцрогдол нөхөх арга зүйн зөвлөмжийг бүх ангийн бүх хичээлээр байршуулан багш нар хичээл сургалтын үйл ажиллагаандаа татаж аван ашиглаж байна.

1.1.13.Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Боловсролын ерөнхий хууль, түүнийг дагалдан гарах хуулиудад нэмэлт өөрчлөлтийг оруулж хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлэв. Цахим сургалтын тогтолцоог бий болгохтой холбогдуулан сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулийн төсөлд дараах заалтуудыг тусгасан байна. Үүнд:

- (i) цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааг танхимын сургалтаас гадна зайн, цахим болон холимог хэлбэрээр зохион байгуулах,
- (ii) эрх бүхий байгууллагын шийдвэрээр танхимын сургалтын үйл ажиллагааг түр зогсоох тохиолдолд сургалтыг зайн эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах,
- (iii) ерөнхий боловсролын сурах бичиг нь цахим хэлбэртэй байх,
- (iv) багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зайн, цахим хэлбэрээр зохион байгуулах,

нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага нь иргэн зайн, цахим хэлбэрээр боловсрол эзэмшихэд зориулж харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц, программ болон техник хангамжийг хариуцан шийдвэрлэх тухай зэрэг болно.

БШУ-ны сайдын 2022 оны А/488 тоот тушаалаар боловсролын салбарт цахим шилжилтийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг, А/489 тоот тушаалаар “Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохицуулах журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

1.1.14.Боловсролд зориулсан зардлыг урьдчилан нөөцлөх, орон нутгийн төсвийн орлогыг зарцуулах, боловсролд дутагдаж байгаа зардлыг шийдвэрлэнэ.

Биелэлт: Орон нутгийн төсвөөс боловсролын салбарын үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 2022 оны 1-4 дүгээр сард 55.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн. 2022 онд Төрийн үйлчилгээний албан хаагчдын дутагдалтай цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт сургуульд 3743.6 сая төгрөг, цэцэрлэгт 962.8 сая төгрөг нэмэлтээр санхүүжүүлэхээр орон нутаг шийдвэрлэсэн. БЕГ-ын даргын 2022 оны А/110 дугаар тушаалаар “Цэцэрлэгийн зориулалтаар ашиглах болон ерөнхий боловсролын сургуулийн гурван ээлжээр хичээллэдэг сургуулийг хоёр ээлжинд шилжүүлэх” зорилгоор ажлын хэсэг 2022 оны 6-8 дугаар сард ажиллан нийслэлийн Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн 152 байрыг түрээсэлж ашиглахаар шийдвэрлэж, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн засаг дарга нь орон нутгийн төсвийн хөрөнгөнөөс сургууль цэцэрлэгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, зөөлөн эдлэл болон бусад зардалд нийт 1386.0 сая төгрөг шийдвэрлэлээ. Одоогийн байдлаар Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Дархан-Уул, Хөвсгөл, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн төсвийн хөрөнгөөр боловсролын байгууллагуудад компьютер тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, байр ашиглалтын түрээс, урсгал засварын 8965.2 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэсэн байна.

1.1.15.Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолно.

Биелэлт: 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 1а/3371 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтран баталсан “Боловсролын байгууллагын багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах” удирдамжийг баталсан. Тус удирдамжийн дагуу боловсролын байгууллагын багш, ажилтныг багц үзлэгт хамруулах ажлыг 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 9 дүгээр сарын 31-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 34073 багш, цэцэрлэгийн 28070 багш, ажилтан 100 хувь хамрагдсан байна.

Хичээлийн жил эхлэхтэй уялдуулан багш нарыг вакцинжуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид ковидын эсрэг дархлаажуулалтын 1 дүгээр тунд 95,1 хувь, 2 дугаар тунд 94,7 хувь, 3 дугаар тунд 58,9 хувьтай хамрагдаад байна.

Хүүхдийн өвчлөл, эрүүл мэндийн судалгаа, Монгол орны цаг агаарын нөхцөл байдалд үндэслэн Хичээлийн жилийн бүтэц тогтоосон БШУ-ны сайдын А/244 дүгээр тушаалаар ид хүйтэн, ханиад томууны дэгдэлтийн үе 12 дугаар сарын 19-нөөс 1 дүгээр сарын 16 хүртэлх хугацаанд ерөнхий боловсролын сургуулиудыг амраах зохицуулалт хийв.

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Эрүүл мэнд

2.1.Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.1.1.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ:

2.1.1.1. “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээ;

Биелэлт: “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/195 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг төлөвлөгөөний төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/780 дугаар тушаалаар “Эрүүл идэвхтэй амьдрал” 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна, 2022 онд нийт 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 38.4 хувьтай байна.

2.1.1.2. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээ;

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/528 дугаар тушаалаар “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх 2022-2025 оны арга хэмжээний төлөвлөгөө” батлагдсан бөгөөд төлөвлөгөөнд 8 зорилт, 166 арга хэмжээ тусгагджээ. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/5075 тоот албан бичгийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлээд байна.

2.1.1.3. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээ;

Биелэлт: “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/471 дүгээр тушаалаар байгуулсан. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/760 дугаар тушаалаар батлан, хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 35.8 хувьтай байна.

2.1.1.4. “Хавдрын эсрэг” арга хэмжээ;

Биелэлт: “Хавдрын эсрэг” 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар батлуулсан. Арга хэмжээг 6 зорилт, 61 үйл ажиллагааг шалгуур үзүүлэлтийн хамт боловсруулсан. Мөн Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Хүүхдийн хорт хавдартай тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/201 дүгээр тушаал батлуулж, хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээ, хяналтыг сайжруулах 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион

байгуулалт, зохицуулалтаар хангах Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тус тус баталсан.

2021 оны байдлаар улсын хэмжээнд умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 67,308 эмэгтэй хамрагдаж, зорилтот насны эмэгтэйчүүдийн эрт илрүүлэгт хамрагдалт 26.6 хувьд хүрсэн байна. Хөхний хорт хавдрын илрүүлэгт улсын хэмжээнд нийт 366,918 эмэгтэй буюу зорилтот насны эмэгтэйчүүдийн 35.9 хувь нь хамрагдаж, үүнээс 1,341 эмэгтэй эмнэл зүйн шинжилгээгээр эерэг гарч, 10 хүнд хөхний өмөн оношлогдсон байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 182,270 (21.6 хувь) хүн хамрагдсанаас 122 тохиолдолд хорт хавдар оношлогдсон байна.

2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт улсын хэмжээнд 616,519 хүн хамрагдсанаас 279,213 буюу 45.3 хувь нь эрэгтэйчүүд, 337 306 буюу 54.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Үзлэгт хамрагдсан 18-60 насны хүн амаас хавдрын 184 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 31-45 насны ангилалд 49 тохиолдол буюу 26.6%, 46-60 насны ангилалд 135 тохиолдол буюу 73.4% -ийг эзэлж байна. 31-45 насныхны дунд ходоодны өмөн 26.5%, хөхний өмөн 24.5%, элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн 20.4%, 46-60 насны ангилалд элэг ба элгэн дэх цөсний өмөн 24.4%, ходоодны өмөн 24.4%, хөхний өмөн 10.4%-ийг тус тус эзэлж байна. 61-ээс дээш насны ангилалд хорт хавдрын 165 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн 38.8%, ходоодны өмөн 26.7%, улаан хоолойн өмөн 15.2%-ийг тус тус эзэлж байна. Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралт 18.6 хувьтай байна.

2.1.1.5. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээ;

Биелэлт: “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр төслийг боловсруулж, ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Арга хэмжээний төлөвлөгөөг эцэслэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулахаар хүлээгдэж байна.

2.1.1.6. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээ;

Биелэлт: Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/816 дугаар тушаалаар “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан бөгөөд төлөвлөгөө нь 4 зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 50.3 хувьтай байна.

2.1.1.7. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ.

Биелэлт: “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийг 11 байгууллагын төлөөлөл оролцуулан Эрүүл мэндийн сайдын А/559 дүгээр тушаалаар байгуулсан бөгөөд төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/559 дүгээр тушаалаар баталсан. Улсын хэмжээнд урологи-андрологийн чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрэгтэйчүүдийн тасаг, кабинет ажиллуулж байгаа төр, хувийн хэвшлийн нийт 20 эмнэлгийн үйл ажиллагаа, хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг гаргасан.

2.1.2. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан Эрүүл мэндийн сайдын “Заавар шинэчлэн батлах тухай” 2019 оны А/586 дугаар тушаалаар баталсан “Гепатитын С вирусын халдварын илрүүлэг, тандалт, оношилгоо, эмчилгээ, гепатитын В, Д вирусын халдварын илрүүлэг, оношилгоо, эмчилгээний заавар”-ыг шинэчлэн боловсруулахаар мэргэжлийн салбар зөвлөлөөс саналыг авч шинэчлэн боловсруулж байна. Хүний эмийн зөвлөлөөр элэгний Д вирусын эсрэг “Bulevirtide (Hercludex) эмийг эмийн жагсаалтад 2 жилийн хугацаатай бүртгэсэн.

2.1.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна:

2.1.3.1. Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв;

Биелэлт: Эрхтэн шилжүүлэн суулгах төв нь Улаанбаатар хот Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хашаанд 60.2*30 м хэмжээтэй цоколийн 2 давхартай, 8 давхар барилгатай, шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдээр бүрэн хангагдсан байхаар төлөвлөгдсөн. Тус төсөл арга хэмжээний ТЭЗҮ боловсруулагдсан бөгөөд 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг шаардлагатай. Санхүүжилтийг Монгол Улсын Төсвийн тухай хууль болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэхээр судалж байна.

2.1.3.2. Зүрх судасны үндэсний төв;

Биелэлт: Зүрх судасны төвийн зураг төсвийг Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “Зүрх судасны төв байгуулах” төслийн 1.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн хүрээнд хийж магадлалаар баталгаажуулсан. Төвийн барилгыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн хашаанд барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Барилга угсралтын ажлын дүн 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ба санхүүжилтийг Монгол Улсын Төсвийн тухай хууль болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэхээр судалж байна.

2.1.3.3. Сүрьеэгийн эмнэлэг;

Биелэлт: Сүрьеэгийн эмнэлгийн барилга угсралтын ажлын сонгон шалгаруулалтын явцад оролцогч компаниуд шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргаснаар барилга угсралтын ажлын гэрээ байгуулагдаж чадаагүй байна. Шүүхийн шийдвэрийн дагуу захиргааны хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түр зогсоогоод байна.

2.1.3.4. Геронтологийн үндэсний төв;

Биелэлт: Геронтологийн төвийн барилга царцсан, барилга угсралтын ажил хийгдээгүй байна. Барилга угсралтын ажлын зураг төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдсэн. Геронтологийн төвийн барилгын ажлын явц 46 хувьтай байна.

2.1.3.5. Түлэнхийн төв;

Биелэлт: Түлэнхийн төвийн барилга угсралтын ажлын явц 95 хувьтай байна. Улсын комисс ажиллуулах хүсэлтийг Хотын стандарт, хөгжлийн газарт хүргүүлсэн бөгөөд Улсын

комисс ажиллуулахаар хүлээгдэж байна. Мөн “Түлэнхийн төвийн тоног төхөөрөмж” нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зарласан.

2.1.3.6.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн салбар-II;

Биелэлт: Халдварт өвчин судлалын үндэсний төвийн салбар-II барих зураг төслийн ажил хийгдэж дууссан. Төв аймгийн Сэргэлэн сумын 20 га газрыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд шилжүүлэн гэрчилгээг олгосон.

2.1.3.7.Хавдар судлалын үндэсний төвийн салбар эмнэлэг-II.

Биелэлт: Хавдар судлалын үндэсний төвийн салбар II барилгын зураг төсвийн ажил 80 хувьтай үргэлжилж байна. Газрын асуудал шийдэгдэж, Баянзүрх дүүргийн Чулуутын аманд 10 га газарт барилга барихаар болсон.

2.1.3.8. Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барина.

Биелэлт: Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэгийн барилгын зураг төслийн ажил хийгдэж байна. Уг эмнэлгийн барилгыг барихаар олгогдсон 7,000 м2 газарт эмнэлгийн барилга багтахгүй байгаа тул газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж, мөн зураг төсвийн ажил хүлээгдэж байна.

2.1.3.9.Гадаадын зээл, тусламжийн хүрээнд эрүүл мэндийн салбарт цөмийн дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Олон улсын атомын энергийн агентлаг, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Техникийн хамтын ажиллагааны хүрээ 2022-2027 он” баримт бичгийн хүрээнд 2023 онд Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-д “Шугаман хурдасгуурт суурилсан стереотактик туяа эмчилгээний аргыг нэвтрүүлж, түгээмэл тохиолддог хорт хавдрын эмчилгээний чанарыг сайжруулах нь” MON6022 төслийг агентлагийн 364 мянган еврогийн санхүүжилтээр хэрэгжүүлэх ба төслийн хүрээнд стереотактик эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, хүний нөөц бэлтгэгдэнэ. Төслөөр олон улсын туршлага судлах 1 танилцах дадлага, 4 эмч, техникчийг дунд хугацааны дадлагажих сургалтад хамруулж, 2 шинжээчийг урьж ажиллуулхаар төлөвлөсөн.

ХСҮТ-д “Шугаман хурдасгуурт суурилсан стереотактик туяа эмчилгээний аргыг нэвтрүүлж, түгээмэл тохиолддог хорт хавдрын эмчилгээний чанарыг сайжруулах” MON6021 төслийн хүрээнд дүрслэлийн төхөөрөмж (Onboard Imaging)-ийг Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд авах ажил хийгдэж байна. Тус худалдан авалтын эхний ээлжийн ачаа болох амьсгал хянах төхөөрөмжийг 2022 оны 09 дүгээр сард ХСҮТ-ийн туяа эмчилгээний тасаг хүлээн авсан.

2.1.3.10. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 169 дүгээр тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж эхлээд байна. Сумын 10, 15, 22 ортой Эрүүл мэндийн төв, 50 ортой Хүүхдийн эмнэлгийн барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газар 2021 онд баталгаажуулсан. 30 ортой

сүрьеэгийн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн барилгын нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулсан.

2.1.4.Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ:

2.1.4.1.орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна.

Биелэлт: Осол, гэмтэл ихээр гардаг Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хөвсгөл аймгийн Хатгал, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Булган аймгийн Хутаг өндөр, Архангай аймгийн Тариат, Ховд аймгийн Булган, Завхан аймгийн Их-Уул, Орхон аймгийн Баян-Өндөр, Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Мандал сум зэрэг 10 цэгт яаралтай тусламжийн жишиг цэгийг байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийн худалдан авалтыг ДЭМБ-ын санхүүжилтээр хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/502 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад тоног төхөөрөмжийг хуваарилсан. Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг яаралтай тусламжийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна.

2.1.4.2.эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана.

Биелэлт: Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр-5”-ийн хүрээнд “Яаралтай үеийн тусламжийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд нийт 12 бүлэг 27.9 сая ам.долларын төсөл арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн. Тухайлбал, гэрээ байгуулсан 7 төсөл, арга хэмжээний 13.65 сая ам.доллар, тендер зарлахаар бэлтгэж байгаа 1 төсөл, арга хэмжээний 2.23 сая ам.доллар, тендерийн үнэлгээ хийгдэж байгаа 2 төсөл, арга хэмжээний 2,38 сая ам.доллар, Тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн 2 төсөл, арга хэмжээний 9.67 сая ам.долларын хөрөнгө оруулалт тус тус хийгдээд байна.

2022 онд алсын зайн болон яаралтай тусламжийн үйл ажиллагаанд ашиглах туулах чадвар өндөртэй түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг болон лавлагаа шатлалын Халдварт өвчин судлалын үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улсын гуравдугаар төв эмнэлгүүдэд нийт 4,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгоод байна. Мөн түргэн тусламжийн УАЗ-фургон автомашиныг 11 аймгийн 22 сумын эрүүл мэндийн төвд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгож ашиглалтад оруулаад байна. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт Хөгжлийн төлөвлөлтийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн коронавируст халдвар КОВИД-19-ыг эмчлэх, урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд 8 ширхэг иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашиныг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгөв.

2.1.4.3.яаралтай тусламж үйлчилгээнд агаарын үйлчилгээг /нисдэг тэрэг/ нэвтрүүлнэ.

Биелэлт: Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-6 төслийн хүрээнд яаралтай тусламжийн үйлчилгээнд нисдэг тэргийг нэвтрүүлэх арга хэмжээ тусгагдсан байна. Түргэн тусламжийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах олон улсын тендер зарлагдсан бөгөөд үнэлгээ хийгдэж байна. Олон улсын зөвлөх компанийн үйл ажиллагааны хүрээнд

нисдэг тэргийг түргэн тусламж, үйлчилгээнд ашиглах хэрэгцээ шаардлагын судалгаа хийгдэж байна. Үүнтэй холбоотойгоор ГССҮТ, ЭХЭМҮТ-д нисдэг тэрэг буух талбайг байгуулсан. Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээнд ОБЕГ, хувийн хэвшлийн байгууллагатай иргэд хувиараа хамтран ажиллаж, нисдэг тэргээр тусламж, үйлчилгээ авч байна.

2.1.4.4. түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ.

Биелэлт: “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” нэмэлт төслийн хүрээнд “Яаралтай үеийн тусламжийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд 21 аймагт эмнэлгийн бүрэн тоноглогдсон автомашин нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. НҮБ-ийн Хүүхдийн сангаас 221.0 сая төгрөгийн санхүүжилтээр нийт 5 аймгийн 9 сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн тоногдсон эмнэлгийн автомашин хүлээлгэн өгсөн. 2022 оны байдлаар 50 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин хүлээлгэн өгөв.

2.1.5. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль, эрх зүйн орчныг бий болгоно.

Биелэлт: “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг 17 аймаг (Архангай, Орхон, Төв, Баянхонгор, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн Хархорин, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Дорноговь аймгийн Замын Үүд, Сэлэнгэ, Булган, Увс, Завхан, Дорнод), 3 дүүргийн Эрүүл мэндийн төв (Баянзүрх, Багануур, Сонгинохайрхан), төрөлжсөн мэргэшлийн 3 эмнэлэг (УГТЭ, УХТЭ, УНТЭ)-т байгуулж нийт 1.2 тэрбум төгрөгийн өртөгтэй, 20 гаруй төрлийн иж бүрэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслээр хангасан. Нийт 12.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

Хүн амыг өвчилсөн хойно нь бус өвдөхөөс өмнө нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Өвөрхангай, Ховд аймгийн БОЭТ, нийслэлийн Хан-Уул, Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн дэргэд “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулж тоног төхөөрөмжөөр хангасан. Эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээнд зориулж 1.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 20 гаруй төрлийн иж бүрэн тоног төхөөрөмжийг дагалдах хэрэгслийн хамт суурилуулсан. Эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлийн судалгааны ажлыг дэмжих зорилгоор 2021 оны 2 дугаар хагаст Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр 2,9 тэрбум төгрөгийн нийт санхүүжилт бүхий 30 төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр сонгон шалгаруулж, “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, санхүүжилтийг олгосон.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан хуулийн төсөл боловсруулж байна. Тамхины хяналтын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийг боловсруулж байна.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн өөрчлөлтийн төслийг боловсруулсан бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

2.1.6. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: “Эмнэлэгт үзүүлэх цаг захиалгын 1800-0119 нэгдсэн төв”-ийг нээж, ашиглалтад оруулан, иргэд эмнэлэгт биеэр очиж цаг авдаг очер, дараалал сарын дотор 86 хувиар буурч, иргэд чирэгдэлгүй тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүллээ. Цаг захиалгын 1800-0119 дугаарт Эрүүл мэндийн яамны харьяа 9 төрөлжсөн төв эмнэлэг болон аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэгт цаг товлох үйлчилгээ бүрэн нэвтэрч нийт 39

эрүүл мэндийн байгууллагыг холбон үйл ажиллагаа жигдрээд, дуудлага хүлээн авч байна. Тус төвийг яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төв дээр түшиглэн зохион байгуулж, тусгай мэргэжлийн төв болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, дүүргийн Эрүүл мэндийн төвүүдийн ажлын дадлага, туршлагатай 30 цахим бүртгэгч, хүүхдийн 10 эмч, нарийн мэргэжлийн эмч нар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна. 2021 оны байдлаар нийт 48 эрүүл мэндийн байгууллагыг шилэн кабелийн VPN сүлжээний дэд бүтцэд холбоод байна. 2021 онд 63, 2022 онд 56 сум, өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн.

Эрчимт эмчилгээний тасгуудын хооронд телемедицийн сүлжээ байгуулах үйл ажиллагааны хүрээнд ГССҮТ, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ЦТЭ зэрэг 6 эрүүл мэндийн байгууллагыг холбон үйл ажиллагаа жигдэрсэн. Мөн E-health програм хангамжид тулгуурлан 48 эрүүл мэндийн байгууллага дүрс архивлан хадгалах /PACS/ системийг суурилуулан ашиглаж байна. ЭМДЕГ-тай гэрээ бүхий лавлагаа шатлалын болон анхан шатны эмнэлэг, 50 гаруй хувийн эмнэлэг зэрэг эрүүл мэндийн байгууллагуудыг НIEP системд холбож, нийт эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны платформыг нэвтрүүлсэн.

Алсын зайн анагаах ухааны суурь системийг Улсын гуравдугаар төв эмнэлгийн зүрхний төвийн санаачлагаар лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 9 аймгийн А зэрэглэлийн 18 сумын эрүүл мэндийн төвд шинээр нэвтрүүлсэн. Уг системийг анхан болон лавлагаа шатлалын 264 эрүүл мэндийн байгууллагын 574 хэрэглэгч ашиглан телемедицинээр тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх хүсэлт, шийдвэрлэлт, олгох, сунгах зэрэг ажлууд цахимжсан. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар тусгай зөвшөөрөлтэй нийт 6,122 байгууллагуудын мэдээллийн шинэчлэлийг хийж, мэдээллийн сан баяжуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.

Биелэлт: Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулах тухай” 02 дугаар тогтоол батлагдсан. Уг эрсдэлийн санг эрүүл мэндийн сангийн 2021 оны орлогын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулсан.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 239 хувийн хэвшлийн ортой эмнэлгийн 196 буюу 82 хувьтай нь ЭМДЕГ-аас гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг зөвхөн төрийн эрүүл мэндийн байгууллагуудад үзүүлдэг байсныг ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор өөрчилж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нээлттэй болгож, ижил тарифаар санхүүжүүлэх нөхцөл бүрдүүлсэн.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 328 сумын ЭМТ, лавлагаа шатлалын 64 эмнэлгийн байгууллагад гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нэвтэрсэн. ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнг үнэлж, үнэ тарифын өсөлт, цалингийн доод жишиг шинэчлэхтэй холбоотойгоор уг журмыг дахин шинэчлэн боловсруулж, ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлав. 562 оношийн хамааралтай бүлгийг 705 болгож, амбулаторийн тусламж, үйлчилгээ, өдрийн мэс засал, ажилбар, эмчилгээг даатгалаас санхүүжүүлэхээр жагсаалтыг өргөжүүлсэн. Мөн ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн журам”-ын хэрэгжилт, үр дүнг үнэлж, журмыг шинэчлэн ЭМДҮЗ-ийн 2022

оны 05 дугаар тогтоолоор батлуулж анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний санхүүжилтийн уялдаа холбоог хангасан.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/334 дүгээр тушаалаар Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх зааврыг батлав. “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журам”, “Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах журам”-ыг тус тус шинэчилсэн. 2022 оны байдлаар нийт 21 эрүүл мэндийн байгууллагад ТУЗ байгуулагдсан болон байгуулагдах шатандаа байна.

Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах ажлын хүрээнд 1/ Иргэд даатгуулагчдад зориулсан 1818.mn цахим хуудсыг шинээр нээн ажиллуулсан, 2/e-daatgal гар утасны апплейкешн хэрэглээнд нэвтрүүлсэн, 3/ Эрүүл мэндийн даатгалын цахим нэгдсэн системд бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбож төлбөрийн нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлж байна.

2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналт нэвтрүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн нэгдсэн сан байгуулах ажлын хүрээнд хамтатган зохион байгуулсан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, гадаадын эмийн үйлдвэрийн төлөөлөгчийн газрууд www.licemed.mohs.mn домайн хаягаар, иргэд, олон нийт www.druginfo.mohs.mn домайн хаягаар хандан ашигладаг ба нээлттэй мэдээлэл бүрэн байршсан. Лайсмед программд эмийн аюулгүй байдлын тайлан илгээх боломжтой 384 эм ханган нийлүүлэх, үйлдвэрлэх байгууллагыг цахимжуулах ажил бүрэн хийгдсэн.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулгын үйл ажиллагаа 2021 оны 8 дугаар сарын 03-ны өдрөөс эхэлсэн бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 73 эрүүл мэндийн байгууллагын 13 нэр төрлийн 873 эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт, тохируулга хийхэд 88.8 хувь эмнэлгийн тоног төхөөрөмж шалгалт, тохируулгад тэнцсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/23 дугаар тушаалаар “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ийг 80 орон тоотойгоор батлан, үйл ажиллагаа явуулж байна.

2010 оноос үйл ажиллагаа нь зогсоод байсан “Биобэлдмэлийн үйлдвэр” КОВИД-19 цар тахлын эсрэг иммуноглобулин үйлдвэрлэх боломж нөхцөл нээгдэж байгаа бөгөөд 2021 онд үйлдвэрийн чанарын хяналтын лабораторид шаардлагатай 10 төрлийн тэжээлт орчин, 2022 онд 24 төрлийн тэжээлт орчинг технологийн зааврын дагуу үйлдвэрлэж, чанарын хяналтын албанд хэрэглэж байна.

Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төсөлд зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт хийх заалт тусгасан бөгөөд хуулийн төслийг боловсруулж байна.

2.1.9.Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.

Биелэлт: Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг сайжруулах, эмнэлгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор эрүүл мэндийн

ажилчдын цалингийн доод жишгийг шинэчлэн тогтоож, эрүүл мэндийн байгууллагууд эмч, ажилчдын цалинг нэмсэн.

2021 онд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, орон нутгийн лабораторийн хүчин чадлыг сайжруулах зорилгоор ПГУ-ын молекул биологийн лаборатори шинээр байгуулах, ажиллах хүний нөөц эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажиллан суралцах журмын дагуу зохион байгуулж энэхүү үйл ажиллагааны хүрээнд орон нутгаас 32, нийслэлээс 32, нийт 64 эмч, мэргэжилтнийг ажиллан суралцах журмаар 2021 оны 2-3 дугаар сард 1 сарын хугацаагаар сургалтад хамруулав.

2021 онд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Нэгдсэн лабораторийн албаны вирус судлалын лабораторийн тасгийн 2 их эмч, 1 био-анагаах судлаач нар Япон Улсад “SARS COVID” бүрэн генийн дараалалыг тодорхойлох сургалтад, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн Хүүхдийн гэмтэл согогийн тасгийн 1 их эмч Турк Улсад хүүхдийн гэмтлийн мэргэжил дээшлүүлэх сургалтад тус тус хамрагдсан. 2022 онд Улсын гуравдугаар төв эмнэлгээс Япон Улсад Уушиг судлал чиглэлээр 1, БНСУ-д Мэдрэл судлал чиглэлээр 1 эмч, нийт 2 эмч гадаад улсад суралцаж байна. Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээний хүрээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 271 эмчийг ажлыг байранд сургасан. “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаал батлагдаж, 32 эмнэлэгийн мэргэжилтэнг ОХУ, Турк, АНУ, Тайвань, БНСУ зэрэг улсад богино хугацааны сургалтад хамруулав.

2020 онд олон улсын чанартай алсын зайн цахим, цуврал модуль бүхий сургалтад давхардсан тоогоор 349 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Мөн 2020 онд олон улсын эрүүл мэндийн салбарт хамгийн өргөн хэрэглэгддэг цахим платформ “UpToDate”-г ашиглах эрхийг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд нээлттэй болгосон.

2.1.10.Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

2.1.11.Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийг үе шаттайгаар байгуулна.

Биелэлт: Ховд, Увс аймгийн БОЭТ-ийн барилгын ажлын даалгаврыг боловсруулан дуусгасан. Барилгын зураг төслийг боловсруулах ажил хийгдэж байна. 2021 онд Дорнод аймгийн БОЭТ-ийн Хүүхдийн эмнэлгийн 200 ортой эмнэлэг барих 2.0 тэрбум төгрөгийн төсөв суусан бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, шалгарсан компанитай гэрээ байгуулж, барилга угсралтын ажил 40.0 хувьтай байна. 2021 онд Өмнөговь, Орхон, Ховд, Дорнод, Өвөрхангай зэрэг 5 аймгийн БОЭТ-д 6.9 тэрбум төгрөгийн 64 зүслэгтэй компьютер томографийн аппарат, 8.9 тэрбум төгрөгийн ангиографийн тоног төхөөрөмж ханган нийлүүлсэн.

2.1.12.Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд өрх, сумын эрүүл мэндийн төвийн 36 шилжих барилга байгууламжийн төсөл хэвийн үргэлжилж байна. 2021 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан 31.9 тэрбум төгрөгийн 21 шинэ барилгын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 19 барилгын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан бөгөөд барилга угсралтын ажил эхэлсэн.

Эрүүл мэндийн салбарын хэмжээнд шинээр хэрэгжүүлэхээр нийт 8.8 тэрбум төгрөгийн 32 их засварын төсөл, арга хэмжээ батлагдсанаас 27 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулсан бөгөөд засварын ажлын гүйцэтгэл 80 хувьтай, 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарлагдсан.

Төсвийн тухай хуульд 2022 онд ашиглалтад орох шилжих барилга 25, шинэ барилга 3, 2022 онд ашиглалтад орох шилжих барилга 2, нийт 30 барилга, 161.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр батлагдсан. Нийт 21 өрх, сумын ЭМТ-ийн барилгын барилга угсралтын ажлын явц 75.0 хувьтай байна. Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын зурагт өөрчлөлт орж, хийгдэж дууссан.

2.1.13.Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.

Биелэлт: Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 257/А/562 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ыг хүчингүй болгож Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор шинэчлэн батлуулж, эрх зүйн уялдааг хангав.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн журмыг шинэчилж ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор баталж, 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн ЭМДҮЗ-ын 13 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үлгэрчилсэн гэрээ, гэрээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг батлуулж сар бүр 80 хувийн урьдчилгаа санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 20 хувийг хянаж олгохоор зохицуулсан. Ингэснээр иргэн анхан шатны тусламж, үйлчилгээг хаанаас авч байгааг цахимаар хянаж, тусламж, үйлчилгээ үзүүлж буй анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх боломж бүрдсэн. Шинэчилсэн журмын дагуу нэг иргэнд ногдох нормативт зардлыг 2 дахин нэмэгдүүлж санхүүжилтийг олгож байна.

2.1.14.Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.

Биелэлт: Эрүүл мэндийн төвүүдийн 76.5% нь нүхэн жорлон тогтмол ашигладаг, 13.1% нь хааяа ашигладаг, 2.0% огт ашигладаггүй бол 8.4% нь гадна нүхэн жорлонгүй байна. Нүхэн жорлон ашигладаг байдлыг бүсээр харахад баруун бүсийн сумын ЭМТ хамгийн их буюу 89.2%, зүүн бүс 78.6%, хангайн бүс 78.1%, төвийн бүс 60%-д нүхэн жорлон тогтмол ашигладаг байна. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд 24,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 аймгийн нийт 15 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгохоор төсөвлөсөн бөгөөд 2022 онд санхүүжих дүн 360.0 сая төгрөг батлагдсан. Зураг төсөл хийгдэж, магадлалын ерөнхий дүгнэлт хүлээгдэж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 174 тоот тушаалаар “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн төсөл арга хэмжээ” арга хэмжээний хүрээнд сумдад дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээг барьж, нүхэн жорлонтой сумдын эмнэлгийг орчин үеийн ариун цэврийн

байгууламжтай болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж хоногт 6м3, 12м3 бохир ус цэвэрлэх бага хүч чадлын септик технологийн цэвэрлэх байгууламжид холбоход боловсролын байгууллагын барилгын ариутгах татуургын "Цэвэрлэх байгууламж /шингээх/" нэг маягийн батлагдсан бөгөөд Улсын 2022 оны төсөвт 3 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил туссан.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймагт "Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ" төслийн хүрээнд 3 аймгийн 15 сумын Эрүүл мэндийн төвд нүхэн жорлон ба сайжруулсан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлэх 423.0 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулсан. Барилга, байгууламж барих зураг төсөл боловсруулж гүйцэтгэх компанийг сонгох, сонгон шалгаруулалт хийгдсэн.

Биеийн тамир, спорт

2.2.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

2.2.1.Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.

Биелэлт: "Хүн амын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ыг 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд төлөвлөгөөт хуваарийн дагуу зохион байгуулсан. Улсын хэмжээнд 3-64 насны 347237 иргэн бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдлаа. Энэ нь нийт хүн амын 10.1% -ийг эзэлж байгаа бөгөөд сорилд хамрагдсан иргэдийн 47.8% эмэгтэйчүүд /166042/, 52.2% эрэгтэйчүүд /181195/ байна. Уг тайлант хугацаанд сорил авсан нийт иргэдийн 78.5% нь буюу 272726 иргэн А, В, С хангалттай үнэлгээ авсан байна. Иргэдийг насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх зорилгоор "Эрүүл мэндийн цахим гүйлт", "Дасгал хөдөлгөөнөө хийцгээе", "Цахим гимнастрада", "Иргэдийн наадам-21", "Өртөөт марафон", "Үнэгүй фитнес" арга хэмжээг төрийн болон төрийн бус 70 гаруй байгууллагатай хамтран зохион байгуулсан. Цахим биеийн тамирын арга хэмжээнд 80,250 хүн, оролцож алхах, гүйх, дугуй унаж 513 582 км замыг туулсан, мөн цахим дасгалыг "Үнэгүй фитнес" ТББ хамтран зохион байгуулж 1,5 сая хүн хамрагдсан бол спорт заал болон гадаа арга хэмжээнд 2291 багийн 19541 иргэн хамрагдсан.

2021 онд улсын хэмжээнд 60 арга зүйч ажиллаж байна. 2022 онд сумын биеийн тамирын арга зүйчийн тоог 63-аар нэмэгдүүлэв. Иргэдийн дунд дасгалаар дархлааг дэмжих, зөв дадал хэвшилтэй иргэдийг бий болгох зорилгоор эрүүл зөв хооллолт, үндэсний наадгай, иог, цахим гүйлт, алхалт, дугуй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэр бүлийн орчинд дэмжих арга хэмжээг зохион байгуулж гүйцэтгүүлэхээр 33 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж түр ажлын байраар хангасан. 2022 онд нийтдээ төрийн бус 97 байгууллагаар үйл ажиллагааг гүйцэтгүүлэн дэмжлэг үзүүлж, түр болон байнгын 949 ажлын байр бий болгон ажилласан.

Үндэсний шигшээ багт сонгогдсон 22 төрлийн спортын холбоо, 240 дасгалжуулагч, тамирчдыг ажлын байраар ханган санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд сонгогдоогүй даам, туялзуур сэлэм, усан спортын төрлөөр 4 холбоодтой гэрээ байгуулж санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Залуучуудын шигшээ багийг спортын 14 төрөлд, 3 дасгалжуулагч, 55 тамирчны орон тоотой төсвөөс цалин, тэмцээн уралдаан

бэлтгэл сургалтын зардал санхүүжилтийг хариуцан ажиллаж байна. Залуучуудын шигшээ багийн боксын спортын төрлөөр 2021 онд залуучуудын ДАШТ-ээс 2 хүрэл медаль хүртсэн амжилттай байна.

2.2.2.Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.

Биелэлт: Үндэсний спортын төвд 8 үндэсний /морин уралдаан, жороо морь, ширээний шагай, халх сурын харваа, бариуд сурын харваа, морин харваа, уран уургач, эмнэг сургагч, тэмээн поло/ спортын задгай талбайг байгуулахаар төлөвлөсөн ба ерөнхий төлөвлөлтийн зургийг боловсруулж байна. Үндэсний спортын тоглоом наадгайн төрөл болох шагайгаар тоглох спорт тоглоомыг зохион байгуулах шийдвэрийг НҮБ-ын ЮНЕСКО-гийн Уламжлалт спорт, тоглоом наадгайн олон улсын зөвлөлөөс гаргуулахаар ажиллаж байна. Үндэсний шагайн харваа, мөсөн сур спортын 2 төрлөөс ажлын даалгаварт тусгуулах санал авч олон улсын брэнд наадмыг зохион байгуулах хөтөлбөрийн төслийн боловсруулалт хийгдэж байна.

2022 онд Монголын оюутны спортын V наадам эхний хагас жилд спортын 10 төрлөөр 29 их, дээд сургууль хамрагдсан. Улсын хэмжээний анхан шатын тэмцээнд 4500 тамирчид, шигшээ наадамд 1607 тамирчид хамрагдав. Монголын үндэсний спортын наадмыг 4 жил тутамд нэг удаа зохион байгуулагдаж 2022 онд өвлийн 2 төрлийг 2 сард, зуны 13 төрлийн тэмцээнийг 8 сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан. шигшээ тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 2648 тамирчид 53 багц, 561 медалийн төлөө өрсөлдсөн. "Монголын бүх ард түмний спортын XV зуны спортын наадам"-д олимпын спортын 18 төрөл, оюуны спортын 2 төрөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 6 төрөл, нийт 26 спортын төрөлд 4500 гаруй тамирчид оролцож байна.

2.2.3.Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.

Биелэлт: Баянгол дүүргийн усан бассейн бүхий спортын цогцолбор ашиглалтад орсон. Налайх дүүргийн усан бассейн бүхий спортын цогцолборыг 2023 онд ашиглалтад оруулна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл-95 хувьтай. Баянзүрх дүүргийн усан бассейн бүхий спортын цогцолборын төсөвт өртгийн зөрүү 2,7 тэрбум төгрөг 2022 оны төсвийн тухай хуульд туссан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл-90 хувьтай 2023 онд ашиглалтад оруулна. Нийслэлийн усан бассейн бүхий спортын цогцолбор угсралтын ажлын төсөвт өртгийн зөрүү 2,5 тэрбум төгрөг 2022 оны төсвийн тухай хуульд батлагдсан. Барилга угсралтын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй, 2023 онд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Сүхбаатар дүүргийн усан бассейн бүхий спортын цогцолборын барилга угсралтын ажлын төсөвт өртгийн зөрүү 2,8 тэрбум төгрөг 2022 оны төсвийн тухай хуульд батлагдсан. Барилга угсралтын ажил 50 хувийн гүйцэтгэлтэй, 2023 онд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Сум болон аймгийн төвд баригдах спортын заал, усан бассейн бүхий спорт цогцолборыг нэг маягийн зураг төсөл, төсөвтэй батлагдан хэрэгжиж байна. 2021 онд 5 сумын спорт заалны барилга, 1 усан бассейн бүхий спорт цогцолборын ажлыг хэрэгжүүлсэн. Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дундговь, Сайнцагаан сум/ угсралтын ажил эхэлсэн.

2020 онд дараах биеийн тамир, спортын зориулалттай талбай, барилга байгууламжуудыг барьж ашиглалтанд орууллаа. Үүнд: Биеийн тамир, хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, 10, 11 дүгээр хороо/, "Миний Монгол" цэцэрлэгт

хүрээлэнгийн хөл бөмбөгийн иж бүрэн талбай, тохижилт /Дархан-Уул аймаг, Дархан сум/, Наадмын талбайн тохижилт /Увс аймаг, Улаангом сум/, Хорооны дугуйн зам, тохижилт /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг/, Хүүхэд, залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай /Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/.

“Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн”-гийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, эх загвар зураг (эскиз)-ийг боловсруулж байна. Төслийн концепц, загвар зураг төсөл боловсруулах уралдааныг зарлан, сонгон шалгаруулалтыг хийж “Хаус дизайн” ХХК-ийн боловсруулсан “Хийморь цогцолбор” бүтээлийг шалгарсан. Цэнгэлдэх хүрээлэнг Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэр 30.0 га газарт байгуулахаар газрын асуудлыг шийдвэрлэсэн.

Боловсрол

2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.

2.3.1.Яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийн дэмжих хөтөлбөрийн төслийг НҮБ-ын Хүүхдийн сан, Боловсролын хүрээлэнтэй хамтран боловсруулж Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар батлууллаа. Засгийн газрын 2022 оны 97 дугаар тогтоолоор “Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох” журам, ХНХ-ын сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/38 тоот тушаалаар “Хүүхэд харагч бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр”, ХНХ-ын сайдын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/151 дугаар “Журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам” шинэчлэн батлагдсан. Монгол Улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд хүүхэд харах үйлчилгээний зардалд 2.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад батлагдсан бөгөөд энэ хүрээнд 2022 онд 1894 хүүхэд (үүнээс 106 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд) тус үйлчилгээнд хамрагдах тооцооллыг хийсэн.

2020-2021 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд 12-23 хүртэлх бүлэгтэй төрийн өмчийн 134 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 2021-2022 оны хичээлийн жилд 12-оос дээш бүлэгтэй төрийн өмчийн 60 цэцэрлэгийн дэргэд байршил, хэрэгцээ шаардлагыг харгалзан яслийн бүлэг нээх, үндэсний тогтолцоог сэргээх ажлыг эхлүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах бэлтгэл ханган ажилласан. Яслийн үндэсний тогтолцоо, хүүхэд харах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд энэ асуудлыг тусган баталж, хуулийн төсөлд эдгээр үйлчилгээнд хамрагдах нас болон бусад зохицуулалтыг тусган боловсруулсан. Яслийн нэг бүлэгт 1-2 насны 15 хүүхэд, 1 багш, 2 туслах багш ажиллуулахаар тооцсон бөгөөд цаашид яслийн орчин, хүний нөөцөд тавигдах нийтлэг шаардлагыг хангасан төрийн бус өмчийн цэцэрлэгт нэг хичээлийн жилд хамгийн багадаа яслийн насны 8000 хүүхэд хүлээн авч, ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй эхчүүдэд энэ үйлчилгээг сонгон хүүхдээ хамруулах боломж бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгохоор төлөвлөн ажиллаж байна.

2.3.2.Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.

Биелэлт: Манай Улсын хэмжээнд 2-5 насны 309.6 мянган хүүхэд байгаагаас 2020-2021 оны хичээлийн жилд 1454 цэцэрлэгт нийт 247.040 хүүхэд /үүнээс 2 хүртэлх насны 2538, 2 насны 42536, 3-5 насны 201381, 6 насны 585 хүүхэд/ хамрагдаж, хамран сургалт 79,7 хувь болж өмнөх оноос 4,5 хувиар буурсан дүнтэй байна. Энэ нь Коронавирус /Ковид-19/-ын цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалт эхэлсэн, 9 дүгээр сарын 21-ний өдрөөс цэцэрлэгт 2 настай хүүхдийг элсүүлсэн зэргээс шалтгаалан 2020-2021 оны хичээлийн жилд хамран сургалт буурахад нөлөөлсөн. Хамрагдалтыг нэмэгдүүлж, хүүхдийн сургуульд элсэн суралцах бэлтгэлийг хангах зорилтын хүрээнд цэцэрлэгт хамрагдаж чадаагүй 2389 хүүхдийг төрийн бус өмчийн 14 цэцэрлэгт нэмэлтээр элсүүлэн, цэцэрлэгийн байрны түрээсийн зардалд 2020 онд 643.7 сая төгрөг зарцуулсан. Цэцэрлэгт хамрагдах насыг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн өөрчилж 3-5 нас болгох, 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах асуудлыг Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусган баталж, Боловсролын ерөнхий хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах хуулиудын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлэв.

Засгийн газрын 2022 оны "Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тухай" 218 дугаар тогтоол батлагдаж, тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэцэрлэгийн зориулалтаар байр түрээслэх, хувийн өмчийн цэцэрлэгийн сул орон тоонд хүүхэд элсүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага дэргэдээ цэцэрлэг байгуулах санаачилгыг дэмжих, орчин үеийн шинэ дэвшилтэт технологи ашиглан гэр цэцэрлэг байгуулах, ачаалал өндөртэй хороодын хувийн өмчийн цэцэрлэгт хувьсах зардлыг хоёр дахин нэмэгдүүлж өгөх, хоолны зардал олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр нийслэлийн 3-5 насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 92,4 хувьд хүрлээ. Дээрх цогц арга хэмжээний хүрээнд улсын хэмжээнд 3-5 насны 228030 хүүхдийн 206,150 буюу 90,4 хувь нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд өнгөрсөн хичээлийн жилээс 4,3 хувиар өссөн байна. 2022-2023 оны хичээлийн жилд малчин өрхийн Сургуулийн өмнөх насны 47,413 хүүхэд байгаагаас сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 33,544 /70,7 хувь/ нь хамрагдаж өмнөх хичээлийн жилээс 20,0 хувиар нэмэгдсэн байна. 5 настай 15223 хүүхэд байгаа ба цэцэрлэгт 7807, хувилбарт сургалтад 5 настай 2515 хүүхэд хамрагдаж байна.

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, суралцах чадамжид суурилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах агуулгын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж буй 331 багшийг мэргэжүүлэх сургалтад хамрууллаа. Эдгээр бэлтгэгдсэн багш нарын хариуцсан бүлэгт 904 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.

2.3.3. Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.

Биелэлт: Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас 3 жил тутамд ерөнхий боловсролын сургуулийн 15 настай хүүхдийг хамруулан зохион байгуулдаг PISA (Programme for International Student Assessment/) сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгаанд Монгол Улс 2021 онд хамрагдах хэлэлцээрт талууд 2018 оны 07 дугаар сард гарын үсэг зурсан. PISA 2021 судалгаанд манай орны 15 настай сурагчид унших, математик, байгалийн ухааны хичээл болон бүтээлч сэтгэлгээний чадварыг үнэлэх даалгавар гүйцэтгэж, асуулга бөглөнө. "Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA-2022" туршилтын шалгалт /судалгаа/-ыг 2021 оны 5-р сарын 17-24-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Түүвэрт хамрагдсан ерөнхий боловсролын 19 сургууль /нийслэлийн 10, хөдөөгийн 9/-ийн 15-16 насны 700 гаруй суралцагч туршилтын

шалгалтад хамрагдаж, математик, унших, байгалийн ухааны хичээлээр эзэмшсэн мэдлэгээ амьдрал ахуйдаа ашиглах болон бүтээлч сэтгэлгээний чадварыг үнэлэх даалгаврыг тус тус гүйцэтгэсэн. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтыг үнэлэх “PISA-2022” Олон улсын үндсэн судалгааг 2022 оны 4-5 дугаар сард зохион байгууллаа. Судалгаанд нийслэлийн 85, хөдөө орон нутгийн 110 нийт 195 сургуулийн 7300 орчим сурагчийг түүврээр хамруулсан бөгөөд тэдний математик, байгалийн ухаан, уншиж ойлгох чадвар болон бүтээлч сэтгэлгээний мэдлэг, чадварыг үнэлэх шалгалт, судалгааг компьютерт суурилсан хэлбэрээр зохион байгуулсан. Боловсролын чанарын үнэлгээний судалгааг 10 дугаар сард 2022-2023 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын сургуулийн 6, 10, 12-р ангийн суралцагчид, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 2, 3 дугаар курсийн суралцагчдаас түүврийн аргаар сонгон хамрууллаа. Одоогийн байдлаар боловсролын чанарын үнэлгээний судалгааны дата боловсруулалтын ажил явагдаж байна.

БШУ-ны сайдын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн А/347 дугаар тушаалаар батлагдсан “Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол улсын ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэн тооцох тухай” журмын дагуу Кембрижийн IGCSE, O, AS, A, IB- International Baccalaureate, AP- Advanced Placement, TOEFL, IELTS, SAT, Их, дээд сургуулийн элсэлтийн шалгалт нь төгсөлтийн шалгалттай нэгдмэл зохион байгуулагддаг гадаадын ахлах сургууль төгссөн болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бусад хөтөлбөрөөр суралцаж төгссөн оюутан, суралцагчдын сурлагын дүн, оноог зэрэг гадаад улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг олон улсын шалгалтын оноог ЭЕШ-ын оноонд дүйцүүлэх хүсэлтийг цахимаар авч, 300 гаруй суралцагчийн хүсэлт ирснээс 100 орчим суралцагчийн олон улсын шалгалтын дүн оноог ЭЕШ-ын оноонд шилжүүлсэн.

Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-д дараах тэтгэлэг олгохоор тусгалаа:Үүнд:

1. Холбогдох төрийн захиргааны төв байгууллагын хүлээн зөвшөөрсөн олон улсын олимпиадад медальт байрт шалгарсан иргэнийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын тогтоосон эрэмбээр дэлхийн шилдэг 100-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцуулах сургалтын тэтгэлэг.

2. Холбогдох төрийн захиргааны төв байгууллагын хүлээн зөвшөөрсөн олон улсын олимпиадад медальт байрт шалгарч, дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын зэрэглэл тогтоосон эрэмбээр их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах албан ёсны урилга хүлээн авсан иргэнд тэтгэлэг.

Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор баталсан "Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-д ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд олон улс (математик, биологи, газар зүй, физик, мэдээлэл зүй, хими, Менделеевийн олон улсын химийн олимпиад)-ын болон тивийн (Азийн физикийн олимпиад, Ази, Номхон далайн орнуудын мэдээлэл зүйн олимпиад) хэмжээнд зохион байгуулагддаг олимпиадад оролцож амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулахаар тусгасан. 2022 онд олон улсын олимпиадад амжилттай оролцсон 23 суралцагчдад мөнгөн урамшуулал олголоо.

Улсын олимпиад зохион байгуулах журмыг шинэчлэн боловсруулж байна. Журамд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олимпиадаас медаль хүртсэн ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, бэлтгэсэн багшийг урамшуулах асуудлыг тусгахаар ажиллаж байна.

2.3.4.Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан

чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.

Биелэлт: Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/164 дүгээр тушаалаар “Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийг батлан, түүх, үндэсний уламжлал, ёс заншлын талаар мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх агуулгыг тусган хэрэгжүүлэх талаар ажиллаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар өмчийн хэлбэр харгалзахгүй ерөнхий боловсролын бүх сургуулийн суралцагчдын судлах “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг баталж, ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн суралцагчид 2019 оны 9 дүгээр сараас уг хичээлийг 7 хоногт тус тус 2 цагаар судалж эхэлсэн. Ерөнхий боловсролын нийт сургуульд “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрөөс гадна монгол хэл, бичиг, уран зохиол, түүх зэрэг суралцагчдыг хүмүүжүүлж, төлөвшүүлэх зорилготой олон сургалтын хөтөлбөрийг зэрэгцүүлэн хэрэгжүүлж байна.

Монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх арга зүй боловсруулан, тус арга зүйн дагуу 2021 онд шинжилгээ хийсэн болно. Бага, дунд боловсролын Монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын хөтөлбөрт шинэчлэн боловсруулах үзэл баримтлалын төсөл боловсруулж, түүнийг мэргэжлийн байгууллага, судлаачид болон эцэг эх, олон нийтийн төлөөллөөр хэлэлцүүлэх 8 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан үр дүнг үзэл баримтлалын төсөлд тусгаж эцэслэн боловсруулав.

Үндэстний цөөнх хүүхдүүдийн (казах, тува) сургалтын чанарыг дээшлүүлэх, тэдний төрийн (монгол) хэл болон эх хэлний үгийн нөөцийг нэмэгдүүлэх, хос хэлээр суралцахад сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах монгол-казах, казах-монгол, монгол-тува, тува-монгол хэл дээр сургалтын толь бичиг боловсруулах зорилгоор БШУ-ны сайдын 2021 оны А/94 дүгээр тушаалаар "Сургалтын толь бичиг"-ийг (математик, биологи, байгалийн шинжлэл, дүрслэх урлаг, биеийн тамирын хичээлийн) зохиож, хэвлэн туршиж байна. 2022 онд казах хэл дээр 11250 ширхэг сурах бичгийг 56,2 сая төгрөгийн зардлаар хэвлэн түгээсэн бөгөөд бага ангийн суралцагчид сурах бичгээр 100 хувь хангагдсан.

Ерөнхий боловсролын сургуульд 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн сэтгэл зүйчийг ажиллуулж эхэллээ. Энэ хүрээнд "сэтгэл зүйч" мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн 62 иргэнийг 12 багц цагийн мэргэшүүлэх сургалтад хамруулж, сургуулийн сэтгэл зүйчээр давтан бэлтгэсэн бөгөөд 2021 оны жилийн эцэст 121 сургууль (төрийн өмчийн 99 сургууль)-д нийт 124 (төрийн өмчийн сургуульд 102) сэтгэл зүйч ажиллаж байна. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 682 ерөнхий боловсролын сургууль секц, дугуйланг судлагдахууны болон бусад чиглэлээр зохион байгуулж байна. Үүнд: Нийт сургуулийн 20 хувь нь урлаг хөгжмийн хичээлийн дугуйлан, 6 хувь нь дүрслэх урлаг, дизайн технологийн хичээлийн дугуйлан, 53 хувь нь биеийн тамир, спортын чиглэлийн дугуйлан, 20 хувь нь бусад чиглэлийн дугуйланг хичээллүүлж суралцагчдыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

2022-2023 оны хичээлийн жилд I-V ангийн суралцагчдад 1,2 сая ширхэг сурах бичгийг 3,7 тэрбум төгрөгөөр, VI-XII ангийн суралцагчдад түрээсээр ашиглуулах 1,0 сая ширхэг сурах бичгийг 3,7 тэрбум төгрөг, нийт 2,2 сая ширхэг сурах бичгийг 7,5 тэрбум төгрөгийн зардлаар тус тус хэвлүүлэн хэвлэлийн компаниудтай хийсэн гэрээний дагуу сурах бичгийг суралцагчдад бүрэн хүргэсэн. "Гадаад дахь монгол хүүхдэд зориулсан монгол хэл, соёлын жишиг хөтөлбөр"-ийг БСШУС-ын сайдын 2017 оны А/123 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Мөн уг хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих үүднээс, олон улс оронд ажиллаж буй монгол хэл, соёлын сургалтын төвийн хүүхдүүд ашиглах

боломжтойг харгалзан web суурьтай цахим сурах бичиг /tsakhim.reader.mn/ боловсруулсан бөгөөд хилийн чанад дахь зарим сургалтын төв үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2.3.5.Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлнэ.

Биелэлт: Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэв. Уг хуулийн төсөлд эндоумент, венч сан байгуулах журмыг батлуулах, судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх, орлогын олон талт эх үүсвэрийг бий болгох талаар тусгав. Их сургуулийн эндоумент санг МУИС 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан бөгөөд тус сургуулийн 29 багш өөрийн судалгааны ажлын үр дүнгээс бий болсон ашгаас өөрийн сургуулийн эндоумент сандаа хөрөнгө оруулалт хийсэн байна. “Судалгааны үр дүнд бий болсон ашигтай загварын патент эзэмшигчдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын төслийг боловсруулсан.

Азийн хөгжлийн банкны 30.0 сая ам.долларын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Судалгааны их сургууль” төсөл хэрэгжүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. Судалгааны ажлын явц, үр дүнг хянах, хүлээж авах, үнэлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, олон улсад өндөр чансаатай мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн шилдэг судлаачдыг урамшуулах журмын төсөл боловсруулах шатандаа явагдаж байна. БШУЯ, EBSCO болон Монголын номын сангуудын консорциумын хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажилладаг их, дээд сургуулиудад зориулан EBSCO-ийн шинжлэх ухааны бүхий л салбарын 210,000 орчим дижитал ном бүхий мэдээллийн санг үнэ төлбөргүйгээр ашиглах эрхийг МУИС, ШУТИС, МУБИС, АШУҮИС, МГТИС, СУИС зэрэг байгууллагуудад нээгээд байна.

БШУ-ны сайдын 2022 оны 160 дугаар тушаалаар мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн баталж олон улсын жишигт нийцүүлсэн бөгөөд 10 чиглэлээр 453 мэргэжлийн жагсаалт батлагдсан. 2022-2023 оны хичээлийн жилд молекул биологи сургалтын хөтөлбөрт 65 суралцагч, биотехнологи сургалтын хөтөлбөрт 2068 суралцагч, нано шинжлэх ухаан, инженерчлэл сургалтын хөтөлбөрт 179 суралцагч тус тус суралцаж байна.

Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор “Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт”-аар 13 чиглэлийн 37 мэргэжлийн хөтөлбөрийг баталсан. Төрийн болон төрийн бус өмчийн 47 их дээд сургууль тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж үзүүлэлтийг сүүлийн 4 жилийн байдлаар мөшгих судалгаа хийхэд дараах үр дүн гарсан байна. Үүнд: төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж нь 2016 онд 80.4 хувь, 2017 онд 73.2 хувь, 2018 онд 82.9 хувь, 2019 онд 82.7 хувьтай буюу тэргүүлэх мэргэжлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн сүүлийн 4 жилийн дундаж нь 81.5 хувь байна.

2021 оны байдлаар суурь судалгааны үргэлжлэн хэрэгжиж буй 115 төслийн 1 тэрбум 870 сая төгрөг, шинээр хэрэгжиж буй 64 төслийн 811 сая, суурь хавсарга судалгааны 18 грант төсөлд 113 сая төгрөг, гадаадтай хамтарсан 32 төслийн 285.1 сая төгрөг, үргэлжлэн хэрэгжиж буй улсын захиалгат 54 төслийн 1 тэрбум 314 сая төгрөг, шинээр хэрэгжиж буй 28 төслийн 687 сая төгрөг, инновацийн 16 төслийн 331.2 сая төгрөг, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 14 төслийн 231.6 сая төгрөг, докторын дараах инновацийн 20 төслийн 145 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгох шийдвэрийг гаргаж, шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүлээ. 2022 онд шинжлэх ухаан, технологийн сангаас төр, хувийн өмчийн

8 их, дээд сургуулийн судалгааны багуудын 79 төсөлд 1494,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

2.3.6. Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох “Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр” хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 275 дугаар тогтоолоор Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмууд батлагдсан. Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамрагдах иргэдийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу 2021 оны 10-11 дүгээр сард зохион байгуулж, 428 суралцагч сонгогдсон. Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгийн эхний шалгаруулалтад тэнцсэн 428 хүүхдийг МУИС, ШУТИС-ийг түшиглэн “Бэлтгэл хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2021 оны “Боловсролын зээлийн сан”-д үйл ажиллагааны зардалд 1,4 тэрбум төгрөгийн санхүүжилт туссан байна. 2020 онд “Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг”-т 30 оюутанд нийт 40.0 сая төгрөг олгосон. Ерөнхий сайдын 2022 оны 79 дүгээр захирамжаар тэтгэлэгт тэнцсэн 44 суралцагчид сургалтын тэтгэлэг олгох шийдвэр гарсан.

Гадаадын их, дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт 31 иргэн (1 доктор, 30 магистр) тэнцсэн бөгөөд суралцах мэргэжлээр нь авч үзвэл боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр 8, байгалийн шинжлэх ухаан 5, Мэдээлэл, харилцаа холбооны технологи 2, Архитектур ба барилга, угсралт 2, санхүү, эдийн засаг 4, Олон улсын харилцаа 3, Эрх зүй 1, төрийн удирдлагын чиглэлээр 6 оюутан тус тус суралцахаар болсон.

Засгийн газрын 347 дугаар тогтоолоор “Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам” батлагдсан.

Монгол Улсын Засгийн газар, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /ЖАЙКА/, Боловсрол, шинжлэх ухааны яамны хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн Коосэн хөтөлбөрт Япон Улсад амжилттай суралцсан 44, Бакалаврын хамтарсан хөтөлбөрт амжилттай суралцсан 45, нийт 89 төгсөгч эх орондоо ирсэн. Дээрх оюутнуудыг ажлын байранд зуучлах, эзэмшсэн мэргэжил, мэдлэг, ур чадварыг Монгол Улсын хөгжил дэвшилд ашиглах зорилгоор “1000 ИНЖЕНЕР-АЖЛЫН БАЙР” сэдэвт өдөрлөгийг 2 жил дараалан зохион байгуулав. 2020 онд болсон өдөрлөгт нийт 38 төгсөгч эзэмшсэн мэргэжлийн дагуу ажлын байраар хангагдсан нь өмнөх оноос 18 төгсөгчөөр нэмэгдсэн байна.

2.3.7. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 321 дүгээр тогтоолоор Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр төрөлжүүлэх; Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг уул уурхай, технологийн чиглэлээр тус тус төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгах ажлууд хийгдэж байна.

Дээрх ажлын хүрээнд Дорнод аймаг дахь “Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв”-ийн Ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, эхний ээлжийн барилгажилтын зургийг хийж гүйцэтгэсэн ба Дархан-Уул, Орхон аймгууд дахь “Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор”-ын Ерөнхий төлөвлөгөөний загвар, ТЭЗҮ-ийн ажлын даалгавруудын төслийг хийж гүйцэтгэлээ. Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа

технологийн дээд сургуулийг байгуулж 2022-2023 оны хичээлийн жилд сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус сургуулийг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" хотхоноор хөгжүүлэх хүрээнд төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Оюу-Толгой ХХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Түншлэлийн хүрээнд Оюу-Толгой ХХК нь тус цогцолборын техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын зургийг хийж гүйцэтгэнэ.

2.3.8. "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ.

Биелэлт: Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд багшийн ажлыг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, "Чадварлаг багш" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын хурлаар хэлэлцүүлсэн ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Боловсрол, шинжлэх ухааны сайд 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд Английн Засгийн газрын дэмжлэгтэйгээр Глобал Грөүф институттэй хамтран нийт төрийн өмчийн 669 ерөнхий боловсролын сургуулийн захирал, багш, менежерийг "Дэлхийн түвшний менежер" хөтөлбөрт 12 багц сэдвээр сургалтад хамруулав.

2020 онд төрийн өмчийн их дээд сургуульд Багш мэргэжлээр суралцдаг 1239 оюутанд 1.4 тэрбум төгрөг, 2021 онд 1443 оюутанд 1,2 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, БШУ-ны сайдын А/122 дугаар тушаалаар багшийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон. Засгийн газрын 252 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох зохицуулалтыг шинэчлэн хэрэгжүүлж байна. Багш ажлын байран дээр бие даан болон хамтран суралцах замаар тасралтгүй хөгждөг байх концепц/үзэл баримтлалд тулгуурлан "Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих журам"-ыг батлан хэрэгжүүлж байна. Ментор багшийг бэлтгэх сургалтад 30 зөвлөх багшийг хамруулж бэлтгэсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн захирал удирдах ажилтанд үр дүнгийн урамшуулал олгох шалгуур үзүүлэлтийг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" А/35, А/10, А/9 тушаалыг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хамтарсан тушаалаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг баталсан. Багшийн мэргэжлийг дээшлүүлэх сургалтыг дараах 3 хэлбэрээр зохион байгуулсан.

1. 2020-2021 ОНЫ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДСЭН СУРГАЛТ /давхардсан тоогоор 10880 багш хамрагдсан/

2. ЗАХИАЛГАТ СУРГАЛТ- /давхардсан тоогоор 1757 хүнд хүргэсэн/

3. ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТ /сургалтад 21 аймаг, 9 дүүргийн нийт 20769 багш, удирдах ажилтан сургалтад хамрагдсан/

2.3.9. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ:

2.3.9.1. 273 цэцэрлэг ашиглалтад оруулах;

Биелэлт: Боловсрол, шинжлэх ухааны яамнаас салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хамран сурах тойрог, кластер системийг шийдвэр гаргах түвшинд оновчтой болгох зорилгоор Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан бодлого, төлөвлөлтийн системийг 2022 оны 3 дугаар сараас үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. 2023 оны улсын төсвийн төсөлд нийт 477 шинэ төсөл, арга хэмжээний санал ирүүлснээс GIS шинжилгээгээр 88 төсөл, арга хэмжээг нэн шаардлага, хэрэгцээтэй гэж шинжилгээ хийв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга угсралтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2021 онд нийт төсөвт өртөг 179.5 тэрбум төгрөгийн 51.0 тэрбум төгрөгөөр санхүүжиж 76 төсөл арга хэмжээ ашиглалтад орсон. 2020 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт 5265 хүүхдийн хүчин чадал бүхий 42, нийслэлд 4050 хүүхдийн хүчин чадал бүхий 21 буюу нийт 63 цэцэрлэг /нийслэлд 21, орон нутагт-42/-ийн барилга ашиглалтад орсон. 2022 онд 33 сургууль, 41 цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орсон. Гадаад зээл тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа 9 сургууль, 18 цэцэрлэгийн барилгаас 2022 онд 2 сургууль, 2 цэцэрлэгийн барилга ашиглалтад орж нийт 35 сургууль, 43 цэцэрлэг ашиглалтад орсон.

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмж сайжруулах төсөл”-ийн хүрээнд дараах 4 цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил үргэлжилж байна. Үүнээс: Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар 2 цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлсэн. АНУ-ын элчин сайдын яамны санхүүжилтээр 1 цэцэрлэг ашиглалтад орж, 3 цэцэрлэгийн барилгын ажил үргэлжилж байна.

2.3.9.2.200 шинэ сургууль ашиглалтад оруулах;

Биелэлт: 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 54368 хүүхдийн хүчин чадалтай, 148,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 127 төсөл арга хэмжээ, өмнөх оноос шилжин хэрэгжих 116,6 тэрбум төгрөгийн өртөгтэй, 39498 хүүхдийн хүчин чадалтай, 82 төсөл арга хэмжээ хэрэгжиж, жилийн эцсийн байдлаар 10680 хүүхдийн хүчин чадалтай 31, гадаадын тусламжаар 6, нийт 37 сургууль /нийслэлд-11, орон нутагт-26 / ашиглалтад орсон. 2022 онд 35 сургууль баригдаж ашиглалтад орсон байна.

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмж сайжруулах төсөл”-ийн хүрээнд дараах 10 сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажил үргэлжилж байна. Хятадын Засгийн газрын тусламжаар 3, Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 3 нийт 6 сургууль ашиглалтад бүрэн орсон.

2.3.9.3.тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх;

Биелэлт: Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Журам батлах тухай" А/177 дугаар тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам"-ыг баталсан. Ингэснээр цэцэрлэгийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах эрх зүйн орчин бүрдэж, хүүхэд оршин байгаа газартаа сургуулийн өмнөх боловсролд хамрагдах, бусдын адил тэгш, хүртээмжтэй оролцох, хөгжих, сурч боловсрох боломжтой боллоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирох орчин, хэрэглэгдэхүүн бүрдсэн 320 хүүхдийн хүчин чадалтай тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургуулийн барилга болон тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгад /Сонгинохайрхан дүүрэг/ 2021-2022 онд хэрэгжихээр тус бүр 4 тэрбум батлагдсан. Тус 2 төсөл арга хэмжээний зураг, төсвийг Барилга, хот байгуулалтын яамнаас хийж байна. “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах зорилгоор Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий аймгуудын төвийн сургуульд "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим" байгуулан нийт 265,2 сая

төгрөгийн өртөг бүхий ном, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом, туслах хэрэгсэл нийлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. 2020-2021 оны хичээлийн жилд Японы “Хүүхдийг ивээх сан”-гийн “Хүүхэд бүрийг тэгш хамран сургах нь” төслөөс 16 сургууль 5 НТБТ-д 41 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүн нийлүүлсэн байна. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29, харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургуулиуд дээр эрүүл мэндийн танхим байгуулсан.

2.3.9.4.жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох.

Биелэлт: “Боловсролын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 127 дугаар тогтоолыг батлав. Тус тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор БШУ-ны сайд төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл, арга хэмжээний жагсаалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан бөгөөд 1, 2 дугаар ээлжид 16 аймгийн 103 суманд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхээр гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулсан бөгөөд барилга угсралтын ажлыг гүйцэтгэж эхлээд байна. Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг төвлөрсөн ариун цэврийн байгууламжтай болгох хүрээнд нийт 26 багц 16 аймгийн 92 суманд 128 сургууль, 77 цэцэрлэг, 102 дотуур байрны төсөл арга хэмжээ, нийт 307 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс ашиглалтад оруулах бэлтгэл ажил хийж байгаа 8, комисс ажилласан 149, акт баталгаажсан 109 төсөл арга хэмжээ байна.

2.3.10.Цэцэрлэг, дотуур байр, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан 2-оос доошгүй дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” болгоно. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана.

Биелэлт: Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн нэг сурагчид ногдох үдийн хоолны зардлын нормативыг хүн амын зохистой хооллолтын талаарх зөвлөмжид заасан хэмжээ, инфляцын түвшинтэй уялдуулан 1500 төгрөг байхаар тогтоож, 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлээд байна. 2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 371 480 сурагчид үдийн цайны үйлчилгээнээс үдийн хоолны үйлчилгээнд шилжээд байна. Үдийн хоолны үйлчилгээнд хамрагдах суралцагчийн тоог урьдчилсан байдлаар гаргахад 2022-2023 оны хичээлийн жилд 1-9 дүгээр ангийн 643678 сурагч, 2023-2024 оны хичээлийн жилд 1-12 дугаар ангийн 806,972 сурагч хамрагдах тооцоотой байна.

“Сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага” стандартын төслийг боловсруулсан бөгөөд батлуулахаар ажиллаж байна.

2020 оны хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байр, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжид нийт 4.0 тэрбум төгрөгийг төлөвлөсөн. Сургууль, сургуулийн дотуур байранд 16 нэр төрлийн 84 багц, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 14 нэр төрлийн 100 багц тоног төхөөрөмж худалдан авч, нийлүүлсэн.

2021 онд 9.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Тус төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан, төлөвлөгөөт хугацаанд сургууль,

цэцэрлэг, дотуур байр, насан туршийн боловсролын байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжийг олгож ажилласан.

2022 онд 134 сургуулийг нийт 888 нэр төрлийн 1,417,736,402 төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан. Ингэснээр нийт сургуулийн 46.8 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдсан. Олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх төслийн хүрээнд 52 сургуульд хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль дээр стандартын шаардлага хангасан ундын цэвэр ус уух боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд 2022 онд 30 сургуульд 78.4 сая төгрөгийн 80 ширхэг ус шүүгч төхөөрөмж, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 98 сургуульд 112.7 сая төгрөгийн 145 ширхэг ус шүүгч төхөөрөмж нийлүүлсэн.

2.3.11. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд спортын техник хэрэгсэл худалдан авах 650.0 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хөгжмийн техник хэрэгсэл худалдан авах 320.0 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуульд хөгжмийн зэмсэг, хөгжмийн кабинетэд тоног төхөөрөмж худалдан авах 320.0 сая төгрөг тус тус батлагдсан бөгөөд төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан, төлөвлөгөөт хугацаанд сургууль, цэцэрлэг, дотуур байр, насан туршийн боловсролын байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжийг олгов.

2.3.12. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.

Биелэлт: Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Теле болон цахим хичээл зохион байгуулах тухай” А/165 дугаар тушаалаар улсын хэмжээнд бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалт, үйл ажиллагааг теле хичээл, цахим хичээл хэлбэрт шилжүүлж сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. Боловсрол, шинжлэх ухааны яамны Econtent.edu.mn нэгдмэл веб хуудсанд Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, тусгай хэрэгцээт болон насан туршийн боловсролын сургалтын хөтөлбөрийн дагуу 2020-2021 оны хичээлийн жилд суралцагчдын судлах 4800 цагийн теле хичээл, түүний хуваарь, сурах бичиг болон интерактив цахим хичээлийг тухайн хүүхдийн сургалтын хөтөлбөрийн агуулгад тохирсон байдлаар өөрсдийгөө сорих, хөгжүүлэх дасгал, даалгавруудын хамт тогтмол байршуулан ажиллаж байна. Иргэдийн насан туршдаа суралцахуйг дэмжих зорилгоор <https://medle.mn/tele/21> сайтад бага боловсролын түвшинд монгол хэл, математик, иргэний боловсрол гэсэн судлагдахуунаар 12, суурь боловсролын түвшинд монгол хэл, математик, иргэний боловсрол судлагдахуунаар 12, иргэдийн боловсролд зориулан гэр бүлийн боловсрол, мэдээлэл, харилцаа холбоо технологийн боловсрол, эрх зүйн боловсрол, амьдрах ухааны боловсрол, эрүүл мэндийн боловсрол, соёл, гоо зүйн боловсрол, санхүүгийн боловсрол, Санхүүгийн боловсрол, Тогтвортой хөгжлийн боловсрол чиглэлээр 229 теле хичээлийг байршуулан түгээн дэлгэрүүлж байна.

Дүйцсэн хөтөлбөрийн болон насан туршийн боловсролын 10 агуулгын хүрээнд 193 теле хичээлийг аймаг, дүүргийн насан туршийн боловсролын төв, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, хувь хүмүүстэй хамтран амжилттай зохион байгуулж, бэлтгэсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 1000 ширхэг зөөврийн компьютер олгох 2,000.0 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2200 ширхэг зөөврийн компьютер олгох 4,000.0 сая төгрөгийг тус тус батлуулж, тендерт шалгарсан “Саммит компьютер технологи” ХХК, “Ай ти зон” ХХК-тай гэрээ байгуулж ажилласан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/266 дугаартай тушаалаар баталсан хуваарийн дагуу 21 аймаг, 9 дүүргийн нийт 1534 байгууллагын 3275 үндсэн багшид зөөврийн компьютер олгох ажлыг хийсэн.

2021 онд “Ерөнхий боловсролын сургуульд Мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмж” худалдан авах төсөвт өртөг бүхий 1 тэрбум төгрөг баталсан. Төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах шатандаа явж байгаа бөгөөд 2021 оны 8 дугаар сараас хэрэгцээ шаардлагатай сургуульд орчин үеийн мэдээлэл зүйн кабинетыг бий болгоно.

2022 онд Мэдээлэл зүйн кабинетийн тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээнд 981,429,320 төгрөгийг төлөвлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулж нийслэл, орон нутгийн 18 ЕБС-д нийлүүлсэн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 11 дүгээр 8-ны өдрийн А/452 дугаар тушаалаар төрийн өмчийн бүх сургуулиудад компьютер тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 33,300.0 сая төгрөгийг хуваарилан худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг сургуулийн захирлуудад шилжүүлсэн.

Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх сургалтын байгууллагын тусгай зөвшөөрлийн лавлагааг 2021 оны 2 дугаар сараас эхлэн ТҮЦ машин болон E-Mongolia цахим системээр дамжуулан олгож байна. 2011 оноос хойших ерөнхий боловсролын элсэлт, төгсөлт, журнал хөтлөлт, боловсролын баримт бичиг олголт, элсэлтийн ерөнхий шалгалтын материал түгээлт, засалт, түүний чанарын үнэлгээний судалгаа, багшийн эрхийн бүртгэл, салбарын шагнал урамшууллын хүсэлт, үнэмлэх тэмдгийн нөхөн олголтын хүсэлт зэрэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Цаашид сургуулийн өмнөх боловсролын байгууллагын элсэлт, төгсөлт, гадаад улсад боловсрол эзэмшсэн иргэнийг дүн болон боловсролын баримт бичгийг дүйцүүлэх, Монгол улсад багшаар ажиллаж буй гадаад улсын иргэний багшлах эрхийн хугацаа сунгах, боловсролын баримт бичгийг боловсролын салбарын мэдээллийн системд бүртгүүлэх хүсэлт зэрэг Боловсрол, шинжлэх ухааны яамнаас иргэн, аж ахуй нэгжид хүргэдэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна.

БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд олон улсын түвшинд хүрэхүйц мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн гадаад аутсорсингийг хөгжүүлэх зорилготой “Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төсөл” хэрэгжиж байна.

2.3.13.Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, чадавхыг дээшлүүлнэ.

Биелэлт: Боловсролын ерөнхий хуулийн төслийн 19 дүгээр зүйлд боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын чиг үүргийг шинэчлэн тодорхойлж, тасралтгүй хэрэгжүүлэх суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлын чиглэлийг шинэчлэн томъёолсон. Хуулийн төсөл батлагдсанаар Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх эрх зүйн үндэс бүрдэнэ. Засгийн газрын 2021 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 407 дугаар тогтоолоор Боловсролын хүрээлэнг “Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн” болгон өөрчлөн зохион байгуулсан. Мөн Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Боловсролын ерөнхий газар байгуулав.

Засгийн газрын 2021 оны 407 дугаар тогтоолоор “Боловсролын хүрээлэн”-г “Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн” болгон өөрчлөн зохион байгуулж, дүрэм,

зохион байгуулалтын бүтцийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/10 дугаар тушаалаар баталлаа. Хүрээлэн нь боловсролын хөгжлийн онол, арга зүйн судалгааны ажил эрхлэх, боловсролын шинэчлэл, өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлох, инноваци хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний үр дүнгийн мэдээллээр үйлчлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Боловсролын үнэлгээний төвийн чиг үүргийг өргөжүүлж, дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/21 дүгээр тушаалаар шинэчлэн баталлаа. Төв нь боловсролын бүх түвшний үнэлгээ, шалгалт зохион байгуулах, үнэлгээний удирдлага, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах зэрэг чиг үүрэг хэрэгжүүлнэ.

2.3.14.Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан “үндэсний судалгааны төв”-үүдийг байгуулан төрийн захиалгат төсөл болон их сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжихэд зориулж 2021 оны улсын төсөвт 5.0 тэрбум төгрөг батлан хэрэгжүүлэв.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, сургалт, судалгааны ажлыг дэмжих зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанитай хамтран ажиллах санамж бичиг байгуулан энэ онд байгалийн ухаан, инженер технологийн чиглэлээр суралцаж буй 8 докторантад 6.0 сая, 5 магистрантад 4.0 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор нийт 68.0 сая төгрөгийн санхүүжилт бүхий судалгааны төслийн сонгон шалгаруулалтыг зарлан зохион байгуулсан. Их сургуулийн төгсөх ангийн судлаач оюутнуудын дунд 5.0 сая төгрөгийн шагналын сан бүхий төслийн уралдаан зарлан хэрэгжүүлээд байна.

Төрийн өмчийн их, дээд сургуулийн судалгааны зардалд төрөөс буюу Шинжлэх ухаан, технологийн сангаас ШУТИС-ийн 18 төсөл, МУИС-ийн 32 төсөл, ХААИС-ийн 15 төсөл болон АШУҮИС-ийн 9 төслийн санхүүжилтэд нийтдээ 1,447 тэрбум төгрөгийг олгосон. Мөн Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээл (7,5 тэрбум иен) болон Монгол Улсын төсвийн санхүүжилт (615 сая иен)-ээр хэрэгжиж байгаа "Инженер, технологийн дээд боловсрол" төслийн хүрээнд:

1) Монгол Улсын их сургууль болон Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн сургалтын тоног, төхөөрөмж, лабораторийг шинэчлэх, хүртээмжийг сайжруулах зорилгоор нийт 9,4 сая ам.долларын үнэ бүхий 253 нэр төрийн 409 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.

2) Төслийн хүрээнд МУИС-ийн 10 болон ШУТИС-ийн 10 судалгааны багийг шалгаруулан 384 багш, судлаачид Япон Улсын 40 гаруй их сургууль, хүрээлэнгийн 170 судлаачидтай хамтран Монгол Улсад нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэж байна. Эдгээр хамтарсан судалгааны багуудын судалгааны ажлын үр дүнд өссөн дүнгээр Олон Улсын сэтгүүлд 335 өгүүлэл, дотоодын сэтгүүлд 267 өгүүлэл хэвлүүлж, 37 бүтээлийг оюуны өмчийг бүртгүүлж, гарааны 3 компани үйл ажиллагаа явуулж байна.

2.3.15.Орон нутаг дахь мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, их, дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 346 дугаар тогтоолын 2 дугаар заалтаар Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн

"Журам батлах тухай" 347 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 5.1.3-д "Оюутны хөгжлийн зээлийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн их, дээд сургуульд бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцагчийн сургалтын төлбөрийн 50 хүртэлх хувийг зээлээр олгоно", 5.1.4-д "Оюутны хөгжлийн зээлийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн их, дээд сургуульд суралцагчдад энэ журмын 5.1.1-д заасан тэргүүлэх болон эрэлттэй мэргэжил харгалзахгүй олгоно" гэсэн заалтуудыг нэмж оруулав.

Засгийн газрын "Их, дээд сургуулийг" сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 321 дугаар тогтоолын 3 дугаар заалтад орон нутаг дахь төрийн өмчит их, дээд сургуульд ажиллаж байгаа багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан бол зохих тэтгэмж олгох, хөнгөлөлттэй зээлд хамруулдаг байх зохицуулалт бий болгох асуудлыг судлан, эрх зүйн орчныг бүрдүүлэх, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон.

Боловсролын зээлийн сангаас Дорноговь аймаг, Дархан-Уул аймаг, Говь-Алтай аймаг дахь дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцаж байгаа 691 оюутанд 608 сая төгрөг, Дорнод аймаг, Архангай аймаг, Ховд аймаг, Баян-Өлгий аймаг дахь дээд боловсролын сургалтын байгууллагад багш мэргэжлээр суралцаж байгаа 81 оюутанд 60,5 сая төгрөгийн тэтгэлэг олгосон.

МУБИС-ийн Архангай дахь Багшийн сургууль, СУИС-ийн салбар Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж, Монгол Улсын Консерваторид нийт 88 сая төгрөгийн хөгжмийн хөтөлбөрийн арга зүйн тоног төхөөрөмжийг 7 сард нийлүүлсэн. АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн хичээлийн шинэ байрыг улсын төсвийн 6.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2020 оны 10 дугаар сарын 23-нд ашиглалтад оруулсон. Тус хичээлийн байр нь 960 оюутны хүчин чадалтай дөрвөн давхар спорт, урлагийн заалтайгаас гадна сургалтын лаборатори ашиглалтад орсноор оюутнууд дадлагажиж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн.

2.3.16.Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэх асуудлаар Кембрижийн олон улсын төвтэй хамтран ажиллах (зөвлөх үйлчилгээ) гэрээний төслийг боловсруулж, талууд хэлэлцэж байна. 2020-2021 оны жилийн эцсийн байдлаар Кембрижийн ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр хичээллэдэг төрийн болон хувийн өмчийн 22 сургууль үйл ажиллагаа эрхэлж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын замын зураглал хийж, Кембрижийн их сургуультай хамтран ажиллах үйл ажиллагааны хоёр дахь шатны гэрээ байгуулахаар ажиллаж байна. Энэхүү гэрээний дагуу ерөнхий боловсролын сургуулиудад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үндэсний чадавхыг бэхжүүлэх ажлыг 2023 оны нэгдүгээр улирлаас эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын тогтолцоог бий болгох, бодлогын хэрэгжилт, зохицуулалтыг хангах, зураглал, төлөвлөгөө боловсруулж, шаардагдах зардлын хүрээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хяналт шинжилгээний хүрээг тогтоох Техник ажлын зохицуулалтын багийг байгуулсан. Техник ажлын зохицуулалтын баг нь бага, дунд боловсролын багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, баталгаажуулах, олон

улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлэх багш нарын англи хэлний чадавхыг дээшлүүлэх, боловсролын удирдах ажилтны манлайлал, менежментийн чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана.

Шинжлэх ухаан, технологи, инновац

2.4.Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.

2.4.1.Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлнэ.

Биелэлт: 2022 онд Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулсан. Гүйцэтгэл үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны асуудлыг хөндөхдөө шинжлэх ухаан, технологи, инновацын хамтын ажиллагааг эдийн засгийн хөшүүргээр дэмжих, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хамтарсан дэмжлэгийг бүрдүүлэх, хамтын түншлэлд суурилсан судалгаа хөгжүүлэлтийг эрчимжүүлэх талаар тодорхой эрх зүйн зохицуулалт бүхий заалт тусгасан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/367 дугаар тушаалаар 10 инновацийн төсөлд грант олгосон. 2022 онд үргэлжлэн хэрэгжих технологийн туршилт зүгшрүүлэлтийн 7 төслийн санхүүжилтийг шийдвэрлэлээ. "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-ын дагуу 2022 оноос эхлэн хэрэгжих технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 22 төсөл хэрэгжихээр батлагдсан. БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яамтай хамтран 2022 онд 12 төслийг хамтран шалгаруулсан. БШУЯ-ны харьяа Шинжлэх ухаан, технологийн сан нь Тайвань улсын Үндэсний шинжлэх ухаан, технологийн зөвлөлтэй 6 төсөл, БНХАУ-ын Байгалийн шинжлэх ухааны сантай 6 төсөл, Беларусийн Бүгд Найрамдах суурь судалгааны сантай 11, нийт 23 төслийг тус тус үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 377 дугаар тогтоолоор Боловсрол, соёл урлагын газрыг Боловсрол, шинжлэх ухааны газар болгосон, БШУ-ны сайдын А/125 дугаар тушаалаар бүтэц, орон тооны жишгийг баталж, аймаг орон нутагт орон тооны шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан мэргэжилтнийг ажиллуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэв.

Шинжлэх ухаан, технологийн сангийн төсөл, арга хэмжээний 2021 оны төсвийн зардалд 5,0 тэрбум төгрөг батлуулсан. Санхүүжилтийн хүрээнд 2021 оны байдлаар суурь судалгааны үргэлжлэн хэрэгжиж буй 115 төслийн 1 тэрбум 870 сая төгрөг, шинээр хэрэгжиж буй 64 төслийн 811 сая, суурь хавсарга судалгааны 18 грант төсөлд 113 сая төгрөг, гадаадтай хамтарсан 32 төслийн 285.1 сая төгрөг, үргэлжлэн хэрэгжиж буй улсын захиалгат 54 төслийн 1 тэрбум 314 сая төгрөг, шинээр хэрэгжиж буй 28 төслийн 687 сая төгрөг, инновацийн 16 төслийн 331.2 сая төгрөг, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 14 төслийн 231.6 сая төгрөг, докторын дараах инновацийн 20 төслийн 145 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгох шийдвэрийг гаргаж, шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүлээ. Засгийн газрын 2020 оны 33 дугаар тогтоолоор "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр"-ийг 3 зорилт 11 арга хэмжээний хүрээнд, 95 дугаар тогтоолоор "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл"-ийг 5 технологи, 11 салбар чиглэлд хэрэгжүүлэхээр тус тус батлуулсан. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний

өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлийг үндэслэн "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шинжлэх ухаан, инновацийн нэгдсэн цогцолборын барилгын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлж, 2021 онд улсын төсвийн 4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлыг үргэлжлүүлэн тасралтгүй явуулж байна.

2021 онд "Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл", "Шинжлэх ухааны академийн эрх зүй байдлын тухай хуулийн төсөл"-ийг УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахаар ажиллаж байна. Мөн "Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл", "Судалгааны их сургуулийн тухай хуулийн төсөл", "Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журмын төсөл"-ийг тус тус батлуулахаар холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Эдгээр хууль тогтоомжийн төсөлд судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулж буй төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүжилтийн зарчмыг шинэчлэх, улсын төсвөөс гадна гадаад дотоодын тусгай зорилтот сангууд зэрэг санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох замаар оновчтой механизмыг бүрдүүлэн хөгжүүлэх, тэдгээрт шаардагдах хүний нөөц, ялангуяа судлаачдын чадавхийг бэхжүүлэхэд эерэг үр дүнг авчрах зохицуулалтыг тусгасан болно.

"Инновацийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх заавар"-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А/76 дугаар тушаалаар баталж, инновацийн 16 дэд төсөлд 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Үүний зэрэгцээ судалгаа хөгжүүлэлтийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор инновацийн 16 төслийн 331.2 сая төгрөг, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 14 төслийн 231.6 сая төгрөг, докторын дараах инновацийн 20 төслийн 145 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжилтийг хангасан.

2.4.2. Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартад нийцүүлнэ.

Биелэлт: Монгол Улсад ШУПарк байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын /техникийн/ даалгаврыг боловсруулж, урьдчилсан судалгааг хийсэн. Монгол улсад Шинжлэх ухааны парк байгуулах байршлыг Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих Шинэ Зуунмод /Аэросити/-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгав.

Улсын төсвийн 94.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдах Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластерийн барилгын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлсэн. Уг кластер нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд 4,8 га талбайд баригдах ба 74,300 м² ашиглалтын талбай бүхий үндсэн 7 хэсэг барилга, байгууламжаас бүрдэх бөгөөд цогцолборыг 2023 онд ашиглалтад оруулна. 2020 оны улсын төсөвт 3 тэрбум, 2021 оны улсын төсөвт 24 тэрбум, 2022 онд 18 тэрбум төгрөг батлагдсан. Уг цогцолбор нь олон улсын стандартад нийцсэн нээлттэй, салбарын дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудтай байх бөгөөд Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд болон бусад их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын 3300 орчим эрдэмтэн судлаач, албан хаагчид ажиллах хүчин чадалтай шинжлэх ухаан, технологи, инноваци, танин мэдэхүйн төв болох юм.

Азийн хөгжлийн банкны 30 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 2021-2024 онуудад хэрэгжих "Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх" төслийн хүрээнд шинжлэх ухааны байгууллагуудын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлын үр дүн, судалгааны бүтээлүүдийг их, дээд сургуулиудын сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацийн төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулахаар ажиллаж байна.

2.4.3.Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эдийн засаг, нийгмийн хөгжилд өгч байгаа үр өгөөжийг шалгуур болгон санхүүжүүлдэг өрсөлдөөнт тогтолцоонд шилжүүлж, нэгдсэн, төрөлжсөн, нээлттэй лабораторийг байгуулан салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

Биелэлт: “Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төслийг боловсруулж, батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын дэргэд нийт 25 гарааны компани байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Шинжлэх ухааны академийн дэргэд Технологийн Инкубатор ХХК биотехнологи, микробиологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, технологийн хөгжүүлэлт хийж байна. МУИС, ШУТИС, АШУУИС, ХААИС-ийн дэргэд Инноваци, технологи дамжуулах төвүүд байгуулагдан, үйл ажиллагаа нь тогтмолжсон.

Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор сургалт, судалгаа, шинжилгээ, хяналтын нийт 54 байгууллагын 311 лабораторийн судалгаа хийж, судалгаагаар улсын хэмжээнд 164 лаборатори итгэмжлэгдсэнээс их сургууль хүрээлэнгийн харьяа 13 лаборатори (7.9%), үндэсний болон олон улсын хэмжээнд итгэмжлэгдсэн бол салбар дундын нээлттэй лабораторийн сүлжээнд нэгдэх боломжтой яам, агентлаг, тусгай газрын 11 лаборатори итгэмжлэгдсэн байна. Судалгааны үр дүнд үндэслэн “Шинжлэх ухааны салбар дундын нээлттэй лабораторийн үйл ажиллагааг зохицуулах” журмын төслийг боловсруулав. Баянзүрх дүүрэгт “Байгалийн ухааны нэгдсэн лаборатори”-ийн барилгын ажлыг гүйцэтгэж 2022 онд дуусгахаар ажиллаж байна. Тус барилгад их сургуулиуд болон шинжлэх ухааны байгууллагуудын дундын багажит эрдэм шинжилгээний нэгдсэн төв лабораторийг байгуулахаар төлөвлөж байна. 2022 оны 9 дүгээр сарын байдлаар төрийн өмчит 7 их сургууль /МУИС, ШУТИС, АШУУИС, ХААИС, МУБИС, ҮБХИС, ХСИС/-ийн дэргэд 103 туршилт, судалгааны лаборатори тухайн шинжлэх ухааны салбар бүрээр судалгаа шинжилгээ, туршилтыг бүрэн хүчин чадлаар хийж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

2.5.Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.

2.5.1.Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.

Биелэлт: Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг дахин боловсруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 10 дугаар сарын 07-ны А/197 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж 12 дугаар сарын 3-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хамтран батлаад байна. Түүнчлэн Нийгмийн даатгалын ерөнхий (Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг дагалдах 10 хуулийн төсөл), Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиудын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулж, хуулийн төслүүдийн үр нөлөөний, зардлын тооцооны судалгааг боловсруулав. Хуулийн төслүүдийг Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд Улсын Их Хуралд 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн

мэдүүлсэн болно. Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл нь одоо мөрдөгдөж буй эв санааны нэгдлээс хуримтлалын тогтолцоонд шилжих, нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр нь даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай байх, мөн санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх зэрэг зарчимд үндэслэн боловсруулж, шинэчлэлийн асуудлыг тусгав.

2.5.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд тэтгэврийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогын тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан болно.

2.5.3. Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.

Биелэлт: Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай” 63 дугаар захирамжаар хуримтлалын нэгдсэн сан бий болгох, бүрдүүлэх, хуримтлалын нэгдсэн сангаас санхүүжүүлэх үйл ажиллагааны талаар судалж, санал боловсруулахыг үүрэг болгосон.

Дэд ажлын хэсэг Сингапур улсын хуримтлалын сангийн туршлага, Норвеги, Бутан улсын тэтгэврийн тогтолцооны туршлагыг тус тус судлав. Хуулийн төсөлд ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгохоор хуулийн зохицуулалтуудыг оруулахаар ажиллаж байна. Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг 9 бүлэг, 46 зүйлтэй байхаар томьёолж, боловсруулаад байна.

Монгол Улсад Хуримтлалын нэгдсэн сан бий болгоход дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврыг боловсруулж Дэлхийн банкинд хүргүүлж батлуулсан. Энэхүү техникийн нөхцөлийн дагуу Сингапураас авах зөвлөх үйлчилгээний 1 ба 2 шатны тодорхой хэсгийг Дэлхийн банкнаас Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан гэрээгээр санхүүжүүлэхээр болов.

2.5.4. Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах бусад хуулийн төсөл”-ийг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 02-ний өдрийн чуулганаар баталсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, ниймийн хамгааллын сайдын 2020 оны А/162 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооцоо, судалгаа бусад баримт бичгийн хамт боловсруулж байна.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн төслийг Монгол Улсаас гадаад улсад, гадаад улсаас Монгол Улс руу чиглэсэн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний харилцаанд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шилжилт хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтыг үндэсний хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд тулгуурлан, нэгдмэл байдлаар зохицуулах зорилгоор 5 бүлэг, 41 зүйлтэй байхаар боловсрууллаа. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж

2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн чуулганаар баталсан. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний зөвшөөрөл олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2020 онд эхлүүлж, цахим системийн хөгжүүлэлт хийгдэн, ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор ezuvshuurul.mn цахим хаяганд төвлөрүүлэн бүрэн ашиглалтад оруулан ажиллаж байна. Цахим шилжилттэй холбогдуулан шаардагдах дүрэм журмыг батлуулж, иргэд, аж ахуйн нэгжээс цахим системээр дамжуулан бичиг баримтыг хүлээн авч шийдвэрлэж байна.

Боловсролын салбарын гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцооны схем, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, түүнийг үнэлэх үнэлгээний зааварчилгааг Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 252 дугаар тогтоолоор батлан, хэрэгжүүлж байна.

2.5.5.Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг урьд нь мөрдөж байсан цалингийн сүлжээний хамгийн өндөр буюу 5 дугаар шатлалаар тогтоосон. Үр дүнд нь төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин дунджаар 8.5 орчим хувиар нэмэгдсэн. Мөн Засгийн газрын 2022 оны 193 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах болон ТЗ-5 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг, төрийн захиргааны албан тушаалын АА-9 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүгчийн туслах болон АА-10 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоосон.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөвт төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчлэх замаар цалин хөлсийг ажилласан жил, бүтээмж, хүрсэн үр дүнтэй уялдуулан тогтоодог болох, төрийн албан хаагчдын цалин хөлсийг тодорхой хувь хэмжээгээр нэмэгдүүлэх дараах арга хэмжээ тусгагдсан. Үүнд:

1.Төрийн албаны цалингийн олон шатлал, зэрэглэлийг цэгцлэн үндсэн цалинг шатлалгүй болгож, төрийн захиргааны 15 зэрэглэлийг 10 болгоно.

2.Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг тодорхой хувиар нэмэгдүүлнэ.

3.Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, төвлөрлийг сааруулах хүрээнд орон нутгийн нэмэгдэл олгоно. Ингэхдээ улсын төсвөөс 20 хувийн нэмэгдлийг олгох ба энэ хэмжээг 100 хүртэл хувьд хүргэх эрхийг орон нутагт нь олгоно.

4.Нийт төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дээшлүүлэх хүрээнд тэдний ажилласан жил бүрийг үнэлж нэмэгдэл олгодог болно.

Тэтгэврийн худалдан авах чадварыг хэвээр хадгалах зорилгоор инфляцийн түвшинтэй уялдуулан Засгийн газраас 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа бүх тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөгт, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгт тус тус хүргэхээр шийдвэрлэсэн. Ингэснээр дундаж тэтгэврийн хэмжээ 29.4 хувиар нэмэгдэж 547.2 мянган төгрөгт хүрсэн.

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 5 дугаар сарын 4-ний 10 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс сард 550000 төгрөг байхаар шинэчлэн тогтоов.

2.5.6. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.

Биелэлт: Нийгмийн халамжийн нэгдсэн систем болох ehalamj.mn системийг 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлж, 2020 онд 6, 2021 онд 20, 2022 онд 36 төрлийн үйлчилгээг цахимжуулсан бөгөөд одоогийн байдлаар 72 нэр төрлийн үйлчилгээнээс 64 үйлчилгээг цахимжуулсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор 1,2 сая иргэн хамрагдаж, нийт хамрагдсан иргэний 89.8 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар авч байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах зорилгоор нийгмийн даатгалын 34 төрлийн үйлчилгээнээс 24 төрлийн үйлчилгээг цахимжууллаа. 2021 онд нийгмийн даатгалын 17 нэр төрөл үйлчилгээг цахимжуулахаар процессын зураглал, тайлбарыг боловсруулан ажиллав. 2021 оноос эхлэн тэтгэврийн цаасан дэвтэр олгохгүй бөгөөд тэтгэвэр тогтоолтын хуудсыг цахимаар эсвэл цаасаар авах боломжтой болсон. E-Mongolia цахим системд 12 үйлчилгээг холбосон. Цахимжуулсан 11 үйлчилгээний хувьд 1 жилд 11.2 тэрбум төгрөг иргэд хэмнэжээ.

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах аж ахуйн нэгж байгууллагын гадаадын ажиллах хүч мэргэжилтэнд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээг цахимжуулж, бүрэн ашиглалтанд оруулж, сургалт сурталчилгааг хийж байна. Мөн Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэн ашиглалтанд оруулж, сургалт сурталчилгаа хийгдэж байна. Дээрх 2 цахим системийг ezuuvshuurl.mn цахим хаяганд байршуулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад орууллаа. Шинэ системд ажилд зуучлах алгоритм үүсгэж ажил хайгчдын ажлын туршлага, ур чадвар, чадамжийг харгалзан хүний оролцоогүйгээр системийн тусламжтайгаар ажилд зуучлах давуу талтай болж байна.

2.5.7. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна.

Биелэлт: Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хамтран батлав. Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Орлогыг орлуулан тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны А/225, А/60 тоот хамтарсан тушаалаар баталсан бөгөөд шинэчлэн боловсруулах хүрээнд шаардлагатай хувьсагч үзүүлэлт сонгох, коэффициент бодож шалгах зэрэг холбогдох тооцоо судалгааг хийх, 2018 оны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дата мэдээллийг, гааль, татвар мэдээллийн технологийн төв байгууллагын татвар орлогын талаарх дата, мэдээлэлтэй тулгах ажлыг зохион байгуулж байна.

Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулинд Улсын Их Хурлаас нэмэлт, өөрчлөлт оруулснаар 2021 оны 07 дугаар сараас эхлэн хүүхдээ гэртээ харж байгаа аав нь хүүхэд асарсаны тэтгэмжийг авах боломжийг нээсэн. Ингэснээр 20.000 орчим аавууд тус тэтгэмжид хамрагдана. 2021 оны 11 дүгээр сарын мэдээгээр 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 200,119 иргэнд 81,9 тэрбум төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмжид 77,891 иргэнд 10,5 тэрбум төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмжид 775 иргэнд 1.6

тэрбум төгрөг, өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 7,677 иргэнд 8,9 тэрбум төгрөгийн тэтгэмж олгох ажлыг зохион байгууллаа.

Насны хишиг тэтгэмжийг 2021 оны 1 дүгээр сараас эхлэн e-halamj.mn цахим системд холбосноор анх удаа тэтгэмжийг авах насны болзол хангасан ахмадууд хүсэлтээ цахимаар гаргах боломжтой болов. 2021 оны Цагаан сарын болон Улсын баяр наадмын олголтоор нийт 143,522 ахмад настанд насны хишгийг олгоод байна. 2022 онд хүлээгдэж 65 ба түүнээс дээш настай 168,2 мянган ахмад настанд 25.4 тэрбум төгрөгийн насны хишиг тэтгэмжийг олгов.

2.5.8. Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.

Биелэлт: Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Улсын Их Хурлын 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Хүүхдийн төлөө санг сэргээн байгуулах, Засгийн газрын тусгай сангийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд батлагдав. Хүүхэд хамгааллын тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/26 дугаар тушаалаар Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зусланг байгуулах асуудлаар бэлтгэл ажлыг хангаж ажиллах чиг үүрэг бүхий салбар дундын ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслангийн 60 га газрыг 5 жилийн хугацаатай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам эзэмших эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/122 тоот тушаалаар батлагдсан. Мөн 2022 оны улсын төсвийн тухай хуульд 10 тэрбум төгрөгийг “Олон улсын хүүхдийн “Найрамдал-2” зуслан байгуулах барилгын зардалд тусган барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан боловч тендерт оролцох сонирхсон этгээд тендерт саналаа ирүүлээгүй байна.

Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2021 онд нийт 12 төвийн санхүүжилтийн асуудлыг тусгасан бөгөөд 2 төвийн ажил дуусаж, 10 төвийн барилга угсралтын ажил явагдаж байна. 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийг дэмжих чиглэлээр шинээр 5, шилжих 12 барилга байгууламж барихаар 24,6 тэрбум төгрөгийг батлуулан, хэрэгжүүлнэ.

АХБ-ны санхүүжилтээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Ховд, Хөвсгөл, Архангай, Дархан-Уул, Дундговь, Дорнод зэрэг 6 аймагт олон улсын стандартад нийцсэн, түгээмэл загвар бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барина. 6 аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулахаар барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан шалгарсан 6 байгууллагатай гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн бөгөөд 42-95 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын зураг, төсвийг 2021 оны 12 дугаар сард батлуулсан. Тус төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалтын дотоодын тендерийг 2022 оны 2 дугаар

сард зарлаж, гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулж, барилга угсралтын ажлыг 2022 оны 06 дугаар сард эхлүүлэв.

Улсын хэмжээнд 34 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр насанд хүрсэн 1299 хүчирхийллийн хохирогч, 2699 хүүхэд үйлчлүүлсэн. Нийт үйлчилгээ авсан хүүхдийн 116 нь 2-оос дээш удаа түр хамгаалах байранд ирсэн байна. Гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн 1757, асрамж, халамжийн үйлчилгээнд 82, дэмжих, холбон зуучлах үйлчилгээг 860 хүүхдэд үзүүлж, аюулгүй байдлыг ханган ажилласан.

2.5.9. Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Биелэлт: Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 01 тогтоолоор батлуулав. Хөтөлбөрүүдийг 2021-2022 онд хэрэгжүүлнэ.

- Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 2021 оны 11 сарын байдлаар нийт 14,045 иргэн хамрагдаж 8,357,823.2 мянган төгрөг зарцуулж 9,615 ажлын байр бий болсон байна.

- Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 677 ахмад мэргэжилтэн хамрагдаж, 1,037,722.0 мянган төгрөг зарцуулж, 708 ажлын байр бий болсон байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр 2,848 иргэн хамрагдаж, 4,482,057.42 төгрөгийг зарцуулж 1,101 ажлын байр бий болсон байна.

- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 8,091 иргэн хамрагдаж 557,247.38 мянган төгрөг зарцуулж 5,747 иргэн ажлын байраар хангагдсан байна.

- Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 2021 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр 4,022 иргэн хамрагдаж, 233 иргэн ажлын байраар хангагдаж, 244,270.88 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2022 оны жилийн эцэст хүлээгдэж байгаа дүнгээр: Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 11112 иргэн хамрагдаж, 1224 иргэн ажлын байраар хангагдаж, 601,943,740 төгрөгийг зарцуулсан байна.

2.5.10. Томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд бүрэн нийцүүлнэ.

Биелэлт: Боловсролын ерөнхий хуульд болон дээд боловсролын хуулийн төсөлд Мэргэшлийн үндэсний хүрээг тогтоох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах тогтолцоог бэхжүүлэх зохицуулалт туссан бөгөөд УИХ-аар хэлэлцэгдэж байна. Мэргэшлийн үндэсний хүрээг бусад улсын туршлагыг судлан өөрийн орны онцлогийг тусган 10 түвшинтэйгээр боловсруулсан. 2021 онд 1 болон 2.5 жилийн 50 мэргэжлийн чиглэлээр жишиг сургалтын төлөвлөгөөг баталсан. Сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсонтой уялдан шинэ мэргэжлийн 59, сайжруулсан ЧСС-ын хөтөлбөр 125 нийт 184 сургалтын хөтөлбөр боловсруулуулж давхардсан тоогоор 400 гаруй арга зүйч, менежер, мэргэжлийн багш нарт арга зүйн зөвлөгөө өгч дүгнэлт гаргав.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн нэгдсэн систем”-ийн 2 дугаар шатны хөгжүүлэлтийн хүрээнд asc.mn, mergejl.mn зэрэг дэд системүүдийг нэгтгэн вэб технологид суурилсан мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын цахим мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, хүлээн авсан. Хөгжүүлэлтийн баг иргэд олон нийт системээр дамжуулан мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллүүдийг нээлттэйгээр хүлээн авах, боловсролын баримт бичиг шалгах, нөхөн авах, сургалтын алба, суралцагчийн удирдлагын программын суралцагчийн элсэлт, анги бүлэг үүсгэх, төгсөлт, шилжилт хөдөлгөөн, анги дэвшилт, ирц, тэтгэлэг олголт зэрэг сургалтын алба, суралцагчтай холбоотой бүхий л үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж байна. Ингэснээр суралцагчийн бүртгэлийн давхардал, тэтгэлэг олголт хойшлох асуудлыг шийдэж, иргэдийн өмнөх мэдлэг, ур чадварыг үнэлэх RPL үнэлгээнд хамрагдах иргэд хүсэлтээ илгээх, онолын мэдлэгээ үнэлүүлэх, үнэлгээтэй холбоотой төлбөрөө төлөх, ур чадварын шалгалтын хуваарь товлох зэрэг үйл ажиллагааг цахимжуулж иргэдэд хүрэх үйл ажиллагааг нээлттэй түргэн шуурхай хүргэж байна. Мөн сургалтын байгууллага, суралцагч, эцэг эх, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд хоорондын харилцааг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн ил тод байдал, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулсан.

2.5.11.Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангана.

Биелэлт: Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг түшиглэн эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн салбар дундын дадлагын бааз бүхий Чадамжийн төвүүдийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд барилга, зам тээвэр, хөдөө аж ахуйн салбарын 15 мэргэжлийн чиглэлээр нийт 19 сургалтын байгууллагын дадлагын сургалтын орчинг бүрдүүлж, барилга угсралт, их болон урсгал засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг гүйцэтгэсэн.

- Авто зам, гүүрийн барилгын мэргэжлийн Чадамжийн төв – Налайх дүүрэг дэх политехник коллеж;

- Хөдөө аж ахуй, ноос, ноолуурын мэргэжлийн Чадамжийн төв – Төв аймаг, Баянчандмань суман дахь политехник коллеж;

- Барилгын мэргэжлийн Чадамжийн төв – Барилгын политехник коллеж.

Мөн Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн хүрээнд 7 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад салбар дундын дадлагын бааз бүхий Чадамжийн төвийг бий болгосон. Чадамжийн төвүүд нь ашиглалтад орсноор мэргэшлийн ахисан түвшний сургалт эрхлэх, иргэний өмнөх мэдлэг, ур чадварыг үнэлэх, гэрчилгээжүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын захиалгат сургалт явуулах, ур чадварын тэмцээн, уралдаан зохион байгуулах, мэргэжлийн багш нарыг мэргэшүүлэх, судалгаа, шинжилгээ, инноваци, мэдлэгийн менежментийг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байрын засвар /40,0 сая/, Монгол-Солонгосын ПК-ийн сургуулийн засвар, дотуур байрны тоног төхөөрөмж /135,0 сая/, Завхан аймгийн ПК-ийн зоорь, засвар, тоног төхөөрөмж /135,0 сая/ нийлүүлэх ажил хийгдэв. Өмнөговь аймаг дахь дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 3000 оюутны хүчин чадал бүхий “Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулахаар Оюу толгой ХХК-тай хөрөнгө оруулалтын санамж бичгийг байгуулсан. Оюу Толгой ХХК нь бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр 2022 оны 9 дүгээр

сарын 5-ны өдөр сонгон шалгаруулалт зарлан гүйцэтгэгч компанийн шалгаруулж, судалгааныг ажлыг эхлүүлсэн.

2.5.12.“Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг 2021 оны 11 сард баталж, Ирээдүйн өв сангийн 2022 оны орлогоос Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрд мөнгөн хуримтлал үүсгэх хууль эрх зүйн боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг уул уурхайн баялгийн өгөөжид суурилсан “Хуримтлалтай Монгол хүүхэд” хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлж эхлэв. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор “Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам”-ыг баталсан.

2022 оны 10 дугаар сарын байдлаар 23909 хүүхдэд 3.0 тэрбум төгрөгийн мөнгөн хуримтлал үүсгэсэн байна. Харин хүүхдийн мөнгөн хуримтлалаас дунджаар 1,234.175 хүүхдэд 100.0 мянган төгрөгийг бэлэн мөнгө хэлбэрээр олгоход 1,234.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

2.5.13.Тусгай хэрэгцээ /байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл/-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжоор хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Хуулийн төсөлд байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхдээ асран, ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төрөөс төлөх зохицуулалтыг тусгасан болно.

2.5.14.Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд байгуулсан "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2020 онд 7,415,000,000,0 (долоон тэрбум дөрвөн зуун арван таван сая) төгрөгийг Төрийн банк болон ХААН банкаар олгохоор 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулж зээл олгож эхлээд байна. 2020 оны 11 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр дамжуулан зээлдэх гэрээний дагуу 916 зээлдэгчдэд 8.1 тэрбум төгрөгийн жижиг зээл олгож, 1076 ажлын байр бий болж үүнээс 597 ажлын байр шинээр бий болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд өрхийн үйлдвэрлэл эрхлэх, ажлын байраа өргөжүүлэх, аж ахуй эрхлэх зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох, борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. Энэхүү арга хэмжээнд малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн хамрагддаг ба 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 6791

иргэн хамрагдаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 12,079.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнд зориулсан жижиг зээлийг Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд олгож байгаа бөгөөд Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд 2021 оны 10 дугаар сарын өссөн дүнгээр нийт 1225 иргэнд 10,9 тэрбум төгрөгийн зээлийг олгож нийт 2385 ажлын байрыг бий болгосон байна. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 2021 оны 11 сарын байдлаар нийт 14,045 иргэн хамрагдаж 8,357,823.2 мянган төгрөг зарцуулж 9,615 ажлын байр бий болсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр 2,848 иргэн хамрагдаж, 4,482,057.42 төгрөгийг зарцуулж 1,101 ажлын байр бий болсон байна.

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд гэрээ байгуулсан хугацаанаас хойш Хаан банк, Төрийн банкаар дамжуулан 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 1402 иргэнд 12,5 тэрбум төгрөгийн зээлийг олгож нийт 2740 ажлын байрыг бий болгосон байна. Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 2022 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр нийт 9095 иргэн хамрагдаж 18.2 тэрбум төгрөг зарцуулж 3764 ажлын байр бий болсон байна. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2032 иргэн хамрагдаж, 2263 ажлын байр бий болж, 13.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 702 өрхийн 1704 иргэн хамрагдаж, 1452 ажлын байр бий болж, 3.8 тэрбум төгрөгийг зарцуулсан.

2.5.15.Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.

Биелэлт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, ниймийн хамгааллын сайдын 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/162 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооцоо, судалгаа бусад баримт бичгийн хамт боловсруулж байна. Уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эх орондоо эргэн ирж, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зохицуулалт тусгахаар тооцоо, судалгаа хийж байна.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар батлав. Уг хуулийн 20 дугаар зүйлд Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх зүйл, заалтыг тусгасан.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэх, сайжруулах, ажил зуучлах үйлчилгээний цахим хэлбэрийг хөгжүүлэх зорилгоор БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, “Воркнэт” төсөлтэй хамтран ажиллаж байна. E-job платформыг нэвтрүүлэх ажил 2022 оны 11 дүгээр сард дуусгав.

Үндэсний бахархал, өв соёл

2.6.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.

2.6.1.Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна:

2.6.1.1.“Чингис хаан” хаад, язгууртны музейн шинэ барилга, бусад түүхэн газар нутагт баригдаж байгаа цогцолборууд;

Биелэлт: “Чингис хаан” хаадын музейн бүтээн байгуулалтыг улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлж 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр ашиглалтад хүлээн авч, 11 дүгээр 09-ний өдөр нээлтээ хийсэн. Музейн барилга нь хүчин чадлын хувьд 2.500 мкв талбай бүхий 9 давхар барилга бөгөөд нийт талбайн 60 хувийг музейн үзмэр, үзүүлэг эзлэх бөгөөд үндсэн гурван хэсэг 15 байнгын үзмэрийн танхимтай, шинээр 160 ажлын байр бий болно. Музейн үзүүлэг, дэглэлтийг 15 танхимд нийт 6033 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл дэглэхээр батлагдсан. Үүнээс 5927 ширхэг буюу нийт үзмэрийн 98,2 хувийг нь дотоодын эх үүсвэрээс, 106 ширхэг буюу 1,8 хувийг нь гадаадын музей, номын сан, архив зэрэг байгууллагын эх үүсвэрээс бүрдүүлэх бөгөөд одоогийн байдлаар 27 байгууллагаас 5742 үзмэр шилжүүлэх, 8757 үзмэр авах тооцоог хийж баталгаажуулж, 111 дэсийн 160 ширхэг үзмэрийг бүртгэж хүлээн авсан. Музейн сан хөмрөгийг баяжуулах чиглэлээр Австри, ХБНГУ, ОХУ, Польш, Их Британи, Япон улсад хадгалагдаж байгаа монголын түүхэнд холбогдох 9 ховор үзмэрийн А хуулбарыг хүлээн авч, музейн сан хөмрөгт шилжүүлсэн. Япон улсаас 3 үзмэрийг хуулбарлах ажлын гэрээг байгуулж, ажлыг эхлүүлээд байна.

2.6.1.2.Байгалийн түүхийн музейн шинэ барилга;

Биелэлт: Засгийн газраас музейн барилгыг Их тэнгэрийн аманд баригдаж байсан Асем зочид буудал, үндэсний хурлын танхимын барилгын зориулалтыг өөрчилж музей болгож үргэлжлүүлэн барихаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд музейн зураг төсвийг боловсруулж, 2020 онд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар 3 удаагийн тендер зохион байгуулсан ч амжилтгүй болсон. 2020 оны Улсын төсвөөс музейн барилга угсралтын ажил болон дуусаагүй барилгын нөхөн төлбөрт 18,0 тэрбум төгрөгийг хуваарилсан бол 2021 оны Улсын төсвөөс музейн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэхэд зориулан 13,3 тэрбум төгрөгийг хуваарилсан. Дуусаагүй барилгын гүйцэтгэл музейн зураг төслийн харьцуулсан дүнгээр 25 орчим хувийн гүйцэтгэлтэй юм. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд музейн бүтээн байгуулалтад 25.0 тэрбум төгрөг батлагдсан. Төслийн ажил үргэлжилж байна. Байгалийн түүхийн музейн шинэ барилга нь байгалийн түүхэнд холбогдох үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, судалж, сурталчлах соёл, боловсрол, шинжлэх ухааны цогц музей байхаар төлөвлөгдсөн бөгөөд 47733 мкв талбай бүхий, шинээр 240 ажлын байр бий болох юм.

2.6.1.3.Үндэсний номын сангийн шинэ барилга;

Биелэлт: Барилгын гадна фасадны ажил 100 хувьтай, дулаалгын ажил 95 хувьтай, 1 давхрын чулуун фасадны чулууны ажил 80 хувьтай, “А”, “В” блокийн дээврийн ажил дууссан, дотор шаврын ажил, “Б” блокийн дээврийн ажил, дотор халаалт, дотор цахилгаан, дотор холбоо, галын дохиоллын монтажны ажил дууссан, гадна цахилгааны трассын ажлууд хийгдсэн, гадна инженерийн шугам сүлжээний ажил дууссан, барилгыг битүүлж, дулаан авсан бөгөөд барилгын гадна фасадын дулаалга 90 хувьтай байна. АНУ-ын Элчин сайдын яамны тусгай хэрэгцээний газраас 2000 м.кв талбайг Монгол Улсын Үндэсний номын санд номын сангийн зориулалтаар шилжүүлэх Нийслэлийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/1288 тоот захирамж гарсан. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд 2 тэрбум төгрөг батлагдсан. 2022 онд ашиглалтад бүрэн оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Барилгын ажлын явц 90 хувьтай үргэлжилж байна.

2.6.1.4.Үндэсний урлагийн их театрын шинэ барилга;

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгөөр Сүхбаатар дүүргийн 9, 11 дүгээр хороо, 10 га газарт Үндэсний урлагийн их театр баригдахаар тусгагдсан бөгөөд тус байршлын нөлөөлөлд 160 нэгж талбар өртсөн. Нийслэлийн Засаг даргын газар эзэмших эрх олгох тухай 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн А/635 дугаар захирамжаар 5,5 га газарт Үндэсний урлагийн их театрт эзэмшүүлсэн. Одоогийн байдлаар нийт оноогдсон газрын 90 хувь нь баталгааждаг байна.

Барилгын зураг төслийг “Бьюлдингс Техноложи” ХХК хийж, загвар зургийг Соёлын яаманд батлуулахаар ирүүлсэн. УСҮГ-аас цэвэр бохир ус, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-аас холбооны техникийн нөхцлүүд авч, Эрчим хүчний яамнаас цахилгаан дулааны техникийн нөхцлүүдийн бэлтгэл ажил хангагдсан. Барилгын газар чөлөөлөх ажил хийгдэж байна. Төслийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэхээр Ерөнхий сайдын 2021 оны 156 дугаар захирамж гарсан.

2.6.1.5. Үндэсний археологи, палеонтологи, угсаатны зүйн музей, лаборатори;

Биелэлт: Музей, лабораторийн барилгын зураг, төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зураг, төслийн ажил хийгдэж дууссан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Балданс” ХХК шалгарсан бөгөөд барилгын ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр эхлүүлсэн. 2022 оны байдлаар барилга угсралт 50 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд энэ онд санхүүжих дүнгээс барилга угсралтын ажил 20 хувийн илүү гүйцэтгэлтэй байна.

2.6.1.6. Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв”;

Биелэлт: Хөвсгөл нуурын байгаль экологи, соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, судалж, сурталчлах цогц музей байгуулах зорилтын хүрээнд Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв”-ийг байгуулахаар төлөвлөсөн. 2021 онд төслийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг бэлэн болгосон. 2022 онд “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв”-ийн зураг төслийн ажилд 120.0 сая төгрөг батлагдсан.

2.6.1.7. Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театр;

Биелэлт: Нийслэлийн Засгийн дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Хүүхдийн төв номын сан, Хүүхэлдэйн театрын шинэ барилгыг Чингэлтэй дүүргийн 5-р хороонд байрлах Тасганы овоонд 11000 м² талбай бүхий газар олгосон. Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар “Цогцолбор барилгын ажлын загвар, зураг боловсруулах ажлын даалгавар”-ыг 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан. Баталсан ажлын даалгаврын дагуу барилгын загвар зургийг боловсруулах ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан 850 хүний суудалтай “Соёлын ордон”-ны барилгыг Засгийн газрын 2021 оны 158 дугаар тогтоолоор “Хүүхэд, залуучуудын театр”-ын зориулалтаар ашиглахаар шийдвэрлэсэн.

2.6.1.8. соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Архангай аймгийн Хөгжимт драмын театрын барилга угсралтын ажил 80 хувьтай явж байна. Барилгын нийт төсөв 9.9 тэрбум төгрөг, 2020 онд 3543.8 сая төгрөг батлагдсан, барилгын ажлыг 2023 онд дуусгахаар төлөвлөсөн. **Завхан** аймгийн театрын

шинэ барилгын төсөв 9.9 тэрбум төгрөг, театрын барилга угсралтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй, барилгын ажлыг 2023 онд дуусгахаар төлөвлөсөн. **Хэнтий** аймгийн чуулгын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2020 оны байдлаар 85 хувьтай байна. **Увс** аймгийн хөгжимт драмын “Ойрад” театрын барилга угсралтын ажил 2020 оны Улсын төсөвт 4800.0 сая төгрөг тусгагдан батлагдсан, Театрын барилга нь 2023 онд ашиглалтанд орно. Барилга угсралтын ажил 80 хувьтай байна. **Дундговь** аймгийн театрын шинэ барилгын ажлыг 2023 онд дуусгахаар төлөвлөсөн. **Дорноговь** аймгийн Саранхөхөө театрын барилга 2021 онд 1 тэрбум төгрөгийн санхүүжилтыг улсын төсөвт тусган, 2021 онд барилгын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2023 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. **Говьсүмбэр** аймгийн чуулгын барилга угсралтын ажлыг 2021 оны 5 сард эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна. **Дархан-Уул аймгийн** Дархан суманд баригдаж буй музей, номын сангийн цогцолборын барилга угсралтын ажлын зураг төсөл боловсруулж, гүйцэтгэгчээр шалгарсан компани 2021 онд гэрээний дагуу барилгын суурийн давхаргын ажлыг гүйцэтгэсэн. 2023 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

2021 онд орон нутагт 8 соёлын төв, 2022 онд 14 соёлын төвийг ашиглалтад орууллаа. 2020 онд нийт 163.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий 68 соёлын төв орон нутагт шинээр ашиглалтад орсон. 2020 оны эцсээр барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 70-95 хувийн гүйцэтгэлтэй 42 соёлын төв, 50-69 хувийн гүйцэтгэлтэй 10 соёлын төв, 30 хувь хүртэлх гүйцэтгэлтэй 11 соёлын төв байна.

2.6.1.9.“Төв Азийн түүх, соёлын голомт” судалгаа, сурталчилгаа, хамгаалалтын цогцолборыг Орхон-Тамир, Хануй-Хүнүйгийн дурсгалуудыг түшиглэн байгуулна.

Биелэлт: Орхон-Тамир, Хануй-Хүнүй голын хөндийд орших цогцолбор дурсгалд нөлөөллийн судалгааг хийж, урьдчилсан ТЭЗҮ-г бэлтгэх, судалгаа, сурталчилгаа, хамгаалалтын цогцолборын байршлыг Архангай аймгийн Өлзийт сумын нутагт орших “Харганын дөрвөлжин” хэмээх газраас илрүүлсэн хүннүгийн шаньюйн орд өргөө, нийслэл Луут хотын туурийг түшиглэн эхлүүлсэн. 2022 онд Хотын туурийг тойруулан 300х250 метрийн хамгаалалтын хашаа барьснаас гадна дурсгалт газрыг зорин ирэх ард иргэд, зочид гийчдэд дурсгалын талаарх үнэн зөв, цэгцтэй мэдээллийг өгөх, археологийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг сурталчлан таниулах зэргээр тав тухтай орчинд олон талын үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн “Соёл, мэдээллийн төв”-ийн барилгыг барьж байгуулаад байна.

2.6.2.Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлнэ:

2.6.2.1.“Цахим соёл” арга хэмжээ;

Биелэлт: Соёлын салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх, соёлын салбарын мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, соёлын өвийн бүртгэлийг цахимжуулах зорилтын хүрээнд 2021-2024 онд хэрэгжих “Цахим соёл” арга хэмжээний бодлогын баримт бичгийг боловсруулан Соёлын сайдын 2022 оны А/91 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж эхэллээ. Цахим орчинд нийт 85 шууд бичлэг /live/-т уран бүтээлчдийг оролцуулж, мэргэжлийн урлагийн байгууллагын нийт 214 бүрэн болон богино хэмжээний тоглолт, дүрслэх, дизайн урлагийн нийт 286 уран бүтээлчдийн 378 бүтээлийг цахим үзэсгэлэн хэлбэрээр түгээсэн нь давхардсан тоогоор нийт 3,580,104 хэрэглэгчдэд хүрсэн. Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл мэдээллийн санд RICH 3.0 программ хангамжид нийт Улаанбаатар хотын 9 дүүрэг,

21 аймгийн 330 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг хамрагдсан.

2.6.2.2. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээ;

Биелэлт: Соёлын сайдын А/173 тушаалаар, 21 аймаг болон харьяа байгууллагын хүрээнд “Соёлын боловсролын үндэсний сургагч багш” бэлтгэх сургалтад 60 ажилтныг хамруулан сургагч багшаар бэлтгэж, тогтвортой хөгжлийн зорилт, соёлын олон талт байдал, соёлын үнэт зүйлийг хүртэх, эзэмших, хамгаалах, нийгмийн соён гэгээрлийг нэмэгдүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах багш нар бэлтгэгдсэн. “Бүх нийтийн соёлын боловсрол олгох” бодлогын баримт бичгийг боловсруулахад шаардлагатай нөхцөл байдлын тоон судалгаа, хүн амын нас сэтгэхүйн онцлогт тохирсон амьдралын зураг авалтын чанарын судалгааг улсын хэмжээнд авах бэлтгэлийг хангав. Судалгааны дүнг 2022 оны 2 дугаар сарын 01-ний дотор нэгтгэхээр ажиллаж байна.

Оюуны өмчийн эрхтэйгээр уран бүтээлийн франчайзинг 4 театрт хэрэгжүүлсэн. Орон нутгийн хүүхэд, залуучуудад урлагийн боловсрол олгох зорилгоор орон нутгийн театр, чуулгуудад оюуны өмчийн эрхтэйгээр уран бүтээлийн франчайзинг Улсын Хүүхэлдэйн театр, Баянхонгор аймгийн Тэмүүжин театр, Дундговь аймгийн Хөгжимт Драмын Театр, Дархан-Уул аймгийн Шарын голын соёлын төвүүдэд хэрэгжүүлсэн.

“Урлаг ба Хүн” хөтөлбөрөөр дамжуулан Хөвсгөл, Увс, Ховд аймгийн 800 орчим сурагчдыг хамруулсан. “Урлагийн боловсролын хөтөч” хөтөлбөрөөр дамжуулан 500 орчим сурагчдыг хамруулсан. Соёлын цаг аян-Нийтийн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэх соёл урлагийн үйлчилгээг иргэдэд ойртуулах чиглэлээр 9 дүүрэг, 21 аймагт соёл урлагийн байгууллагууд өөрсдийн уран бүтээлийг хүргэж ажилласан. “Бүх нийтийн хөгжмийн баяр-2020” аян-Хөгжмөөр дамжуулан ард иргэдэд урлагийн боловсролыг олгох чиглэлээр хөгжмийн уралдаан, наадмыг нэгтгэн шинэлэг менежментээр улс орон даяар зохион байгуулсан.

2.6.2.3. “Сонгодог урлаг-III” арга хэмжээ;

Биелэлт: “Сонгодог урлаг-III” дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021-2023 онд хэрэгжүүлэхээр 5 зорилтын 91 арга хэмжээтэйгээр Соёлын сайдын 2021 оны А/77 дугаар тушаалаар батлан, хэрэгжүүлж байна. Кино урлагийг дэмжих тухай хуулийг боловсруулан батлуулав. Судалгаа, эрдэм шинжилгээний 6 судалгаанд дэмжлэг үзүүлж, 105 эрдэмтэн судлаач, 56993 уран бүтээлч үзэгч хамрагдсан. Сургалт-Мэргэжлийн урлагийн 6 уран бүтээлчийг олон улсын өндөр зэрэглэлийн сургалтад, төв, орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагын удирдах ажилтнуудыг 2 удаагийн сургалтад тус тус хамруулсан. Бүтээлч үйл ажиллагааны 12 төсөл арга хэмжээнд 506 уран бүтээлч оролцож, танхимаар 1220, цахимаар 1,414,022 үзэгчдэд хүргэлээ. Сонгодог урлагийн гала фестивалийг телевизийн нэвтрүүлэг хэлбэрээр зохион байгуулж, Үндэсний эрх чөлөөний өдрөөр МҮОНТ-ээр дамжуулж 100,000 үзэгчдэд хүргэсэн. Тус нэвтрүүлэгт үндэсний сонгодог урлагийн талаар үзэгчдэд мэдлэг олгох зорилгоор бүтээж “Шивээ хиагт”, “Учиртай 3 толгой”, “Ламбугайн нулимс”, “Хан бүргэд”, “Чингис хаан”, “Хөхөө намжил”, “Уран хас” зэрэг 7 дуурийн хэсгээс бүрдүүлсэн.

“Гэгээн Муза-15” олон улсын театрын наадам 2020 оны 08 дугаар сарын 30-ны өдөр “Хүн” театрт болж, драмын урлагийн шилдэг уран бүтээл, уран бүтээлчдийг шалгаруулсан. Наадамд орон нутгийн 10 гаруй театр, чуулга, продакшны бүтээл оролцсон, 12 улсын уран бүтээлчид, Монгол, ОХУ, Словени, Швейцар, Швед, Грек зэрэг улсын шүүгчид хамтран ажилласан. Наадамд нийт 90 гаруй уран бүтээлч 23 бүтээлээрээ монодрам, хөгжимт жүжиг, хүүхдийн жүжиг, хоёр хүний жүжиг, драмын тоглолт гэсэн үндсэн таван төрөлд нэр дэвшиж

өрсөлдсөөс Дорнод аймгийн ХДТ-ын “Мангасуудын хаан” жүжиг Гранпри шагналыг хүртсэн.

2.6.2.4. “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээ;

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 316 дугаар тогтоолоор “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээ”-г батлуулсан. Соёлын бүтээлч үйлдвэрлэл арга хэмжээг 1 дүгээр үе шатыг бүрэн хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хүрээнд тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний боломжит зах зээлийг тэлэх, экспортод чиглүүлэх зорилгоор “Соёлын бүтээлч сар” аяныг 2022 оны 11 дүгээр сард соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарыг хамааруулан 1-р долоо хоногийг “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”, 2-р долоо хоногийг “Бүх нийтийн соёлын боловсрол”, 3-р долоо хоногийг “Соёлын аялал жуулчлал”, 4-р долоо хоногийг “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” гэсэн сэдэв агуулгын хүрээнд тус бүр зохион байгуулсан.

Арга хэмжээг боловсруулах хүрээнд шаардлагатай “Соёлын үйлдвэрлэл, инновацын хөгжлийн бодлогын хамрах хүрээ ба түүний нийгэм, эдийн засагт оруулах хувь хэмжээг нэмэгдүүлэх боломж” эхний шатны тандалт судалгааг хийсэн. “Монгол соёл-Монголын баялаг” цогц арга хэмжээний стратегийг боловсруулан Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд танилцуулж, Засгийн газрын 14 дүгээр тэмдэглэл гарсан. 11 дүгээр сарыг Соёлын бүтээлч сар болгон, зарлаж, аяны хүрээнд 150 гаруй арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд 11 дүгээр сарын 30-ны өдөр Соёлын бүтээлч сарын ажлаа дүгнэж Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн форум”-ыг Төрийн ордонд зохион байгууллаа.

2.6.2.5. “Монгол өв ба дэлхий дахин” олон улсын арга хэмжээ.

Биелэлт: “Монгол өв ба дэлхий дахин” дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, гадаадад “Монголын соёлын төв”-ийг үе шаттай байгуулах хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлыг тандан судлах, эдийн засгийн тооцооллыг боловсруулах зардлыг Соёлын сайдын 2021 оны А/266 дугаартай тушаалаар баталж, ажлын даалгаврыг боловсруулж, судалгааны тайланг боловсруулах гэрээг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнтэй байгуулан ажиллаж боловсруулав.

2021 оны 6 дугаар сард БНХАУ-ын Фужан хотноо зохион байгуулагдах Дэлхийн өвийн хорооны 44 дүгээр чуулганаар Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолборыг дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх асуудлыг хэлэлцүүлэхээр бэлтгэлийг ханган ажиллаж байна. Дэлхийн өвийн жагсаалтад Монгол Алтайн өндөр уулс өвийг холимог ангиллаар бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүрдүүлж, Дэлхийн өвийн төвд хүргүүлээд байна. Дэлхийн өвийн хороо нэр дэвшүүлсэн өвийн газарт үнэлгээ хийлгэхээр байгалийн өвийн шинжээч нарыг 2022 оны 06 дугаар сард Монгол Улсад томилсон. Өвийн газрыг дэлхийн өвийн шинжээчдэд танилцуулж, үнэлгээ хийлгэв. 2021 онд Дэлхийн өвийн үндэсний урьдчилсан жагсаалтад орсон Хүннүгийн язгууртны оршуулгын газар, Говийн хадны зураг өвийг нэр дэвшүүлэх техникийн баримт бичгийг боловсруулах судалгааны ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

“Наурызын баяр” өвийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлэх баримт бичгийг төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтан бэлтгэж, өвийг бүртгүүлэх саналын хамт 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр өвийн оролцогч 12 улсыг тэргүүлж байгаа Исламын Бүгд Найрамдах Иран Улсын Байнгын төлөөлөгчийн газарт хүргүүлсэн бөгөөд “Наурызын баяр” өвийг конвенцын үйл ажиллагааны удирдамжид заасны дагуу баримт бичигт үнэлгээ хийж,

оролцогч талуудын саналыг цуглуулан конвенцын нарийн бичгийн газарт өргөн мэдүүлэх бэлтгэл ажил хангагдсан.

2022 оны хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд зориулан Катарын Үндэсний музейд гаргасан "On the Move" /Нүүдэл/ тусгай үзэсгэлэнд Монголын Үндэсний музейн сан хөмрөгөөс 61 дэсийн 251 ширхэг үзмэрийг, Монголын Уран зургийг галерейн сан хөмрөгөөс 4 дэсийн 4 ширхэг бүтээлийг Монголын хэсэгт дэлгэн олон нийтэд сурталчилсан. Энэхүү үзэсгэлэнд нүүдлийн ахуй соёлын төлөөлөл болгон Монгол, Катар, Алжир 3 улсын түүх, соёлын дурсгалыг тусгайлан сонгож, нэг дор хамтатган гаргасан бөгөөд үзэсгэлэнгээр нүүдлийн ахуй, соёлыг уламжлан тээж яваа харилцан адилгүй бүс нутагт аж төрж байгаа ард түмнүүдийн ахуй амьдралын төсөөтэй болон ялгаатай байдлыг таниулах, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах, түгээж сурталчилсан.

2.6.3.Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацийн салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ:

2.6.3.1.монгол хэл, соёлыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх “Монголын соёлын төв”-ийг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагыг түшиглэн байгуулна.

Биелэлт: “Монгол Үндэсний үнэлэмж” цогц арга хэмжээ, “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээний төслийг тус тус боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэлийг ханган ажиллаж байна. Хилийн чанад дахь “Монголын соёлын төвүүд” болон сургуулиудыг дэмжих асуудлаар санал боловсруулж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар 10 улсад 42 монгол хэл, соёлын сургууль болон төв үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны дэргэд Монголын соёл, мэдээллийн төвийг байгуулан үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр нээсэн.

2.6.3.2.олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ.

Биелэлт: ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр 2021-2022 оны хичээлийн жилд Монгол Улсаас 550 оюутныг суралцуулахаар шийдвэрлэсний 15 хуваарийг соёл, урлагийн чиглэлээр суралцах оюутанд хуваариалан сонгон шалгаруулав. 2022 онд ОХУ-д хөгжмийн зохиолч, хөгжмийн судлал, хөгжимчин, дуучин, зохиолч, барималч, зураач, соёлын менежмент чиглэлээр 15 оюутан амжилттай суралцаж байна. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёл, спорт, аялал жуулчлалын яамны 2022 оны албан ёсны хөгжлийн тусламжийн хүрээнд “Соёлын түншлэл” мэргэжил дээшлүүлэх сургалтад соёлын салбарын 13 албан хаагчийг хамруулж, албан хаагчид сургалтаар олж авсан арга зүйн хүрээнд соёлын бодлогын төсөл боловсруулж, хамгаалсан.

Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн хөгжлийн 2021-2024 оны хөтөлбөрийг тус тус боловсруулж байна. Соёлын төв, соёлын ордны үндсэн 5 мэргэжлийн ажилтнуудыг мэргэшүүлэх зорилгоор СУИС-тай хамтран 2 кредит тооцох богино хугацааны 5 өдрийн цахим сургалтыг зохион байгууллаа. Сургалтад номын сангийн чиглэлээр 298, соёлын өвийн 223, соёл, урлагийн менежментийн 419, хөгжмийн багшийн 272, бүжгийн багшийн 208, нийт 1420 соёлын ажилтнууд сургалтын динамик платформд хамрагдсан.

Монголын номын санчдын улсын 7 дугаар зөвлөгөөнийг 2020 онд зохион байгуулж, 170 соёлын ажилтныг мэргэжил дээшлүүлсэн. Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх институтын зураг төсөл боловсруулахаар ажиллаж байна.

2.6.3.3.үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.

Биелэлт: УИХ-ын 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Кино урлагийг дэмжих тухай хууль батлагдлаа. Хууль 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйлчлэхтэй холбогдуулан тус хуулийг дагалдан гарах Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, түүнд хяналт тавих журам болон бусад эрх зүйн актын төслийг боловсруулан, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулан, Засгийн газар болон сайд нарын хамтарсан тушаалаар батлуулахад бэлэн болоод байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, олон улсын болон төрийн бус байгууллага, үндэсний үйлдвэрлэгч нар болон бизнесийнхэн нэгдэн “Экспорт Монгол 2020” олон улсын цахим форум үзэсгэлэнг 12-р сарын 15-18-ны хооронд зохион байгуулахад хамтран ажиллаж, виртуалаар оролцуулж, олон улсын 47 орноор дамжуулан сурталчилсан.

Соёлын яам, Association-YATOO нийгэмлэг, Монголын Байгалийн Уран Бүтээлчдийн Холбоо хамтран “Дэлхийн Нүүдлийн Урлагийн Төсөл “GNAP-2020” олон улсын хөтөлбөрийг зохион байгуулж, уран бүтээлчдийн зургийн үзэсгэлэнг Франц, Монгол, Солонгос Улсад зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч Ковид 19 цар тахлын улмаас энэ жилийн хамтарсан үзэсгэлэн онлайн хэлбэрээр БНСУ-ын Гонжу хот, Улаанбаатар хотноо 2020 онд нээлтээ хийв. Үзэсгэлэнд Монгол, Солонгос, Франц, Австрали, Герман, Унгар, Итали, Индонез, Энэтхэг зэрэг 9 орны 20 гаруй уран бүтээлчдийн 80 гаруй бүтээл дэлгэгдсэн. Соёлын яамнаас санаачлан Б Контемпорари арт галерейтай хамтран зохион байгуулж буй “Алтан намар-2020” судалбар зургийн үзэсгэлэнг гурав дахь жилдээ МУЭ-ийн дэргэдэх Б Контемпорари арт галерей-д зохион байгуулагдлаа. Энэ удаагийн судалбар зургийн үзэсгэлэнд нийт 75 мэргэжлийн уран бүтээлчийн 170 гаруй бүтээл цугласнаас шилдэг 70 орчим бүтээлүүд дэлгэгдсэн.

Соёлын сайдын 2022 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн А/264 дугаар тушаалаар “Соёл урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, санхүүжилт батлах тухай” тушаалаар нийт 34 төсөлд 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах зорилгоор нийт 90 төсөл, арга хэмжээг “Монгол соёл – Монголын баялаг” нэртэйгээр тус бүр 40 минутын нийт 10 цуврал нэвтрүүлэг болгож МҮОНТ - ээр үзэгчдийн хүртээл болсон.

Кино урлагийн үндэсний зөвлөлөөс кино урлаг дэмжих сангийн төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар 2022 оны 09 дүгээр сарын 21-ээс 2022 оны 11 дүгээр сарын 21-ныг хүртэл 2 үе шаттай олон нийтэд нээлттэй зарласан. Төслийн сонгон шалгаруулалтыг зарлахдаа төрөл сэдвийн хувьд дараах байдлаар удирдамжид тусгасан байна. Үүнд: НЭГДҮГЭЭРТ Эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүжилтийн төслөөр хэрэгжүүлэх “Кино бүтээх” төсөл, ХОЁРДУГААРТ Эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн төсөл.

2.6.3.4.нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлж, бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадвар бүхий монгол брэндийг бий болгож соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

Биелэлт: “Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал байгуулах тухай” Монгол улсын ерөнхийлөгчийн 2005 оны 20 дугаар зарлигийн хүрээнд шинээр баригдах Үндэсний урлагийн их театрын хүний нөөцийн бодлогын хөтөлбөрт үндэсний их найрал хөгжлийн хөгийн судалгаа хийх бэлтгэл ажлыг эхлүүлсэн.

Мэргэжлийн урлагийн байгууллагын олон улсад өрсөлдөх уран бүтээлд дэмжлэг үзүүлэх хүрээнд Чингис хаан музейг олон улсад сурталчлах баримтат кино, Хүүхэлдэйн театрын Монгол Улсад анх удаа Puppet movie төрлөөр бүтээж буй бүрэн хэмжээний “Пөөдөө” хүүхэлдэйн кино, Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын “Жангар” хүүхдийн жүжигт санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ.

Улсын филарманийн “Симфони найрал хөгжим”-ийн зэмсгийг шинэчлэхэд зориулж нэг тэрбум 800 сая, “Морин хуурын чуулга”-д шаардлагатай 200 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргах тухай Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 128 дугаар тогтоолоор батлав. Худалдан авах ажиллагааны тендерийн ажил үргэлжилж байна. Үндэсний хөгжимчдийн “Гэрэгэ” анхдугаар уралдаан, “Грандпрайс” балетын олон улсын уралдаан, Г.Долгорсүрэнгийн нэрэмжит “Гоцлол бүжигчдийн уралдаан” зэргийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Олон улсад өрсөлдөх “Хотулун гүнж” түүхэн уран сайхны киног Берлиний ОУ-ын кино наадам болон “НордАрт 2022”, “Венецийн биенналь 2022”, “Каннын кино наадам”-д 70 уран бүтээлчийн 100 гаруй уран бүтээлд дэмжлэг үзүүлсэн.

2.6.3.5.соёлын удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, санхүүжилтийн олон эх үүсвэртэй, хүртээмжтэй, үр ашигтай механизмыг бүрдүүлэн соёлын үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэнэ.

Биелэлт: Соёлын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, жишиг соёлын төвийн шалгуур, стандартыг боловсруулж байна.

Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дэх соёл, урлагийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулахаар 2022 оны 12 дугаар сарын байдлаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар болон аймаг, нийслэлийн соёл, урлагийн газрын 23 даргыг томилон ажиллуулж байна.

2.6.3.6.иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд суурилсан соёлын өвийг хамгаалах үр ашигтай, тогтвортой механизм бүрдүүлж, соёлын биет болон биет бус өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж, цахим соёлын санг бүрдүүлнэ.

Биелэлт: “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг таньж тогтоох, бүртгэх журам”-д соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын ур чадвар, өвийг үеэс үед өвлөн уламжилсан байдал, төрүүлсэн шавийн тоо зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэж аймаг, нийслэлийн жагсаалт, үндэсний жагсаалтад оруулдаг болгох зохицуулалтыг нарийвчлан тусгахаар төсөл боловсруулж байна. “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д багтсан 102 өвлөн уламжлагч (2022 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 76 өвлөн уламжлагч амьд сэрүүн байна)-ийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах арга хэмжээг Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж байгаа “урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо” арга хэмжээнд улсын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар хамруулж байна. Тайлант хугацаанд өссөн дүнгээр 72 нь буюу 94.7 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан.

АНУ-ын Элчин сайдын нэрэмжит “Соёлын өвийг хамгаалах сан”-гийн санхүүжилтээр Чойжин ламын сүм музейн үл хөдлөх дурсгалт уран барилга болох Б.42.4 хувийн дугаартай “Ядам сүм”-ийг 2021-2022 онд иж бүрэн сэргээн засварлахаар болсон. Дээрх сэргээн засварлалтын ажлуудыг 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 8 дугаар сарын 30-ны өдөр дээврийн ажлыг бүрэн дуусгасан бөгөөд сэргээн засварлах ажлын гүйцэтгэл 90 хувьтай. Чойжин ламын сүм музейн сэргээн засварын ажил 2022 оны улсын төсөвт 1.7 тэрбум

төгрөгөөр батлагдсан бөгөөд 2022 онд зураг төсвийн ажил хийгдсэн. Сэргээн засварын сонгон шалгаруулалтын ажилд маргаан гарсан түр түдгэлзүүлсэн.

Хууль сахиулах байгууллагад соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх нэгж байгуулж, чадавх бэхжүүлэх зорилтын хүрээнд Соёлын яам, ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар хооронд 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр 4500435906 дугаартай гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна.

2.6.3.7.соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх зорилгоор хууль, эрх зүйн орчныг сайжруулна.

Биелэлт: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/315 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн бүтцэд “Түүх соёлын дурсгалт зүйлийн хууль бус эргэлттэй тэмцэх тасаг”-ийг 5 орон тоотой байгуулсан. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны “Албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу Соёлын яам, Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран 1 эрдэм шинжилгээний хурал, 1 уулзалт, зөвлөгөөн, 1 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 28 алба хаагчийг хамруулсан. Алба хаагчдыг сургалт, зөвлөгөөнд хамруулснаар тэдний соёлын өвийг хамгаалах мэдлэг ойлголт, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлсэн ач холбогдолтой болсон.

2.6.4.Хэвлэл мэдээллийн салбарыг үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх чиглэлээр хөгжүүлнэ.

Биелэлт: “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэхэд хэвлэл, мэдээллийн байгууллагын оролцоо, нөлөөлөл” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтаар “Хүний хөгжилд соёлын үзүүлэх нөлөө”, “Бүх нийтийн соёлын боловсролд сэтгүүлчдийн оролцоо”, “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үзүүлэх нөлөө”, “Нийгмийн соён гэгээрэл ба сэтгүүл зүй”, “Сэтгүүлч-нийгмийн сэтгэл зүйч” сэдвийн хүрээнд илтгэлүүд хэлэлцүүлж, санал солилцлоо. 2022 онд Соёлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд арилжааны болон өргөн нэвтрүүлгийн 74 телевизийн агуулгад үндэсний болон хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, контентын эзлэх хувийг тодорхойлох мониторинг судалгааг “Максима медиа” ХХК-аар гүйцэтгүүлсэн. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, иргэдийг соён гэгээрүүлэх 22 нэвтрүүлэг, контентийг өргөн нэвтрүүлгийн 10 гаран телевизээр нэвтрүүлсэн.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Санхүү, төсвийн зохицуулалт

3.1.Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.

3.1.1.Инфляцын зорилтот түвшин, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, валютын нөөцийн хүрэлцээтэй байдлыг нэмэгдүүлэх макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Инфляцын түвшин 2021 оны 2 дугаар улирлаас идэвхжиж, 2021 онд 13.4 хувь, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 13.2 хувьтай байна. Хилийн хязгаарлалт, хил

дээрх ачаа барааны бөөгнөрөл, малын гоц халдварт өвчний тархалт, тээврийн зардлын өсөлт, гадаад зах зээл дээрх тухайн барааны үнийн өсөлт зэрэг нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт инфляцын дийлэнхийг бүрдүүлж байна.

Засгийн газар богино, дунд хугацаанд экспортоос олох валютын бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ашигт малтмалыг олборлох, боловсруулах, тээвэрлэх бүх дамжлагуудад цахим төлбөрийн баримт үйлдэх, холбогдох бүх гэрээг татварын нэгдсэн системд бүртгэх, гаалийн автомат бүрдүүлэлтийн систем болон нүүрсний шинжилгээний лаборатори, ухаалаг гарцын байгууламж байгуулах, ашигт малтмалын олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд ашигт малтмалыг уурхайн ам нөхцөлөөр борлуулах шинэ гэрээ байгуулахыг зогсоох, Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэж байгаа хөрс хуулалт, тээвэрлэлтийн төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгүүлэх, ашигт малтмалын экспортын хэмжээ, валютын бодит орлогыг нэмэгдүүлэх чиглэлд төмөр замын тээврийг оновчтой зохион байгуулах, ашигт малтмалыг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулах уул уурхайн биржийн тогтолцоо, нэгдсэн цахим системийг бий болгохоор ажиллаж байна.

Монгол банк 2022 онд дунд хугацаанд инфляцыг зорилтот түвшин рүү бууруулах, төгрөгийн өгөөжийг өсгөх, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангах зорилгоор бодлогын хүүг үе шаттай нэмэгдүүлж 13 хувьд хүргэлээ.

Түүнчлэн Засгийн газар Монголбанктай хамтран Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын эсрэг “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байгаа ба Нөөцийн махны борлуулалтын хяналтыг сайжруулах, түгээлтийг хүртээмжтэй байдлаар зохион байгуулах чиглэлээр тус хөтөлбөрийн хүрээнд 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож байгаа бол Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 341 дүгээр тогтоолоор 2021 оны намрын ургацаас гурил, тэжээлийн үйлдвэрт улаанбуудай, дотоодын үйлдвэрт тосны ургамал худалдан авахад зориулан 150.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор болсон.

2022 оны 12 дугаар сарын гүйцэтгэлээр нийт албан нөөц 3.4 тэрбум ам.долларт хүрч, импортын 4.7 сарын нөөцийг хангахаар байна.

3.1.2.Эдийн засгийн эрсдэлээс сэргийлж, эдийн засаг өсөлттэй үед төсвийг тогтворжуулж, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

Биелэлт: Эдийн засгийн идэвхжил КОВИД-19 цар тахлаас үүдэн суларсантай холбоотойгоор Засгийн газраас төсвийн зардлыг нэмэгдүүлэх замаар нийт эрэлтийг дэмжиж, мөчлөг сөрсөн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн нь ДНБ-ний агшилтыг хязгаарлахад хувь нэмэр оруулж байна. Мөн Засгийн газраас цар тахлын үед аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй татвар, нийгмийн даатгалаас чөлөөлөх зэрэг арга хэмжээнүүд нь өрхийн хэрэглээг дэмжиж эдийн засгийн агшилтыг хязгаарлахад хувь нэмэр оруулж байна.

Засгийн газраас эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих бодлогын арга хэмжээнүүдийг 2021 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. УИХ-аар баталсан төсвийн хүрээний баримт бичигт төсвийн алдагдлыг ДНБ-ний -5.1, -3.6, -2.8 хувьд тус тус байхаар баталсан. Эдийн засгийн хямралтай үед иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор иргэн бүрт 300.0 мянган төгрөгийн мөнгөн дэмжлэг, коронавирусын вакцины бүрэн тундаа хамрагдсан иргэдэд 50.0 мянган төгрөгийн урамшуулал олгоод байна. 2021 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зардал өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар өссөн бөгөөд үүний хамгийн өндөр буюу 8.3 нэгж хувийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зарлагын өсөлт (998 тэрбум төгрөг) бүрдүүллээ.

2022 онд Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд үр дүнгээ өгч төсвийн алдагдал 60 хувиар буурч, хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж байна. Экспорт, гадаад худалдаа сайжирч байна. Засгийн газраас эдийн засгаа сэргээхэд чиглэсэн боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны нэгдүгээр улиралд -3.9 хувьд хүрч унаад байсан эдийн засаг оны эцэст 4.0 орчим хувьд хүрч сайжирсан.

3.1.3.Банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд хийж, банк, санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжиж, банкны зээлийн сарын хүүг 1 хувиас хэтрүүлэхгүй болгож, эрсдэл даах чадамжтай болгоно.

Биелэлт: Банкны салбарт олон нийтээс итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тус салбарын хүртээмжийг дээшлүүлэх, олон нийтийн оролцоог сайжруулах хүрээнд УИХ-аас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 1 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганаар хэлэлцэж, батлуулсан. Үүний үр дүнд банкны хувьцаа эзэмшигчийн давамгайлсан байдлыг хязгаарлах, олон нийтэд нээлттэй арилжих компанийн хэлбэрт шилжих, банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх хүлээлттэй байна. Иймд системийн нөлөө бүхий банкууд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр гэхэд олон нийтэд нээлттэйгээр арилжаалагдаж, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэхэд хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн дээд хязгаар 20 хувь байх хязгаарлалтыг хангасан байна. Арилжааны банкуудыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээс өмнө Монголбанкнаас эдгээр банкуудад активын чанарын үнэлгээг хийх шаардлага тавигдсаны дагуу банкуудын IPO хийх хугацааг нэг жилээр буюу 2023.06.30-ны өдөр хүртэл сунгах зохицуулалтыг УИХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн банк, Голомт банк олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжих анхдагч арилжааны нээлтээ Монголын Хөрөнгийн биржид хийн, хувьцаагаа олон нийтэд санал болгон, IPO амжилттай хийгээд байна. Арилжааны банкууд олон нийтэд нээлттэй хэлбэрт амжилттай шилжсэнээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, засаглалын хувьд илүү ил тод, нээлттэй болж, банкны салбар, хөрөнгийн зах зээл өргөжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, зохистой хөгжлийг дэмжих, харилцагч, хадгаламж эзэмшигчийн хууль ёсны эрхийг хамгаалах зорилгоор Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас баталсан.

3.1.4.Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.

Биелэлт: Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 49 дүгээр зүйлд тусгасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу тандан судалгаа, үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл зэргийг боловсруулж байна. Хуулийн төсөлд санхүүгийн түрээсийн салбарыг зохицуулагч этгээдээр Санхүүгийн зохицуулах хороог байхаар тусгасан бөгөөд тус асуудлаар салбарын оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулахад, заавал зохицуулагч этгээд байх шаардлагатай эсэх, байвал заавал СЗХ байх эсэх зэрэг зарчмын зөрүүтэй саналууд гарсан тул асуудлыг цааш судлах шаардлага бий болсон. Иймд хуулийн төслийг 2023 онд өргөн мэдүүлэхээр хойшлуулж шаардлагатай судалгааг хийж байна.

3.1.5. Санхүүгийн түрээсийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 49 дүгээр зүйлд тусгасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу тандан судалгаа, үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл зэргийг боловсруулж байна. Хуулийн төсөлд санхүүгийн түрээсийн салбарыг зохицуулагч этгээдээр Санхүүгийн зохицуулах хороог байхаар тусгасан бөгөөд тус асуудлаар салбарын оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулахад, заавал зохицуулагч этгээд байх шаардлагатай эсэх, байвал заавал СЗХ байх эсэх зэрэг зарчмын зөрүүтэй саналууд гарсан тул асуудлыг цааш судлах шаардлага бий болсон. Иймд хуулийн төслийг 2023 онд өргөн мэдүүлэхээр хойшлуулж шаардлагатай судалгааг хийж байна.

3.1.6. Иргэдийг санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх замаар мөнгө хүүлэлтийг таслан зогсооно.

Биелэлт: Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Монголбанкны ерөнхийлөгчийн 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А-6 тоот тушаалаар байгуулсан бөгөөд "Чанаргүй активыг бууруулах стратеги"-ийг хэрэгжүүлэх хүрээнд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэхгүй уддаг болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлд ажиллагаанд учирдаг хүндрэлүүдийг судалж холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Тус хуулийн төсөлд Санхүүгийн омбудсманы талаар санал авахаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд тус хуулийн төслийг УИХ-ын 2023 оны хаврын чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

3.1.7. Иргэн, хуулийн этгээд хөрөнгийн биржийн арилжаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан, цахим арилжааны дэд бүтцээр шууд оролцох боломжийг бүрдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан системийг нэвтрүүлж, арилжааг эхлүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын үнэт цаасыг блокчейн технологи дээр суурилсан платформаар зохион байгуулахаар "Юби Сток Эксченж" ХХК болон Хаанбанк, Төрийн банк, Голомт банкуудтай төстийн орчинд үүсгэн арилжааны системийг төстэлж дуусаж бодит төстийн орчинд арилжаа зохион байгуулах ажлууд бүрэн хийгдэж дууссан. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа зохион байгуулах талаар холбогдох тушаал, шийдвэр гараагүй тул 2022 оны байдлаар ямар нэгэн арилжаа хийгдээгүй болно.

3.1.8. Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийнэ.

Биелэлт: Хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахаар Засгийн газраас Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төсөлд хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлагыг ангилах, хангах, хэрэг гүйцэтгэгчийн томилох, чөлөөлөх, нэхэмжлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ,

хуралд оролцох саналын эрх, хуваарилагдах хөрөнгө, хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэхтэй холбогдсон асуудлыг нарийвчлан тусгасан. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2022.10.12-ны өдрийн хуралдаанаар тус хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн.

3.1.9.Хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэн Засгийн газрын өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын гадаад өрийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өрийн удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2019-2022 оны өрийн удирдлагын стратегид нийцүүлэн Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 102 дугаар тогтоолын дагуу олон улсын санхүүгийн зах зээлд жилийн 5.125% -ийн купонтой 5.5 жилийн хугацаатай 600.0 сая ам.долларын Номад бондыг 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр арилжаалж, 2021 оны 4 дүгээр сард төлөх Мазаалай бонд, 2022 оны 12 дугаар сард төлөх Чингис бондуудын тодорхой хэсгийг буцаан худалдан авсан. Дэлхий даяар тархаад буй Ковид-19 цар тахлын нөлөө Монгол Улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж буй энэ цаг үед Засгийн газар нь 2021 онд эргэн төлөгдөх 10.875 хувийн хүүтэй Мазаалай бондыг 5.125 хувийн бага хүүтэй шинэ бондоор сольж, жил бүр Засгийн газрын гадаад бондын хүүгийн зардлаас 26.7 сая ам.долларыг хэмнэх боломжтой болсон.

Засгийн газраас 2020 онд авч хэрэгжүүлсэн “Номад” өрийн зохицуулалтын арга хэмжээ, 2021 онд авч хэрэгжүүлсэн “Сенчири” өрийн зохицуулалтын арга хэмжээний үр дүнд 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр эргэн төлөгдөх хуваарьтай Чингис бондын хоёрдугаар транч болох 10 жилийн хугацаатай, 5.125 хувийн хүүтэй, нийт 1.0 тэрбум ам.долларын дийлэнх хэсгийг дахин санхүүжүүлж, үлдээд байсан 136.8 сая ам.долларын төлбөрийн эргэн төлөлтийг 2022 оны 12 дугаар сарын 5-нд бүрэн төлж барагдуулсан.

3.1.10.Гадаад худалдааг дэмжсэн гаалийн үйлчилгээг хялбаршуулж, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн хураахад чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

Биелэлт: Бараа бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан хувь хүн, хуулийн этгээдийн гаалийн импорт, экспортын мэдүүлэг болон цахим төлбөрийн баримтаар хэвлэсэн баримтын мэдээлэл бүртгэдэг болсон. Худалдан авалт борлуулалтын шат дамжлагад хяналт тавих, барааны үлдэгдэл тооцох боломжтой болсон бөгөөд ОАТ тэмдэгтийн захиалга бүрэн автоматжсан. Эм, эмийн бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийг ГЕГ-ийн гаалийн бүрдүүлэлтэд ашиглаж цахимаар мэдээлэл лавлах боломжтой болсон.

ОАТ тэмдэгтийн захиалга, Татвар төлөгч хүсэлтээ гаргах ТЕГ баталгаажуулалтын процессоор дамжин хэвлэх үйлдвэрлүү илгээгдэж хэвлэлтээс гарах процесс цахим болсон. Татвар төлөгч "и-баримт" аппликейшн ашиглан онцгой албан татвартай бүтээгдэхүүнд наасан QR кодтой тэмдэгтийг уншуулснаар гарал үүсэл, үйлдвэрлэсэн огноо, импортолсон огноо, ААН-ийн мэдээлэл шалгаж, хяналт тавих боломжтой болсон.

3.1.11.Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Татвар төлөгчийн бүртгэл, татварын тайлан, татварын төлөлт зэрэг татварын албаны үйл ажиллагаа нь бүрэн цахимжсан бөгөөд татварын үйлчилгээг ил тод, бүрэн цахим болгосноор татвар төлөгчийн цаг, зардлыг хэмнэх, татварын үйлчилгээг түргэн

шуурхай авах, цар тахлын үед халдвараас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм. 2020 оны 1 дүгээр сараас эхлэн газар, үл хөдлөх эд хөрөнгө, буу, авто тээвэр зэрэг хувь хүнд хамаарах бүхий л татварын нэхэмжлэлийг цахим төлбөрийн баримтын системээр хүргүүлэн, богино хугацаанд цахимаар, хялбар төлөх боломжийг олгоод байна.

"И-баримт" аппликейшн ашиглан үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, малын тоо толгойн албан татвар, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, газрын төлбөр, галт зэвсгийн албан татварын нэхэмжлэхийг цахимаар хүргүүлж, төлөх боломжийг бүрдүүлсэн.

3.1.12.Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ.

Биелэлт: Төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлж, төрийн албан хаагчийн орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд бүртгэлтэй 4200 төсвийн байгууллагын албан хаагчдын цалин хөлсийг байгууллагын нягтлан бодогч Төрийн албаны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС)-ээр тооцоолж эхлээд байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS системийг Фискал системтэй холбосноор гүйцэтгэгчид цахим системээр дамжуулан санхүүжилтийг шууд олгох ажил амжилттай хийгдэж, гүйцэтгэлийн санхүүжилтийг гүйцэтгэгчийн дансанд шууд шилжүүлдэг боллоо. Хуучин гүйлгээний процесс дунджаар ажлын 7-14 хоног байсан бол шинэ гүйлгээний процесс 20-30 минут болсон. ТЕЗ, байгууллага, гүйцэтгэгч тал санхүүжилтийн явцын талаар бүрэн мэдээлэлтэй болсон.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний жагсаалтыг ТЕЗ болон эх үүсвэрээр нэгтгэсэн. Нийт 15.5 их наяд төгрөгийн 111 төсөл, арга хэмжээний жагсаалтыг нэгтгэсэн. Үүнээс 13.6 их наяд төгрөгийн 82 зээлийн төсөл, 1.9 их наяд төгрөгийн 29 тусламжийн төслүүд байна. Нийтдээ 17 донор улс орон, олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, арга хэмжээнүүд байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг 2022 оны 11-р сарын 17-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг 2022 оны 11-р сарын 25-нд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан.

3.1.13.Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ.

Биелэлт: Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг тус тус боловсруулах ажлууд хийгдэж байна.

"Монголын үндэсний их сургууль" ХХК-ийн хуулиар хориглосон зар сурталчилгаа түгээсэн үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлийг оногдуулсан. "Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх талаар цахим сургалт"-ыг zoom аппликэйшн ашиглан 21 аймгуудын Засаг даргын Тамгын газрын 56 албан хаагчдад зохион байгуулсан.

3.1.14.Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн бодлого, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоно.

Биелэлт: Засгийн газраас цар тахлын үеийн эдийн засгийг эрчимжүүлэх, эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг ханган бэхжүүлэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого хэрэгжих суурь нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх зорилго бүхий “Шинэ сэргэлтийн бодлого”-ийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2021 оны 12 дугаар сарын 30-нд батлууллаа. “Шинэ сэргэлтийн бодлого” нь боомтын сэргэлт, эрчим хүчний сэргэлт, аж үйлдвэржилтийн сэргэлт, хот, хөдөөгийн сэргэлт, ногоон хөгжлийн сэргэлт, төрийн бүтээмжийн сэргэлт гэсэн үндсэн зургаан багц асуудлаас бүрдэх юм. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг амжилттай хэрэгжүүлснээр боомтын хүчин чадал гурав дахин нэмэгдэж, экспортлох бүтээгдэхүүний хэмжээ хоёр дахин өснө. Эрчим хүчний чадал 2.5 дахин нэмэгдэж, хөгжлийн мега төслүүд бодитой хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ. Эдгээр төслүүдийн үр дүнд 2025 он гэхэд 285 мянган ажлын байр шинээр нэмэгдэж, Улаанбаатарыг зорьсон их нүүдэл багасаж, хөдөө орон нутагт өндөр цалинтай ажлын байр олноор бий болж, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжил хангагдана. Дотоодын нийт бүтээгдэхүүн буюу эдийн засгийн хэмжээ хоёр дахин томорно. Эдийн засгийн цар хүрээ тэлэгдсэнээр хүний хөгжлийн зорилтууд хангагдаж, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ сайжирч, иргэдийг орон сууцжуулах асуудал шийдвэрлэгдэж, Монгол хүний цалин орлого нэмэгдэж, чинээлэг дундаж давхарга тэлж, амьдралын чанар эрс сайжирна гэж тооцсон.

Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийн нөхцөл байдлыг урьдчилан таамагласны үндсэн дээр хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, илүү таатай болгох эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулав. Хувийн хэвшлийн санхүүгийн санаачилгыг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх Үндэсний Нэгдсэн Санхүүгийн хүрээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор сангийн дэд сайдаар ахлуулсан, салбарын дундын Ажлын хэсэг байгуулан Монгол Улсын хөгжлийн бодлогыг санхүүжүүлж буй эх үүсвэрүүдэд үнэлгээ хийв. Түүнчлэн Монгол Улсад байгаа санхүүжилтийн боломж, эх үүсвэрүүдийг хэрхэн оновчтой болгох санал дүгнэлт боловсруулж, үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх стратегийн төслийг боловсруулан төр, хувийн хэвшил, судлаачдаар хэлэлцүүлж тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх Үндэсний Нэгдсэн Санхүүгийн Загварыг (INFF) нэвтрүүлэх замын зураглал хийж байна.

3.1.15.Дотоодын давхар даатгал хөгжих, урт хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ.

Биелэлт: Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүдийн үзэл баримтлал болон хуулийн төслийг эцэслэн боловсруулан олон нийтээс санал авах ажил хийгдэж байна. Хуулиудын төсөлд холбогдох саналуудыг тусгаснаар үндэсний давхар даатгалын тогтолцоог бэхжүүлэх, даатгалын салбарын оролцогчдод цахим дэвшилтэт техник технологид суурилсан даатгалын үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх, амьдралын даатгалыг хөгжүүлэх, заавал даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгох, технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, мэргэжлийн хөрөнгө оруулагч даатгагчдыг бий болгох, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин сайжрах зэрэг ач холбогдолтой.

3.1.16.Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгана.

Биелэлт: Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан тендерт оролцогчдын дараах мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтуудыг “Худалдан авах ажиллагааны цахим систем” /www.tender.gov.mn/-д бодит цагийн горимд авах боломжийг бүрдүүлэв. 2021 онд төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, худалдан авах ажиллагааны цахим системд холбогдсон мэдээллийн системийн тоог нэмэгдүүлэх, цахим системд бүртгэгдэж буй машин унших боломжтой өгөгдлийн тоог нэмэгдүүлж, нээлттэй өгөгдлийг түгээх, тендер шалгаруулалтын үнэлгээнд хүний оролцоог бууруулах арга хэмжээний хүрээнд “Худалдан авах ажиллагааны цахим систем” /www.tender.gov.mn/-д шүүхийн ерөнхий зөвлөлөөс олгодог шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолтыг цахимаар олгох ажлыг 2021.04.21-ний өдрөөс ашиглалтад оруулж, тендерийн үнэлгээг үнэн бодит мэдээлэлд тулгуурлан хийх боломжийг бүрдүүлэв.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл, дээд боловсролын баримт бичгийн мэдээлэл, Авто тээврийн үндэсний төвийн тоног төхөөрөмж, машин механизмын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг шинээр, хуулийн этгээдийн лавлагааг шинэчилсэн байдлаар ХУР системээр дамжуулан лавлаж, тендерийн үнэлгээнд ашиглах боломжийг бүрдүүлэх бэлтгэл ажил 95 хувьтай байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “ТА9158-MON: Засгийн газрын Худалдан авах ажиллагааг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Интерактив ХХК цахим каталогийн дэд системийг хөгжүүлэлтийн ажлыг дуусгасан. Тусгай зөвшөөрөл олгогч байгууллагуудаас 2021 оны 10, 11 дүгээр сарын байдлаар хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшиж буй компаниудын мэдээллийг гаргуулан авч, цахим системд оруулсан.

Хүний нөөц, тоног төхөөрөмж, машин механизмын нэгдсэн мэдээллийг цуглуулах ажил 70 хувьтай байна. Ижил төстэй ажлын гэрээний мэдээллийн нэгдсэн мэдээлэл болох гэрээний гүйцэтгэлийн мэдээллийг оруулах тухай зарлалыг тендерт оролцогч удаа хүргүүлсэн боловч тайлант хугацаанд Гэрээ байгуулсан 762, гэрээ байгуулах эрх олгосон 12874 тендер шалгаруулалт байгаа ба тайлант хугацаанд 11727 гэрээний мэдээлэл цахим системд бүртгэгдсэн байгаа нь 86 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд нийт 141 гэрээний 170 гүйцэтгэлийн мэдээлэл цахим системд бүртгэгдсэн байна. Дээрх мэдээллүүдийг цуглуулж дуусвал хиймэл оюун ухаанд суурилсан тендерийн үнэлгээ хийх ажлын гүйцэтгэл 85 хувьтай болно.

“Худалдан авах ажиллагааны цахим систем” /www.tender.gov.mn/-ийн гар утасны аппликэйшнг хөгжүүлэн PlayStore-д байрлуулсан. Тендерт оролцогчид шалгарсан оролцогчийн нууц биш тендерийн материалтай танилцах боломжийг бүрдүүлж, захиалагч байгууллага тендер шалгаруулалтын үр дүнг цаг хугацаанд оруулаагүй тохиололд тендерт оролцогчид шаардлага тавих, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр 2020 онд нийт 22604 тендер зарлагдсанаас 20685 нь “Үр дүн гарсан” төлөвтэй байгаа нь нийт зарласан тендер шалгаруулалтын 91,5 хувийг эзэлж байгаа ба 2019 оны мөн үетэй харьцуулахад 2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн шалгарсан 1619 тендерт оролцогчийн нууц биш 9281 тендерийн материалыг 1459 тендерт оролцогч нийт 22186 удаа үзэж танилцсан байгаа ба нь 2019 оны үзүүлэлттэй харьцуулахад 46 дахин өссөн үзүүлэлттэй байна.

3.1.17.Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.

Биелэлт: “Замын-Үүд” чөлөөт бүсийн дулааны станцыг байнгын ашиглалтад оруулахад шаардлагатай 1.5 тэрбум төгрөгийг Засгийн газрын 2021 оны 179-р тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас гарган, ашиглалтад оруулсан. Улсын төсвийн 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Замын-үүд” чөлөөт бүсийн “Харуул хамгаалалтын нэгдсэн систем”-ийг барьж байгуулав.

“Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн 35 КВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын ТЭЗҮ боловсруулах ажлыг 2022 онд гүйцэтгэхээр 1 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн тендер зарлагдаж, барилга угсралтын хийгдэж байна.

“Цагааннуур” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах гэрээт ажлыг гүйцэтгэж байна. Цагааннуур чөлөөт бүсийн хажуугаар Ази, Европыг холбосон АН-4 олон улсын авто зам дайрч өнгөрдөг бөгөөд бүсээс Цагааннуур боомт хүртэлх 22.8 км авто замыг 2022 онд дуусгахаар ажиллаж байна. 2021 оны байдлаар тус бүсэд үйл ажиллагаа явуулахаар 9 аж ахуйн нэгж бүртгэлийн гэрчилгээ авсан.

3.1.18.Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэнэ. Хилийн заставуудын барилга, объектуудыг шинэчилж чанарыг сайжруулна.

Биелэлт: Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Боршоо, Шивээхүрэн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор боомтын бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна. Мөн ОХУ-тай хиллэдэг 3, БНХАУ-тай хиллэдэг 7 буюу нийт 10 боомтыг шинээр өргөтгөн шинэчлэхээр төлөвлөсөнтэй холбогдуулан гаалийн байгууллагаас зураг төслийн компаниудтай хамтран ажиллаж, тухайн боомтуудад баригдах барилга байгууламж болон байрлуулах гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн тоо, байрлалыг тогтоосон. Хилийн боомтоор нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх, мөн хилийн хяналтын албан хаагч нарын оролцоог багасгах зорилгоор автозамын хилийн боомтуудад орчин үеийн тоног төхөөрөмж суурилуулахаар төлөвлөсөн. Үүнд:Рентген: 5-12 км цагийн хурдтай явж байгаа тээврийн хэрэгсэлд ачсан барааг шалгах эхний ИСБ-А рентгенийг Шивээхүрэн боомтод суурилуулсан. Ухаалаг гарцын систем: Гашуунсухайт боомтын ойролцоо байгуулагдсан чингэлэг терминал гаалийн хяналтын бүсэд ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор улсын хилээр орох, гарах чиглэлд тус бүр 1 буюу нийт 2 эгнээ замд ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг сайжруулахаар ажиллаж байна. Түүнчлэн хилийн боомтын шинэчлэл төслийн хүрээнд гаалийн нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад болон дотоод эх үүсвэрээс тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийхэд 120,0 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөсөн. 2022 оны 11-р сарын 22-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргаж, барьцаа хөрөнгийн данснаас 5 тэрбум төгрөг чөлөөлсөн.

2020 онд “Замын-Үүд боомтын шугам сүлжээ /Дорноговь, Замын-Үүд сум/” төсөлд 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. 2021 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын багцад “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төсөл, хилийн боомтын дэд бүтцийн хүрээнд хийгдэх ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв /Улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээнд 5.0 тэрбум төгрөг батлагдаж 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2020 онд улсын төсвөөс “Гаалийн боомтуудыг шилэн кабельд холбох /Улсын хэмжээнд/” төсөлд 3.0 тэрбум төгрөг олгосон бөгөөд 2021

оны төсвийн тухай хуульд 2.5 тэрбум төгрөг батлагдаж 12-р сарын 30-ний өдрийн байдлаар санхүүжилтийг бүрэн олгосон байна.

3.1.19.Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулна.

Биелэлт: Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аар 2021 оны 12-р сарын 17-ны өдөр батлуулав. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Замын-Үүд, Эрээний Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хэлэлцээр”-ийг УИХ-аар 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр соёрхон батлуулав.

3.1.20.Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна.

Биелэлт: “Экспортын баталгааны сан” байгуулах боломжийн талаарх судалгааг Дэлхийн банкны санхүүжилттэй “Экспортыг дэмжих төсөл” болон Европын Холбооны санхүүжилттэй “StepEcoLab төсөл”-тэй хамтран ажиллаж байна. Дэлхийн банкны санхүүжилттэй “Экспортыг дэмжих төсөл”-өөс жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг сайжруулах, санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх зорилгоор Түншлэлийн хөтөлбөрийг ЖДҮГ-тай хамтран хэрэгжүүлэв. 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар тус хөтөлбөрт хамрагдахаар нийт 43,1 тэрбум төгрөгийн 203 хүсэлт ирүүлснээс шаардлага хангасан 8,2 тэрбум төгрөгийн 38 төсөл дэмжигдэж, 37 төсөлтэй түншлэлийн гэрээ байгуулаад байна.

Уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилттэй Экспортыг дэмжих төслийн хүрээнд Үндэсний Давхар Даатгал ХК-тай хамтран Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Судалгааны ажилд үндэслэн, даатгуулагчид үүсэх эрсдэлээс хамгаалж олон улсын давхар даатгалын 12 компанид хамтран ажиллах хүсэлт хүргүүлснээр Францын олон улсын давхар даатгагч SCOR групп хүлээн авч, Үндэсний Давхар Даатгал ХК-тай экспортын худалдааны зээлийн хувь тэнцүүлсэн давхар даатгалын гэрээг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 1 жилийн хугацаатай байгуулж, SCOR групп гэрээний хариуцлага болон хураамжийн 80.0, Үндэсний Давхар Даатгал ХК 20.0 хувийг тус тус хариуцсан. Экспортын зээлийн даатгалын үйл ажиллагааг хамтран явуулах зорилгоор Үндэсний Давхар Даатгал ХК нь Бодь даатгал, Миг даатгал ХХК-тай давхар даатгалын мастер гэрээ байгуулав. Санхүүгийн зохицуулах хороо зах зээлд нэвтрүүлэхээр “Экспортын зээлийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр бүртгэв. Экспортод гаргаж буй бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор экспортод бүтээгдэхүүнээ гаргасан “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Зээлийн хүүгийн татаас олгох” журам боловсруулж байна.

3.1.21.Нийслэлээс 1000 км-ээс дээш алслагдсан бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд 10 дахин бага буюу 1 хувийн татвар төлөх хуулийн хөнгөлөлтийг үргэлжлүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг санхүү, татварын бодлогоор дэмжиж, бүсийн нэмэгдэл олгоно.

Биелэлт: УИХ-ийн 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар ААНОАТ-н хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж "аймаг, сумын төв нь нийслэл /Улаанбаатар/ хотоос 550 км-ээс хол байршилтай аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, бүртгэлтэй, орон нутгийн төсөвтэй харьцдаг, гурваас доошгүй ажлын байр бий болгож байгаа албан татвар төлөгчийн орлогын албан татварыг 550 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар" хөнгөлөх гэсэн заалтыг оруулсан болно. Хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй Татварын ерөнхий газраас нийслэл хотоос 550 км болон түүнээс хол алслагдсан аймаг, сумын төвийн байршил, зайн хэмжээ болон олон улс, улсын чанартай авто замын чиглэлийн мэдээллийг орон нутгийн татварын албадад хүргүүлж, хууль хэрэгжүүлэх талаарх сургалтыг орон нутгийн татвар төлөгч, татварын улсын байцаагч нарт танхимын болон онлайн хэлбэрээр зохион байгуулсан.

3.1.22.Хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

Биелэлт: Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх тухай хуулийн хүрээнд 889,356 иргэнийг 209.4 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлсөн байна.

Уул уурхай, хүнд үйлдвэр

3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.

3.2.1.Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ:

3.2.1.1.Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулна.

Биелэлт: Ашигт малтмалын тухай хуулийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу “Оюутолгойн далд уурхайн хүдэр тээвэрлэх шугам /үе шат1/-ыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах” тухай техникийн ажлын хэсгийг 2021.02.05-ны өдөр ажиллуулж, Оюутолгойн далд уурхайг Улсын комисс ашиглалтад бүрэн хүлээж авах хүртэл үйлдвэрлэлийн зориулалтаар түр ашиглах нь зүйтэй дүгнэлтийг гаргасан болно.

Оюу Толгой төслийн гүний уурхайн бүтээн байгуулалтын зардал хэтэрсэн, гүний уурхай ашиглалтад орох хугацаа хойшилсон асуудлаар хөндлөнгийн шинжээчдийн багийг сонгон ажиллуулсан. Тус багийн зүгээс 2021.08.03-ны өдөр шинжээчийн дүгнэлтийг хүлээлгэн өгсөн болно. Дүгнэлтээр Оюу толгойн далд уурхайн зардал хэтэрсэн, хугацаа хойшилсон шалтгааныг геотехникийн хүндрэлээс болоогүй гэж дүгнээд байна. 2022 оны 12-р сарын 30-ны байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-90 хувь, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-100 хувь, далд уурхайн бүтээн байгуулалт 84 хувьд хүрсэн.

3.2.1.2.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: 2022 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ийн хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 80%-д хүрсэн. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 93%-тай. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100%-д хүрсэн. Засварын механикийн заводын ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хэлэлцүүлж хүлээн авсан. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл 80%-тай байна.

3.2.1.3.Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулна.

Биелэлт: Техник эдийн засгийн үндэслэлийн тодотголыг бэлтгэсэн. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зорилгоор уулзалт, хэлэлцээрүүд хийгдэж байна. Цар тахлын улмаас төлөвлөгдсөн ажлууд хойшлогдсон. Бүтээн байгуулалтын ажил 69 хувьд хүрсэн. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

3.2.1.4.Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг бууруулна.

Биелэлт: Багануурын нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэл 51 хувь буюу 2020 оны гүйцэтгэл 100 хувь, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36 хувь буюу 2020 оны ажлын гүйцэтгэл 100 хувьд тус тус хүрсэн. 2022 оны байдлаар Багануурын нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50 хувь, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 35 хувьд хүрсэн ба цар тахал болон санхүүжилтийн улмаас зарим төлөвлөгдсөн ажлууд хойшлогдсон.

3.2.1.5.Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ.

Биелэлт: Туршилт судалгааны ажил 30 хувь, зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтыг 60 хувь, дэд бүтэц, бэлтгэл ажлын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 7 хувьд тус тус хүрсэн. Ордын хэмжээнд 5000 га талбайд М 1:2000 гадаргын бүрэн зураглал хийх, тусгай зөвшөөрлийн хил хязгаар тогтоох шав тэмдэг тавих тендерийн баримт бичиг, техникийн даалгаврыг боловсруулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна. Нөөцийн категорийг өнөөгийн нөөцийн ангилалд нийцүүлэх ажил хийгдсэн.

3.2.1.6.Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна.

Биелэлт: Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын “Чайна металлуржикал инженеринг компани” /СМЕС/ боловсруулж 2021 оны 4 сарын 1-ний өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Уурхайд 86 тэрбум төгрөг бүхий 23 ш техник, тоног төхөөрөмжийг худалдан

авсан. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэлтийн хөрөнгө оруулалт 7 хувьд хүрсэн. Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл 20 хувьтай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Ачилтын нэгдсэн төв байгуулах ажил 44.9 хувьд хүрсэн. Загийн усны хоолойн гүний усны ордоос Тавантолгой уурхай хүртэл 70 км шугам хоолой татах трассыг баталгаажуулан захирамж гаргасан. Ус хангамжийн системийн зураг төсөл боловсруулах ажил дууссан ба төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж, төслийн нийт гүйцэтгэл 69.7 хувьд хүрсэн.

3.2.2.Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ:

3.2.2.1.Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана.

Биелэлт: “Эрдэнэс сильвер ресурс” ХХК-ийн Дундговь аймгийн нутаг дахь Салхитын мөнгөний ордыг ил аргаар ашиглах уурхай 2020 оны гүйцэтгэлээр 209.3 мян.тн хүдэр олборлож, 105.9 мян.тн хүдэр баяжуулж, 1944.2 тн баяжмал үйлдвэрлэж, нийт 101.1 тэрбум төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан байна. Цаашид тус компанийн зүгээс Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах хүрээнд жилд 300 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилгын материалын захиалгыг хийсэн. 2021 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэх ажил 80 хувь. Салхитын мөнгөний ордын нөөцийг нэмэгдүүлж, ордын насжилт өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны хайгуулын ажлын хүрээнд хийгдсэн геологи хайгуулын нарийвчилсан ажлын үр дүнд ордын нөөцийг бодитой ба боломжтой /В+С/ зэрэглэлээр 3,169,815.5 тонн хүдрийн нөөцийг ЭБМЗ-ийн 2021.04.15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлэв. 2022 оны 10-р сарын байдлаар 92.6 мян.тн хүдэр олборлож, 33.5 мян.тн хүдэр, 1.97 мян.тн баяжмал борлуулж, 45.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.

3.2.2.2.Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна.

Биелэлт: Зүүн Цагаан Дэлийн орд газрыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг (тодотгол) боловсруулж ЭБМЗ-ийн 2021 оны 4-р сарын 13-ны өдрийн хурлаар шийдвэрлүүлсэн. Далд уурхайг ашиглах ТЭЗҮ, БОННУ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгал орчны менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг боловсруулан батлуулсан. Цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5 км түр агаарын шугамыг барьсан. Уурхайн налуу ам 80 м нэвтэрсэн ба 2021 оны эцэст нэвтрэлтийн хэмжээ 120м-130м-т хүрсэн. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан. Далд уурхайн налуу гол амны малталт нэвтрэлтийн ажлыг эхлүүлэн 2022 оны 10 дугаар сарын байдлаар 1043,0 у.м уулын ажил хийж 82 хувийн гүйцэтгэлтэй, дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих болон кэмпийн барилга байгууламжийн ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Зүүн цагаан дэлийн далд уурхайн эхний ээлжийг 2022 оны 09-р сарын 28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгөөд байна.

3.2.3.Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлэх хүрээнд 2020 онд шинээр Овоот толгой-50, Улаангом-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Хар хайрхан-50, Их бэрх уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Их хараат уул-50, Үнэгт уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, нийт 12 төслийг шинээр хэрэгжүүлж эхэлсэн. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг К

хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг нутаг дэвсгэрийн 220,395 кв.км талбайд буюу 14 хувьд хийж дууссан. Монгол орны баруун хэсэгт буюу 104,044.0 кв.км талбай /6.6%/-г хамарсан агаарын геофизикийн 1:200000-ны масштабын 5 сувгийн судалгааны ажил хийгдэж байна. 2020 онд Монгол орны төв, зүүн хэсэгт буюу L-47, 48, 49, M-47, 48, 49 хавтгайд хээрийн судалгааны дээжлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд ингэснээр судалгааны талбайн 65 хувьд хээрийн судалгааг гүйцэтгэсэн.

2021 онд Цахир мушгиа уул-50, Олон гол-50, Номгоны нуруу-50, Худгийн нуруу-50 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Ингэснээр 14,278.29 км² талбай буюу 0.91 хувь, нийтдээ 41.97 хувийг судалгааны ажилд хамруулаад байна. Эдгээр 4 төслийн судалгааны үр дүнд алтны шороон илрэл Хуурай сайр (P2 зэргээр 224.19 кг), Угалзын худаг (P2 зэргээр 1524.1 кг), Дөшийн ам (P3 зэргээр 80 кг), Баян тохой, Цагаан толгой, Их Номгон, зэсийн Урт булаг, Ил худаг, холимог металлын Буйлст, элсний Угалзын ам, шаврын Зуух булаг (P1 зэргээр 232.8 мян.тн), Ширээ тээг (P1 зэргээр 26.1 сая тн) зэрэг ашигт малтмалын хэтийн төлөвтэй 20 талбайг ялгасан.

2022 онд агаарын соронзон болон спектрометрийн өндөр эрчимжилтэй гажлуудыг 14 талбайд шалгах газрын геофизикийн хэмжилтийн ажлыг төлөвлөн, геологийн маршрут, соронзон орон ба цацраг идэвхижилийн судалгааг төлөвлөсөн хэмжээнд хийсэн. Мөн петрофизикийн дээжүүд авч лабораторид шинжлүүлэхээр өгсөн ба ингэснээр төслийн хээрийн судалгааны ажил дуусгавар болсон.

3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.

Биелэлт: Геомэдээллийн сан хөтөлбөрийн хүрээнд бүх төрлийн геологийн судалгааны ажлын явцад авсан чулуун дээжийг цэгцлэх, мэдээллийн сан үүсгэх болон геологийн баримтын төв архивт хадгалагдаж байгаа анхдагч баримт бичгүүд, цаасан тайланг цахим архивт оруулах зорилгоор Геологийн баримт-1, Цахим архив-1, Чулуун дээжийн сан-1 төслүүдийг хэрэгжүүлэхээр тооцоо, судалгааг хийн бэлтгэл ажлыг хангаж байна, төслүүдийг 2022 оны 11 дүгээр сард сонгон шалгаруулалт зарлаж, шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах шатанд байна. Төрийн цахим мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож, хөгжүүлэх зорилтын хүрээнд байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа геологийн чиглэлээр хийсэн 21 салангид мэдээллийн сангуудыг нэгтгэн, Геомэдээллийн нэгдсэн сангийн байгууллагын дотоодод болон олон нийтэд мэдээлэл түгээх портал хөгжүүлэх ажил хийгдэж байна.

3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.

Биелэлт: Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших 245.01 кв.км талбайд үнэт, холимог металлын чиглэлээр эрэл-үнэлгээний ажил (ЭҮ-1-2020)-ыг шинээр хэрэгжүүлж 2020 онд хээрийн судалгааны ажлын анхдагч баримт материалыг хүлээн авсан. 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн “БӨМ-Алт-2019”-ын 2020 оны А/322 дугаар тушаалаар, 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн 2021.03.29-ний өдөр хэлэлцсэн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2021.05.20-ны өдрийн А/124, А/138 дугаар тушаалаар батлаж ажлыг эхлүүлсэн.

2020 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 6 багцаар 53 талбай зарласнаас 27 хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон бол 2021 онд 10 багц талбайг зарлаж 109 тусгай зөвшөөрөл олгосон байна. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон

шалгаруулалтаар Улсын төсөвт 2020 оны жилийн эцсийн байдлаар 4.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бол 2021 онд 29.6 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.

2021 онд Ашигт малтмалын хайгуулын ажлын 104 тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн алт /үндсэн/ 76,433.75 мян.тн/кг металлаар, алт /шороо/ 3,799.34 кг металлаар, мөнгө 862.01 мян.тн/тн металлаар, зэс 65,749.25 мян.тн/тн металлаар, төмөр 1,366.17 мян.тн хүдрээр, никель 15,918.09 мян.тн/тн металлаар, вольфрам 2,147.29 мян.тн/тн металлаар, кобальт 1,501.36 тн металлаар, хайлуур жонш 974.31 мян.тн металлаар, манган 97.06 мян.тн металлаар, чулуун нүүрс 195.06 сая тн, шохойн чулуу 249.8 сая.тн, дайрга 68.7 сая м3, бал чулуу 1,057.73 мян.тн, гөлтгөнө 161.22 мян.тн, занар 21,976.5 мян.м3, лити 713.15 мян.тн металлаар, стронци 831.74 мян.тн, кали 20,685.47 мян.тн металлаар, молибден 21,211.56 мян тн/тн металлаар, цагаан тугалга 290.06 тн металлаар, кварц 465.21 мян.тн, гантиг 5,274.15 мян.м3, элсэн чулуу 56,877.52 мян.м3, элс 5,740.11 мян.м3, шавар 5,736.63 мян.м3, элс-хайрга 1,627.04 мян.м3, газрын тос 1.04 сая баррель-ийг улсын нэгдсэн санд бүртгэн нөөцийг өсгөсөн.

Шинэчилэн батлагдсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох хууль эрх зүй, талбайн геологийн мэдээлэл болон цахим хэлбэрээр явуулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан бөгөөд 25 талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгохоор 2022.11.23-ны өдөр tender.gov.mn платформ-оор зарласан. Цаашид 7 хоног тутамд 25 талбайг дээрх платформоор дамжуулан зарлахаар бэлтгэл ажлыг хангасан.

3.2.6.Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.

Биелэлт: Ашигт малтмалын тухай хуулийн шинэчлэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар батлуулан, эцэслэн боловсруулаад байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалтын журмын төслийг боловсруулан Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж, журам батлах эрхийг УУХҮСайдад олгосон. “Зарим орон нутагт Эрдэс баялгийн нэгж байгуулах тухай” асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай инженер, техникийн ажиллагсадыг бэлтгэх ажлын хүрээнд “Газрын тосны инженерчлэл” бакалаврын хөтөлбөрт БШУСайдын 2022.05.09-ний өдрийн А/160-р тушаалаар 072407 тоот индекс авсан. Энэхүү хөтөлбөрийг 2022-2025 онуудад хэрэгжүүлэх бөгөөд 2022-2023 онд инженерийн чиглэлээр элссэн оюутнуудыг 4 жилээр, инженерийн чиглэлээр сурч байгаа 2-р дамжааны оюутнуудыг 2.5 жилээр, инженерийн суурьтай төгсөгчдийг 2 жилээр сургах бөгөөд 2022 оны 9 дүгээр сараас элсэлт авахаар төлөвлөж байна.

3.2.7.Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ:

3.2.7.1.хар төмөрлөгийн /кокс, ширэм, шууд ангижруулсан төмөр/ үйлдвэрлэлийг Дархан-Уул, Орхон, Дорноговь аймагт хөгжүүлнэ.

Биелэлт: Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийн техник-эдийн засгийн үндэслэлийг Канад Улсын “Hatch” компани гүйцэтгэн 2017 онд, “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ”-г Монгол

Улсын “Экотон” ХХК болон “Ажид” ХХК, “Экосфер” ХХК-иуд гүйцэтгэж 2019 онд тус тус хүлээлгэн өгсөн.

- Ган бөмбөлгийн цувих үйлдвэр барих талбайн инженер геологийн судалгаа;

- 25000 тн/жил хүчин чадалтай ган бөмбөлгийн давтах аргын үйлдвэр;

- 6 кв-ын цахилгаан дамжуулах кабелийн шугам, 6 кв-ын хуваарилах байгууламж, 6/0.4 кв-ын 2х2500 кВА чадалтай дэд станцын барилга;

- Бэлдэц үйлдвэрлэх цех дэх 25 тн багтаамжтай шанаган зуухны тоног төхөөрөмж;

- Бэлдэц үйлдвэрлэх цехийн 6/0.4 кв-ын 1600 кВА дэд станц, үйлдвэрийн 110/22/6.6/6 кв-ын Төмөрлөг дэд станцыг 110/22 кв-ын 6.3 МВА дэд станцаар өргөтгөсөн өргөтгөл, 22кв-ын цахилгаан дамжуулах кабелийн шугам, барилга;

- Хаягдал төмрийг боловсруулах пресс хайчны тоног төхөөрөмжийн угсралт;

- Цахилгаан соронзон холигч, хэлбэлзүүлэгч ширээ, зэс талсжуулагч шинээр суурилуулах ажлыг 2019 оны 3 дугаар сард эхлүүлсэн бөгөөд туршилтын ажлыг хийж 4 сард ашиглалтад оруулсан. Төслийн хүрээнд дээрх бүтээн байгуулалтын ажилд нийтдээ 630.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээд байна. Төслийн явц 75 хувьтай байна.

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн хэрэгжүүлж байгаа төслийн технологи өөрчлөгдөх нөхцөл байдал үүсч өмнө сонгосон технологиос хөрөнгө оруулалт 3 дахин бага, цахилгаан эрчим хүчний зарцуулалт мөн 3-4 дахин багатай технологи болох “Мини домен зуух бүхий гангийн үйлдвэр байгуулах” ТЭЗҮ-ийг шинээр боловсруулах ажлыг БНХАУ-ын металлургийн инженерингийн компани болох “MCC-CERI” компаниар /712.5 сая төгрөг/ гүйцэтгүүлж, 2021 оны 5 дугаар сард хүлээн авсан. Урьдчилсан төлөвлөгөөгөөр нийт 400 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар 350 мянган тонн ган бүтээгдэхүүн /жилд арматур-200 мян.тн, круг-80 мян.тн, булан төмөр- 40 мян.тн, төмөр утас- 30 мян.тн/ үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 2024 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

“Бэрэн групп” ХХК нь 2014 оноос 200 мян.тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх домен зуух-хүчилтөрөгчийн конвертор-цахилгаан нуман зуух-шанаган зуух-тасралтгүй цутгах машин-цувих гэсэн тасралтгүй ажиллагаатай ган үйлдвэрлэлийн циклийг бий болгох зорилгоор Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж байгаа ба төслийн хэрэгжилт 70 орчим хувьтай байна.

3.2.7.2.Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулна. Паркийн бүрэлдэхүүнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр болон исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэсийн үйлдвэр байгуулна.

Биелэлт: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь үйлдвэрлэсэн зэсийн баяжмалаа тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор зэсийн баяжмал хайлуулан, боловсруулах металлурги-химийн үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулахаар БНХАУ-ын ENFI болон NFC консорциумтай 2019 оны 9 сарын 25-ны өдөр 5/289-19 тоот гэрээ байгуулж, 2020 оны 9 дүгээр сард ТЭЗҮ-ийн эцсийн тайланг хүлээн авсан. Үйлдвэрийн холбогдох инженер, техникийн ажилтнууд тус үйлдвэрлэлийн туршилтын техникийн даалгавар, гэрээний нөхцөл зэрэг баримт бичгийг боловсруулж, туршилтыг гүйцэтгэх “China ENFI Engineering” компани (тус технологийн цорын ганц патент эзэмшигч)-тай 6/005-21 тоот гэрээг 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулан ажиллаж байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ тус гэрээний дагуу “China ENFI Engineering” компанид 2021 оны 5 дугаар сард урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэн. “China ENFI” компани туршилтын үйлдвэр барьж байгуулах ажлын явцын талаар 2021 оны 12-р сарын 31-ний өдөр сүүлийн тайланг ирүүлсэн. Тайланд дурдсанаар зураг төслийн ажил 85 хувийн гүйцэтгэлтэй, тоног төхөөрөмжийн худалдан авалт 75 хувьтай байна. Үйлдвэрлэлийн туршилтын ажлын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, зохион байгуулалтын оновчтой арга хэмжээ авснаар 2023 оны 06 дугаар сард дуусгах

боломжтой гэж үзэж, энэ талаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр ENFI компанид албан бичгээр мэдэгдсэн байна. 2022 оны 11 дүгээр сарын 01 өдөр зохион байгуулсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын удирдлага, холбогдох мэргэжилтнүүд China ENFI Engineering (ENFI)-ийн Дэд ерөнхийлөгч болон бусад холбогдох төлөөлөл оролцсон цахим хурлаар үйлдвэрлэлийн туршилтын ажлыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн.

Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн үйлдвэрлэл, технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, техник, технологийн үнэлгээ хийлгэх, паркийн геоэкологи, гидрогеологийн судалгаа гүйцэтгэх ажлыг тайлант хугацаанд зохион байгуулсан. Мөн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гүйцэтгэх ажлыг зохион байгуулсан. Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. “SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зохион байгуулж, “Майнинг шорт лонг терм” ХХК-тай 2021 оны 9-р сарын 17-нд гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч байгууллагын мэргэжилтнүүд Эрдэнэт үйлдвэр дээр ажиллаж туршилтын дээж авч ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

3.2.7.3. үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна.

Биелэлт: “Эрдэнэс Алт ресурс” ХХК төслийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2020 онд дараах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- БОАЖЯ-ны Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар төслийн Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсан;

- Япон улсын хөрөнгө оруулалтын SBI групптэй төслийн хөрөнгө оруулалтын асуудлаар уулзалт, хэлэлцээр хийж, харилцан мэдээлэл солилцож байна;

- Үйлдвэрийн барилгын зураг төсөл, төсөв болон Төслийн инженер-геодезийн зургыг боловсруулсан.

Бүгд Найрамдах Казахстан Улсын “Сымбат инженеринг” ХХК нь алт цэвэршүүлэх үйлдвэр барихад шаардагдах санхүүжилтийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжтойг уламжилсан саналд “Эрдэнэс алт ресурс” ХХК нь санал болгож буй хөрөнгө оруулалтыг хүлээн авч бүх талаар хамтран ажиллах саналаа 2022.08.31-ний өдрийн EA22/65 албан бичгээр илэрхийлсэн. Мөн үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн төсөлд оролцох саналаа илэрхийлсэн БНХАУ-ын уул уурхайн тоног төхөөрөмжийн Шинхай компанийн төлөөлөлтэй төслийн хөрөнгө оруулалт, хүчин чадал, өртөг зардлын талаар цахим уулзалтыг хийв.

3.2.7.4. үнэт металлын сорьц тогтоох салбар лаборатори байгуулж, үнэт металлыг сорьцлох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл, ажиллагааг өргөжүүлж иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Үнэт металлын сорьц тогтоох салбар лаборатори байгуулах байршлыг тогтоох, судалгааны шинжилгээг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хийж байна. 2020 оны жилийн эцэст давхардсан тоогоор 3794 аж ахуйн нэгж, иргэдэд ажил үйлчилгээ үзүүлж, 20,2 тн алтны, 3,7 тн мөнгөний сорьц тогтоох шинжилгээ хийж 2 тэрбум 546 сая 600 мянган төгрөгний үндсэн орлого (301 хувь), 2 сая 90 мянган төгрөгийг нэмэлт орлого (116 хувь) улсын төсөвт төвлөрүүлсэн нь түүхэн дээд амжилт болсон. Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр алт хайлах зуух шинээр худалдан авсан (Итали- F12-

D/400), хайлах цех, химийн лабораторийн агааржуулалтын системийг шинэчлэн засварласан, эрдэнийн чулуу таних багаж худалдан авсан (АНУ Gemlogis), сорилтын үр дүнг цахимаар илгээх боломж бүрдэж, тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлыг амжилттай туршсан. Мөн Үнэт металлын сорьц тогтоох шинжилгээнд гарал үүсэлтэй, баталгаажсан алт, мөнгийг үйлдвэрлэгч (Швейцарь Улс-Argor)-ээс нь авч хэрэглэж эхэлсэн нь шинжилгээний үр дүнд итгэх итгэлийг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил боллоо.

3.2.7.5. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: Төслийн "Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал" болон "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төслийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг /USAID/-ийн Азийн Товчооны гэрээ хэлцлийн түншүүдтэй хамтран олон улсад мөрдөгдөж байгаа жишиг аргачлалын дагуу боловсруулахаар 2022.07.01-ний өдрөөс 2022.11.25-ны өдрийн хооронд хамтран ажилласны хүрээнд "Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал" болон "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төслийн сүүлийн хувилбарыг хүлээн аваад байна.

2020 онд Өмнөговь аймгийн Ханбогд суманд ажиллаж үйлдвэрийн ус хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор гадаргын болон газрын доорхи усны эх үүсвэр олох судалгааг гүйцэтгэж, үр дүнгээр тайлан боловсруулсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн макетыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, үйлдвэрийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, гадаад дэд бүтэцтэй холбох судалгааны ажлын хүрээнд үйлдвэр байгуулах талбайн топо суурь зураг, цахилгаан эрчим хүчний агаарын шугам, дэд өртөө, салбар төмөр зам байгуулах замын зураглалыг гүйцэтгэсэн. ЗББҮ-ээс гарах дайвар бүтээгдэхүүн болох хүхрийн хүчлээр фосфорын баяжмалыг боловсруулан фосфорын бордоо үйлдвэрлэх ТЭЗҮ-ийн төсөл боловсруулан УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн БҮСХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна:

3.2.8.1. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө.

Биелэлт: Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Гэрээлэгч компаниуд болох "Жи Өү Эйч" ХХК, "Монголын Алт" ХХК, "Зон Хэн Юу Тиан" ХХК, "Смарт петролеум" ХХК, "Түмэн Ойл" ХХК, "Макс Ойл" ХХК нар 2020 онд газрын тосны чичирхийллийн судалгаа, цооногийн геофизикийн судалгаа, хайгуулын өрөм, усны цооног өрөмдөх, цооногийн туршилт хийх, нөөцийг тооцоолол хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн, хайгуул, судалгааны ажилд нийт 33.4 сая ам.доллар зарцуулахаар хөтөлбөр, төсвийг баталсан бол 2021 онд хайгуулын ажилд нийт 40,6 сая ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас гадаад ажиллах хүч, машин механизм, тоног төхөөрөмж Монгол Улсын хилээр нэвтрэх боломж нөхцөл хязгаарлагдсан, эдийн засгийн байдал хүндэрсэнтэй холбоотойгоор гэрээлэгчдийн үйл ажиллагааг түр зогсоох буюу 1 жилийн мораториум олгох шийдвэрийг АМГТГ-аас гаргасан. Номгон IX талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгааны ажил гүйцэтгэж буй Жи Өү Эйч ХХК нь дотоодын нөөц боломжийг ашиглан, 2020 оны 07 дугаар сараас хайгуулын ажлыг эхлүүлж, 1.2 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар хайгуулын 4 цооног өрөмдөж, 105 км чичирхийллийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. 2020 онд нийт 5 бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хийх 12 гэрээ хэрэгжиж байна.

Хайгуулын 10 талбайд төлөвлөгөө төсөв баталсан. Эдгээр талбайд 2022 оны төлөвлөгөөгөөр нийтдээ 33.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр байна.

Газрын тосны хайгуулын Матад-ХХ талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Петроматад ХХК-ийн хайгуулын ажлын үр дүнгээр тогтоогдсон газрын тосны нөөцийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, газрын тосны баталгаат нөөц 338,78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43,38 сая тн болсон. Баталгаат нөөц 1 сая тн-р нэмэгдсэн.

Улсын хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 550 мян.тонн газрын тос олборлож, 555 мян.тонн газрын тосыг экспортолж, борлуулалтын орлогоос улсын төсөвт 102,8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 628,854 тонн газрын тос олборлож, 590,878 тонн түүхий тос БНХАУ-д экспортлоод байна. Газрын тосны орлогоос 2021.11.30-ны өдрийн байдлаар 180,5 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээд байна.

2022 онд нийт 6.28 сая баррель буюу 851 мянган тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2022.01.01-2022.12.20 хүртэл хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 2 098 172 баррель буюу 284 295 тонн газрын тос олборлож, 2 131 376 баррель буюу 289 475 тонн түүхий тос БНХАУ-д экспортлох төлөвтэй байна.

3.2.8.2.газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

Биелэлт: Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгуудын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх трассын дагуу хээрийн судалгааны ажил хийж гүйцэтгэн хоолойн трассыг шинэчлэн тогтоож, 540 км урттай байхаар төлөвлөөд байна. Дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийн ажлын даалгавар боловсруулах, трассыг эцэслэн тогтоох, уг трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар санал, дүгнэлт боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг сайдын 2020.10.23-ны өдрийн А-267 дугаар тушаалаар байгуулж трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авхуулаар холбогдох мэдээллийг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газарт хүргүүлээд байна. Дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барих гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах талаар Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 69 дүгээр тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хороог байгуулсан. Шалгуур хангасан 15 компанид тендерийн баримт бичгийг 2021.04.23-ны өдөр хүргүүлж, тендерийг 2021.06.23-ны өдрийн дотор ирүүлэх мэдэгдлийг явуулсан. Цар тахлын нөхцөл байдлын улмаас тендерт оролцогчдоос ирүүлсэн удаа дараагийн хүсэлтийг харгалзан тендер ирүүлэх хугацааг нийт 4 удаа сунгаж 2021.10.23-ны өдөр тендерийг нээж техникийн болон санхүүгийн саналыг үнэлэн гүйцэтгэх компанийг шалгаруулж, компанитай байгуулах гэрээний нөхцөл, гэрээний төслийг боловсруулж байна. Шалгаруулалтыг EPC+F буюу санхүүжүүлж барьж байгуулах нөхцлөөр явуулсан тул ТЭЗҮ боловсруулж хүлээн авах шаардлагагүй болсон. Түүхий тос дамжуулах хоолой санхүүжилт шийдэгдэж, гүйцэтгэчээр БНХАУ-ын Норико интернэйшнл кооперэйшн компани шалгарч зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажил эхлүүлсэн.

3.2.8.3.Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.

Биелэлт: Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтыг БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Эксим банк, Төслийн менежментийн зөвлөх /ТМЗ/ компанитай зөвшилцсөний үндсэн дээр үндсэн 4 хэсэгт хуваан хэрэгжүүлж байгаа ба эдгээрт:

ЕРС-1: Технологийн бус барилга байгууламж

ЕРС-2: Анхдагч процессийн болон дагалдах байгууламж

ЕРС-3: Үйлдвэрийн цахилгаан станц

ЕРС-4: Лицензит технологийн байгууламж

Тайлбар: (ЕРС: Инженерчлэл-худалдан авалт-барилга-угсралт)

Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.11.22-ны өдрийн байдлаар 75.0%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-98,69%, Оффис, сургалтын төв-80,68%, Хоолны газар-89,82%, Лаборатори-89,17%, Эмнэлгийн барилга-83,84%, Агуулах-58,47%, Нэвтрэх хаалга-1-82,80%, Нэвтрэх хаалга-2-56,32%, Гал унтраах ангийн барилга-68,29%, Засварын цех-51,0%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-53,0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-60,63%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, Худгийн барилга-79,74%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй.

Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс текноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮӨҮПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичиг боловсруулж байна.

Лицензгүй технологийн байгууламжийн ажил /ЕРС-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ний өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /ЕРС-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. ЕРС-2, ЕРС-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Mera инженеринг инфрастракчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан.

“Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг боловсруулан, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар баталсан.

Монгол Улс 2022.11.21-ний байдлаар нийт 1,456,818.6 тонн шатахуун импортолсон. Үүнд: дизелийн түлш 846,626.1 тонн, автобензин 578.866.5 тонн байгаагаас К5 /Евро-5/ стандартын автобензин 148,998 тонн, дизелийн түлш 156,446.3 тонн, бүгд 305,444 тонн байгаа нь нийт импортолсон шатахууны 21 хувийг эзэлж байна.

3.2.9. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, уул уурхайгаас олох үр шимийг Баялгийн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш, шударга хүртээх тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгэв. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн

төслийг эцэслэн боловсрууллаа. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

3.3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.3.1.Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: 2022 онд 4.5 тэрбум төгрөгөөр 44 ш комбайн, 12ш трактор 5-40 морины хүчтэй трактор 4 ширхэг, 35-40 морины хүчтэй тракторт угсрах хүнсний ногооны үрлүүр 4 ширхэг, Роторт сийрүүлүүр 4 ширхэгийг нийлүүлсэн. Мөн гадаргын усыг тариалангийн үйлдвэрлэлд ашиглах зорилгоор Увс аймгийн Улаангом сумын Арсай голыг түшиглэн 700 га талбайн "Арсай" усалтын системийг байгуулах ажлыг 2022 оны Улсын төсөвт суулган барилгын ажлыг эхлүүлсэн. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 54-125 га талбайг услах хүчин чадал бүхий том оврын бороожуулагч 18 ширхэг, төмс, хүнсний ногооны бага оврын бороожуулагч 65 ширхэг, 3 га-ийн намираа зөөврийн усалгааны систем 48 ширхэг, 1-5 га-ийн дуслын усалгаа 27 ширхэгийг үр тариа, төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч нарт Хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан 50 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр 6 жилийн хугацаатай жилийн 6 хувийн зээлээр олгосон. Эдгээр ажлын дүнд усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 1724 га (ХААДС)-гаар нэмэгдүүлэх боломж бүрдүүлж ажилласан байна. 2022 онд улсын төсвийн 900.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 400 м2, Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 500 м2 өвлийн хүлэмж, АХБ-ны 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Улаанбаатар хотод 800 м2 дэвшилтэт технологийн хүлэмжийг байгуулж байна. Мөн Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд үрсэлгээний болон өрхийн 5700 м2 талбайтай 75 иж бүрдэл зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулав.

2021 онд БНБУ-ын хөнгөлөлттэй зээлийн 4,5 сая еврогоор ногоон тэжээл тариалах зориулалттай тоног төхөөрөмж, БНПУ-ын хөнгөлөлттэй зээлийн 3,2 сая еврогийн эх үүсвэрээр төмс, хүнсний ногооны техник, ОХУ-ын 10,0 сая долларын зээлийн эх үүсвэрээр үр тарианы техник нийлүүлэх ажлууд хэрэгжиж байна. АНУ-ын 3.0 сая ам.долларын буцалтгүй тусламжаар "Монгол улсад өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх төсөл" хэрэгжүүлэхээр 2020 онд 2 тал тохиролцсон. 2021 оны 6 дугаар сард тус улсаас төслийн санхүүжилтийг эцэслэн баталснаа мэдэгдсэн. 20 га талбай бүхий өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах төсөл боловсруулж томоохон уул уурхайн компанийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2021 онд импортын болон дотоодын нийт 16631 тн бордоогоор 126964 га талбай буюу нийт талбайн 29.9 хувийг бордож, 2021 онд үр тариа өнгөрсөн оноос 173.4 мян тн, тэжээл 130.0 мян тн, тосны ургамал 132.3 мян тн, хүнсний ногоо 3.6 мян тн-оор тус тус нэмэгдсэн байна. Энэ нь 2020 оны ургацтай харьцуулахад 37.9 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 2021 онд 15 аймаг, нийслэлийн 60 иргэн, аж ахуйн нэгжийн шинээр байгуулагдсан өвлийн хүлэмжийг цахилгааны хөнгөлөлтөд хамруулахаар Эрчим хүчний яаманд хүргүүлснээр хүлэмжийн талбай 6.6 га-гаар нэмэгдсэн байна. 2021 онд 11 нэр төрлийн 176.2 тн үр авснаас импортын үр 160.2 тн нийлүүлэгдсэн, шар манжин, шар лууван, хүрэн манжин, гоньд, саримсны үр 16000 кг үйлдвэрлэсэн. Улаанбуудайн эх орны

супер элит үрийн хангамж нэмэгдүүлж, супер элит үр 56 тн, элит үр 400 тн, нэгдүгээр үржүүлгийн үр 4500 тн нөөцтэй болсон.

2020 онд Хөдөө аж ахуйг дэмжих сангаас Увс аймгийн Баруунтуруун сум, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд 10.0 мянган тонн багтаамжтай үр тарианы элеватор байгуулахаар төлөвлөж, элеваторын зураг төсөл, төсөв, барилгын талбайн инженер геологийн судалгааны дүгнэлтийг хийлгэсэн. Тус элеваторын суурийг 2022-2023 онд байгуулахаар 2022 оны улсын төсөвт 2 тэрбум төгрөг тусгасан. Засгийн газрын 2020 оны 138 дугаар тогтоолын дагуу 10.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий 23 нэр төрлийн 277 ширхэг техник, тоног төхөөрөмжийг 263 иргэн, аж ахуйн нэгжид, 2.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 177 тонн ургамал хамгааллын бодис, 842 тонн нийлмэл бордоо, 72 тонн гумины бордооны үнийг тус тус 50 хувиар хөнгөлж нийтдээ 335 иргэн, аж ахуйн нэгжид 20-50 хүртэл хувийн урьдчилгаатайгаар тариалалтын өмнө зээлээр олгох ажлыг зохион байгуулав. Мөн БНХАУ-ын Засгийн хөрөнгөөр нийлүүлсэн төмс, хүнсний ногооны зориулалттай 50-80 морины хүчтэй дугуйт трактор, хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулсан техник тоног төхөөрөмжийн үнийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 145 дугаар тушаалаар 50 хувиар бууруулж, ногоочдод олгосон. Хүнсний ногооны механикжуулалтын түвшин ногооны төрлөөс хамаарч 45-60 хувьтай байна.

ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас 2020 онд Говь-Алтай, Орхон, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймаг Улаанбаатар хотын 19 аж ахуйн нэгжид хүлэмжийн аж ахуйг байгуулахад зориулан 1,886.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгоод байна. Улсын төсвийн 74.2 сая төгрөгийн санхүүжилтээр 32 м² талбай бүхий 45 иж бүрдэл нийлэг хальсан зуны хүлэмж нийлүүлж хүлэмжийн талбайг 1440 м² талбайгаар нэмэгдүүлэв. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногооны аж ахуйг хөгжүүлэх" төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 228 сая төгрөгийн өртгөөр 500 м² өвлийн хүлэмжийг байгуулж байна. Тус төслийн хүрээнд 345.5 сая төгрөгийн санхүүжилтээр 32 м² талбай бүхий 110 иж бүрдэл, 120 м² талбай бүхий 50 иж бүрдэл нийт 9520 м² талбай бүхий зуны хүлэмж нийлүүлж Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Увс аймгийн ногоочдод олгов.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод 4 аж ахуйн нэгж 6.4 тэрбум төгрөгөөр 11200 м², Төв аймагт 3 аж ахуйн нэгж 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2400 м² хүлэмж байгуулав. Эдгээр арга хэмжээний үр дүнд хүлэмжийн талбай 30000 м²-аар, хүлэмжийн ногооны үйлдвэрлэл 700 тонноор нэмэгдэх боломж бүрдэж байна.

3.3.2. Газар тариалан, хөдөө аж ахуйн төв Дархан, Сэлэнгэ бүс нутагт агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Сэлэнгэ аймгийн Сант суман дахь Хөдөө аж ахуйн сургалт үйлдвэрлэлийн баазыг өргөтгөн хөгжүүлж, газар тариалангийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх малчид, тариаланчдыг сургах, давтан сургах, залуу тариаланч, малчдыг бэлтгэх "Илгээлтийн эзэн" аяныг өрнүүлэх талаар Монгол, Германы хамтарсан Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил төсөл болон Германы Хөдөө аж ахуйн яаманд уламжлан хамтран ажиллах саналыг хүргүүлсэн. ХААИС-ийн Инженерийн сургуультай хамтран ажиллаж байна. ХААИС, Сэлэнгэ аймгийн Сант суманд байрлах МСҮТ-ийн барилга байгууламжийг ашиглан "Хөдөө аж ахуйн инноваци, технологийн парк байгуулах" ТЭЗҮ-ийг боловсруулав.

Тариалангийн бүсэд суурин болон хагас суурин хэлбэрийн аж ахуй эрхэлж байгаа болон нутагтаа үлдэж эрчимжсэн аж ахуй эрхлэх хүсэлтэй өрхийн судалгааг аймаг, сумаар гаргаж, тэдгээрт шаардлагатай өндөр ашиг шимт малын төрөл, үүлдэр, ашиг шимийн чиглэлийг тодорхойлох ажлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран гаргаж, Эрчимжсэн аж ахуй эрхлэх төслийн тооцоо, судалгааг хийж эдгээр хүмүүст орон нутгийн мэргэжлийн байгууллагаар нь дамжуулан 2 удаагийн сургалт зохион байгуулсан.

3.3.3.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

Биелэлт: 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 6.4 мян.тн мах, махан бүтээгдэхүүн, 2021 онд адууны мах 8,0 мян.тн, дулааны аргаар боловсруулсан мах 14.4 мян.тн, нийт 22.4 мян.тн мах, махан бүтээгдэхүүн, 2020 онд 38,6 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн тус тус экспортолсон байна.

Дэлхий банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Экспортыг дэмжих төсөл"-ийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсэгт "Монгол органик хүнс" гэрчилгээг импортлогч улс (БНХАУ)-д хүлээн зөвшөөрүүлэх, техникийн шаардлагыг дүйцүүлэх, IFOAM (International Federation of Organic Agriculture Movements)-д гишүүнээр элсэх, IFOAM-ын магадлан итгэмжлэлийн хөтөлбөрт "Монгол органик хүнс" баталгаажуулалтын схем эзэмшигчийг хамруулах санал хүргүүлж, дэмжигдэв. Монгол улс анх удаа дэлхийн органик үйлдвэрлэлийн статистик мэдээллийн санд мэдээллээ хүргүүлэх боломж бүрдэв. Монгол улсын мэдээлэл бүхий FiBL-ийн 2020 оны бюлетен хэвлэгдэн дэлхийн 180 гаруй улсад түгээгдэв.

Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд 9986.9 тн нөөцийн мах, бодлогын гэрээ байгуулсан 13 аж ахуйн нэгжийн экспортолсон махны 10 хувь болох 379.2 тн, нийт 10370.0 тн махыг 2021 оны 3 дугаар сарын 26-наас 07 дугаар сарын 10-ны өдрүүдэд борлуулсан. Махны үнийг 2021 оны 3-6 сарын дундаж үнэтэй харьцуулахад хонины ястай мах 55.7 хувь, үхрийн ястай мах 55.8 хувь, ямааны ястай мах 65.8 хувиар хямд үнээр зах зээлд нийлүүлсэн. 2020 онд нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд 28 аж ахуйн нэгжийн 21.2 мянган тонн мах бэлтгэж, борлуулсан бөгөөд нөөцийн махны хүүгийн хөнгөлөлтөд 5,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Монгол улсад нийтдээ 22 хамтын, 2 хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага органик хүнсний баталгаажуулалтыг явуулж, 2022.11.23-ны өдрийн байдлаар баталгаажсан 645 органик, шилжилтийн үеийн органик 33, импортын 82 органик хүнс бүртгэлтэй байна. Монгол улсын 500 гаруй үйлдвэрлэгч 932.5 га талбайд органик үйлдвэрлэл эрхэлж, 2022 онд нийт 170 тн хүнсний ногоо, малын гаралтай 8 тн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлжээ.

2375 малчин, эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчийн 2020-2021 оны сүүний урамшуулалд 4,1 тэрбум төгрөгийг Төрийн сангийн дансаар дамжуулан олгосон. Өвлийн улиралд нийлүүлсэн шингэн сүүний хэмжээ урьдчилсан гүйцэтгэлээр 16 хувийн өсөлттэй байна.

2021 онд төмс 18.5 мянган талбайгаас 181.5 мянган тн, хүнсний ногоо 10.0 мянган га талбайгаас 118.6 мянган тн ургац хураан авсан. Энэ нь дотоодын үйлдвэрлэлээр төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 60 хувьтай хангасан үзүүлэлт юм. Хүн амын хэрэгцээний нормыг дотоодын ургацаас тооцвол 2021 оны байдлаар байцааны хангамж 67 хувь, шар лууван 142, шар манжин 168.6 хувь, хүрэн манжин 100 хувь, сонгино 70.2 хувь, сармис 53.6 хувь, хэмх 78.1 хувь бусад ногоо 12.9 хувийг хангаж байна. 2020 оныхоос байцаа 4 хувь, хүрэн манжин 72 хувь, сонгино 25.3 хувь, сармис 13.2 хувь, хэмх 17.6 хувь, бусад салат ногоо 4.2 хувиар өссөн бол лооль 5.5 хувиар буурсан байна.

2022 онд хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 118 дугаар тогтоолоор ил талбайн болон хүлэмжийн хүнсний ногооны үрийг 80 хувь хөнгөлж, улсын төсвийн 1,3 тэрбум төгрөгөөр 12 нэр төрлийн 81 тонн үрийг ногоочидод аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газруудаар дамжуулан олгов. Ургац хураалтын урьдчилсан дүнгээр 19.7 мянган га-гаас 215.5 мянган тонн төмс, 11.8 мянган га-гаас 146.8 мянган тонн хүнсний ногоо авсан нь өнгөрсөн онтой харьцуулахад төмс, хүнсний ногооны ургац тус бүр 18-25 хувиар тус тус нэмэгдсэн байна.

УИХ-ын 2022 оны 04 сарын 29 өдөр баталсан "нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай" хуулиар дотоодын түүхий эдээр үйлдвэрлэсэн ургамлын тос, дотоодын хүнсний үйлдвэрт борлуулсан хүнсний зориулалттай тосны ургамлыг нэмэгдсэн өртгийн

албан татвараас чөлөөлж, Засгийн газрын 2022 оны 144, 175 дугаар тогтоолын хүрээнд жилийн 3 хувийн хүүтэй, эргэлтийн хөрөнгийн зээлийн дэмжлэг үзүүлснээр 2022 оны хаврын тариалалтаар 79.5 мян.га талбайд тосны ургамал тариалсан байна.

3.3.4.Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, “Монгол мал-II” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2022 онд “Шинэ хөдөө” хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн нийт 130,0 сая төгрөгийн санхүүжилтээр махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн 430 толгой үржлийн үхэр, 260 толгой үржлийн сарлаг, махны чиглэлийн Эдильбай үүлдрийн 60 толгой өсвөр хуцыг тус тус худалдан авч Архангай, Говь-Алтай, Төв аймгийн үржлийн цөм сүргийн аж ахуй эрхэлж байгаа 50 иргэн, аж ахуй нэгжийг сонгон шалгаруулж тухайн орон нутгийн малын чанар сайжруулах нөхцөлтэйгөөр түрээсийн гэрээ хийж олгов. Хавар, намрын технологийн хугацаанд улсын төсвөөр 2 аймгийн 21 сумын 151.7 мянга, орон нутгийн төсвөөр 16 аймгийн 71 сумын 170.3 мянган үржлийн малд үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, МҮТАҮ-ний 42 нэгж, 600 хүн, 160 техник хэрэгсэл ажиллаж 250 гаруй түр ажлын байр бий болгов. Орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц нутгийг ашиглалтыг сайжруулах зорилгоор Өмнөговь аймгийн отрын нөөц нутаг бүхий 9 суманд 21 инженерийн хийцтэй худаг барьж байгуулахад улсын төсвийн 98.0 сая, орон нутгийн төсвийн 515.2 сая нийт 613.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд 21 аймагт инженерийн хийцтэй 99 худаг шинээр барьж байгуулах ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна. 2022 онд 6979 малчин, фермерийн 8.9 сая литр сүүнд 4.4 тэрбум төгрөгийн урамшуулал олгоод байна.

Засгийн газрын 2021 оны 42 болон 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан “Ажлын байр дэмжих зээл”-ийн хүрээнд “Малчдыг дэмжих зээл”-ийг нийт 200.0 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд зээл нь жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай, 2021 оны 12 дугаар сарын байдлаар 13500 малчин өрх хамрагдсан байна. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын 50.0 сая еврогийн Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд махны чиглэлийн Лимузин, Ангус, Герефорд үүлдрийн 509 толгой өндөр ашиг шимтэй үхэр, болон сүүний саалтуур, хөргүүртэй танк нийлүүлэх гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр байгуулаад байна. 2021 онд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 13 нэгж шинээр байгуулагдаж, улсын хэмжээнд нийт 155 нэгж үйл ажиллагаа явуулж байна. 2020 онд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 18 нэгж шинээр байгуулагдаж, улсын хэмжээнд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нийт 139 нэгж үйл ажиллагаа явуулж байв.

Монгол Улсад баталгаажсан 52 үүлдэр, омгийн малын цөм сүргийг бүрдүүлэх, үзлэг ангилалт хийж ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, технологит хугацаанд нийт 12.9 мянган малчин өрхийн цөм сүрэгт бүртгэгдсэн 325.4 мянган малыг шинээр ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд /оффлайн, онлайн/ 1.555.2 сая малын мэдээллийг орууллаа. Мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн 1.5 сая малын 1.1 хувь 17.4 мянга нь үржлийн хээлтүүлэгч байна.

2021 онд “Малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх” хөдөлгөөнийг өрнүүлж, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 411 иргэн, ААН-ийн нийт 16404 толгой малд биотехнологийн дэвшилтэт арга технологийг ашиглан зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлэв.

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд 2021 онд улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 72, орон нутгийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 84, төсөл, хөтөлбөрийн 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 310, нийт инженерийн хийцтэй 466 худаг, 189 гар худаг барьж байгуулан ашиглалтад оруулснаар 850.2 мянган га бэлчээр, 2708 малчин өрх, 1.5 сая толгой мал сүргийг усаар хангах боломжийг бүрдүүлсэн.

2020 онд гойд ашиг шимтэй махны чиглэлийн Сэлэнгэ, Герефорд, Сүүний чиглэлийн Швейцын бор, Хар тарлан үүлдрийн бухаас 5500 тун үр, тоо толгой цөөрч доройтож мөхөх, устахаас хамгаалах зорилгоор Баянхонгорын Бөмбөгөрийн улаан, Увс аймгийн Баяд үүлдэр, Сартуул үүлдрийн хуцаас 4800 тун үр, гойд ашиг шимт Суффолк, Романов, Брекшон, Дүйчер, Меринос үүлдрийн хуцаас 2500 тун үр, нийт 12800 тун үр үйлдвэрлэн малын генийн санд баяжилт хийв. 2020 онд нийт 9290 малд зохиомол хээлтүүлгийн ажлыг 85,6-90,0 хувийн үр дүнтэй хийж гүйцэтгэв.

2020 онд Улсын төсвийн 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Завхан, Увс, Төв, Хөвсгөл аймгийн 209 цэгт хайгуулын ажил хийв. 2020 онд Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймгийн 193 сумдад улсын төсвийн 1,670.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 83, гадаадын төсөл, хөтөлбөрийн 3,700.0 сая төгрөгөөр 180, орон нутгийн төсвийн 3,700.0 сая төгрөгөөр 287 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачлагаар 170 гар худаг, нийт 9,000.0 сая төгрөгөөр 550 инженерийн хийцтэй худаг гаргасан нь 825.0 мянган га бэлчээр, 2.7 мянган малчин өрхийн 1.5 сая толгой малын усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон.

3.3.5.Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна.

Биелэлт: 2022 онд бэлчээрийн ургамлыг мэрэгч амьтны хөнөөлөөс хамгаалах хаврын ажлыг 14 аймгийн 61 сумын 610 мянган га бэлчээрийн талбайд орон нутгийн төсвийн 520.0 сая төгрөгийн хөрөнгөөр тэмцэх арга хэмжээг хэрэгжүүллээ. Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг 9 аймгийн 114 сум, 4 отрын бүс нутагт, царцаатай тэмцэх арга хэмжээг 2 аймгийн 4 сумын нутагт нийт 528.0 мянган га бэлчээрийн талбайд улсын төсвийн хөрөнгөөр зохион байгуулав. Үр дүнд нь нийт 100 гаруй мянган га бэлчээрийн ургамлыг мэрэгч амьтны хөнөөлөөс хамгаалж мал аж ахуйн үйлдвэрлэлд хэвийн ашиглах боломжийг бүрдүүлсэн. Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлснээр зун, намрын улирлын бэлчээрийн малын тэжээлийн нөөцийг 122.0 мянган тонноор нэмэгдүүлэв.

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээнд 2020 онд нийт 17 аймгийн 174 гаруй сум, 4 аймаг дундын отрын бүс нутгийн 1.63 сая га бэлчээрийн талбай хамрагдаж үлийн цагаан оготны хөнөөлөөс хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлж ажиллав. Ингэснээр эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан нийт тэмцэх шаардлагатай талбайн 15.47 хувьд тэмцэх ажил зохион байгуулав. 2020 оны гүйцэтгэл нь өмнөх оноос 600 мянган га, сүүлийн 10 жилийн дунджаас 1.0 сая га талбайгаар тус тус нэмэгдсэн байна. Мөн онд бэлчээрийн 66 мянган га талбайн ургамлыг царцааны хөнөөлөөс хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлд хэвийн ашиглах боломжийг бүрдүүлсэн.

3.3.6.Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2024 он/ батлан, хэрэгжүүлж эхэллээ. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл оны үнээр 7.2 их наяд төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 14.2 хувиар өссөн байна. Малчин өрхийн жилийн дундаж орлого 2020 онд 15.243.468 төгрөг байсан бол 2021 онд 16.531.216 төгрөг болж 7.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. “Малын тоо толгой, албан татварын тухай” хуулийг 2021 оны 7-р сарын 01-нээс хэрэгжүүлж эхэлснээр 5.0 орчим тэрбум төгрөгийн татварын орлогыг сум хөгжүүлэх санд төвлөрүүлж мал аж ахуйн салбарт зарцуулах боломж бүрдэв.

Дэлхийн банкны “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн санхүүжилтээр 21 аймгийн 330 суманд ажиллаж амьдарч буй 176966 малчин өрх тус бүрд 100 мянган төгрөгийн дэмжлэг буюу нийт 17,696,600,000,0 төгрөгийг Төрийн сангаар дамжуулан шилжүүлэв. 2021 оны 3-р дугаар сард сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн 1,897,521 литр үнээний шингэн сүү бэлтгэн нийлүүлсэн 1724 малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 948,760,500 төгрөгийн мөнгөн урамшууллыг төрийн сангийн дансаар дамжуулан шилжүүлсэн. Үндэсний 78 үйлдвэрт 18,566.3 тонн хонины ноос, 676.2 тонн тэмээний ноос бэлтгэн нийлүүлсэн 88,669 малчин, мал бүхий этгээдэд 30.7 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг малчдын дансанд шилжүүлээд байна.

“Хөдөө аж ахуйн зээл”-ийн зээлийн хүүгийн дэмжлэгийн санхүүжилтийн гэрээг 2021.04.29-ний өдөр ХХААХҮЯ, Сангийн Яам, Монгол банкны хооронд байгуулав. “Хөдөө аж ахуйн зээл”-ийн санхүүжилтийн хүрээнд 2021 онд нийт ноос, ноолуур, арьс ширний салбарын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 51 аж ахуйн нэгжид 111,3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгожээ.

2022.11.04-ний өдрийн байдлаар ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 31 ААН-д 106.96 тэрбум, ноос бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 8 ААН-д 8.01 тэрбум, арьс шир бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 6 ААН-д 4.95 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгоод байна. Зээлийн батлан даалтын сангаас 32 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 11,789 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 22,32 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов.

3.3.7. Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно.

Биелэлт: 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулахад зориулж Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 419, 2020 оны 85 дугаар тогтоолоор 18 аймагт улсын нөөцийн 5771 тн өвсийг үнэгүй, 4759 тн тэжээлийг 50 хувь хямдруулан малчдад, хамгийн эрсдэл өндөртэй 7 аймагт 350.0 сая төгрөг олголоо. Засгийн газрын 138 дугаар тогтоолоор аймаг дундын 7 отрын бүсэд өвөлжиж, хаваржиж буй малчдад зориулсан аюулгүйн нөөцийн ногоон тэжээл 612.5 тн, хивэг 350 тн хивэг худалдан авах 406.0 сая төгрөг шийдвэрлүүлэв.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд малчдын түвшинд өвс, тэжээлийн нөөцийг 100.9 хувьтай буюу төлөвлөгөөнөөс давуулан биелүүлсэн. Аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн бүрдүүлэлт өвс 40.3 хувьтай бэлтгэсэн байна. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд Архангай аймгийн Хангай, Өвөрхангай аймгийн Сант, Хархорин, Дундговь аймгийн Сайнцагаан, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Галшар, Сүхбаатар аймгийн Асгат, Дорнод аймгийн Гурванзагал, Цагаан-Овоо, Булган сумд буюу төсөл хэрэгжигч 6 аймгийн 11 суманд сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн агуулах, саравчийг барьж байгуулах ажил хийгдэж байна.

3.3.8. Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.

Биелэлт: Биокомбинат үйлдвэрийн дэд бүтэц, үйлдвэрийн технологийг шинэчлэх төслийн хүрээнд Унгарын “Мега-ложистик” компани шинэ үйлдвэрийн, биоаюулгүй ажиллагааны 3 дугаар зэргийн лабораторийн барилгын зураг төсөв, технологийн зураг хийгдэж байна. Үйлдвэрийн барилгын зураг төсөв нь нарийн төвөгтэй, олон улсын стандартын дагуу хийгдэж буй тул цаг хугацаа нилээд шаардагдаж байна. Төслийн үе шатны ажлын хуваарийн дагуу 2020 оны 11-р сарын 06-ны өдрөөс төслийн ажлыг эхлүүлсэн бөгөөд 2021 онд гүйцэтгэгч компаниас төслийн төсөвт өртгийг нэмэх, гэрээний хугацааг сунгах хүсэлт ирүүлснийг судалж байна.

2022 онд улсын төсвөөс санхүүжүүлэх 6 нэрийн өвчний дархлаажуулалтад 3 дугаар улирлын мэдээгээр 19,8 сая толгой мал, амьтан хамруулж 85,3 хувьтай хэрэгжүүлж байна. 2022 оны жилийн эцсийн урьдчилсан мэдээгээр 17 нэрийн халдварт өвчнөөр 1694 толгой мал өвчилсөн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад халдварт өвчний тоо 2 (10.5 хувь)-оор, тохиолдлын тоо 3688 (68.5 хувь)-аар тус тус буурсан байна. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 2022 онд нийт 21 аймаг, нийслэлийн 336 сум, дүүргийн 12.9 сая толгой мэдрэмтгий мал сүргийг 95.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хамруулсан. Шүлхий өвчин 20 аймгийн 204 сумын 461 тохиолдол бүртгэгдсэнээс жилийн эцсийн байдлаар 1 аймгийн 1 сумын 1 голомтод хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байна. Бог малын мялзан өвчний тохиолдол 11 аймгийн 46 сумын 79 голомт оношлогдсонтой холбогдуулан 10 аймгийн 25 сумын нийт 2,9 толгой мэдрэмтгий мал сүргийг 94,0 хувийн гүйцэтгэлтэйгээр вакцинд хамруулсан. Хонины цэцэг өвчин 3 аймгийн 4 суманд 4 голомт бүртгэгдсэнтэй холбогдуулан 4 аймгийн 10 сумын нийт 2,4 сая толгой хонин сүргийг 94,7 хувийн гүйцэтгэлтэйгээр вакцинд хамруулсан. 2022 оны тандалтын урьдчилсан дүнгээр 0.05 хувь болж бол галзуу өвчний тохиолдлын тоо 70.8 хувиар тус тус буурсан байна. Боомын өвчний тохиолдол 3-аар нэмэгдэж бүртгэгдсэн байна.

2021 онд улсын төсвөөс санхүүжүүлэх дархлаажуулалтын арга хэмжээний 7 нэрийн вакцинд 8.7, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх дархлаажуулалтын 9 нэрийн вакцинд 11.6, иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлэх дархлаажуулалтын 3 нэрийн вакцинд 4,2 сая толгой мал, амьтан, нийт 19 нэрийн өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд давхардсан тоогоор 24.4 сая толгой мал, амьтныг хамруулахаас 23.7 сая толгой мал, амьтан хамруулж, 96.9 хувьтай урьдчилан сэргийлэх арга хэмжээг гүйцэтгэсэн байна. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 2021 онд нийт 19 аймгийн 116 сумын 23.2 сая толгой мэдрэмтгий мал сүргийг 93.5 хувийн гүйцэтгэлтэй хамруулсан. Шүлхий өвчин 20 аймгийн 167 суманд 307 тохиолдол бүртгэгдсэнээс жилийн эцсээр 17 аймгийн 98 сумын 167 голомтод тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлж байна. Нийт 14.1 сая тун вакцин худалдан авахад Засгийн газрын нөөц хөрөнгөөс 2.9 тэрбум, МЭЕГ-ын төсвөөс 8.7 тэрбум төгрөг зарцуулсан.

2021 онд бруцеллёзын дархлаажуулалтын төлөвлөгөөний дагуу 13.66 сая толгой охин төл хамруулж, 94.0 хувьтай гүйцэтгэсэн бөгөөд бруцеллёзын халдварлалтын хувь 0.25 хувь болсон байна. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 3.1 сая толгой мал хамруулахаас 2.8 сая толгойг хамруулж, 90.3 хувийн гүйцэтгэсэн бөгөөд галзуу өвчний гаралтыг 2020 онтой харьцуулахад гаралт 28.8, адууны өвчлөл 53.0, тэмээний өвчлөл 56.5, хонины өвчлөл 35.6 хувиар тус тус буурсан. Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 4.4 сая толгой мал хамруулахаас 100.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн ба 2021 онд 5 голомтод үхэр 7, хонь 2 өвчилж, өмнөх оноос голомтын тоо 16.7, тохиолдлын тоо 35.7 хувиар буурсан.

2020 онд баталсан төлөвлөгөөний дагуу орон нутгаас санхүүжүүлэх 9 нэрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2020 онд 11.6/11.8 сая толгой мал, амьтан хамруулж 98.8, иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлэх 3 нэрийн вакцинд 4.9/5.0 сая толгой мал, амьтан хамруулж 97.7 хувь, нийт 12 нэрийн мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд давхардсан тоогоор 16.5/16.8 сая толгой мал, амьтан хамруулсан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2020 онд мал, амьтны 8 нэрийн халдварт өвчний голомтын тоо 22.3 хувиар өсч, тохиолдлын тоо 1.1 хувиар буурсан.

Монгол улсад 2020 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар мал, амьтны гоц халдварт өвчингүй, тайван байна. Монгол улсын баруун бүс буюу Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл аймгийг шүлхийгүй, вакцин хэрэглэдэггүй бүс болохыг ДМАЭМБ-аар хүлээн зөвшөөрүүлэхээр илгээх баримт бичиг (dossier)-ийн баримт бичгийг 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдөрт багтаан ДМАЭМБ-д илгээхээр төлөвлөсөн боловч Ховд аймгийн Булган суманд 2021 оны 07-р сард шүлхий өвчний тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотойгоор ажил тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна. Дэлхийн мал, амьтны эрүүл мэднийн байгууллагын 2022 оны 5 дугаар сард болсон хуралдаанаар Монгол улсыг үхрийн цээж өвчнөөр тайван болхыг албан ёсоор баталгаажуулсан байна.

3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Итали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 440.5 сая төгрөгийн үнэ бүхий 8 тоног төхөөрөмжийг Монголын Ноос Ноолуурын Холбооны дэргэд байгуулсан “Итали-Монголын Текстил (нэхмэл)-ийн технологийн төв”-д суурилуулан тохируулж, төвийн үйл ажиллагааг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр албан ёсоор нээсэн. Говь ХК 8,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Итали улсын иж бүрэн 2 самнах машин шинээр суурилуулж, байнгын 10 ажлын байрыг бий болгон ээрэх хүчин чадлыг 350 тонноор нэмэгдүүлснээр улсын хэмжээнд нийт ээрэх хүчин чадал 2970 тн-д хүрсэн. Арьс шир, ноос ноолуурын салбарын техник технологийн хүрсэн түвшинг тогтоох, тулгарч буй асуудал, гарц шийдэл, R&D судалгаа хөгжүүлэлт, инновац дамжуулалтын чиглэлийг тодорхойлох, дотоод ба гадаад хамтын ажиллагааг уялдуулан өргөжүүлэх ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төвийг Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 93 дугаар тогтоолоор байгуулсан.

“Гоёл кашемир” ХХК нь АНУ-ын DFC банкнаас 5 сая ам. долларын зээлийн хөрөнгө оруулалтаар шинэ үйлдвэрийн байр ашиглалтад оруулж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн. Европын холбооны Трам төсөлтэй хамтран сарлагийн хөөвөр боловсруулах чиглэлээр загвар төслөөс “Жинст мөрөн” ХХК, “Сноу филдс” ХХК, “Мөнхбумууд” ХХК, “Бест кашемир” ХХК, “Уужин” ХХК, “Сор кашемир” ХХК зэрэг үйлдвэрүүд кластерын зарчмаар ажиллах загвар хэрэгжүүлж, бүтээгдэхүүнээ Европт гаргах эхлэлийг тавьж, Герман улсад бараа бүтээгдэхүүнийг борлуулах дэлгүүрийг 2020.11.20-нд нээхэд дэмжлэг үзүүлсэн. 2020 онд 44 аж ахуйн нэгжид 103,9 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээлийг ноолуур бэлтгэлийн зориулалтаар олгосон. 2021 онд ноос, ноолуур, арьс ширний салбарын 47 аж ахуйн нэгжид 100.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

3.3.10. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Экспортын хэмжээ /угаасан болон самнасан ноолуур, сүлжмэл болон нэхмэл бэлэн бүтээгдэхүүн/ 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 252,215.30 ам.доллар байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 12,7 хувиар өссөн байна. Италийн ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг томоохон компаниуд болох “Colombo”, “Falconeri”-ийн

захиалгаар "Ханбогд кашимер" ХХК нийт 20 тн ноолуур, үүнээс "МХШ" чанарын гэрчлэх тэмдгээр баталгаажсан 10 тн ноолуурыг Итали улс руу газраар тээвэрлэсэн.

Арилжааны банкуудад 2021 онд ноолуур бэлтгэлийн зээлийг 38 аж ахуйн нэгжид 94.9 тэрбум төгрөгийн зээл олгож, 10 аж ахуйн нэгж 17.1 тэрбум төгрөгийн дахин санхүүжилтэд багтсан байна. Ноосны хөнгөлөлттэй зээлийг 4 аж ахуйн нэгжид 3.2 тэрбум төгрөгийн, Арьс шир бэлтгэлийн чиглэлээр 5 аж ахуйн нэгжид 2.8 тэрбум төгрөгийн зээл тус тус олгосон. Үйлдвэрүүдэд ноолуур бэлтгэлийн зориулалтаар 2020 онд 44 аж ахуйн нэгжид 103,900.0 сая төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээлийг МУХБ-наас олгосон.

2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 31 ААН-д 106.96 тэрбум, ноос бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 8 ААН-д 8.01 тэрбум, арьс шир бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 6 ААН-д 4.95 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгоод байна.

Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтад Хөгжлийн банкны зээл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар цэвэрлэх байгууламжийн барилга, цахилгаан түгээх, хангах дэд бүтэц, гадна инженерийн шугам сүлжээ, технологийн уур зэрэг ажлуудад нийт 54.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт зарцуулсан бөгөөд бүтээн байгуулалт 55.1 хувьтай хэрэгжиж байна.

3.3.11.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно.

Биелэлт: УИХ-ын 2020 оны 32, Засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолоор 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, бэлтгэсэн нэг килограмм ноолуур тутамд 20,000 төгрөгийн урамшуулал олгохоор баталж, нэг ямааны ноолуурын гарцыг дунджаар 300 гр-аар тооцон 203 641 малчин, мал бүхий этгээдэд 175 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон. 2020 онд үндэсний үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах, нөгөө талаас малчдын орлогыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 37,825 малчин /2,610,197 ширхэг арьс ширэн түүхий эд/-д 9.9 тэрбум, 49,625 малчин /11.5 мян.тн ноос/-д 12.9 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон. 2021 онд хонь, тэмээний ноос бэлтгэн нийлүүлсэн 91,977 малчин, мал бүхий этгээдэд 32,3 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг олгоод байна.

Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох” журам баталсан. Сүүний 8 үйлдвэрт 1,939,944.0 литр түүхий сүү нийлүүлсэн 2375 малчин, ЭМАА эрхлэгчдэд 969.97 сая төгрөгийн урамшуулал олгосон. 2020 оны 12 болон 2021 оны 1-3 дугаар сард давхардсан тоогоор 9516 малчин, фермерт 8.5 сая литр сүүг үндэсний 8 үйлдвэрт тушаасны урамшуулалд 4.3 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон. 2022 оны 1, 2, 3 дугаар сард 8,848,448 литр сүү бэлтгэн нийлүүлсэн 6979 малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 4.4 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Тариаланчдад нийт 23,900.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. 2020 оны ургацын тариаланчдад олгох буудайн урамшуулалд 13 аймгийн 776 иргэн, хуулийн этгээдэд 22.7 тэрбум төгрөг зарцуулав.

3.3.12.Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: Улсын хэмжээнд төмс, хүнсний ногооны 225.0 мянган тонн багтаамжтай 10 гаруй мянган зоорь, агуулах бүртгэлтэй байна. Үүнээс Улаанбаатар хотод 76.6 мянган

тонн багтаамжтай зоорь, агуулах ашиглаж байна. Хадгалалтын дэвшилтэт технологитой, халаалт хөргөлтийг автомат, хагас автомат аргаар тохируулдаг механикжсан агуулахын багтаамж 62.0 мянган тоннд хүрсэн. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, махны хадгалалт борлуулалтын цогцолбор төвийн ТЭЗҮ-ийг 2018-2019 онд боловсруулсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийсэн, газрын асуудлыг Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас шийдвэрлэсэн, зураг төсөл хийгдэж байна. “Төмс, хүнсний ногооны 500, 1000, 2500 тонн багтаамжтай агуулахын цогцолбор”-ын нэг хэв маягийн зураг төсөл, төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулсан. Тус нэг маягын зураг төсвийг төмс, хүнсний ногоо агуулах шинээр байгуулахаар төлөвлөж буй орон нутгийн Засаг захиргаа болон иргэн, аж ахуйн нэгжүүдэд хуулбарлан хүргүүлсэн.

Монгол Улс-БНПУ-ын Засгийн газар хооронд Монгол Улсад “Хүнсний ногооны үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” 10.2 сая еврогийн санхүүжилттэй төслийн хүрээнд төмс, хүнсний ногооны агуулах байгуулах ажлыг 7.0 сая еврогоор 5 аймаг, нийслэлд нийт 6 байршилд 8500 тонн багтаамжтай иж бүрэн механикжсан агуулахыг байгуулахаар, мөн хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулсан трактор, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлийг 3.2 сая еврогоор хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөж байна.

Сум тус бүрт дундын хоршоо, орон нутгийн оролцоотой агробизнесийн компани байгуулах, Агробизнесийн компани нь дундын хоршооны гишүүн байхаар төлөвлөсөн. Аймаг хөгжүүлэх сангийн нийт эх үүсвэрийн 30 хувийг хоршооны үйл ажиллагааг дэмжихээр шийдвэрлэж, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийн эх үүсвэрийг жил бүр 600.0 сая -1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж “Аймаг хөгжүүлэх сан”-гаас 11 хоршоонд 375.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн байна. “Хоршоонд суурилсан ХАА-н тогтвортой үйлдвэрлэл-53036-001 Монгол Улс” төслөөс Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум, Архангай аймгийн Өлзийт суманд “Малчдын хоршилт, хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээр, усны менежмент, бүтээгдэхүүний өртгийн сүлжээ, зах зээлтэй холбогдсон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах” зорилгоор хэрэгжиж, төслөөс малчдын хоршооны сайжруулсан загвар бүхий хоршооны бүтэц, зохион байгуулалтын загварыг 2 суманд туршиж байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлт, чанар нь дотоодын хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлэх, гадаад орнуудад экспортлох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор АРАС (Ази Номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага)-ын ижил түвшний үнэлгээнд 2021 оны 9-р сарын 6-10 өдрүүдэд амжилттай хамрагдсан. Ингэснээр манай улсын тохирлын үнэлгээний байгууллагаас гаргасан үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөх урьдчилсан нөхцөл хангагдсан. “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын дагуу Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 2 сорилтын лаборатори, 2 баталгаажуулалтын байгууллагын чадавхи нь холбогдох стандартын шаардлага хангасныг тогтоон анх удаа итгэмжлэлд хамруулсан.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг хянахад дэмжлэг үзүүлэх (малын болон ургамлын гаралтай хүнсний, ноос ноолуурын бүтээгдэхүүн) баталгаажуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 байгууллагад шинээр итгэмжлэл олгосон.

Хөдөө аж ахуйн бирж нь 2022 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 996 хэлцлээр 1 их наяд 70 тэрбум төгрөгийн 157 удаагийн арилжаа зохион байгуулсан. Арилжааны дийлэнх хувь нь түүхий эдийн боловсруулах үйлдвэрээс экспортлогч компанийн хооронд хийгдэж байгаа ба бирж орон нутгийн хоршооноос дотоодын үйлдвэрийн хооронд арилжаа зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд 6 аймгийн 32 хоршоог биржийн байнгын бус гишүүнээр бүртгэн гэрээ байгуулан ажиллаж байгаа ба Хэнтий, Төв аймгийн сумдын 3 хоршооноос нийт 230 богц ноолуурын арилжааг 3 удаа амжилттай зохион байгуулсан.

3.3.13. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газраас "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө"-г баталсан. Энэ арга хэмжээний хүрээнд ажлын байрыг дэмжих хоёр их наяд төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан жилийн гурван хувийн хүүтэй, гурван жилийн хугацаатай, эхний 12 сар хүртэл үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэйгээр 500 хүртэл сая төгрөгийн зээлийг олгохоор боллоо. Тус зээлд хамрагдах жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн барьцаа хөрөнгө хүрэлцээгүй тохиолдолд Зээлийн батлан даалтын сангаар 60 хүртэлх хувийг батлан даалгах боломжтой бөгөөд батлан даах дээд хэмжээ 300,0 сая төгрөг байхаар Засгийн газар, Монголбанк, арилжааны банкуудтай гэрээ байгуулсан. Ажлын байрыг дэмжих зээлд хамруулахаар 784 аж ахуйн нэгжид тодорхойлолт олгосноос 206 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 70,0 тэрбум төгрөгийн зээл авч, 28.0 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. Сум хөгжүүлэх сангаас 2021 онд 2200 төсөлд 17,9 тэрбум төгрөгийг хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож, шинээр 4614 ажлын байр, 2944 ажлын байр хадгалж үлдсэн байна. 2021 онд аймаг бүрт "Нэг суурин - Нэг бүтээгдэхүүн" аяны хүрээнд санхүүжилт хуваарилсны дагуу 21 аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд удирдамж, мэдээлэл өгч аяны хүрээнд 32 брэнд бүтээгдэхүүн шинээр үйлдвэрлэв.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2020 онд эргэн төлөлтийн эх үүсвэрийн хүрээнд төсөл хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 1579 төслийн 238,4 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт хүлээн авч 249 аж ахуйн нэгжийг 22,9 тэрбум төгрөгөөр дэмжиж, 1497 шинэ ажлын байрыг бий болгов. 2022 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 4 шатны нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, нийт 151 төсөлд 18.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосноор 1053 ажлын байрыг хадгалан үлдсэн ба 839 ажлын байрыг шинээр бий болгов. Зээлийн батлан даалтын сангаас 32 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 11,789 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 22,32 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов. Батлан даалтын үр дүнд 1250 ажлын байр шинээр бий болсон.

Экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх ажлын хүрээнд Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэн 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн бөгөөд экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай даатгалын үйлчилгээ нэвтрүүлсэн.

3.3.14. Оюутолгой, Эрдэнэт зэрэг томоохон үйлдвэрийн захиалгат ажлыг үндэсний жижиг, дунд бизнес эрхлэгчид гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: "Үндэсний ханган нийлүүлэлт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд уул уурхайн салбарын ханган нийлүүлэлтийн талаарх үндсэн ойлголтууд болон ханган нийлүүлэлтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, холбогдох цахим системийг ашиглалтад оруулсан улсуудын туршлагын талаар судалгааг хийсэн. Дэлхийн банк группын Олон улсын санхүүгийн корпорацид тус асуудлын хүрээнд хамтран ажиллах санал хүргүүлж, холбогдох яриа хэлэлцээг эхлүүлсэн. Мөн хөтөлбөрийн хүрээнд "Монголын ЖДҮ+" төслийг Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, хамтын ажиллагааны гэрээний төслийн хугацааг сунгаж, ханган нийлүүлэлтийн цахим систем байгуулахаар тооцоо судалгаа хийж байна.

"Оюу толгой" компани "Монголд үйлдвэрлэв" худалдан авалтын стратегийн хүрээнд "Хос-Аз" ХХК-тай хөдөлмөр хамгааллын гутал ханган нийлүүлэх 3 жилийн хугацаатай, 2.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулж, жилдээ "S3" олон улсын стандартын шаардлага хангасан хөдөлмөр хамгааллын 5,000 хос гутлыг нийлүүлж байна. "Дархан

минж" ХХК нь "Оюу толгой" компанид сард 15000 ширхэг ажлын арьсан бээлийг тогтмол нийлүүлж байна. Уул уурхайн зориулалт бүхий хүнд даацын шуудайн "Шинэ гантиг" ХХК, "Цасода пластик" ХХК, "Минерал байг" ХХК нь "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, "Оюу толгой" ХХК-тай баяжмал савлах зориулалттай шуудай, бэлдэц материалыг нийлүүлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу нийлүүлж байна. "ISO 9001-2015 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо" стандартыг "Мон-Ирээдүй" ХХК арьс шир боловсруулах үйлдвэр, "Бест Шүес" ХХК гутлын үйлдвэр, "Дархан Нэхий" ХК нэхий, арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээ авлаа.

3.3.15.Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Ногоон хөгжлийг дэмжих санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, тогтвортой санхүүжилтийн урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр нэмэлт судалгаа хийх "Бэлэн байдлын дэмжлэг" хүссэн саналыг НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан (УАНС)-д 2021 оны 4-р сарын 21-ний өдөр хүргүүлж, УАНС-ийн Удирдах хорооны хуралдаанаар 2021 оны 10-р сарын 29-ний өдөр батлуулсан. 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдөр санхүүжилтийн гэрээ зурагдаж мөн оны 3 дугаар улиралд багтаан судалгаа хийх салбарыг сонгож, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг гүйцэтгэх бэлтгэл хангагдсан болно. "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төслийн хүрээнд байгаль орчны бичил зээл, "Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь" төслийн хүрээнд орчны бүсийн эргэлтийн сангийн зээл олгох ажлын бодлогын удирдамжаар ханган ажиллаж, 2022 оны байдлаар нийт 300 гаруй иргэн, аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Ногоон зээлийг дэмжих чиглэлээр 2022 онд 1.7 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаасын эх үүсвэрийг төсөвлөн иргэн, аж ахуйн нэгжид жилийн 3-8 хувийн хүүтэй ногоон зээл олгож байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 309 иргэн, 11 аж ахуй нэгжид 854,6 сая төгрөгийн зээлийн хүүний санхүүжилт олгосон байна. Япон Улсын "Жайка" байгууллагын санхүүжилттэй "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төсөл"-ийн зээлд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 24 төсөл дэмжигдэж 13,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Ногоон зээлийг санхүүжүүлэх ажлын хүрээнд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийж, шалгуур үзүүлэлтийг боловсруулан Хаан банк, Хас банкт байгуулсан гэрээг 2022 оны 4 дүгээр сард шинэчлэн батлуулав. 2021 онтой харьцуулахад ногоон зээлд хамрагдах бүтээгдэхүүний тоог 5-аар нэмэгдүүлж нийт 30 бүтээгдэхүүн болгосон.

Орчны бохирдлыг бууруулах, ногоон төсөл хөтөлбөрийг дэмжих "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор "Ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болгоход дэмжлэг үзүүлж, зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаас олгох" арга хэмжээг хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жилийн 9 хүртэл хувийн хүүтэйгээр санал болгож байна.

Аялал жуулчлал

3.4.Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.4.1.Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг Хөвсгөл, Хэнтий, "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II"-ийг Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Увс, Ховд зэрэг аймагт хэрэгжүүлж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг Хөвсгөл, Хэнтий аймгуудад хэрэгжүүлэх хүрээнд Хөвсгөл аймагт 3 чиглэлийн 37.9 км авто зам, 7 авто зогсоолын барилгын ажлын нийт гүйцэтгэл 22 хувьтай байна. Хөвсгөл нуурын БЦГ-т 15 км явган болон морин аяллын жимийн тохижилтын зураг төсөл боловсруулагдсан. Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Хэнтий аймгийн Дадал суманд хатуу хог хаягдлын ландшафт байгууламжийн барилга угсралтын ажил Дадал суманд 72 хувьтай, Хатгал тосгонд 80 хувьтай хийгдэж байна. Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх суманд Бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил Хатгал тосгонд 95 хувьтай хийгдэж байна. Хөвсгөлийн УТХГ-ын "Хамгаалалтын захиргаа/ жуулчны мэдээллийн төв"-ийн барилгын зураг төсөл боловсруулах ажил 70 хувьтай байна. Ханх сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил 95 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөг эцэслэн аймгийн ИТХ-аар 09-р сарын 29-ний өдөр батлуулсан. Чингис хаан аялал жуулчлалын цогцолборын шинэчилсэн дизайныг боловсруулах баг 2021 оны 6 дугаар сард эхний концепцыг боловсруулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 106 дугаар захирамжаар "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл II"-ыг санхүүжүүлэхэд зориулсан Монгол Улс, Азийн Хөгжлийн Банк хоорондын зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Сангийн сайд Б.Жавхланд олгосон ба БОАЖ-ын сайдын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 01/5748 тоотоор Азийн Хөгжлийн банкт байгуулах зээлийн хэлэлцээрийг УИХ-аар батлуулах хүсэлтийг хүргүүлсэн. 30 сая ам.долларын зээлийн гэрээг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулав.

3.4.2.Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд "Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор"-ын ажлуудыг цогц байдлаар дуусгаж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулна.

Биелэлт: Хэнтий аймгийн Батноров суманд "Хүлэг Боорчи-Андлалын өргөө" цогцолборын бүтээлийн зохиогч Д.Эрдэмбилэг агсны ар гэрээс "Бүтээл ашиглуулах гэрээ"-г цуцлах хүсэлтийн дагуу цогцолборыг буулгасан. Тус арга хэмжээний хүрээнд санхүүжилтгүй болсон тул Хэнтий аймгийн нутгийн зөвлөлийн санаачилгаар суурин дээр нь МУГЗ уран барималч А.Очирболдын загвараар "Тэнгэрийн Андгай" хөшөөг байршуулсан. Уг хөшөөний зардлыг иргэдийн хандиваар бүрдүүлсэн болно.

"Шихихутаг-Их засаг" цогцолборын ажлын хүрээнд дараахь 5 багц ажлууд хийгдэж байна. Үүнд: барилга угсралтын ажил-75 хувь, гадна шугам сүлжээний ажил-100 хувь, гадна тохижилтын ажил-65 хувь, барилгын дотор интерьер-30 хувьтай байна. Нийт 1365.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

"Их хуралдай" цогцолборын барилгын интерьер, дотоод уран сийлбэр шинэчлэл, гадна цахилгаан хангамжийн ажлыг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Улсын комисс ажиллан хүлээн авсан. Гадна ажлын гүйцэтгэл: газар тэгшилсэн 90 хувь, картограмм ажил буюу 3200м³ шороо зөөх ажил 70 хувь, 78ш гэрлийн шон цутгах ажил 100 хувь, гадна гэрэлтүүлэг монтажны ажил 90 хувь, худаг гаргах ажил 100 хувь, худаг, харуулийн байр-70 хувь, гэрэлтүүлгийн ажил 80 хувь, гадна хашаа барих ажил 90 хувь тус тус хийгдээд байна.

"Монголын нууц товчоо" цогцолборын барилгын үндсэн төмөр арагт бүтээц, гадна метал фасад-85 хувь, шилэн фасад-85 хувь хийгдсэн. Гадна цахилгаан хангамж 04/10 кВа-ийн КТП угсрах ажил 100 хувь дуусч ашиглалалтад оруулах комисс ажиллан 14 хоногийн хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Тус цогцолборын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.

3.4.3.Манзуширын түүхэн дурсгалт газрыг түшиглэн соёл, шашин, аялал жуулчлалын олон улсын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: Төслийн хувьд 250 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай, үүнээс зөвхөн сэргээн засварлах ажлуудыг улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлэж, үлдсэн санхүүжилтийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр төлөвлөж байна. Төслийн хөрөнгө оруулалт: 45 хувийг хөнгөлөлттэй зээл, 13 хувийг төсвийн хөрөнгө оруулалт, 36 хувийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар, 6 хувийг шашин, төрийн бус байгууллагын хөрөнгөөр байгуулахаар ТЭЗҮ-д тусгасан. Хөрөнгө оруулалт татах чиглэлээр ажиллаж байна. Эхний шатанд хийгдэх Манзуширын хийдийн сэргээн засварлалт, тохижилтын ажил хийгдэж дууссан.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 5 дугаар 10-ны өдөр хуралдсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтад Манзуширын хийдийн цогцолборын улсын төсвөөс хийгдэх ажилд 42 тэрбум төгрөгийг тусган санхүүжүүлэх саналыг хүргүүлсэн боловч батлагдаагүй.

3.4.4.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.

Биелэлт: НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг сэргээх стратеги төлөвлөгөөг боловсруулан баталсан. “Аялал жуулчлалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, УИХ-д 2022 оны 11 дүгээр сарын 28-нд өргөн мэдүүлэв. Мөн аялал жуулчлалын сан бий болгох хуулийн төслийг боловсруулж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөнд хамгийн их өртсөн аялал жуулчлалын салбарыг хэрхэн сэргээх талаар нэгдсэн ойлголтод хүрэх, дэлхийн аялал жуулчлалын чиг хандлага, аялал жуулчлалыг сэргээж буй арга, туршлага, сүүлийн үеийн аргазүйг хуваалцах зорилгоор БОАЖЯ, МҮХАҮТ, МАЖХ, Экспортыг дэмжих төсөл, төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтран “Шинэ хэвийн байдал-Аялал жуулчлалыг сэргээх стратеги” уриан дор “Tourism Forum Mongolia 2021” арга хэмжээг зохион байгуулсан. Форумын үр дүнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” А/379 дугаар тушаалаар “Аялал жуулчлалыг сэргээх стратеги төлөвлөгөө” боловсруулах ажлыг удирдан чиглүүлэх үүрэг бүхий Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Соёлын яам, Улсын онцгой комиссийн шуурхай штаб, Нийслэлийн онцгой комисс, мэргэжлийн холбоод болон хувийн хэвшлийн төлөөллүүдийг оролцуулан холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд нийцүүлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулагдан ажиллаж байна. 2021 оны байдлаар 29 мянган жуулчин ирсэн үзүүлэлттэй байна.

Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоолоор БНСУ-ын жуулчдыг визийн шаардлагаас чөлөөлсөн шийдвэрийг гарган, 2022 оны хувьд аялал жуулчлалын голлох зах зээлийн орныг Азийн орон гэж тодорхойлсон ба тус зорилтын хүрээнд Монгол Улсыг зорин ирж аялсан Солонгос жуулчдын тоо 50 мянгад хүрсэн ба 2022 оны 2 дугаар сарын 14-ний өдөр олон улсад хилээ нээснээ зарласнаас хойших 9 сарын хугацаанд Монгол улсад ирсэн гадаад жуулчдын тоо 240 мянгад хүрч эдийн засагт 307 сая ам.долларын орлого ороод байна.

3.4.5.Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжинэ.

Биелэлт: 2022 онд Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжих зорилтын хүрээнд Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, цар хүрээг өргөжүүлэхээр ажиллаж байна. Үүнд: Алтай таван богд Байгалийн цогцолбор газарт "Альпиниад-2022" их наадам, "Бүргэдийн баяр", Хөвсгөл аймагт "Хөх сувд" мөсний баяр, "Цаатангуудын баяр, Булган аймгийн Орхон сумын "Өрмийн цагаан нуур"-ын эрэгт "Айргийн баяр" арга хэмжээ, Өмнөговь аймагт "Тэмээний баяр", "Элсэн манхны баяр", Төв аймагт "Хонины найр", "Төр түмний цэнгэл" баяр наадам, Улаанбаатар хотод "Дээлтэй монгол" наадам, "Хүрээ цам" даншиг наадам, "Нүүдэлчин Монгол" наадам, "Наадам найт" арга хэмжээ, Плэй тайм арга хэмжээ, Өвөрхангай аймагт "Сарлагийн баяр", "Монгол эсгий урлалын баяр", "Монголын уламжлалт биет бус өв соёл дэмбээ наадгай", АйТиЭм олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, Шинэ сэргэлт ба Аялал жуулчлал 2022, Хорека Монголиа 2022 зочлох үйлчилгээний үзэсгэлэн, Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойд зориулсан "Зүүн бүсийн аялал жуулчлалын зөвлөгөөн" арга хэмжээ, "Талын түмэн адуу" нийт 30 гаруй арга хэмжээ зохион байгуулав.

2020 онд БОАЖЯ-аас "Айрагны баяр"-ыг 8 дугаар сарын 22-ны өдөр, Төв аймгийн Алтанбулаг суманд "Хонины найр" арга хэмжээг 7 дугаар сарын 25-ны өдөр, Баян-Өлгий аймаг Бугат суманд "Бүргэдийн баяр" арга хэмжээг 9 дүгээр сарын 03-ны өдөр, Хуралдай наадам "Шонхорын баяр"-ыг Чингис Хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт 10 дугаар сарын 03-ны өдөр, Сүхбаатар аймагт Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам, олон улсын гэрэл зурагчдын уралдааныг орон нутгийн онцлогт тулгуурлан иргэдийн оролцоотой тус тус зохион байгуулсан.

3.4.6.Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Биелэлт: 2022 онд Хэнтий аймгийн Жаргалтхаан суманд "Инсун мод" ХХК, Завхан аймгийн Сонгино суманд "Титан Би" ХХК, Архангай аймгийн Цэнхэр суманд "Заяын өгөөж" ХХК, Булган аймгийн Хутаг өндөр суманд "Уньтын рашаан" ХХК, Төв аймгийн Баянцагаан суманд "Мандах бадрах булаг" ХХК, Хэнтийн аймгийн Жаргалтхаан суманд "Инсун мод" ХХК өөрийн хөрөнгөөр авто замын дагуу үйлчилгээний цогцолборыг барьж ашиглалтад оруулсан. Мөн 2022 онд 10 отоглох цэгийг байгууллаа. 2021 онд Увс аймгийн Увс нуур, Хяргас нуурын Хар тэрмис болон Хэцүү хад, Архангай аймгийн Өгийнуур, Ховд аймгийн Хар ус нуурын УТХГ, Гурван Цэнхэрийн агуйд цэвэрлэх байгууламжтай нийтийн бие засах газар, сүүдрэвч, машины зогсоол, гэрэлтүүлэг, спорт талбай бүхий 5 отоглох цэгийг байгуулсан.

"Аялал жуулчлалын гол чиглэл болон хот хоорондын нийтийн тээврийн маршрутын дагуух үйлчилгээний цэгүүдийн мэдээлэл, судалгаа боловсруулах" судалгааны ажил хийгдсэн бөгөөд авто замын дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах 30 цэгийн байршлыг тогтоож, холбогдох аймгуудын ИТХурлаар хэлэлцүүлэхээр саналаа аймгуудад хүргүүлсэн. Одоогоор 12 цэгт баталгаажуулалт хийгдсэн. МҮХАҮТ-аас эдгээр цэгүүдэд үйлчилгээний цогцолбор байгуулах саналыг тавьсаны дагуу 18 аж ахуй нэгж, байгууллага хүсэлтээ ирүүлээд байна. Авто замын дагуу Төв аймгийн Баян сум, Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт үйлчилгээний цогцолбор байгуулагдаад байна.

Говийн бүсийн аялал жуулчлалын Өмнөговь, Дорноговийн чиглэлд аялал жуулчлалын нөөц, хүний нөөцийн нөхцөл байдал, статистик болон хууль эрх зүйн орчны судалгаа хийгдэж аялал жуулчлалын хөгжлийн бодлого, зөвлөмжийг гаргасан. Төслийн суурь судалгааны тайланг хүлээн авсан.

Монголын говьд шинжлэх ухаан, тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх Mars-V төслийг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2021 оны А/77 дугаар тушаалаар "Ажлын хэсэг" байгуулан төслийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулж баталсан. Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Нэмэхтийн хонгил гэдэг газарт "Сургалтын баазын загвар төв"-ийг байгуулахаар ажиллаж байна. Загвар төв баригдсаны дараа хөрөнгө оруулах олон улсын баг ирж төслийг хэлэлцэх ба үндсэн төсөл нь эцэслэгдэж түүнийг дагасан эцсийн ТЭЗҮ-г батлуулахаар MARS-V төслийн нэгж ажиллаж байна. АНУ-ын Марс гарагийн цөлийн судалгааны төв (Mars Desert Research Station)-тэй хамтран 2023 оны 05 дугаар сард эхний 6 хүний бүрэлдэхүүнтэй Марс дээр ажиллах багийг Монголын говьд бэлдэх сургалт, туршилтын хөтөлбөрийг боловсруулах ажлыг эхлүүлэхээр бэлтгэж байна.

3.4.7. Хил орчмын аялал жуулчлалыг дэмжиж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

Биелэлт: Хил орчмын аялал жуулчлалыг дэмжиж, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад улсын сайд Чирипов Даба-Жалсан Шагжиевич, Буриад Улсын аялал жуулчлалын сайд А.Д. Доржиев нартай уулзалт зохион байгуулж 2 улсын дотоодын аялал жуулчлалын 30 тур компанийн төлөөллүүд туршлага судлах болон цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцож, Монгол, Буриад хоёр улсын хамтарсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, ОХУ-ын дотоодын жуулчдыг төдийгүй цаашлаад Азийн бусад орнуудаас ирэх жуулчдын урсгалыг Байгаль нуурын аяллаар дамжуулан Монгол Улс уруу татах мөн Байгаль нуур-Хөвсгөл нуур чиглэлийн маршрутыг хөгжүүлж, бодит ажил хийхээр төлөвлөсөн. Монгол, Орос, Хятад 3 улсын сайд нарын "Цайны зам" аялал жуулчлалын хурлыг БНХАУ-д 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөөд байна. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын виз олгох журам шинэчлэгдэж хил орчмын жуулчдад 72 цагийн виз олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Хилийн боомт дээр цахимаар виз олгох болон дээрх журмын хэрэгжилтийг хангах зорилгоор хамтарсан мэдээлэл сурталчилгааны цогц ажлыг хэрэгжүүлэх тухай асуудлыг 5 дугаар сарын 4, 11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар танилцуулан тэмдэглэлд тусган ажилласан. БНХАУ-ын хил нээгдэх үед хил орчмын жуулчин авах бэлтгэлийн хүрээнд гарын авлага боловсрууллаа. ОХУ-аас буюу Монгол Улсын хойд хилээр орж ирэх Орос жуулчдын тоо сар бүр өсөлттэй байгаа байгаа бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 150.000 жуулчин Монгол Улсад аялж, 181 сая ам долларын орлого оруулсан байна.

Хил орчмын аялал жуулчлалыг дэмжиж, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "Цайны зам" хил дамнасан аялал жуулчлалын төсөл хэрэгжүүлэхээр Монгол, Орос, Хятад гурван улсын аялал жуулчлалын сайд нарын VI дугаар ээлжит хуралдааныг Монгол Улс цахим хэлбэрээр 2021 оны 12 дугаар сард зохион байгуулсан. Хурлын протоколоор "Цайны зам"-ын аялал жуулчлалын хамтарсан ажлын төлөвлөгөөг баталсан.

3.4.8. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.

Биелэлт: Цахим технологид суурилсан Монгол Улсын аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлэхэд зориулж mongoliatravel.guide цахим платформыг 2022 оны 7 дугаар сард ашиглалтад оруулсан. Үйл ажиллагаанд хөгжүүлэлт хийх ажлын хүрээнд 6 хэл дээр мэдээллийг бэлтгэж оруулсан бөгөөд цахим платформын хөгжүүлэлтийг сар бүр хийж байна. Хандалтын тоог нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхээр Япон Улсын агаарын тээврийн JAL компанитай хамтран ажиллахаар болсон. Гар утасны FeelMongolia аппликейшнийг хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлж, энэ онд "I Hotel" ХХК-тай хамтран цэс нэмэх,

21 аймгийн мэдээллийг нэмэх ажлуудыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байна. Аялал жуулчлалын цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд аялал жуулчлалын чиглэлээр иргэд, байгууллагад үзүүлдэг үйлчилгээг e-Mongolia платформд оруулах ажлыг үе шаттай хийж байгаагаас гадна аялал жуулчлалын салбарын цэсийг байршуулахаар хэлцэл хийж байна. Гадаад сурталчилгааны сэтгүүлийг Англи, Япон, Хятад, Орос, Франц, Герман хэлээр бэлтгэн, голлох зах зээлийн орнуудын жуулчдад цахимаар болон хэвлэмэл байдлаар түгээх ажлыг зохион байгуулсан. Гадаад сурталчилгааны 30 секундээс 10 минут хүртэлх 15 видео контентыг боловсруулж, түгээх ажлыг зохион байгуулсан. Нийгмийн сүлжээнүүдэд Монгол Улсыг сурталчлах хуудаснуудыг нээж, тогтмол мэдээлэл нийтэлж, идэвхижүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Цар тахлын дэгдэлттэй холбогдуулан Үндэсний их баяр наадмыг цахимаар зохион байгуулахтай холбогдуулан наадмын арга хэмжээг аялал жуулчлалын сурталчилгааны контент болгох ажлыг зохион байгуулж, нийт 5 хэл дээр, 10 цагийн бичлэг, 2,000 фото зураг боловсруулсан. Гадаадын жуулчдад зориулан нэг дороос мэдээлэл авах, аялах газраа сонгох, захиалга өгөх боломжийг бүрдүүлсэн "Travel to Mongolia" гар утасны аппликейшныг англи хэл дээр боловсруулж, 2020 оны 6 дугаар сараас ажиллуулж байна.

3.4.9. Аялал жуулчлалын сургалтын төв байгуулж, салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд байгуулсан яриа хэлэлцээрийн дагуу Монголын аялал жуулчлалын сургалтын төв байгуулах, салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төслийг хамтран хэрэгжүүлэхээр 2019 онд санамж бичиг зурсан. Аялал жуулчлалын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах хүрээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх, газрын инженер геологийн дүгнэлт гаргуулах, барилгын дэвсгэр зураг боловсруулах, архитектур төлөвлөлтийн даалгавар авах, сургалтын төвд цэвэр, бохир, ус холбогдох асуудлыг шийдвэрлэх, ТЭЗҮ, зураг, төсвийг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраар батлуулах, барилгын хөгжлийн төв ТӨҮГ-аар магадлангаар оруулж батлуулах ажлыг тус тус гүйцэтгэсэн. БНСУ-д 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Барилгын ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулах тендерийг зарлаж шалгаруулсан ба барилга угсралтын ажил эхэлсэн, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 10 хувьтай байна. Салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хүрээнд: “Зочид буудлын менежмент”, “Аяллын хөтөч”-ийн чиглэлээр нийт 500 хүнийг цахимаар сургалтад хамруулж гэрчилгээ олгосон. БНСУ-ын Си Жуон Их сургуулиас сайн суралцсан 20 хүнийг сонгон шалгаруулж, 2022 оны 4 дүгээр сарын 22-ноос 5 дугаар сарын 8-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад аялал жуулчлалын чиглэлээр тэргүүлэгч Си Жуон Их сургуулиас “Зочид буудлын менежмент, Аяллын хөтөч”-ийн чиглэлээр 80 цагийн сургалтад хамруулж гэрчилгээ олгосон.

Соёл, түүхийн аялал жуулчлалын хөтөч тайлбарлагч бэлтгэх сургалтыг 2021 оны 6 дугаар сарын 2-8-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулж нийт 600 хүнийг хамруулж гэрчилгээ олгов. “Зочид буудлын менежмент”, “Аяллын хөтөч”-ийн чиглэлээр 500 хүнийг сургалтад хамруулж, 20 хүнийг сонгон шалгаруулж БНСУ-ын Си Жуон Их сургуульд суралцуулах эрх олгоод байна.

Эрчим хүч

3.5. Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.

3.5.1. Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ:

3.5.1.1. Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг 46 МВт-аар, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар тус тус өргөтгөж шинэчилнэ.

Биелэлт: Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг 46 МВт-аар өргөтгөх төслийн эхний үе шатанд турбоагрегат №1, 4-ийг 2019 онд ашиглалтад оруулж горим ажиллагаанд холбосон. Төлөвлөгөөний дагуу турбоагрегат №2-ыг шинэчлэх ажлыг 2020 онд хийж дуусгасан бөгөөд турбоагрегат №3-ын шинэчлэх ажил дуусч 2021 оны 1 дүгээр сарын 07-ны өдөр сүлжээнд залгасан. Төсөл хэрэгжсэнээр цахилгааны нийлбэр хүчин чадал 89 МВт-аар, дулааны нийлбэр хүчин чадал 75 Гкал/ц-аар нэмэгдэж, уурын турбинуудын АҮК 2.5-3 хувиар нэмэгдэж, жилд 20000 орчим тонн жишмэл түлш, нүүрс хэмнэх юм. Шинэчлэлтийн төсөлд хамрагдсан дөрвөн турбоагрегатад техникийн комисс үе шаттайгаар ажиллаж, улмаар Улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх барилга угсралтын ажил бүрэн дуусч 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад авсан бөгөөд суурилагдсан хүчин чадал 35 МВт-аар нэмэгдэж төвийн эрчим хүчний системд 71 МВт-ын чадлаар ЦЭХ-ийг нийлүүлэн ажиллаж байна.

3.5.1.2. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлж, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

Биелэлт: Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/253 дугаар тушаалаар УЦС-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж, тендерийн үйл ажиллагааг зохион байгуулан шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээний хэлцлийг хийж, 2021.09.17-ны өдөр гэрээ байгуулсан. Нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн Өмнөговь сумын 125, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 өрхийн биет бус сэтгэл санааны хохирлын нөхөн олговор олгох асуудлыг Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоол гарсан. Иргэдтэй байгуулах нүүлгэн шилжүүлэх гэрээ, нөхөн олговрын гэрээний төслийг Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн Засаг дарга нарт тус тус хүргүүлж, гэрээ байгуулах ажлыг эхлүүлсэн. Усан сан үүсэх 9871.1 га талбайд 206 ширхэг түүх соёлын дурсгалын зүйлс өртөхөөр байгааг авран хамгаалах, малтлагыг 2022-2024 онд хийхээр төлөвлөж, 2022 онд шаардагдах төсвийг батлуулсан. БУА-ын бэлтгэл ажлын хүрээнд гүйцэтгэгч компаниас төслийн талбарт ажиллаж, ажлын зурагт шаардлагатай мэдээлэл цуглуулах, геологи, геофизикийн судалгааны ажил хийгдэж байна. БУА-ын кэмпиог ЦЭХ-ээр хангах ЦДАШ-ын трассын ажил хийгдэж байна.

3.5.1.3. Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөнө.

Биелэлт: Төсөл нийт 79,5 сая ам.доллараар хэрэгжих бөгөөд үүнээс Монгол Улсын хөрөнгө оруулалтаар 52 тэрбум төгрөг /19,5 сая ам.доллар/, Монгол улсын хөгжлийн банкны санхүүжилтээр 420 сая юань /60 сая ам.доллар/-аар санхүүжигдэнэ. Монгол Улсын төсвийн тухай хуульд 52 тэрбум төгрөг батлагдаж, 2020 онд 10 тэрбум төгрөг тусгагдсан ба төсвийн тодотголоор 7 тэрбум төгрөг болсон. 2021 оны Улсын төсөвт 6 тэрбум төгрөг тусгагдсан. Төслийн ерөнхий гүйцэтгэгч “ТБЕА” компани 2019 онд төслийн талбай дээр инженер-геологийн судалгааны ажил хийж дүгнэлт гаргуулсан. Мөн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу нийт гэрээний үнийн дүнгийн 30 хувийг өөрөө эхлэн санхүүжүүлж, ажлыг эхлүүлсэн бөгөөд, 2020 онд төслийн барилга угсралтын суурийн ажил гүйцэтгэв. 2021 оны хавар үндсэн барилга, тоноглолын угсралтын ажил эхэлсэн. 2020 онд:

1. Деаэратор болон нүүрсний бункерийн суурь -100 хувь

2. Турбины суурь - 85 хувь
3. Зуухны суурь - 100 хувь
4. Яндангын суурь - 90 хувь

5. Хөргөлтийн цамхагын суурь -100 хувь хийж гүйцэтгэсэн. Хил гаалийн хорио цээрийн улмаас 2020-2021 онуудад барилга угсралтын ажлыг хэвийн гүйцэтгэх боломжгүй хязгаарлагдмал нөхцөл байдалд ажиллаж, төслийн хэрэгжилт удааширч гэрээт хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон тул гүйцэтгэгчтэй байгуулсан ЭХА-012/2019 тоот гэрээг сунгасан. 2022 оны байдлаар төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 55 хувьтай, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл захиалга 98 хувьтай байна.

3.5.1.4.Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.

Биелэлт: Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийг Засгийн газрын 2020.04.08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, станцыг төрийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах тухай 124 дүгээр тогтоол гарсан. Хувьцаа эзэмшигчдийн 2020.10.05-ны өдрийн хурлаар “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн дүрэм, бүтцийг баталсан. Төслийн санхүүжилтийн 30 хувийг шийдвэрлэх асуудлаар Засгийн газрын 2020.11.11-ний өдрийн 175 дугаар тогтоол гарч “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн 30 хувийг “Эрдэнэс–Тавантолгой” ХК-д эзэмшүүлэх ажлыг зохион байгуулав.

Эрчим хүчний яамнаас 450 МВт-ын Тавантолгой дулааны цахилгаан станц, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2 удаа зарласан боловч тендерт оролцсон компани тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй.

3.5.1.5.төвийн, зүүн болон говийн бүсийн нүүрсний орд газруудыг түшиглэн 300-400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: Багануурын цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг бууруулахгүйгээр нэгж агрегатын хүчин чадлыг бууруулан 2*200МВт+300МВт болгосон ТЭЗҮ-ийг Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2020.01.09-ний өдрийн хурлаар хэлэлцэн зөвшилцсөн. Концессын гэрээний дагалдах Цахилгаан эрчим хүч худалдах худалдан авах гэрээнд өөрчлөлт оруулж, диспетчерийн зохицуулалтад оруулах асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж, гэрээний өөрчлөлтийг тохирсон. Концесс эзэмшигч “Багануур Пауэр” ХХК болон Төрийн худалдан авах ажиллагааны газар хооронд концессын нэмэлт гэрээ 2021.05.14-ний өдөр байгуулагдсан. Концессын гэрээнд өөрчлөлт орсонтой холбогдуулан Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд өөрчлөлт оруулахаар “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, концесс эзэмшигч “Багануур Пауэр” ХХК хооронд хэлцэл хийгдэж, 2021.07.23-ны өдөр нэмэлт гэрээ №2-г байгуулсан. Концессын дагалдах гэрээ болох “Нүүрс худалдах, худалдан авах гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар 2 талууд хэлцэл хийж, гэрээний төслийг эцэслэн тохиролцсон. Эрчим хүчний яамнаас Багануурын 2х200 МВт-ын цахилгаан станцыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох техникийн нөхцөлийг 2021.09.22-ны өдөр олгосон. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас 2021.12.01-ний өдөр Усны дүгнэлт гарсан бөгөөд тус дүгнэлт болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тодотголыг БОАЖЯ-нд хүргүүлж, батлуулах ажлыг гүйцэтгэж байна. Захиалагчийн техник хяналт, газар эзэмших, ус ашиглах зэрэг бусад концессын дагалдах гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон Төрийн холбогдох байгууллагуудаас шаардлагатай тусгай зөвшөөрлүүд авах ажил хийгдэж байна.

Барилга угсралтын ажлын хувьд нийгэм, ахуйн барилга байгууламж 70 хувь, станцын үндсэн туслах тоноглол үйлдвэрлэгдэж байгаа, үйлдвэрлэлийн барилгын ажил эхэлсэн явцтай байна.

3.5.1.6.160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барина.

Биелэлт: Төслийн ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээний болон бусад холбогдох тайлангууд хийгдэж батлагдсан. Төсөл хэрэгжих газрын эзэмшлийг шийдвэрлэсэн. Төслийн бие даасан 2 зөвлөхийг нээлттэй сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажилд хяналт тавих Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж шалгарсан ХБНГУ-ын RWE technology International компанитай Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.04.30-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг гэрээний хэлэлцээр хийж, гэрээ байгуулагдах шатанд байна.

Том чадлын эрчим хүчний хуримтлуурын системийн “Зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралт суурилуулалтын ажлын гүйцэтгэгч” (ЕРС)-ийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулж, Азийн Хөгжлийн банкнаас тендер зарлах зөвшөөрөл авч түлхүүр хүлээлгэн өгөх гэрээний нөхцөлтэй барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.05.07-ны өдөр зарлаж, төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын ZTT-ZEST консорциум шалгарч, 2022 оны 7 дугаар сард гэрээнд гарын үсэг зурсан ба АХБ-ны зөвлөмжийн дагуу гэрээнд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан. БУА-ыг 2022.08.04-ний өдөр эхлүүлсэн ба төслийн ажлын зураг хийгдэж байна. Ерөнхий зураг төслийн ажлын хүрээнд ДҮТ ТӨХХК, ЦДҮС ТӨХК, Төслийн менежментийн зөвлөх компани (ТМЗК) зэрэг талуудын хамтарсан хурлыг 2022.10.26-ны өдөр зохион байгуулж шийдлүүд дээр саналуудаа нэгтгэв.

3.5.1.7. Амгалангийн дулааны станцын хүчин чадлыг хосолмол 50МВт-аар нэмэгдүүлнэ.

Биелэлт: Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийн талаар Хөгжлийн банктай хамтран ажиллаж байна, банкны шаардлагын дагуу ТЭЗҮ-д нэмэлт оруулж, хүргүүлсэн. 2020 онд Хөгжлийн банкнаас “Амгалан дулааны станц” ХХК-ийг бие даасан төрийн өмчит компани болгон өөрчлөн зохион байгуулсны дараа зээл олгохыг шийдвэрлэхээ мэдэгдсэн. Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компани болгон бүтэц, зохион байгуулалтыг нь өөрчилсөн. 2020 оны 04 дүгээр сард хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулсан. Бие даасан компани болсноос эхлэн Хөгжлийн банканд зээлийн судалгаа эхлээд байна. Амгалан дулааны станцыг 116 МВт (100 Гкал/ц) хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөх төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, БНХАУ-ын “Хунан индустриал экүипмент инсталейшн” ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр түлхүүр гардуулах нөхцөлтэй барилга угсралтын ажлын гэрээг байгуулсан. Уг гэрээний дагуу гүйцэтгэгч компаниас зураг төслийн ажлыг хэсэгчилсэн байдлаар хийж байна. Хөгжлийн банкны охин компани “Ди Би Эм лизинг” ХХК, Амгалан ДС, гүйцэтгэгч компанитай 2022.10.26-ны өдөр уулзалт зохион байгуулж, төслийн 85 хувийн санхүүжилт болох санхүүгийн түрээсийн гэрээ байгуулах бэлтгэл хангагдсан. Гэрээг холбогдох байгууллагуудаар албажуулж байна.

3.5.1.8. Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа цахилгаан, дулааны хэрэглээ болон эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Улаанбаатар хотын Дулааны II цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станцын ажлыг төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар эхлүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын эрчим хүчний системд түргэн маневрлах чадвартай турбингенератортой болох зорилгын хүрээнд 50*2 МВт-ын хийн генератор бүхий 100 МВт-ын цахилгаан станцыг ДЦС-2-ыг түшиглэн барьж байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулан 2020 оны 02 дугаар сард ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. “ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн хийн станц барих чиглэлээр нийт 3 ТЭЗҮ, 2 судалгааны ажил хийгдсэн байсныг нэгтгэн, хийн дэд бүтэц, нийлүүлэлтийг хэрхэн шийдвэрлэх асуудлаар дэлгэрүүлэн судалгаа хийж байна. Япон Улсын Хилийн чанад дахь байгаль орчны хамтын ажиллагааны төв (ОЕСС)-өөс Мицубуши Повер компаниас 3х33 МВт-ын устөрөгч болон хийн хосолсон турбиныг санал болгосны дагуу судалгааны ажлыг эхлүүлээд байна. Засгийн газрын 2022 оны 309 дүгээр тогтоолоор “ДЦС-2” ТӨХК-ийн дэд бүтцийг түшиглэн барих 100 МВт-ын хийн цахилгаан станц төсөл”-ийг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д тусгуулах саналыг хэлэлцүүлж, концессын зүйлийн жагсаалтад оруулсан.

ДЦС-3-ын дунд даралтын станцыг буулган 250 МВт-ын станц барих, өндөр даралтын станцын хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. “Дулааны 3 дугаар цахилгаан станцын өндөр даралтын станцын хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх” ТЭЗҮ-ийг боловсруулж, салбарын Шинжлэх, ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. “ДЦС-3” ТӨХК болон Интер РАО Экспорт компанийн хооронд хамтран ажиллах санамж бичгийг 2021.07.09, 2021.12.16-ны өдөр тус тус байгуулж, Интер РАО Экспорт компанийн зүгээс төслийн ТЭЗҮ-ийг 2022 оны 08-р сарын 29-ний өдөр “ДЦС-3” ТӨХК-д хүлээлгэн өгсөн. ОХУ-ын талаас ирүүлсэн төслийн ТЭЗҮ-г судлах хүрээнд Интер РАО-Экспорт, “ДЦС-3” ТӨХК хооронд 2022.10.03-ны өдөр техникийн асуудлаар, 2022.10.24-25-ны өдрүүдэд ЭХЯ-ны удирдлагууд, “ДЦС-3” ТӨХК-ийн төлөөлөл болон Интер РАО Экспорт компанийн төлөөлөлтэй уулзалт хийж, санал солилцов.

ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооноос Эгийн голын усан цахилгаан станцын төсөлтэй холбогдуулан Сэлэнгэ мөрөн, Байгал нуурын Биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааг хийх зөвлөмж гарсан. Франц Улсын “БРЛ Инженер” компани, Монгол Улсын “Престиж Инженеринг” ХХК, “Санни Трейд” ХХК-ийн түншлэлтэй байгуулсан Зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.10.31-ний өдөр хүртэл сунгасан. Тус компанитай 2022.05.27-ны өдөр төслийн явцын талаар уулзалт хийсэн. Судалгааны тайланг зөвлөх компаниас гэрээний дагуу 2022.10.31-нд ирүүлснийг Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Тус зөвлөлөөс Усны зөвлөлөөр хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн.

3.5.1.9.нийслэлийн Багануур, Налайх дүүргүүдэд дулааны станцын өргөтгөл шинэчлэлт хийх; эрчим хүчний шинэ эх үүсвэр, дэд станц шинээр бий болгоно.

Биелэлт: Нийслэлийн Багануур, Налайх дүүргүүдэд дулаан хангамжийн шинэ эх үүсвэр барих ТЭЗҮ боловсруулах ажлыг 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр “ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төсөл арга хэмжээний жагсаалт”-д тусган зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагаа хийгдэж байна. Эрчим хүчний эх үүсвэрийн төслүүдийн ТЭЗҮ боловсруулагдсан ба ТЭЗҮ-д төслийн ерөнхий зураг төсөл хийгдсэн бөгөөд нарийвчилсан буюу ажлын зураг гүйцэтгэгчийн сонгосон технологийн сонголттой уялдан хийгдэх юм. Төслийн техник эдийн засгийн үндэслэлийн төслүүдийг тус бүр 2-3 удаагийн хэлэлцүүлэг хийж, эцсийн тайланг ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021.12.21-ний өдрийн хурлаар хэлэлцэн дэмжсэн.

3.5.2.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана.

Биелэлт: Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 03 тоот захирамжаар Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийн бэлтгэл ажлыг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын хүрээнд хий хоолойн трассын дагуу байрших ашигт малтмалын илрэл, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг хүргүүлсэн. Судалгааны ажил дууссан бөгөөд ТЭЗҮ-г Тусгай зориулалтын компани “Газопровод Союз Восток” ХХК боловсруулж байна. Оросын Холбооны Улс, БНХАУ-ыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийн бэлтгэл ажлыг хангах асуудлын хүрээнд зарим аймаг, сумдын нутаг дэвсгэрийг хамарсан байр зүйн зургийг бэлтгэв. ОХУ-аас БНХАУ руу дамжуулан барих байгалийн хийн хоолой /трассын хувилбар нь/ нь манай улсын нийслэл Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь зэрэг хүн ам ихээр төвлөрсөн суурьшлын бүсүүдээр дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн. 2022.02.28-ны өдөр инженерийн хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудын даалгаврыг баталж “Газопровод Союз Восток” ХХК блон “Газпром Проектирование” ХХН-ийн хооронд инженер хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудыг гүйцэтгэх гэрээнд гарын үсэг зурсан. Үүний дагуу 2022.04.28-ны өдөр инженерийн хайгуул судалгааны ажил эхэлж, судалгааны ажил хэвийн явагдаж байна. 2023 онд тус төслийг гүйцэтгэхэд ОХУ-аас 30 ажилтан ажиллахаар төлөвлөсөн.

3.5.3.Төвлөрсөн хот, сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна. /Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Дундговь, Говьсүмбэр, Төв, Сүхбаатар, Хэнтий аймагт дулааны станц барина./

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын “Экспорт-Импорт банк”-ны холбогдох албан тушаалтнууд 2018.12.17-ны өдөр гарын үсэг зурж, 2018.12.26-ны өдөр хүчин төгөлдөр болсон. 2018 онд БНСУ-ын буцалтгүй тусламжаар төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж, Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн судалгаа хийгдсэн. Төслийн Зээлийн гэрээнд заасны дагуу барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг амжилттай зохион байгуулахын тулд багцлах болон техникийн зарим шаардлагад өөрчлөлт оруулах саналыг БНСУ-ын “Экспорт-Импорт” банканд хүргүүлж, зөвшөөрөл ирсний дагуу тендерийн баримт бичгийг эцэслэн боловсруулсан.

2022 оны байдлаар: Багц-1 /Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Говь-Алтай/, Багц-3 /Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймаг/-ын гүйцэтгэгчээр шалгарсан Бюксан Инженеринг компанитай 2021.12.27-ны өдөр гэрээ байгуулсан. Дээрх 7 аймгийн төвд 2022.05.06-наас 23-ны өдрүүдэд БУА-ыг эхлүүлсэн ба 22 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Багц-2 /Төв, Дундговь аймаг/-ын тендерт оролцогч шаардлага хангаагүй тул тендерээс татгалзаж, дахин зарласан. Мөн Бюксан Инженеринг компани шалгарч, 2022.07.06-нд ЭХЯ-тай гэрээний хэлцэл хийж, БНСУ-ын ЭКСИМ банк зөвшөөрснөөр 2022.08.25-ны өдөр албажсан. Бүх аймгуудад түр цахилгааны хангамж, ажилчдын түр байр, усан хангамжийн асуудлууд шийдвэрлэгдсэн. Станцын үндсэн, туслах тоног төхөөрөмжийн захиалга өгөгдөж, үйлдвэрлэж байна. 8 аймагт станцын барилгын суурийн хөрс хуулалт, ухлагын ажил суурийн нягтруулга, ул бетоны хэв хашмал хийгдэж, ул бетон, суурийн арматурчлал хийгдэж байна. Хэнтий аймагт их хэмжээгээр хөрсний ус гарч, хөрсний ус зайлуулах ажил хийгдэж байгаа нь барилгын ажилд хүндрэл учруулж байна. 2022 онд төлөвлөсөн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85 хувьтай. Архангай аймгийн “Эх голомтын илч” ХХК төслийн хэрэгжилтийг эсэргүүцэж шүүхэд гомдол гаргасан. Нийслэлийн захиргааны хэргийн шүүхээс Архангай аймагт төсөл хэрэгжүүлэх асуудлыг түр зогсоох

мэдэгдлийг ЭХЯ-нд ирүүлснээр төслийг тодорхойгүй хугацаагаар зогсоосон. Дээд шүүхийн шийдвэр 9-р сард, төслийг үргэлжлүүлэхээр болсон. Гүйцэтгэгчийг сонгох худалдан авалтын ажлыг зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Төсөл хэрэгжиж буй 9 аймгийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргасан.

Нийслэлийн Багануур дүүргийн дулаан хангамжийн эх үүсвэрийн ТЭЗҮ, Хөвсгөл аймгийн Хатгал сумын шинэ дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ, Өвөрхангай аймгийн Баянтээгийн уурхайг түшиглэн цахилгаан станц барих ТЭЗҮ боловсруулах ажлыг гүйцэтгэн ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021.12.21-ний өдрийн хэлэлцэн дэмжсэн.

Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төслийн 2021 оны төлөвлөгөөний дагуу 5а магистраль шугамын 2, 3, 4-р багц, 3г магистраль шугам, уурын түр шугамын угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгчидтэй гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн, он дамжин хэрэгжинэ.

“Улаанбаатарын дулаан хангамж” төсөл хэрэгжиж байна. 2021 онд нийт 6 багц тендер зарласнаас 4 багц /1, 2, 3, 5/-д материал ирүүлснийг үнэлж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй, улсын комисс ажилласан.

2022 онд МУ-ын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн дулааны эх үүсвэр, шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүллээ. Хэнтий аймагт улсын төсвийн 5,970.2 сая төгрөгийн санхүүжилтээр дулааны шугам сүлжээний ажил хийгдэж байна. Барилга угсралтын ажил 2023.07.01-ний өдөр хүртэл үргэлжилнэ. Төв аймагт 2022-2023 оны Улсын төсвийн 11,632.5 сая төг-ийн санхүүжилтээр дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн төсөл арга хэмжээ хэрэгжиж байна.

3.5.4.Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах инновац, шинэ техник технологи нэвтрүүлж, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ.

Биелэлт: Дэлхий даяар COVID-19 халдварт өвчин гарсантай холбоотойгоор Монгол Улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээ төлөвлөсөн хэмжээнээс 2.3 хувиар буурч, хэрэглэгчдийн төлбөрийн чадвар буурах, хэрэглэгчдээс авах авлагын хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор хэрэглэгчдийн цахилгаан, дулааны тарифыг индексжүүлэх асуудал хойшлогдсон. Эрчим хүчний зохицуулах хорооны 2022.10.28-ны өдрийн хурлаар аж ахуйн нэгж байгууллагын цахилгаан эрчим хүчний үнэд өөрчлөлт оруулсан.

Түгээх сүлжээний алдагдлыг бууруулах, ухаалаг тоолуур суурилуулах, ухаалаг тоолуур, борлуулалтын нэгдсэн программ хангамж нэвтрүүлэх ажил хийгдэж байна. Борлуулалт, арилжааны программ нэвтрүүлэх ажлын хувьд "ЕСМ" ХХК-тай хийсэн гэрээний дагуу программыг нийлүүлж, хэрэгжүүлж, хүлээн авсан. Орхон, Булган, Өвөрхангай, Хархорин, Архангай салбаруудад мэдээллийн бааз хөрвүүлж сургалт хийгдэх ажлын гүйцэтгэл 85 хувь болж борлуулалтын үйл ажиллагаа шинэ бүтцээр ажиллах боломжтой бүрдсэн. Төслийн БУА-уудаас Говьсүмбэр аймгийн төвийн шугам сүлжээг шинэчлэх ажил 92,7 хувь, Багануур дүүргийн шугам сүлжээг шинэчлэх ажил 89,0 хувь, Өвөршандын 35/10кВ-ын 10МВА дэд станцын БУА 100 хувь, Булган аймгийн төвийн шугам сүлжээний шинэчлэлт 84,4 хувь, Архангай аймгийн төвийн шугам сүлжээний шинэчлэлт 86,4 хувь, Эрдэнэтийн 35/6кВ-ын 2*10МВА дэд станц 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

3.5.5.Бүс нутгийн эрчим хүчний сүлжээг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбож, уул уурхай, хүнд үйлдвэрийн мега төслүүдийн цахилгаан хангамжийг үе шаттайгаар шийдвэрлэж, ухаалаг систем бий болгоно. /Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.

Биелэлт: 2020 онд төслийн зөвлөхийг сонгон шалгаруулж, “Чойр-Сайншандын 220 кВ-ын ЦДАШ, 220 кВ-ын дэд станц”-ын техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчин, нийгмийн судалгааг хийлгэж байна. Мөн Техникийн туслалцааны хүрээнд төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэхээр зөвлөхийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. Эрчим хүчний сайдаас 2021 оны 04 дүгээр сард төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх саналыг ЕСБХБ-нд хүргүүлсэн.

Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил хийгдэж баталгаажсан. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор АХБ болон ЕСБХБ-тай хамтран ажиллаж Засгийн газрын 2022.02.30-ны өдрийн 18 дугаар тэмдэглэлээр АХБ-ны санхүүжилтээр гүйцэтгэхийг дэмжсэн.

2022 оны байдлаар Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих барилга угсралтын ажлын хүрээнд 110/35/6 кВ-ын 10 МВт-ын хүчин чадалтай дэд станцын газрыг өөрчилж дахин геодезийн дүгнэлт хийлгэж, шинээр газар сонгон талбайг тэгшилж дэд станцын барилгын суурийн ажлыг эхлүүлсэн. Шугамын болон бусад тоног төхөөрөмжүүдийг 100 хувь захиалсан, дэд станцын газар шорооны ажлууд хийгдсэн. Станцын газардуулга болон хашаа барьсан. Дэд станцын тоноглолын суурь УСО босгож дуусгасан. 110кВ-н ЦДАШ-н тулгуур гагнах, тулгуурын нүх ухах ажил хийгдэж байна.

“Мандалговь-Арвайхээр 220 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ, 2х63 МВА хүчин чадалтай 220 кВ-ын дэд станц”, “Сайншанд-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 190 км ЦДАШ, дэд станцын өргөтгөл” барих төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил хийгдсэн бөгөөд төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг ЭХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн дэмжсэн.

2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэл болон орон нутагт хэрэгжиж байгаа /Төв аймгийн Баянцагаан сум, Увс аймгийн Баруунтуруун сум, Булган аймгийн Бугат, Ханжаргалант сум, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сум, Завхан аймгийн Улиастай сум, Ховд аймгийн Үенч сум, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг/ цахилгааны шугам сүлжээг шинэчлэх 10 ажил хийгдэж байна, 2022 онд үргэлжлэн хэрэгжинэ.

2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж нийт 36.05 тэрбум төгрөгийн өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ байгаа бөгөөд тэдгээр ажлын гүйцэтгэл дунджаар 80.2%-ийн гүйцэтгэлтэй байна. 3 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусан Улсын комисс ажилласан.

3.5.6.Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах ногоон үйлдвэрлэлийн төслүүдийг хэрэгжүүлнэ. /Салхины цахилгаан станцын 15 МВт-ын хоёр, нарны цахилгаан станцын 35 МВт-ын дөрвөн төсөл хэрэгжүүлнэ/

Биелэлт: Завханы Улиастайн 5 МВт-ын НЦС, 3.6 МВт*ц-ийн цэнэг хураагуурын станцын БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан Япон Улсын JGC, NGK, Монгол Улсын MCS international түншлэлтэй гэрээ байгуулсан ба барилга угсралтын ажил дуусаж 2022 оны 11 дүгээр сарын 26-нд ашиглалтад орсон. Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанитай 2022.05.16-ны өдөр түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг байгуулсан. Талбайд инженерийн хайгуул, судалгааны ажил хийгдэж, барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж байна. Ховд аймгийн Мянгад суманд барих 10 МВ-ын нарны станцын барилга угсралтын ажил 100 хувьтай байна. Говь-Алтай аймгийн Алтай сумын 0.5МВт хосолмол системийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. Төслийн гүйцэтгэл 100 хувьтай.

Газрын гүний дулааны эх үүсвэрийг ашиглах загвар төслүүдийг 5 байршилд хэрэгжүүлэхээс 2022 онд 1 төслийг ашиглалтад оруулж, 1 төсөл дуусах үе шатанд, 3 төсөл худалдан авалтын шатанд байна. Үүнд: Ховд аймгийн Жаргалант сумын 1,500 м² талбайтай Нэгдүгээр цэцэрлэгийн барилгын дулаан хангамжид 135 кВт-ын хүчин чадал бүхий газрын гүний дулааны насосыг суурилуулан 2022 оны 01 дүгээр сард байнгын ашиглалтад оруулсан. Завхан аймгийн Улиастай сумын 2-р сургуулийн өргөтгөлийн барилгын дулаан хангамжид 110 кВт-ын хөрсний дулааны насосын систем суурилуулах ажлын гүйцэтгэл 82 хувьтай. Баянхонгор аймгийн Өлзийт, Говь-Алтайн Алтай, Увсын Өмнөговь сумдад хэрэгжүүлэх газрын гүний дулааны систем суурилуулах төслүүдийн тендерийг 2022.12.09-ний өдөр нээхээр байна.

Эрчим хүчний яамнаас 100 МВт-ын хүчин чадалтай Усан цэнэгт цахилгаан станц барьж байгуулах боломжтой газруудын талаарх урьдчилсан судалгааны ажлыг хийж Хэрлэн голд 3, Ерөө голд 1, Орхон голд 1 байршлыг тус тус илрүүлж, урьдчилсан тооцоо, судалгааны дүнд Хэрлэн голд Усан цэнэгт цахилгаан станц барих байрлалыг олох, ТЭЗҮ хийх судалгааны ажлыг эхлүүлэх, мөн Төвийн бүсийн эрчим хүчний системд горим тохируулгын үүрэгтэй ажиллах Ус хуримтлуурын ЦС барих ТЭЗҮ боловсруулах төслийг Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Өөрийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх хэрэглэгчдийн нийлбэр чадал 2022 оны эцсийн байдлаар 802 кВА (0.76 МВт)-д хүрсэн байна.

3.5.7.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн орон нутагт хэрэгжүүлэх иргэний болон үйлдвэрлэлийн барилга байгууламжийн томоохон төслийн эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, дэд бүтцийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хийнэ. /Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ./

Биелэлт: “Улаанбаатар хотын шинэ дагуул хотуудыг түшиглэн баригдах дулаан, цахилгааны 5 дахь эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах” ажлын зургийн даалгаврыг баталж, үнэлгээний хороог байгуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллан 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдөр тус ажлын гүйцэтгэгчээр “Мон энерги консалт” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. 2022 оны төсвийн тухай хуулиар эхний ээлжийн инженерийн шугам сүлжээнд нийт 33.0 тэрбум, үүнээс 4.0 тэрбум төгрөгийг 2022 онд санхүүжүүлэхээр батлагдсан. Хөшигийн хөндийн 1:5000 масштабтай байр зүйн зургийг боловсруулж дуусган хүлээн авсан. “Хөшигийн хөндий орчмын шинэ дагуул хотын дэд бүтэц” төслийн хүрээнд “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн цахилгаан хангамж зураг төслийг Эрчим хүчний хөгжлийн төвийн 215/2022 тоот магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулж, зураг төсөл 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

“Олон улсын нисэх онгоцны “Чингис хаан” буудлыг түшиглэн бий болох Богд хаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлох 2020/46 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын даалгавар”-ыг Барилга, хот байгуулалтын сайд баталсан. Тус ажлын гүйцэтгэгчээр нийслэлийн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ шалгарч, 2021.01.28-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.

220/110/35 кВ-ын Сонгино дэд станцын барилга угсралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулсан. Тус дэд станцыг ашиглалтад оруулснаар эрчим хүчний салбарын 2020-2021 оны өвөлжилтийг хүндрэлгүй давах, улмаар цахилгаан хангамжийн тасралтгүй

найдвартай, аюулгүй байдлыг дээшлүүлэх, Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, олон улсын нисэх онгоцны буудлын цахилгаан хангамжийн асуудал шийдвэрлэгдсэн.

Тээвэр, логистик

3.6.Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.

3.6.1.Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ:

3.6.1.1.Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж дуусган, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлнэ.

Биелэлт: 2021 оны байдлаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км урт төмөр замын доод бүтцийн барилгын ажлын гүйцэтгэл нийт 93.6 хувь, дээд бүтцийн барилга, угсралтын ажлын нийт гүйцэтгэл 83.6 хувь, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.2 км урт төмөр замын доод бүтцийн барилгын ажлын гүйцэтгэл нийт 100 хувь, дээд бүтцийн үе угсралт, суурилуулалтын ажил 97.6 хувийн тус тус биелэлттэй байна. Тавантолгой өртөө, 4, 5, 6 дугаар зөрлөгийн дохиолол төвлөрүүлэлт, хориглол ба холбоо мэдээллийн байгууламжийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд урьдчилсан дүгнэлт гаргах Техникийн комисс 2022.09.05-07-ны өдрүүдэд ажилласан.

Өмнөговь аймгийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын төслийн барилгын ажлын нийт гүйцэтгэл 99 хувьтай байна. **Тус төмөр замыг 2022 оны 12 дугаар сард багтаан барилгын ажлыг бүрэн дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.**

Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын техник-эдийн засгийн судалгааны ажил эхлүүлсэн. Төслийн урьдчилсан ТЭЗҮ төслийн трассын дагуу судалгааг БНСУ-ын Ёошинг инженеринг ХХК хийж байгаа бөгөөд төслийн төлөвлөгөөний дагуу урьдчилсан ТЭЗҮ 2023 онд дуусах төлөвлөгөөтэй байна.

Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК байгуулан Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулах, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж шалгарсан хоёр компанитай уулзалт хийж, эхний ээлжинд эдгээр компаниудаас хэрхэн хамтран ажиллах талаар саналуудыг бичгээр хүлээн авч дахин санал солилцохоор тохиролцсон. Концессын сонгон шалгаруулалт удааширч байгаа тул “МТЗ” ТӨҮГ-аас ТЭЗҮ-г боловсруулж байна.

Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 217 дугаар тогтоолоор “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын төслийг “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр уралдаант шалгаруулалт явуулахаар шийдвэрлэсэн. Төслийн концессын гэрээг “Монголиан транс лайн” ХХК болон “Монголиан транс ложистик” ХХК-ийн нэгдэлтэй байгуулах эрхийг Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын хуралдаанаар олгосон. Төслийг 2022 оны 03 дугаар сарын 11-нд эхлүүлсэн бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд: Газар шорооны ажил 100%, гүүрийн ажил 99%, ус өнгөрүүлэх хоолойн ажил 100%, дээд бүтцийн ажил 82%, эрчим хүчний ажил 62%, өртөө зөрлөгийн барилга 95%, дохиолол холбооны ажил 15%, төслийн барилгын ажлын нийт гүйцэтгэл 90 хувьтай байна.

3.6.1.2. Улаанбаатар төмөр замд техникийн болон парк шинэчлэлийг эхлүүлж, 200 км гол замд их засвар хийнэ.

Биелэлт: "Улаанбаатар төмөр зам" ХНН нь 2021 онд 80 км их засвар хийхээр төлөвлөсөн бөгөөд Оорцог-Энгэр-Наран-Элгэн-Агуйт хоорондын замд 56,9км, Толгойт-УБ-Амгалан 18,1км, Баян зөрлөг гол зам 1,1км, Цагаан хяр зөрлөг гол зам 1,4км, Замын-үүд-1 өртөө- Улсын хил хооронд 3,2км замд тус тус их засвар гүйцэтгэж 11 дүгээр сарын 15-ны өдөр 80.7км-ыг бүрэн дууссан.

"УБТЗ" ХНН 2020 оны зам засварын төлөвлөгөөнд 69 км төмөр замыг 57,9 тэрбум төгрөгөөр засварлахаар тусгуулсан бөгөөд 2020.10.27-ны өдрийн байдлаар төлөвлөгөөнд туссан 69 км төмөр замын их засварын ажлыг бүрэн хийж дуусгаад байна.

2022 онд зам, засварын ажлын гүйцэтгэх хугацааг 7/20-11/15-ны хооронд байхаар төлөвлөн, Эмээлт зөрлөгийн 2.3 км сунгалтын ажлыг эхлүүлж, Цомог зөрлөгт 4.5 км сунгалтын ажил дуусаад байна. Замын-Үүд-Шаргын-Овоо чиглэлийн 14.3 км төмөр замыг хос болгох тухай ТЭЗҮ-ийг ЗТХЯ-ны ШУТЗ-ийн дэд зөвлөл болон ШУТЗ-өөр хэлэлцүүлэн, батлуулсан. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгааны ажлууд болон зураг төсөл бүрэн хийгдсэн, БОНБУ боловсруулах, Инженер-геологийн ажлын гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж мөн газар шорооны ажлыг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж төслийн талбайд барилгын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2022 оны байдлаар доод бүтцийн ажлын туслан гүйцэтгэгчээр шалгарсан "Их харгуйн зам" ХХК нь 1700 м3 хөрс хуулалт хийсэн, 5000 м3 далангийн ажил хийгдсэн. Төслийн доод бүтцийн ажил 100%, бетон дэр үйлдвэрлэлт- 100%, зам төмөрийн татан авалт-30%, зам төмөр дэрийн сараалжийг угсрах-5.3 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

3.6.1.3. Богдхан төмөр зам болон баруун босоо чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийг хийж дуусгана.

Биелэлт: "Богдхан төмөр зам" төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг гүйцэтгүүлэхээр АХБ-тай хамтран ажиллаж байна. Богдхан төмөр замын шугамын ерөнхий чигийг шинэчлэн судалж, барилга байгууламжийн байршлын давхардлыг бууруулсан, техникийн шийдлийг сайжруулсан, хот төлөвлөлт, тээвэр, логикийн хөгжүүлэлттэй уялдсан хоёр хувилбарыг боловсруулаад байна. Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д 5 жилийн хугацаатай, мөн 254 дүгээр тогтоолоор суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д тус тус олгосон. Богдхан төмөр замын ТЭЗҮ-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК боловсруулан Төмөр замын салбарын технологийн дэд зөвлөлөөр 2022.01.07-нд хэлэлцүүлсэн. Төслийн эхний 37.5 км төмөр замын зураг төслийг Барилгын хөгжлийн төвөөр батлуулж, барилгын ажил 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр эхэлсэн.

"Баруун чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах" ажил гүйцэтгэх, гүйцэтгүүлэх гэрээг байгуулан ажлын эцсийн тайланг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авч хянаж байна. Урьдчилсан ТЭЗҮ-ийн эцсийн тайланг 2022 оны 1-р улиралд хүлээн авсан. Концессын сонгон шалгаруулалт удааширч байгаа тул "МТЗ" ТӨҮГ-аас ТЭЗҮ-г боловсруулж байна.

"Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв"-ийн барилга барих болон төвийн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төсөл (2021-2026/ 14 сая ам.доллар)-ийн хэлэлцээрийн протоколд Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага 2021 оны 8 дугаар сард гарын үсэг зурлаа. Төслийн удирдлагыг

хэрэгжүүлэх зөвлөх багийн сонгон шалгаруулалтыг зарласан. Төслийн Ажлын даалгаврын “В” хэсэгт тусгагдсан Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулж БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага, “Эм Эс Эл” ХХК, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ болон яам хамтарсан гэрээ байгуулах гэрээний төсөл дээр ажиллаж байна.

3.6.1.4. Азийн авто замын сүлжээний АН-3 буюу Улаанбаатар-Дархан, Дархан-Алтанбулаг, Налайх-Баян чиглэлийн авто замыг 4 эгнээтэй болгож, Азийн авто замын сүлжээний АН-4 буюу Цагаан нуур-Улаан байшинт, Өлгий хотыг тойрсон хатуу хучилттай авто замыг барьж дуусган, Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгийн авто замыг үргэлжлүүлнэ.

Биелэлт: Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын нийт 5 багц хэсгийн барилгын ажлын явц 2022 оны байдлаар, Багц 1-1 хэсэг 96.16%, Багц 1-2 хэсэг 89%, Багц 1-3 хэсэг 99,5%, Багц 1-4 хэсэг 52,3%, Багц 1-5 хэсэг 99,9%-ийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна Нийт хэрэгжилт 82%-ийн гүйцэтгэлтэй байна.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ 202.4 км авто замын багц 1-5 хэсгийн барилгын 2021.03.18-ны өдөр эхлүүлсэн бөгөөд төслийн хүрээнд нийт 5 багцын барилгын талбайд 1228 хүн хүч, 582 тоног төхөөрөмж байршин ажилласан. нийт 5 багц хэсгийн барилгын ажлын явц 2022 оны байдлаар, Багц 1 хэсэг 85,7%, Багц 2 хэсэг 47%, Багц 3 хэсэг 45%, Багц 4 хэсэг 60%, Багц 5 хэсэг 62%-ийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна. Нийт хэрэгжилт 60%-ийн гүйцэтгэлтэй байна.

Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилэх ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, зөвлөхөөр “Эм Си Пи Си Жи Ар” ХХК шалгарч зураг төслийн эхлэлийн шатны тайланг 2022.05.31-ний өдөр хүлээн авсан. Дунд шатны тайланг 2022.08.24-ны өдөр хүлээн авсан. Зураг төсөл зохиогч нь зураг төсөлд магадлалын дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.

Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажил 100%-ийн гүйцэтгэлтэйгээр улсын байнгын ашиглалтад 2022 оны 10 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авсан.

"Нөмрөг Сонгино чиглэлийн 167 км авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам"-ын инженерийн нарийвчилсан зураг төслийг "Аварга зам" ХХК боловсруулан 229/2021 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулан хүлээлгэн өгсөн.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд АХБ-ны 3129-МОН зээлийн хөрөнгөөр хэрэгжих Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км авто замын барилгын ажлыг 4 багц хэсгээр зохион байгуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Эхний 3 багцын ажлыг ашиглалтад авсан. Өлгий хотыг тойруулан гаргах 18.3 км авто зам, 200 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажлын Багц 1 хэсгийн зам барилгын ажил **85 хувь**, Багц 2 хэсгийн ажил **30 хувь**, Багц 3 хэсгийн ажил **75 хувийн** гүйцэтгэлтэй байна.

3.6.1.5. Орхон-Дашинчилэнгийн замаас үргэлжлэх Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгийн авто замуудыг үргэлжлүүлнэ.

3.6.1.6. томоохон суурин газруудыг хилийн боомттой холбосон хатуу хучилттай авто замын төслийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто зам барилгын ажлыг 2020.06.18-ны өдөр эхэлсэн. Одоогоор зам барилгын ажлын талбайд 7 компанийн 400 гаруй техник, тоног төхөөрөмж, 3 чулуу бутлуур, 2 бетон зуурмагийн үйлдвэр, 800 гаруй хүн хүч ажиллаж байна. 2022 оны байдлаар **ажлын гүйцэтгэл 63.2 хувьтай байна.**

Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замыг барих ажлын явц талбайд 464 машин механизм, 750 /монгол 602, гадаад 148/ ажилтан байршин бэлтгэл ажил, кемп байгуулах, трасс сэргээх, карьерын материалын шинжилгээ, хэмжилт, хөрс хуулах, далангийн дүүргэлт, ухмал ухах, худаг гаргах, чулуу бутлах ажил гүйцэтгэж байна. 2022 оны байдлаар **ажлын гүйцэтгэл 42 хувьтай байна.**

Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замыг барих ажлын явц: зам барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг 2021.06.04-ны өдөр олгосон. Барилгын талбайд 134 машин механизм, 267 /монгол 87, гадаад 180/ ИТА болон ажилчид бэлтгэл ажил, замын трасс сэргээх, хөрс хуулах, чулуу бутлах, кемп байгуулах, ухмал, далангийн ажил хийж гүйцэтгэсэн. Сэлэнгэ мөрөн үерлэж орон нутгийн зам эвдэрсэн байсныг сэргээн засварлаж хөдөлгөөнийг нээсэн. 2022 оны байдлаар **ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна.**

Хэнтий аймгийн Жаргалтхаан-Дэлгэрхаан чиглэлийн авто замын зураг төслийг "Ихэр мөнх" ХХК гүйцэтгэж байна. Улсын чанартай авто замаас салаад 52 км авто замын барилгын ажил эхэлсэн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Тэгш плант" ХХК шалгарсан ажлын явц 36 хувьтай байна.

3.6.1.7.хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Чойбалсан-Хавиргын хилийн боомтын чиглэлийн 124.5 км, Норовлин-Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж эхлүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт хасагдаж, 20.8 тэрбум төгрөг төлөвлөснийг 2.5 тэрбум төгрөг болгон баталсан. Төрийн худалдан авах ажиллагааны газар сонгон шалгаруултыг 3 удаа зарласан. Сүүлийн тендерийн нээлт 2022.09.13-нд нээсэн нэг ч оролцогч оролцоогүй байна. Тус ажлын төсөвт өртгийг дахин магадлалаар оруулж, 2023 оны улсын төсөвт санхүүжилтийг суулгасан.

3.6.1.8.аялал жуулчлалыг хөгжүүлэх болон эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий зарим сум, суурин газрууд руу чиглэсэн 2022 км авто замыг барина.

Биелэлт: Завхан аймгийн Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замыг барих ажил батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2020.04.01-ний өдөр эхлүүлсэн. Гүйцэтгэгч компани уг авто замын зорчих хэсгийн хөдөлгөөнийг 2021.12.12-ны өдөр нээсэн, барилгын ажил бүрэн дуусч 06/12/22 дугаар дүгнэлтээр улсын комисс ажиллан хүлээн авсан.

2022 оны байдлаар Даланжаргалан -Бор-өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын ажил ашиглалтад орсон, Орхон гол-Их тамир чиглэлийн 63 км хатуу хучилттай авто замын барилгын ажил 78 хувьтай, Багануур-Мөнгөнморьт чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын барилгын ажил 76.8 хувьтай тус тус хэрэгжиж байна.

Чингис хот-Бэрх чиглэлийн 20 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчээр "Наранбулаг-Хан" ХХК шалгарч барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр байнгын ашиглалтад өгсөн. Тус хатуу хучилттай авто замын үргэлжлэл Чингис хот-Дадал чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчээр "Наранбулаг-Хан" ХХК шалгарч, 2022 оны 7 дугаар сард ашиглалтад оруулсан. Өндөрхаан-Норовлин чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 130 км хатуу хучилттай авто

замыг 2 багц болгон хуваасан. Тус ажлын 1-р багцын гүйцэтгэгчээр “Наранбулаг-хан” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил 52 хувьтай. 2-р багцын гүйцэтгэгчээр “Мотор сервис” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил 27 хувьтай.

3.6.1.9.эдийн засгийн үр ашигтай, хөдөө аж ахуйн тээвэрлэлтийг дэмжсэн “Нутгийн зам төсөл”-ийг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Нутгийн зам төслийн хүрээнд 5 сумын төвийг холбох 155.79 км авто замын төсөл хэрэгжсэн. Архангай аймгийн Өндөр-Улаан сумыг холбох 7 км авто зам-56%, Хөвсгөл аймгийн Тариалан сумын холбох 6.3 км-35.8%, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын төвийг холбох 22.89 км авто зам-100%, Төв аймгийн Мөнгөнморьт сумыг холбох 60 км авто замын барилгын ажлын явц 72%-тай байна. Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг холбох 59.6 км зам барилгын ажил дуусч ашиглалтад оруулсан.

Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр нийт 4 төсөл, арга хэмжээний 89.54 км авто зам: Архангай аймгийн Булган сумыг холбох 35 км, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумыг холбох 16 км авто замын төслийг Дэлхий банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн. Ховд аймгийн Ховд сумыг холбох 18.776 км, Эрдэнэбүрэн сумыг холбох 19.78 км авто замын төслийг АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, тухайн төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

Төслийн хэрэгжилт: Хөнгөвчилсөн хучилттай авто зам барих нийт 19 төсөл, арга хэмжээ-21%, Хатуу хучилттай авто зам барих нийт 5 төсөл, арга хэмжээ-8%, Олон улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу холбогдох нийт 14 төсөл, арга хэмжээ-50%-тай байна.

3.6.1.10.Булган аймгийн Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км авто замыг барина.

Биелэлт: Төрийн худалдан авах ажиллагааны газраас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, 2022.08.09-нд "РЭС" ХХК-тай гэрээ байгуулсан. МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар төлөвлөсөн хөрөнгийг бүрэн зарцуулж, хөрс хуулах, зөөврөөр далан, тохиромжгүй хөрс зайлуулах, хиймэл байгууламж, тэсэлгээний ажил хийгдсэн. Барилга угсралтын ажил 5 хувьтай.

3.6.1.11.Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км авто замыг барина.

Биелэлт: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр тус яамтай хамтран хэрэгжүүлж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн 3 дугаар шатны хүрээнд Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг хэрэгжүүлэх судалгааны зөвлөхөөр “Кокс консалт” ХХК ажилласан. Баруун бүс 3-р шатны зээлийн хэлэлцээрийн АХБ-ны санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт багтсан.

3.6.2.Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын төлбөр хураах, хяналтын механизмыг бүрдүүлэх замаар авто замын сангийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн авто замын санг бие даасан үйл ажиллагаанд шилжүүлнэ:

3.6.2.1.олон улсын болон улсын чанартай 14,918.7 км авто замын сүлжээнд их засвар, ээлжит засвар, арчлалтын ажлыг норм, нормативын дагуу гүйцэтгэнэ.

Биелэлт: 2022 онд төрийн өмчит 20, хувийн хэвшлийн 12 компанитай засвар арчлалтын гэрээг шинэчлэн байгуулж, гүйцэтгэх урсгал засвар, арчлалтын ажлын график төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний дагуу засвар, арчлалтын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгүүлэн, гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа бөгөөд засвар арчлалтын ажлын гүйцэтгэл 89 хувьтай байна.

2021 онд Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто зам, Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн авто замын 57 км авто замын их засварын ажил хийгдэж байна. 2021 оны улсын төсөвт олон улс, улсын чанартай авто замд их засварын хөрөнгө тусаагүй, орон нутгийн чанартай авто замд 9,280.0 сая төгрөг тусгасан. Зам, тээврийн хөгжлийн Сайдын багцаас Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 53 тэрбум төгрөгийн ажил хэрэгжиж байна. Олон улсын болон улсын чанартай 14,918.7 км авто зам, замын байгууламжийн урсгал засвар арчлалтын ажлыг зам хариуцагч төрийн 20, хувийн хэвшлийн 12 нийт 32 компаниар гүйцэтгүүлж, өдөр тутмын бэлэн байдлыг хангуулан ажиллаж байна.

Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 58 км авто замд их засвар хийх ажлыг АХБ-ны МОН-3786 зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ба их засварын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж, 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр гэрээ байгуулсан. Зам барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг 2021.04.30-ны өдөр олгосон. Ажлын талбайд бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Үндсэн зам барилгын ажил 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхэлсэн ба тус онд газар шорооны ажлын 80 хувь, суурийн ажлын 56.21 хувь, хучилтын ажлын 43 хувийг тус тус хийж гүйцэтгэсэн ба нийт ажлын гүйцэтгэл 42 хувьтай байна.

3.6.2.2.Онги, Түргэн, Байдраг, Хэрлэн, Ерөө, Орхон, Гичгэнэ, Чигэстэй голуудын нийт 1306.8 урт метр төмөр бетон гүүрэнд их засварын ажлыг хийнэ.

Биелэлт: Онон голын 209 у/м төмөрбетон гүүр /Хэнтий, Биндэр сум/-ийн барилгын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн, 2021.08.24-нд улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад оруулсан.

Ховд аймгийн Дөргөн суманд байрлах Чоно харайхын гүүрийг 06/15/22 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Онги голын 54.8 у/м төмөр бетон гүүрийг барих барилга угсралтын ажил 100 хувьтай. Улсын комисс 2021.7.28-ны өдөр ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан.

Говь-Алтай аймгийн Шарга сумын Эвийн голын 66.24 у/м төмөр бетон гүүрийг байнгын ашиглалтад хүлээн авсан.

Хэнтий аймгийн Батширээт сумын Бархын голын 121.36 у/м төмөр бетон гүүрийг барих ажил хөрс хуулах, зөөврөөр далан, тохиромжгүй материал зайлуулах, дугуй цохигч цутгах, хиймэл арал байгуулах, хүнхээл ухах, суурь бетон цутгах, захын болон завсрын тулгуур цутгах ажлууд хийгдсэн. Барилгын ажил 34 хувьтай.

3.6.2.3.авто замын ашиглалтын бэлэн байдалд хяналт тавих, төлбөр хураах цэгийн тоог нэмэгдүүлж бүрэн цахимжуулна.

Биелэлт: Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замд Түргэний гүүрийн төлбөр авах цэгт цахим систем нэвтрүүлэх эхний үе шатны туршилтыг амжилттай зохион байгуулсан.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төлбөр авах цэгийн үйл ажиллагааг 2022 оны 08-р сарын 17-ны өдөр эхлүүлсэн. 2022 онд Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 2022.01.05, Ховд аймгийн Манхан суманд 2022.09.18-нд шинээр төлбөр авах цэг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Нийслэл хотыг тойрсон эмээлт, Налайх, Хоолт, Түргэний гүүрийн төлбөр авах

цэгийн үйл ажиллагааг цахимжуулж, тээврийн хэрэгслийн дугаарыг бүртгэж, шууд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна.

3.6.3.Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ:

3.6.3.1.нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг цахилгаан болон байгалийн шатдаг хийгээр ажилладаг хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэлд бүрэн шилжүүлэн, цахилгаан болон байгалийн шатдаг хийгээр цэнэглэх сүлжээг бий болгоно.

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/130 дугаар захирамжаар Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт (Нийтийн тээврийн парк шинэчлэлт) хийх санхүүжүүлэх 21,393.9 сая төгрөгийн санхүүжилтын эрхийг шилжүүлсэн. “НЗДТГ, Сүлдэрхан минералс ХХК болон “Xia men golden dragon bus” Co.,Ltd түншлэлтэй Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл (Улаанбаатар) “Нийтийн тээврийн парк шинэчлэлт”-ийн хүрээнд 60 ширхэг их багтаамжийн автобус, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь БНХАУ-аас Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 10 ширхэг давхар автобус, 1 ширхэг цахилгаан автобус, НЗДТГ, “Моннис Моторс” ХХК -тай байгуулсан гэрээний дагуу сургуулийн 20 ширхэг автобус нийт 91 автобусыг хүлээн авч, 2022 оны 06-р сарын 03-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар үйлчилгээнд ажиллуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд худалдаж авах автобус, дагалдах хэрэгслийн жагсаалтыг баталж, урьдчилгаа төлбөр 60,560.4 сая төгрөгийг шийдвэрлэсэн. “Xiamen Golden Dragon” ХХК-тай эхний ээлжийн их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 224 ш автобусыг худалдан авах гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны 1 дүгээр сарын эхээр эхний 100 автобус ирж, үйлчилгээнд явж байна.

2020 онд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд цахилгаан автомашиныг түргэн цэнэглэх станцыг Петровис группын Энхтайваны гүүрний дор байрлах ШТ-29-д, Toyota-Таван Богд”-ын зогсоолд 60квт түргэн цэнэглэх цэг, Баянгол дүүргийн 4-р хорооллын Смарт худалдааны төвийн авто зогсоолд 60квт түргэн цэнэглэх цэг, Галлериа Улаанбаатар зогсоолд 60квт цэнэглэх цэг, Дүнжингарав худалдааны төвийн урд EDU Samrus-ийн зогсоолд 20квт түргэн цэнэглэх цэг, Замын Цагдаагийн хажууд “Хан-Уул дүүргийн И-март худалдааны төвийн зогсоолд 60квт түргэн цэнэглэх цэгийг тус тус байгуулж, ашиглаж байна. 2022 онд Улаанбаатар хотод цахилгаанаар ажилладаг автомашин цэнэглэх станц 4, Хэнтий аймагт 3, Өмнөговь аймагт 7, нийт 14, хийгээр ажилладаг автомашин цэнэглэх станц орон нутагт 1, УБ хотод 4, нийт 5-ыг байгуулсан.

Хийгээр цэнэглэх 4 байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. 1 байгууламжийг барьж байна. Үүнд: Хэнтий аймагт-1, Орхон аймагт 2, Дорноговь аймагт 1 хийгээр цэнэглэх байгууламж барьж ашиглалтад оруулсан.

3.6.3.2.төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэл болон орон нутагт ачаа, зорчигч тээврийн зориулалт бүхий терминалуудыг байгуулна.

Биелэлт: Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах асуудлыг судалж байна.

Улсын төсвийн 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд Орхон аймагт автобуудал барих төсөл хэрэгжиж байна. Автобуудлын барилга угсралтын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөний дагуу хоцрогдолгүй явж байна. Говь-Алтай аймгийн автобуудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн барилгын зураг төслийн ажлын даалгавар батлагдсан. Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт 5000м2 талбай

бүхий газарт 3.7 тэрбум төгрөг өртөг бүхий автобуудлын барилгын ажлыг эхлүүсэн. Барилгын ажлын гүйцэтгэлийн явц 85 хувьтай байна.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт Тавантолгойн уурхайд Нүүрс угаах, баяжуулах үйлдвэр, Дулааны цахилгаан станц, туузан дамжуулга, төмөр зам, автозам, логистикийн төв зэрэг дэд бүтэц, бүтээн байгуулалтын объектуудын байршлын гадаргын төлөвлөлтийн төслийг боловсруулсан. Уг төлөвлөлтийг Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн. Чингэлэгт тээврийн терминал байгуулах тухай Засгийн газрын 2021.07.02-ны өдрийн 185 дугаар тогтоолын хүрээнд "Энержи ресурс" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК-ийн хөрөнгөөр Гашуунсухайт боомтод жилдээ 10,0 сая тн чингэлэгтэй нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай терминалыг 2021.09.20-нд ашиглалтад оруулсан. Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн нэмэлт терминал байгуулах ажил хийгдэж байна.

Тавантолгойн холимог тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ-г боловсруулж логистикийн төвийн барилгын ажлыг эхлүүлсэн. Барилгын ажлын гүйцэтгэгчээр "Бодь интернэйшнл" ХХК ажиллаж байгаа бөгөөд ажлын явц 40 хувьтай явагдаж байна.

3.6.3.3.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логистикийн төвийн төслийг эхлүүлнэ.

3.6.3.4.төмөр замын сүлжээг түшиглэн олон улсын стандартад нийцсэн хуурай боомтыг барьж байгуулна. Нийслэлийн Налайх дүүрэгт Улаанбаатар төмөр замыг түшиглэн олон улсын стандартад нийцсэн ачаа тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна.

Биелэлт: "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ нь Олон улсын нисэх онгоцны "Чингис Хаан" буудлыг түшиглэн бий болох Богдхаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил мөн дэд бүтэц, эх үүсвэр тодорхойлох ажлуудын эцсийн тайланг боловсруулав. Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад багтаан батлуулахаар уг төслийн хөрөнгө оруулалтын санхүүгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын өгөөж, санхүү болон эдийн засгийн үр ашгийн урьдчилсан тооцооллуудыг боловсруулан 2022 оны 10-р сарын 18-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 17 дугаар хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

3.6.4.Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлж, өрсөлдөөнийг бий болгож, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэн, орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулна:

Биелэлт: Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 онд нийт 20 байршилд бага оврын агаарын хөлөг хөөрч, буух зурвас байгуулах, 3 байршилд шатахуун түгээх төв байгуулах техникийн даалгаврыг боловсруулсан. Аймаг орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар 2020 онд нийт 11 байршилд хөөрч, буух зурвас байгуулагдаад байна.

3.6.4.1.олон улсын нислэгийг өргөжүүлэх, аяллын дугаар хуваах зэргээр нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: 2022 онд Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хооронд байгуулах Агаарын тээврийн тухай хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцов.

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Унгар болон Испанийн Вант Улстай "Агаарын харилцааны тухай хэлэлцээр" байгуулахаар хэлэлцээрийн төслийг эцэслэн

тохиролцсон. Азербайжан, Грекийн талтай үзэглэсэн “Агаарын харилцааны хэлэлцээр”-ийг байгуулах бэлтгэл ажил хангагдсан боловч хэлэлцээрт гарын үсэг зурах ажил цар тахлын улмаас хойшлогдсон. Лавти, Кувейтын талтай Агаарын харилцааны хэлэлцээр байгуулахаар Монголын талын төслийг хүргүүлсэн.

Улаанбаатар-Хонконг чиглэлийн нислэгийн давтамжийг долоо хоногийн 11 байсныг 15 болгож нэмэгдүүлсэн. Монгол-Япон хоорондын нислэгийн давтамж долоо хоногийн 13 хүртэлх давтамж байсныг 9000 суудлын багтаамж, 30 хүртэлх давтамж болгон нэмэгдүүлсэн. Ингэснээр тухайн чиглэлд жилд 1,872,000 суудал нийлүүлэх боломжтой болсон. БНХАУ-тай байгуулсан Иргэний агаарын тээврийн тухай хэлэлцээрийн хүрээнд тохиролцсон Далиан нислэгийн цэгийг Шэньжэнь цэгээр солихоор айлын талтай хэлэлцэж байна. ОХУ-тай Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Улаангом, ОХУ-ын нутаг дэвсгэр дээр Кызыл нислэгийн цэгийг нэмж тохирч, нислэг гүйцэтгэх зохицуулалт бүрдүүлсэн.

3.6.4.2.Ховд, Дорнод, Хөвсгөл аймгуудын нисэх буудлуудыг 4 С ангиллын олон улсын нисэх буудал болгон хөгжүүлэх төслийг эхлүүлнэ.

Биелэлт: “Ховд” нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэхэд нийт 49.9 тэрбум төгрөг, “Дэглий цагаан” нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэхэд нийт 65.6 тэрбум төгрөг, Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэхэд нийт 62.5 тэрбум төгрөг шаардлагатай байна. Ховд, Увс, Дорнод аймгуудын нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4С ангиллын болгох төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, “Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх” төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж байна. Хөвсгөл аймгийн “Мөрөн” нисэх буудлын үерийн хамгаалалтыг сэргээх, аэродромын хүчитгэл, өргөтгөлийн ажлын хяналтын төсвийг шинэчлэх ажлыг гүйцэтгүүлж, Зам, тээврийн хөгжлийн төвөөр баталгаажуулан хүлээн авсан. Шинэчилсэн төсөвт өртөг нь 18.9 тэрбум төгрөгөөр хянагдсан.

Ховдын Булган, Хэнтийн Дадал сумын нисэх буудлын аэродромын их засварын “Ажлын даалгавар”-ыг баталгаажуулсан, аэродромын их засварын санхүүжилтийг Иргэний нисэхийн ерөнхий газрын 2022 оны өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөж байна. “Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл”-ийн барилгын ажил улирлын чанартай зогсоод байсан бөгөөд ажлыг 2021.05.27-ний өдрөөс эхлүүлсэн. 2022 оны байдлаар барилгын ажлын гүйцэтгэл 35.4 хувьтай байна. Аэродромын ажлын гүйцэтгэл 98 хувьтай байна.

Дэлүүнболдог нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолборын барилгын зураг төслийг боловсруулж, магадлалаар баталгаажуулсан. Барилгын ажлыг 2021.04.06-ны өдөр эхлүүлсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 2021 оны байдлаар 33.9 хувьтай байна. 2022.10.06-ны өдөр 288 дугаар нэмэлт гэрээг байгуулж, гэрээний хугацааг сунгасан.

3.6.4.3.төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулна.

Биелэлт: “Чингис хаан” олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг 2021.07.03-ны өдрөөс эхлүүлсэн. Нисэх буудлын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгчдийг сонгон шалгаруулж, “Атибус” ХХК-ийн 12, “Эрдэмтранс” ХХК-ийн 22, “Улаанбаатар такси транспорт сервис” ХХК-ийн 54, “ВИП такси сервис” ХХК-ийн 24 тээврийн хэрэгсэл тухайн чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээнд явахаар болсон.

Автотээвэр болон төмөр замын зорчигч тээврийн нэгдсэн тасалбарын систем хөгжүүлэх чиглэлээр УБТЗ, АТҮТ байгууллагууд холбогдох судалгааг хийж, 2 талын одоо ажиллаж байгаа системүүд дээр веб сервисүүдийн холболтыг хийж, зорчигч үйлчилгээний төв дээр туршилтын цонх нээн ажиллуулсан. Орон нутгийн нисэх буудлын үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд төмөр зам, автотээврийн зорчигч тээврийн буудлын үйл ажиллагааг уялдуулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр цахим төлбөрийн системийг боловсруулж байна.

Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай, Увс аймгуудад 27 байршилд, Хөвсгөл аймагт 12 байршилд буюу нийт 39 байршилд хөөрч, буух зурвасын цэгийг сонгон хэмжилт хийж, координатыг баталгаажуулсан. Ховд аймгийн Чандмань, Өвөрхангай аймгийн Хужирт, Өвөрхангай аймгийн Цагаан нуур сумдад бага оврын агаарын хөлгийн хөөрч буух зурвас байгуулах ажил хийгдэж эхэлсэн. 2021 онд нисдэг тэрэгний 21 хөөрч буух талбайг байгуулсан.

Барилга, хот байгуулалт

3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

3.7.1.Газрын харилцаа, хот байгуулалтын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтооно.

Биелэлт: Газрын багц хуулийн төслийг УИХ-д 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. 2022 оны 11-р сарын 7-ны өдөр УИХ дахь намуудын бүлгийн хурлаар Газрын тухай багц хуулийн төслийг хэлэлцэж, УИХ-ын чуулганаар хэлэлцэгдэж байна. Орон сууцны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслүүдийг боловсруулж байна.

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалтын тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болно.

3.7.2.“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно.

Биелэлт: Улсын төсвийн хөрөнгөөр 2011-2020 онуудад Монгол орны нутаг дэвсгэрийн 45 хувь буюу 704000 км² талбайг 1:25000-ны масштабтай байр зүйн зураг /7328 хуудас/-аар зурагжуулсан. Цаашид Монгол Улсын нутаг дэвсгэрийн үлдсэн 55 хувь буюу 913872.4 км² талбайг 1:25000-ны масштабтай байр зүйн зураг /10914 хуудас/-аар зурагжуулах ажлын ТЭЗҮ-г боловсруулсан. 2020 онд Зүүнбаян-Цогтцэций чиглэлийн төмөр зам, Дархан-Улаанбаатар чиглэлийн автозам, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум /газар тариалан/, Улаанбаатар хот /барилга/, Дорноговь аймгийн Даланжаргалан сум /уурхай/ байршлыг сонгон, Спот 7 хиймэл дагуулын зургийг 2020 оны 5-6 дугаар сард GEOMATICA програм ашиглан 85.6 мянган га талбайд DTM буюу гадаргуун тоон загвар боловсруулж, ортофото зураг үүсгэсэн. Эдгээр мэдээллийг агаарын зураглалын аргаар боловсруулсан өгөгдөл мэдээлэлтэй харьцуулан судлах, нарийвчлалын шаардлага хангаж байгаа талаар судалгаа хийсэн.

“Хаягийн мэдээллийн нэгдсэн систем /Улсын хэмжээнд/” байгуулах ажлыг 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 2020/85-04 тоот дүгнэлт, гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнг

хүлээн авсан. Тус системийг хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авах ажлыг зохион байгуулж байна. Улсын хэмжээнд Дорнод аймгийн 2 сум, Дундговь аймгийн 6 сум, Өвөрхангай аймгийн 4 сум, Хэнтий аймгийн 1 сум, Дархан-Уул аймгийн 1 сум, Завхан аймгийн 1 сум, нийт 5 аймгийн, 15 суманд газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг орон нутгийн төсвөөр хийлгэхээр геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283:2014 стандартыг, “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014, “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4597:2014 стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулж байна.

3.7.3.Хиймэл оюун ухаан болон блокчейн, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангасан технологид суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлнэ.

Биелэлт: Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүрээнд улсын хэмжээнд нийт нутаг дэвсгэрийг хамарсан мониторингийн сүлжээ бүхий “Газрын мониторингийн үндэсний цахим систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэхүү цахим системд газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт буюу бэлчээрийн газрын 8310 цэг, тариалангийн газрын 2190 цэг, хадлангийн газрын 258, хот суурин газрын 1556, ой, усан сангийн газрын 212, тусгай хэрэгцээний газрын 120 цэг болон тус тус нийт 12,646 цэгийн анхдагч мэдээллийг байгуулж мэдээллийн санг үүсгээд байна. Мөн 2020 онд Улсын хэмжээнд бэлчээр болон хот тосгон бусад суурин газрын мониторингийн 1000 цэгийн ерөнхий мэдээлэл, ургамлын бичиглэл, мониторингийн цэгийн хянан баталгааны дүгнэлт зэрэг мэдээлэл бүхий хувийн хэрэг, хөрсний агрохими, хүнд металл, эрүүл ахуйн, дээжний мэдээ, ургамлын бичиглэлийн ажлыг хийж нэгдсэн нэг мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна./www.egazar.gov.mn/.

Байрлалд суурилсан орон зайн мэдээлэл дээр өгөгдөл бүртгэх www.urban.gov.mn цахим системийг байгуулан хэрэглээнд нэвтрүүлж, ашиглаж байна. 2022 оны байдлаар 132 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 21 аймгийн төвийн барилга байгууламж, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хилийн боомтуудын мэдээллийн боловсруулалт хийгдэж байна. Мөн 21 аймаг 309 сумын барилга байгууламж, инженерийн байгууламж, шугам сүлжээ, нийгмийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламжийн мэдээллийг бүрдүүлэх ажил хийгдэж байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр түргэн, шуурхай, ил тодоор зохион байгуулах, газрын барьцаа, түрээсийн бүртгэл хийх, газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулж нэгдсэн мэдээллийн сан бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээ, статистик мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, зорилгоор Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг системийг 21 аймаг, 330 сумын Газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд системээс иргэн, хуулийн этгээд газартай холбоотой бүх төрлийн мэдээ, мэдээллийг авч, өөрийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар бусдад шилжүүлэх болон худалдах, түрээслэх зар мэдээллээ уг системд оруулж бусдад арилжаалах боломжтой бөгөөд Газрын биржийн цахим системд жилд дунджаар 9880068 хүн хандалт хийж нийт 8266 иргэн, хуулийн этгээд үйлчилгээ авсан байна. Дуудлага худалдааны үйл ажиллагаа бүрэн цахимжиж, 2022 оны байдлаар нийт 3786 газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг газрын биржийн mle.mn системээр зохион

байгуулж, нийт 6458 иргэн, хуулийн этгээд оролцож, ойролцоогоор 26,5 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлэх ТЭЗҮ-ийн төслийг эцэслэн боловсруулав. Газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулах ажлын газрын асуудал шийдэгдсэн. Тус ажлын ТЭЗҮ-г боловсруулах ажлын урьдчилсан судалгааг хийх ажлыг зохион байгуулж, мөн тус ажлын зураг төсөл боловсруулах ажлын зардлын тооцоог судалж байна.

Монгол Улсын 2021 оны төсөвт паспортжуулалтын ажлын 70 сая төгрөг тусгагдсаны дагуу нийслэлийн хэмжээнд нийт 89 барилга байгууламжийн суурь судалгаа, байгууламжид биет үзлэгийн судалгааг үе шаттайгаар хийж паспортжуулаад байна. 2020 оны 12 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотод нийт 89 барилга байгууламжийн суурь судалгааг хийсэн бөгөөд үүнээс 46 барилга байгууламжид биет үзлэгийн судалгааг хийсэн байна. Хөвсгөл, Өмнөговь, Увс аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын судалгааг хийж байна.

3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.

Биелэлт: "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" болон "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого"-ын баримт бичгүүдийг боловсруулах үйл ажиллагааг харилцан уялдуулж, зохицуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 126 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн хүрээнд "Хүн амын өсөлт, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн дэд бүтэц", "Аж үйлдвэр дэд бүтэц", "Хүн амын нутагшилт, суурьшил" зэрэг 3 боть "Эцсийн шатны тайлан-1"-г боловсруулж дуусган, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраар захиалагчийн хяналтын дүгнэлтийг гаргуулж, засварлан эцэслэн боловсруулав. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг батлах тухай" УИХ-ын тогтоол, үзэл баримтлалын төслийг боловсруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, үр нөлөөг үнэлэх ажлыг гүйцэтгэж байна.

Хүн амын нутагшил суурьшлын ерөнхий төлөвлөгөө /ХАНСХЕТ/-ийг боловсруулах эхлэлийн, дундын, эцсийн нийт 7 тайлан ирүүлэхээс эхлэлийн 2, дунд шатны 2, "Хүн амын өсөлт, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн дэд бүтэц", "Аж үйлдвэр дэд бүтэц", "Хүн амын нутагшилт, суурьшил" зэрэг 3 боть ХАНСХЕТ-ийн эцсийн тайланг боловсруулж дуусаад байна.

Монгол Улсын 2021, 2022 оны төсвийн тухай хуульд нийт 65,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 51,7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй багц төсөл, арга хэмжээ батлагдсан. Дээрх багц ажлыг үе шаттайгаар зохион байгуулах ажлын хүрээнд салбар яамд, аймаг, нийслэлээс дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгах саналуудыг ач холбогдлоор нь эрэмбэлүүлэн авч, нэгтгэн, батлагдсан төсөвт багтаан хуваарилах, улсын хэмжээнд хэрэглэгдэх нэг маягийн зургууд бүхий сан бий болгох зэрэг ажлыг хэрэгжүүлэв. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 32, 66, 83, 101, 179 дүгээр тушаалуудаар нийт 148 төсөл, арга хэмжээний жагсаалт батлагдсан. Үүнд: 136 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдсан, 10 төсөл, арга хэмжээ тендерийн шатанд, 2 төсөл, арга хэмжээ үнэлгээний шатанд тус тус байна. Гэрээ байгуулагдан хэрэгжиж буй 136 төсөл, арга хэмжээний зураг, төсвийн ажил 100 хувь дуусч хүлээлгэн өгсөн.

3.7.5. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.

Биелэлт: “Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай ТЭЗҮ боловсруулах” арга хэмжээтэй ажлын гүйцэтгэгчээр “Хот төлөвлөлт, судалгааны хүрээлэн” ОНӨААТҮГ шалгаран 2022/226 тоот гэрээг 2022.05.12-ны өдөр байгуулан ажлыг эхлүүлсэн.

Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 03-нд Улсын Их Хуралд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Орхоны хөндийд Шинэ Хархорум хотыг байгуулахаар тогтоож, Орхоны хөндийд шинэ хот байгуулах газрын байршил, хэмжээг тогтоон, холбогдох хууль тогтоомжийн дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, Шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам, тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, Шинэ Хархорум хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төсөвлөн үе шаттайгаар авч хэрэгжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн.

3.7.6. Цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна.

Биелэлт: УИХ-ын 2022 оны 10-р тогтоол, Засгийн газрын 2022 оны 143-р тогтоол “Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай”, 2022 оны 98-р тогтоолыг “Төрийн захиргааны зарим байгууллагыг Хөшигийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний тухай” тогтоолуудыг тус тус батлуулсан. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ болон инженерийн шугам сүлжээний 6 төрлийн ажлын зураг төслийг 2,173.3 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж, Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажил 726/2022 дугаар, Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн мэдээлэл холбооны зураг төсөл боловсруулах ажил 420/2022 дугаар, Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ус хангамжийн зураг төсөл боловсруулах ажил 905/2022 дугаар, Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах ажил хийгдсэн. МУ-ын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр, “Хөшигийн хөндийн шинэ суурьшлын бүс”-ийн эхний ээлжийн инженерийн дэд бүтцийн ажлыг 2022.08.12-ны өдөр албан ёсоор нээж эхлүүлсэн.

3.7.7. “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ хотуудын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 143 дугаар тогтоолоор Шинэ Зуунмод хотын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг баталсан. Ерөнхий төлөвлөгөөний хүрээнд “Орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” ажил, “Эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”, “Тээвэр, логистикийн төвийн ТЭЗҮ, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-ний ажлын явц 90 хувь, “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын явц 90 хувьтай байна.

“Майдар” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэхэд шаардлагатай 8,767.9 тэрбум төгрөгийн

санхүүжилтийн эх үүсвэрийг УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан. “Майдар хот төсөл” хэрэгжүүлэх газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр “Инженер геодези” ХХК шалгарч, 2020/69 тоот гэрээ байгуулан ажиллаж байна.

Төв аймгийн Хөшигийн хөндий дэх бүтээн байгуулалтын ажлын хүрээнд салбар хоорондын ажлын уялдааг хангах, бүтээн байгуулалтад шаардлагатай их хэмжээний хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт, менежментээр хангах, төслийн хэрэгжилтийн явцад хяналт, мониторинг хийх зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг цаг хугацаанд нь шийдвэрлүүлж ажиллах Төв аймгийн Хөшигийн хөндий дэх бүтээн байгуулалтын асуудлыг хариуцсан захиргаа байгуулах тухай асуудлыг Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэв.

3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засгийн газрын хэрэг эрхлэх газраас “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” байгуулах тухай хуралд 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улсын Хөгжлийн банк, Сангийн яам, “ТОСК” ТӨХХК, “НОСК” ХК зэрэг байгууллагууд оролцсон бөгөөд тус хуралд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн дарга нар ҮОСНК-ийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон танилцуулсан. Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК болон “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийг нийлүүлэх замаар өөрчлөн зохион байгуулж төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны 13 дугаар тэмдэглэл гаргасан.

3.7.9. Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ.

Биелэлт: Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр гэр хорооллын 100 га талбайд 10'000 айлын орлогод нийцсэн ногоон орон сууцны төслийг хэрэгжүүлнэ. Төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу олон улсын зөвлөх компани сонгон шалгаруулалтыг АХБ-ны зөвшөөрөлтэй гүйцэтгэж, зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан, ажлаа эхлүүлээд байна. 2022 онд төслийн хүрээнд нарны цахилгаан үүсгүүрийг дэд төвийн төлөвлөлттэй уялдуулан барилгын дээвэр дээр суурилуулах ТЭЗҮ-г боловсруулж, гүйцэтгэл 30 хувьтай явж байна. Шархад дэд төвийн эхний ээлжид баригдах Еко хорооллын концепц Ерөнхий төлөвлөгөө боловсруулсан, 106 айлын эко хорооллын эскиз зураг төслийг батлуулсан. Баянхошуу дэд төвийн В15 талбарын Эко хорооллын инженерийн төслийн барилгын А, В, С, D блокуудын магадлалын нэгдсэн дүгнэлтийг 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр батлуулсан.

БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл”-ийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, захиалагч, зохиогчийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ажлын гэрээнд 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр талууд гарын үсэг зурж баталгаажуулсан. Зээлийн гэрээнд заасны дагуу төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

тендерийн баримт бичгийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банкны “Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан (EDCF)-гийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу боловруулж БНСУ-ын Эксим банкаар тухай бүр хянуулсны үр дүнд 2022 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр тендер зарлаж болох эцсийн зөвшөөрлийг авснаар сонгон шалгаруулах ажилтай холбоотой бүх бэлтгэл ажлыг хангасан.

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах төслийн ерөнхий гүйцэтгэгч “БНХАУ-ын хоёр дахь Металлурги групп корпораци ХХК” компанийг сонгон шалгаруулсан ба 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр гэрээг байгуулсан. Ногоон нуур орчмын хөрсний усыг барилгад нэвчүүлэхгүй байх үүндээс “Усны эрчим” ХХК компанийг сонгон шалгаруулж, төсөл хэрэгжих газрын хөрс, суурь, хөрсний ус шүүрүүлэх ажилд 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 2021/79 тоот гэрээ байгуулан 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс ажил нь эхэлсэн. Төслийн хүрээнд 2022 онд улсын төсвийн 784,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11 айлын газрыг чөлөөлж, барилгажих талбайн газрыг бүрэн чөлөөлж, төслийг эхлүүлээд байна. Суурийн ажил бүрэн дуусаж, 1 дүгээр давхрын барилга угсралтын ажил хийгдэж 5 байрны 1-р давхарын цутгалтыг бүрэн хийсэн.

"Баянголын амны орон сууц" барих төслийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, захиалагч, зохиогчийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ажлын сонгон шалгаруулалтыг БНСУ-ын Экспорт-Импортын банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулж, 2021 оны 09 дүгээр сард гэрээ байгуулагдсан. “Баянголын ам түрээсийн орон сууцны хороолол барих төсөл”-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийн бичиг баримтыг зөвлөхүүдийн хамт боловсруулсан эхний төслийг Солонгос Улсын Эксим банкруу хүргүүлсэн, зөвшөөрөл хүлээж байна. Төслийн барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог Нийслэлийн засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/1457 дугаар захирамжаар байгуулсан.

Улаанбаатар хотын гэр хорооллын газрын дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 2020.11.01-12.01-ний өдрийн хороонд дүн шинжилгээ хийж, нийт 20 байршлын 52090 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх боломжтой талаар дүгнэлт гаргасан. Эдгээр орон сууцны барилгуудыг үргэлжүүлэхэд санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх ажлыг БНХАУ-ын Засгийн газраас олгох 700.0 сая юаны санхүүжилтээр шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. 2022 онд инженерийн дэд бүтцээр хангах ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ 5.0 тэрбум төгрөг; ажлын явц-30 хувь, инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5 дугаар хороо/ Ажлын явц 95 хувь, инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/ Ажлын явц 48 хувь, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ш800-ийн гол шугамыг Ш1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/ ажлын явц 23 хувь, цэвэр, бохир усны шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3, 4, 26, 36 дугаар хороо/ Ариутгах татуургын ф300мм-ийн 2867 метр шугам угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан, ажлын гүйцэтгэл 50 хувь, цэвэр усны шугамын 1.4 км ажлын явц 85 хувь, Буянт Ухаа-2 хороолол орчмын ариутгах татуургын гол шугамын 2 дугаар ээлжийн ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ 2,0 тэрбум төгрөг; Ариутгах татуургын ажил газар шороо 1-р багц БУХ58-90-р худаг хүртэлх ф500мм -ийн 750 метр шугам хийгдсэн, ажлын гүйцэтгэл-25 хувь, Дарь-Эхийн гэр хорооллын ариутгах татуургын төвлөрсөн шугамын холболт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2, 21, 27 дугаар хороо/ ажлын явц -25 хувьтай байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг 2 удаа зарласнаар 20 барилгын 10 багцад төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан 9 аж ахуй нэгжүүдэд Нийслэлийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/330-А/337, 5 дугаар сарын 03-ны өдрийн А/346, А/347 дугаар захирамжуудаар төсөл хэрэгжүүлэх батламжийг гардуулж газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй гэрээ байгуулах эрх олгосон.

Төр хувийн түншлэлийн хүрээнд Залуу гэр бүлийг орлогод нийцсэн орон сууцаар хангахаар тус яамнаас төслийн концепт, техникийн шийдлийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Морингийн даваа орчмын “ТОСК” ТӨХХК-ийн 57 га талбайд “Залуус-1” орон сууцны хороолол барих төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. ТЭЗУС-ыг 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Архитектор төлөвлөлтийн даалгавар 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, Эх загвар зураг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр тус тус батлагдсан. 2022 онд төслийн хүрээнд төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, нийт 5 багц ажлаас 5 багц ажлын гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрийн хооронд байгуулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн. Үүнд: Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажил (гүйцэтгэл 85хувь), дулаан хангамжийн шугам сүлжээний ажил (гүйцэтгэл 80 хувь), хонгилын системийн ажил (гүйцэтгэл 70 хувь), цахилгаан хангамжийн ажил (гүйцэтгэл 20 хувь) тус тус хийгдэж байна.

Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг бууруулах хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд “9.1.3.төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах.” гэсэн нэмэлт, өөрчлөлтийг УИХ-аар 2021.11.12-ны өдөр батлуулсан.

3.7.10.Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, жилийн 4-6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулна.

Биелэлт: Ипотекийн зээлийн хүүг 6 хувиар олгож эхлүүлэх тооцооллыг хийж 2020 оны 9 дүгээр сарын 09-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 03-ны өдрийн хооронд нийт 991 зээлдэгчид 69.6 тэрбум төгрөгийн 6 хувийн хүүтэй зээл олгосон.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудад нийт 1.012.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 13,292 зээлдэгчид олгосноос 81.9 хувь буюу 789.4 тэрбум төгрөгийн 9,550 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 18.1 хувь буюу 174.6 тэрбум төгрөгийн 3,159 зээлийг орон нутагт олгосон байна. Мөн тус хугацаанд гарсан 964.0 тэрбум төгрөгийн зээлийн 600.7 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 363.3 тэрбум төгрөг нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээс санхүүжиж 2020 онтой харьцуулахад даруй 2.5 дахин өндөр байна.

2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар арилжааны банкуудад 611.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 6.732 зээлдэгчид олгоод байна. Үүнээс 82 хувь буюу 502.2 тэрбум төгрөгийн 5,070 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 18 хувь буюу 109.7 тэрбум төгрөгийн 1,662 зээлийг орон нутагт олгосон байна. Мөн тус хугацаанд гарсан 611.9 тэрбум төгрөгийн зээлийн 364.3 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 247.4 тэрбум төгрөг нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээс санхүүжсэн байна.

3.7.11.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ.

Биелэлт: Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулах ажил, цэвэр усны шугамын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл /Улаанбаатар/ боловсруулах ажил, бохир усны шугамын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл /Улаанбаатар/ боловсруулах ажил тус тус хийгдэж байна. 2021 онд аймгийн төвийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох зураг төслийн ажлыг 8 аймгийн төвийн 8 сум, 2 аймгийн 2 суманд хийж гүйцэтгэсэн байна.

"Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, цэвэр ус дамжуулах шугам, дагалдах тоног төхөөрөмж, ус цэвэршүүлэх станцыг барьж ашиглалтад оруулж, улсын комисс 2021.11.24-нд ажиллаж хүлээн авсан.

АХБ-ны зээлээр аймгийн төвүүдэд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байнгын ашиглалтад оруулах ажил үргэлжилэн хийгдэж байгаа бөгөөд Өвөрхангай, Архангай, Булган, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймгуудын цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан. 2022 онд Дорноговь, Өвөрхангай аймгийн Хужирт сум, Сүхбаатар, Дундговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил дууссан бөгөөд тохируулга зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. Дархан хотын бохир усны цэвэрлэх байгууламж болон насос станцуудын шинэчлэлийн ажлын гүйцэтгэл 82 хувьтай хийгдэж байна.

Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх төсөл хэрэгжүүлэхээр тендер зарлаж, тендерт БНПУ-ын "Эй Би энд Эс Эй Индастри" ХХК-ийн түншлэл Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгийн багцад, "Мелиорекс" ХХК-д Дорнод аймгийн багцад шалгаран, 2021.07.13-15-ны өдөр гэрээ байгуулсан. Цэвэрлэх байгууламжийн БУА-ын нээлтийг 2022.09.20-ноос 22-ны өдрүүдэд 4 аймагт хийж, гүний худгийн ажлыг эхлүүлж, ирэх жилийн бэлтгэл ажлыг хангасан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймаг, Улаанбаатар хотын Багануур дүүргийн цэвэрлэх байгууламжийн зураг төслийн ажил 90 хувьтай хийгдэж байна.

Налайхын "Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн дэд станцын бүтээн байгуулалтын ажлыг "Виллвэст" ХХК гүйцэтгэж, Нийслэлийн 2021 оны төсвөөс 400 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2021 оны байдлаар тус компани нь 2 тэрбум төгрөгийн ажлыг гүйцэтгээд байна. Паркийн 2 дугаар ээлжийн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтын ажлын явц 20 хувьтай байна. Налайхын "Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн өргөтгөл 130 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг "Өрх" ХХК гүйцэтгэж, мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан.

3.7.12.Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2021 онд "Улаанбаатар хотын гэр хорооллын үерийг даван туулах чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд хөрсний усны түвшин өндөр, үерт өртөж болзошгүй Баянзүрх дүүргийн 9, Сонгинохайрхан дүүргийн 7, 24, 25, 40, 41, 42, Сүхбаатар дүүргийн 12, 13, 16-р хороодын нутаг дэвсгэрт хийгдэх үерийн далан сувгийн трассыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулж, 10 байршилд 10.5км урт үерийн хамгаалалтын далан сувгийн ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгсөн.

2020 онд Улаанбаатар хотод улсын төсвөөр 1.7 км, нийслэлийн төсвөөр 4.1 км үерийн хамгаалалтын далан тус тус шинээр барьж ашиглалтад оруулсан. Мөн түүнчлэн

нийслэлийн төсвөөр 0.4 км даланг өртгөтгөж, борооны ус зайлуулах 0.6 км шинээр барьсан. Улсын төсвөөс Улаанбаатар хотод нийт 6.9 тэрбум төгрөгийн өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ 90 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлж байна.

Говь-Алтай аймгийн төвд 1,334.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4.9 км, Орхон аймгийн төвд 900 сая төгрөгийн өртөгтэй 1.5 км үерийн хамгаалалт, Баянхонгор аймгийн төвийн 2, 7-р багийн үерийн хамгаалалтын далан сувгийн байгууламжийг ашиглалтад оруулж хүчин чадлыг нэмэгдүүлээд байна. Харин Баян-Өлгий /өртөг 1.2 тэрбум төгрөг/, Хэнтий /өртөг 945.5 сая төгрөг/, Баянхонгор /өртөг 2.3 тэрбум төгрөг/ аймгийн төвд 50-90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

3.7.13.Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

Биелэлт: Ховд аймагт цементийн үйлдвэр байгуулах "Вестерн холд" ХХК-ийн хөрөнгө оруулалтыг зээлээр шийдвэрлэх талаар санал боловсруулж Хөгжлийн банкинд 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01/537 тоотой уламжилснаар тус төсөл Хөгжлийн банкнаас 20 сая ам.долларын зээл авч, барилга угсралтын ажлыг гүйцэтгэж дуусаж 2022.10.11-ний өдөр Ховд аймгийн Буянт сумын нутагт "Ховд эко цемент" үйлдвэрийн чулуунцарын зуухны нээлтийн арга хэмжээ хийж, чулуунцарын зуухаа ашиглалтад оруулжсан. Үйлдвэрийн үндсэн үйл ажиллагааг 10-р сарын 28-ны өдөр бүрэн ашиглалтад орсон.

"Бэрэн металл" ХХК нь Эрдэнэт хотод жилд 200000 тн ган үйлдвэрлэх хүчин чадалтай төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийг барьж байгуулах төслийг хэрэгжүүлж байна. Бэрэнгийн гангийн үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх асуудлаар МУ-ын Хөгжлийн банк болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах тухай санал, дүгнэлт гаргасан. Санхүүжилтийн асуудал шийдэгдсэн тохиолдолд үйлдвэрийг 2022 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Монгол Улсад хавтгай шилний үйлдвэр байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Эрдэс плазм" ХХК-ийн шилний үйлдвэрийн төслийн санхүүжилтын эх үүсвэрийг Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний 2.12. "Тэргүүлэх чиглэлийн 100 төсөл, арга хэмжээг Засгийн газрын 100 хоногт багтаан зарлан хэрэгжүүлэх" гэсэн зорилтын хүрээнд шийдвэрлэх, 2 их наядын санхүүжилтын эх үүсвэрээс санхүүжүүлэх талаар судалгаа хийгдэж байна. Мөн "Эрдэс плазм" ХХК-ийн шилний үйлдвэрийг дэмжин ажиллах бодлогын хүрээнд үйлдвэрлэл, технологийн паркийн орчинд орж ажиллах боломж, давуу талыг танилцуулснаар тус компанид Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 227 дугаар тогтоолоор ҮТП-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг БХБЯ-наас 5 жилийн хугацаатай олгосон.

3.7.14.Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж "Замын-Үүд" чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд оруулна.

Биелэлт: Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 223 дугаар тогтоолын дагуу "Замын-Үүд" чөлөөт бүсийг 2021 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс байнгын ажиллагаанд шилжүүллээ. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 58,8 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 48 га талбайд дээрх ажлуудыг гүйцэтгээд байгаа юм. Тус бүсийн Захирагчийн ажлын албанаас энэ онд уг дэд бүтцийн станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч иргэн, аж ахуйн нэгжүүдэд таатай орчин бүрдүүлэх, боомтын нэвтрэх системийг байгуулах зэрэг ажлыг үе

шаттай хийхээр Азийн хөгжлийн банктай хамтран төсөл хэрэгжүүлж байна. “Замын-Үүд” чөлөөт бүс 900 га нутаг дэвсгэртэйгээс өдгөө 300 га-д нь төлөвлөлт хийсэн. Чөлөөт бүсийн шинэ мастер төлөвлөгөөний дагуу 68 хөрөнгө оруулагчид 101.4 га талбайг сонгон шалгаруулалтаар эзэмшүүлээд байгаагийн 7 га нь аялал жуулчлал, 47.45 га нь үйлдвэрлэлд, 20.05 га-д худалдаа, үйлчилгээ, 25 га-д агуулах, ложистик, 1.4 га нь шатахуун түгээх станцын зориулалттай юм байна.

“Замын-Үүд” чөлөөт бүсийн 900 га газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /тодотгол/, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дууссан. “Алтанбулаг”, “Цагааннуур” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зургийн даалгаврын дагуу нийгэм эдийн засгийн судалгааны одоогийн байдал, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний зураглал, тайлбар бичиг, байр зүйн зураглал, инженер геологийн судалгааны ажлын тайлан болон төлөвлөлтийн шийдлийг боловсруулж байна.

ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

“Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ

4.1.Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

4.1.1.Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.

Биелэлт: Цагдаа, прокурорын байгууллага хооронд цахимаар албан бичиг солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор цагдаагийн “earchive.police.gov” программ хангамжийг прокурорын “erp” програм хангамжтай хооронд холбож, 2022 оны 05 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд туршилтыг амжилттай хийсэн ба Прокурорын байгууллагаас шийдвэр өгсөн тохиолдолд үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр хүлээгдэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын нэгдсэн “Дата төв”, “Видео аналитик, платформ систем”, “Ханан дэлгэцийн систем”, Дата төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж” болон “Орон нутгийн хатуу хучилттай авто зам дагуу байрлах байнгын хяналтын 40 цэг /пост/-ийг камерын систем бүхий “Нэгдсэн удирдлага, хяналтын төв”-ийн барилгын зураг, төслийн ажлыг хийж дуусгав.

Төрийн 37 архивт хадгалагдаж буй цаасан болон тусгай суурьтай баримтаас 2022 онд 727 хөмрөгийн 1,106 дансны 21,377 хадгаламжийн нэгжийн 1,260,542 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, үүссэн мэдээллийн сангаас архивын лавлагаа, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд шуурхай олгож байна. 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар нийт 450368 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

Монгол Улсын бүх иргэнд иргэний бүртгэлийн дугаар олгосон бөгөөд Төрийн мэдээлэл солилцооны /ХУР/ систем дэх Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргаж буй бүх сервист өөрчлөлтийг оруулж, төрийн болон бусад байгууллага иргэний улсын бүртгэлийн дугаараар мэдээлэл авах боломжтой болсон. 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд иргэний регистрийн дугаарыг үнэмлэхийн санах ойд байршуулж, иргэний бүртгэлийн дугаарыг ил бичих бичилтээр бичих тухай санал оруулж 2022.06.03-нд УИХ баталсан. Мөн Боловсрол, шинжлэх ухааны яамны хүүхдийн мэдээллийг иргэний бүртгэлийн дугаараар

дуудаж ашиглах, боломжийг бүрдүүлж программыг шинэчилсэн. Үндэсний дата төвийн “Хур” системээс иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэнд иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан цахим шуудангийн хаягийг нээх боломжийг бүрдүүлсэн.

Үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн байрыг олон улсын стандартын шаардлагыг хангасан байдлаар засварлан тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж, туршилтын ажлыг амжилттай гүйцэтгэж, бичилтийн үйлдвэрийн үйл ажиллагаа 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлж, 11 дүгээ сарын 21-ний байдлаар Улсын бүртгэлийн байгууллагын гадаад паспортын бэлдцэд бичилт хийх үйлдвэр нийт 43082 гадаад паспорт хэвлэж иргэнд хүргээд байна.

УБЕГ газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаарыг дундын мэдээллийн сангаас 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн автоматаар олгодог болсон. 2022 оны 05 дугаар сарын 25-ны статистик мэдээгээр улсын хэмжээнд 34574 газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл улсын бүртгэлд бүртгэж дугаар олгосон байна.

4.1.2.Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана.

Биелэлт: Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудыг Улсын Их Хурал 2021 оны 12 сарын 17 өдөр баталсан. Энэхүү 4 хуулийг дагаж гарах 13 журам, 3 аргачлал, жагсаалтыг Засгийн газар 2022 онд батлан хэрэгжүүлж байна. "Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн төсөл"-ийг 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-ын 2022 оны намрын чуулган, холбогдох байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэгдэж байна. Тус хуулийн төсөлд түншлэлийн төсөл хөгжүүлэх болон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хараат бус гишүүд буюу тухайн салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулах талаар холбогдох зохицуулалтууд тусгагдсан. Хууль батлагдсаны дараа боловсруулах шаардлагатай 10 орчим журмын төсөлд түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлэх ажиллагааг илүү нарийвчилсан байдлаар эхлүүлэх болно.

4.1.3.Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.

Биелэлт: Байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөх, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим систем хөгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 42 дугаар тогтоолоор “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам” гэснийг “Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр алхэрэг хөтлөх нийтлэг журам” гэж өөрчлөн батлуулсан. Албан бичиг солилцоог цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (erp.e-mongolia.mn) -ийг хөгжүүлэн төрийн 1'384 байгууллага, түүний салбар нэгжийг холбож, 20'390 хэрэглэгчид ашиглуулан тус системээр дамжуулан байгууллага хооронд 167'707 (Ирсэн бичиг+Явсан бичиг) ширхэг албан бичгийг цахим хэлбэрээр солилцсон буюу зорилтод түвшиндээ хүрч ажилласан. 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар албан бичиг солилцооны дундын систем /Digidoc/-д нийт 4302

байгууллагын 15 систем холбогдсон бөгөөд нийт 71.424 файл бүхий 51.421 бичгийг илгээж, 55.939 бичиг хүлээж авсан байна.

2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр "Үндэсний цахим шуудангийн үйлчилгээ"-г нэвтрүүлсэн. Үндэсний цахим шуудан нэвтрүүлэх ажлын хүрээнд яамд, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд болон харьяаны байгууллагуудын нийт 193 цахим шуудангийн хаягийг нэгтгэн үндэсний цахим шуудангийн и-мэйлийн жагсаалтад нэгтгэсэн. Ингэснээр иргэд төрийн байгууллагатай цахим шуудангаар шууд харилцах боломж бүрдсэн.

Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг 21 аймагтай холбож, 2022 оны байдлаар хамгаалагдсан интернэт сүлжээнд 56, албан хэрэглээний сүлжээнд 81, тусгай хэрэглээний сүлжээнд 78 төрийн байгууллага тус тус холбогдоод байна.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх систем (emongolia.mn) -ийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр хөгжүүлж, тус системээр 2022 оны байдлаар төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia" платформоор төрийн 67 байгууллагын 789 үйлчилгээг хүргэж, иргэд давхардсан тоогоор нийт 19,715,313 удаа үйлчилгээг цахимаар авсан байна. Мөн тус платформд 21 аймгийн 1234 үйлчилгээг нэгтгэсэн. Цахим үйлчилгээний нэгдсэн www.e-mongolia.mn порталын гар утасны e-mongolia мобайл аппликейшныг хөгжүүлж 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлээд байна.

Төрийн үйлчилгээний төвийн зохион байгуулалтыг Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын хүрээнд Үйлчилгээний төв болгон өөрчлөн зохион байгуулж, Төрийн үйлчилгээний операторын www.operator.e-mongolia.mn системийг хөгжүүлж, 21 аймгийн төв болон 330 сум, суурин газрын ЗДТГ-т нэвтрүүлж 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн операторын горимоор төрийн үйлчилгээг үзүүлж байна.

4.1.4.Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.

Биелэлт: Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх систем (emongolia.mn) -ийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр хөгжүүлж, тус системээр дамжуулан 2021 оны байдлаар тус системд 53 байгууллагын 562 үйлчилгээг нэгтгэж, давтагдсан тоогоор нийт 5,441,581 удаагийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэд, байгууллагуудад амжилттай үзүүлсэн буюу зорилтот түвшинд заасныг давуулан биелүүлж иргэдийн тоог 400.000-р нэмэгдүүлсэн.

Төрийн байгууллага, төрийн өндөр албан тушаалтнууд хооронд цаг үеийн онцгой нөхцөл байдал, "Ковид-19" халдварт цар тахлын үед нууцлал аюулгүй байдлыг хангасан цахим хурал, шуурхай хуралдаан, сургалт, зөвлөгөөн зохион байгуулах зорилгоор төрийн байгууллагуудыг холбосон дүрст хурлын нэгдсэн систем бий болгох ажлын хүрээнд 2022 оны улсын төсвийн нийт 2,097,806,757 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, нутгийн удирдлагын танхимууд, 16 яам, Засгийн газрын хуралдааны танхимыг тус тус төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний албан хэрэглээний нууцлалтай дүрст хурлын дэд систем сүлжээнд холбох ажлыг гүйцэтгэсэн.

2021 оны байдлаар зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээ ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор тус сангийн болон бусад сангийн мэдээллийг агуулсан тусдаа цэс үүсгэн үйл явдал хэсэгт оруулаад байна. Засгийн газрын харьяа тусгай сангуудын үйл ажиллагааг олон нийтэд ил болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд нэгтгэх, боловсруулах зорилгоор судалгааны асуулгыг боловсруулан үйл ажиллагаа явуулж буй 22 тусгай санд албан хүсэлт хүргүүлэн мэдээллийн системийн талаар судалгаа авч дүгнэлтийг боловсруулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системийг боловсронгуй болгоход шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийн зардлыг Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгасан бөгөөд шаардлагатай ажлын даалгавар, судалгаа, мэдээллийг боловсруулж байна.

4.1.5.Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг өргөжүүлж, багтаамжийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурван-Баян Улаан, Дэлгэрхаан сумын Хэрлэн-Баян Улаан, Булган аймгийн Хангал сум, Хялганат тосгоныг, Архангай аймгийн Хашаат сумыг тус тус шилэн кабелийн сүлжээнд холбосон. 2021-2022 онд “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ний хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймгийн Алтай сум, Дорнод аймгийн Халх гол сумыг шилэн кабелийн сүлжээнд холбосон. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх “Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл” -ийн хүрээнд Дорнод аймгийн Дашбалбар сум, Чулуунхороот сум, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан, Хөвсгөл аймгийн Ханх зэрэг 6 сумыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажлын хийгдэх ба энэхүү ажил хийгдэж дууссанаар Монгол улсын 330 сум бүгд шилэн кабелийн сүлжээнд холбогдож дуусна.

Улсын төсвийн болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд нийт 151 км урт шилэн кабелийн сүлжээ байгуулж 3 аймгийн 4 багуудыг холбоожуулсан, 2022 онд 1 аймгийн 1 багт 60 км урт шилэн кабелийн сүлжээ байгуулж харилцаа холбооны үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлсэн.

2022 онд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүрэг, Чингэлтэй дүүрэгт Мобиком корпораци ХХК, Юнител ХХК, Ай Эн Мобайл ХХК, Скайтел ХХК-иуд хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системийн туршилтын бүсийг тус тус үүсгэж, туршилтыг амжилттай хэрэгжүүлж 2023 онд 5G технологийг Монгол Улсад нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан.

Дархан-Уул аймаг дахь Үндэсний дата төвийн нөөц төвийг 2021 оны 6 дугаар сарын 04-ны өдөр Улсын комиссын дүгнэлтээр төвийн барилга засвар, цахилгаан хангамжийн ажлыг байнгын ашиглалтад оруулав.

2021 оны жилийн эцсийн байдлаар Шуудан, ложистик, цахим худалдааны дамжуулах чадварыг өргөтгөн, сайжруулах арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд: Цахим худалдааны Амазон сайтад Монгол Улсыг бүртгүүлж, Монголын компаниуд бараа бүтээгдэхүүнээ уг сайтад байршуулж олон улсад борлуулах боломжтой болсон. Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигтийн хөндийд шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч Монгол Шуудан ХК-ийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй “Шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төв”-ийн барилгын ажил 2020 оны 10 дугаар сараас эхлэсэн ба ажлын явц 60 гаруй хувьтай явж байна. Уг ажлын хүрээнд шуудан, цахим худалдааны дамжуулах чадварын талаарх 1 суурь судалгаа хийгдсэн. Мөн олон нийтэд таниулах үүднээс www.zipcode.mn цахим хуудасны англи хэл дээрх сонголтыг хөгжүүлсэн. Зип код, шуудангийн кодыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай тулгах, нэгтгэх ажил хийгдэж байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан шуудангийн нэгдсэн кодыг бусад платформуудтай холбох API-г Shoppy.mn, zochil.mn-үүдэд оруулахаар тохиролцож холбох ажлыг хийж байна.

Сансар судлал, сансрын технологитой холбоотой хууль эрх зүйн талаар судалгаа хийх ажлыг Сансрын үндэсний зөвлөлийн 2021 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж "Сансрын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд

оруулсан. Сансрын технологи, сансар судлалын чиглэлээр хуулийн зохицуулалт шаардлагатай асуудлуудын жагсаалт гаргахаар ажиллаж байна. Түүнчлэн Ази-Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагаас (APSCO) Европын сансрын агентлагтай (ESA) хамтран 2021 оны 9 дүгээр сарын 6-8-нд зохион байгуулах "Space Law Workshop-21" арга хэмжээнд салбарын мэргэжилтнүүд оролцов. Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/16 тоот тушаалаар "Монгол Улсад нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглахад баримтлах чиглэл"-ийг батлав.

4.1.6. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Улсын Их Хурлын 2021 оны намрын чуулганаар батлагдсан Кибер аюулгүй байдлын тухай хуульд Үндэсний цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв (CERT) болон нийтийн цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв (CERT)-ийг тус тус байгуулахаар тусгасан. Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 30-ны А/32-А/31 дугаар хамтарсан тушаалаар Үндэсний CERT байгуулах ТЭЗҮ боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, соёлын сайд нарын 2022 оны А/260, А/391, А/146, А/260 дугаар хамтарсан тушаалаар "Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2022-2026)"-г баталсан. Уг төлөвлөгөөнд "Ахисан түвшний сургалт"-ын хөтөлбөрт кибер аюулгүй байдлын талаар багц сургалтын хөтөлбөр бэлтгэхээр тусгасан.

Төрийн нэгдсэн сүлжээ болон үндэсний дата төв дээр байрлах өгөгдлийн сангийн бүсүүд болон төрийн үүлэн тооцооллын систем хоорондын хандалтыг хянах, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор хамгаалалтын фаерволл төхөөрөмжийг суурилуулсан. Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал /www.e-mongolia.mn/ системд Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраар эрсдлийн үнэлгээ хийлгэж, гарсан дүгнэлтийн дагуу мэдээллийн аюулгүй байдлын техник програм хангамжийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллаж байна.

Монгол Улсад IPv6 нэвтрүүлэх бодлогын баримт бичгийн эхний төслийг боловсруулж байна. 2021 онд "Төрийн байгууллага дахь мэдээллийн аюулгүй байдал"-ын судалгаанд төрийн 69 байгууллагуудын ашиглаж байгаа сүлжээний төхөөрөмжүүд IPv6 дэмждэг эсэхийг нэгтгэн судалж байна. Уг судалгаанд үндэслэн цаашид авах арга хэмжээг тодорхойлох юм.

Монгол Улсаас гадаад орнуудад суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд төрийн болон албаны нууц мэдээ, мэдээлэл дамжуулах орчны нууцлал аюулгүй байдлыг хангах, мэдээлэл алдагдах, халдлага, аюул заналаас сэргийлэх зорилгоор тус газруудыг холбосон тусгай хэрэглээний сүлжээ байгуулах төслийг 3 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөн, тусгай хэрэглээний сүлжээг зохион байгуулж, 5 Дипломат төлөөлөгчийн газрыг нэмж холбосон. Одоогийн байдлаар нийт 17 Дипломат төлөөлөгчийн газар тусгай хэрэглээний сүлжээнд холбогдоод байна.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн сургагч багш бэлтгэх төслийг Жайхантай хамтран хэрэгжүүлэхээр тогтсон. Төсөл нь 2022 оны 10 дугаар сараас хэрэгжиж эхлэх ба эхний ээлжид ШУТИС, МУИС-ын Мэдээллийн аюулгүй байдлын багш нарыг сургах, Удирдлагын академийн мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахаар тогтсон.

4.1.7.Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

Биелэлт: Төрөл бүрийн салбарын байгууллагууд төрийн үйл ажиллагаанд МХТ-ийн инновацийг нэвтрүүлэх олон ажил санаачилж хийж байна. Боловсролын яамны удирдлагын түвшинд салбарын статистик мэдээлэл, хөрөнгө оруулалтын явцын мэдээлэл, үндсэн тоон мэдээллийг бодит хугацааны горимоор гар утасны аппликешн болон веб хөтөч ашиглан харж, салбарын үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж байна. Мөн сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн ирцийн мэдээллийг Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглан бүртгэж, үр дүнг нь сургууль, аймгийн боловсролын газар, яамны түвшинд нэгтгэж харуулдаг боллоо.

Олон улсын стандартад нийцсэн мэдээлэл, харилцаа холбооны технологийн суурь мэдлэг, ур чадвар олгох бүх нийтийн сургалтыг зохион байгуулах чиглэлээр Фэйсбүүк групптэй хамтын ажиллагаа эхлүүлсний үр дүнд Харвард их сургуулийн Беркман Клейн төвийн мэргэжилтнүүдийн боловсруулсан “Digital literacy library” буюу “Тоон бичиг үсгийн номын сан” хөтөлбөрийг 2019 оны 4 дүгээр сард хэрэгжүүлж эхэлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн 11-18 насны хүүхдүүдийг цахим орчин болон нийгмийн мэдээллийн сүлжээнд зөв зохистой хэрэглээг бий болгон төлөвшүүлэхэд чиглэсэн 5 бүлэг 18 зүйл бүхий “Тоон бичиг үсэгтэн” сургалтын хөтөлбөрийн төслийг орчуулан боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулан гарын авлага хэлбэрээр бэлтгэн хэвлүүлэв.

Е-Mongolia системийг ард иргэдэд таниулан, сурталчлах ажлыг цахимаар болон явуулын сургалт зохион байгуулах хосолсон аргаар зохион байгуулж, е-Mongolia аппликэйшн таталтын тоо 857,634-д хүрч, хэрэглэгчийн тоо 1,8 сая хүрсэн. Нийслэлийн захын дүүргийн 50 хороодын албан хаагчид болон 4,908 иргэнд холбогдох сургалтыг зохион байгуулсан. Фэйсбүүк хуудас болон YouTube сувгаар видео контентуудын үзэлт давхардсан тоогоор 500,000 гаруйд хүрсэн байна. Тухайлбал, гадаад паспорт дахин захиалан авах тухай видеог 35,945 удаа, е-Mongolia систем ашиглан аж ахуйн нэгжээр хэрхэн нэвтрэх тухай видеог 32,146 удаа, е-Mongolia веб портал системээс төрийн үйлчилгээ хэрхэн авах тухай видеог е-Mongolia системийг хэрхэн ашиглах вэ видеог 70,254 удаа тус тус үзсэн байна. Бүх нийтийн цахим ур чадварыг сайжруулах чиглэлээр “Тоон бичиг үсэгтэн” гарын авлагыг 1000 хувь хэвлүүлж, сургагч багш бэлтгэх, нийгмийн ажилтан, ЕБС-ийн багш болон сурагчдад сургалт зохион байгуулж уг гарын авлагыг түгээсэн болно.

Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор баталсан “Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт”-д багтсан байгууллагууд болон төрийн байгууллагын мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан албан хаагчдыг чадавхжуулахаар “Кибер аюулгүй байдал, халдлагад үзүүлэх хариу арга хэмжээ” сэдэвт багц сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 12-ноос 16-ны өдрүүдэд цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулсан. Уг сургалтад төрийн 45 байгууллагын 136 албан хаагч, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад багтсан 166 байгууллагын 427 инженер техникийн ажилтан, нийт 563 ажилтан, албан хаагчид хамрагдаж кибер халдлага, зөрчилд хариу үзүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэхэд бэлтгэх, байгууллагын тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх талаарх мэдээлэл өгч, харилцан туршлага солилцсон.

4.1.8.Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.

Биелэлт: Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор баталсан цахим хэлбэрээр үзүүлж болох 496 үйлчилгээний 320 нь буюу 64 хувь нь баримт бичиг, лавлагаа,

мэдээллийн бүрдэл шаарддаг бөгөөд тус баримт бичиг, лавлагаа, мэдээлэл нь төрийн бусад байгууллагаас олгогддог байна. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гардаг цахим баримт бичгийг байгууллагууд хүлээн зөвшөөрөхгүй, шүүх нотлох баримтаар үнэлэхгүй байх зэрэг асуудал гарч байгаа нь иргэдийг ихээхэн бухимдуулж, хуульчдын дунд маргаан дагуулж эргэлзээтэй байдлыг үүсгэж байна. Дээрх хууль зүйн болон практик шаардлага, судалгаа, тайлан, зөвлөмжид тулгуурлан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хуулийн нэрийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай гэж өөрчлөн Улсын Их Хурлаар 2021 оны 12 дугаар сард батлуулсан болно. Уг хуульд төрийн байгууллагын нээлттэй байх мэдээллийг жагсаалт байдлаар тодорхой тусгахыг зорьж, одоогийн мөрдөж байгаа хуульд заасан нээлттэй, ил тод байлгах мэдээллийг нэмэгдүүлсэн, эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй өгөгдөл бий болгох, түүний нөхцөл, журам, нээлттэй өгөгдлийг төлбөртэй болон төлбөргүйгээр ашиглуулах, төрийн үйл ажиллагааг цахимаар явуулах, иргэн, хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх, төрийн байгууллага хоорондоо болон иргэн, хуулийн этгээдтэй цахимаар харилцахад шаардлагатай нийтийн мэдээллийн дэд бүтэц буюу үндсэн (“Хур” систем) болон дэмжих систем, мөн төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд эдгээр системийг ашиглан иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж болох талаар, мөн мэдээллийн сүлжээ, мэдээллийн сангийн талаарх зохицуулалтыг тус тус оруулсан байна.

Засгийн газрын Нээлттэй өгөгдлийн портал дээр 13 байгууллагын 28 бүлэг 122 өгөгдлийн бүрдлийг 4 төрлийн форматаар байршуулан олон нийтэд түгээж байна. Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын бүртгэл, тайлангийн модулийг Засгийн газрын хуралдааны системийн мобайл хувилбар болон ЗГХЭГ-ын дотоод удирдлагын цахим систем “Дижитал оффис”-тэй холбон хөгжүүлж, нэвтрүүлэхээр ажиллаж байна. Засгийн газрын шийдвэрийн цахим системийн ажлын даалгавар боловсруулах хуулийн болон мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдөр “Ухаалаг засаг” төслийн хүрээнд байгуулж, төслийн дундын тайланг хүлээн аваад байна.

4.1.9.Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

Биелэлт: “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн компаниудыг олон улсын зах зээлд гарахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гарааны бизнесийг дэмжих төлөвлөгөө боловсруулах” үүрэг бүхий төр, хувийн хэвшлийн төлөөллүүд оролцсон ажлын хэсгийг байгуулан, цахим уулзалтууд зохион байгуулж, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 50 гаруй старт ап компаниудаас судалгаа авсан. Цахим уулзалт, хэлэлцүүлэг, ажлын хэсгээс гарсан санал, дүгнэлтүүдийг нэгтгэж тайланг 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүн Х.Ганхуягт хүлээлгэн өгсөн.

Мэдээлэл технологийн үндэсний паркт түшиглэн Мэдээлэл, хандалтын төвийг байгуулахаар шийдвэрлэж, Бүгд найрамдах Солонгос Улсын талаас засвар үйлчилгээний ажил хийж, холбогдох тоног төхөөрөмжөөр хангаж 2022 оны 12 дугаар сарын 15-нд нээлтээ хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Уг төвд цахим ур чадвар чадамжийг дээшлүүлэх сургалтын 2 танхим, контент хөгжүүлэлтийн 1 танхимыг тус тус байгуулна. Энэхүү төвийн Контент хөгжүүлэлтийн танхимд үндэсний контент хөгжүүлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах, бүтээсэн контентыг олон нийтэд сурталчлах зэрэг үйл ажиллагааг явуулах юм.

Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэжил эзэмшүүлэх мэргэжлийн сургалтын “MKIT” төвтэй хамтран найман төрлийн нарийн мэргэжлийн сургалтыг иргэдэд үнэ төлбөргүй зохион байгуулж байна. 1,893 залуусыг сургалтдаа үнэ төлбөргүй хамруулснаас 835 нь сургалтыг амжилттай төгссөн. Энтрепренёршипийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Мэдээлэл технологийн Үндэсний парк” ТӨААТҮГ, Азийн бизнесийн холбоотой хамтран 10 долоо хоногийн “Access Asia” Экспортын хурдасгуур хөтөлбөрийг 2019 оны 4 дүгээр сараас 6 дугаар сарын хооронд зохион байгуулсан.

4.1.10.Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.

Биелэлт: Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын систем дэх албан хаагчдын мэдээлэлд суурилж 2020 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар төсвийн 3,984 байгууллагын 149,692 албан хаагчийн цалин хөлсийг ТАЦНС-д тооцоолж 94,8 тэрбум төгрөгийн цалингийн гүйлгээг Монголбанкны банк хоорондын багц гүйлгээний АСН+ системээр илгээж төрийн албан хаагчдын нэрийн дансанд шилжүүлсэн.

2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар бүх шатны төсвийн 4320 байгууллага, 182.3 мянган албан хаагчдын үндсэн мэдээлэл, үндсэн цалин хөлс, нэмэгдэл цалин хөлсний мэдээллийг ТА3-ийн ХНУМТ цахим системд бүртгэж ТАЦНС-д цахимаар хүлээн авч 1,761.8 тэрбум төгрөгийн цалин хөлсийг тооцоолсон байна.

Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба

4.2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.

4.2.1.Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.

Биелэлт: Засгийн газар Авлигатай тэмцэх комисс байгуулж, даргаар нь Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарыг томилов. Монгол Улс авлигын индексээр 180 орноос 111 дүгээр байрт эрэмблэгдэж байна. Засгийн газар авлигын индексийг хоёр жилийн дотор хоёр оронтой тоонд багтаах зорилт тавьж байна. Авлигатай тэмцэх газар 2019 онд 68 хэрэг шийдвэрлэсэн бол 2020 онд 114 хэрэг шалгаж, шүүхээр шийдвэрлүүлжээ. Авлигын гэмт хэргийг бий болгож байгаа суурь хүчин зүйлс буюу хууль эрх зүйн орчныг сайжруулах, цахим шилжилтийг эрчимжүүлэхэд гол анхаарлаа хандуулах бөгөөд мөн олон нийтийн дунд тандалт судалгааг долоо хоног бүр явуулж, хамтарсан төсөөллийн судалгаагаар хамгийн их хүнд суртал үүсгэж байгаа газрыг тогтоож, комисс асуудлыг шийдэхээр тогтсон.

Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 15-нд Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулсан болно. Хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэгтэй холбоотой бүлгийг бүхэлд нь хөндөж байгаа бөгөөд ингэхдээ энэ бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, тухайлбал, торгох ялын нэг нэгж нь хоёр мянган төгрөгтэй тэнцүү байхаар, зарим гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хасах, хорих ялын хэмжээг нэмэгдүүлэх нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасах, авлигын гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх өөрчлөлтийг тусгасан бөгөөд **хорих ялын хэмжээг нэмж байгаатай холбогдуулан хөөн хэлэлцэх хугацаа нэмэгдэнэ.**

4.2.2.Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ.

Биелэлт: Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгох зорилгоор яам, орон нутгийн түвшинд 23 ажлын хэсэг байгуулж, яам бүр агентлагийн түвшинд мөн дэд ажлын хэсгүүдийг байгуулж нийт давхардсан тоогоор 40 ажлын хэсгийн байгуулан ажилласан. Төрийн захиргааны төв байгууллагуудаас чиг үүрэгтэй холбоотой нийт 59 санал ирснээс тухайн яам өөрийн эрхлэх асуудлын хүрээнд агентлаг байгуулах санал нийт-6, одоо байгаа байгууллагын бүтцэд өөрчлөлт оруулах, шинэ бүтэц бий болгох санал- 3, төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах санал-2 ирсэн бол чиг үүргийг дахин хуваарилах санал-42 байна. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох нийт **192 санал function.gov.mn** цахим системд орсон байгаа бөгөөд ойролцоогоор **224 хуульд** өөрчлөлт оруулах санал ирүүлсэн байна. Гарч байгаа үр дүнгээс дурдвал: Усны тухай хууль шинээр батлагдаж Усны агентлаг байгуулагдаж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зарим чиг үүргийг хэрэгжүүлэхээр болж байна. Мөн Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж эмийн зохицуулалтын агентлаг байгуулах шийдвэр гарсан. Барилга, хот байгуулалтын яамнаас боловсруулсан Газрын тухай, Хот байгуулалтын тухай, Орон сууцны тухай зэрэг хуулиудыг УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн бүтэц, дүрмийн төслийг боловсруулж, төсвийг 2023 он улсын төсөвт суулган батлуулсан. Цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлтэй холбоотой шинэ барилга барихгүйгээр шийдвэрлэсэн тул Засгийн газраас Засгийн газрын XI байранд ЭЗХЯ-ыг оруулах асуудалтай хамт тус хүрээлэнгийн барилга шийдэгдсэн. Төрийн байгууллагад "цалингийн нэгдсэн систем"-д 2021 оны 6-р сарын 18 өдрийн байдлаар 4,146 байгууллагын 168,575 албан хаагчийн 777.8 тэрбум төгрөгийн цалин хөлсийг тооцоолж, Монголбанкны банк хоорондын багцын гүйлгээний АСН системээр дамжуулан арилжааны банк дахь төрийн албан хаагчдын нэрийн дансанд олгоод байна.

4.2.3.“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд зөвшөөрлийн цахим бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрөөс олгох зөвшөөрлийн тоог цөөлж, олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.

Биелэлт: Иргэн, хуулийн этгээдэд зориулсан 205 нэр төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимжуулахаар судалгааны ажил хийгдэж байна. Систем хөгжүүлж, нэвтрүүлэх санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсөв болон “Ухаалаг засаг-2” төслийн эх үүсвэрээс хийгдэхээр болсон.

4.2.4.Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.

Биелэлт: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын статусыг шийдвэрлэж, чадавх, үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийг тодорхой болгох асуудлыг тусгасан.

2022 онд төрийн өмчит хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулсан дүнгээр 6 хуулийн этгээдэд хамаарах нийт 1,180.94 сая

төгрөгийн зөрчил, дутагдлыг баталгаажуулж, шалгалтын мөрөөр авах 71 арга хэмжээг шалгалтын тайлангийн хамт тухайн компанид хүргүүлэн ажиллаж байна.

2021 онд төлөвлөгөөт 11, төлөвлөгөөт бус 6, гүйцэтгэлийн 10 хяналт шалгалт, нийт 27 хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөт хяналт шалгалтын тайлангийн баталгаажсан дүнгээр 12.490.74 сая төгрөгийн зөрчил, төлөвлөгөөт бус баримтын шалгалтад хамрагдсан төрийн өмчит 6 хуулийн этгээдэд нийт дүнгээр 290.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд зөрчил арилгах асуудалтай холбоотойгоор цаашид авч хэрэгжүүлэх нийт 90 арга хэмжээ, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах 86 арга хэмжээ бүхий үүрэг даалгаврыг эрх бүхий албан хаагчдад хүргүүлэн, 69 ажилтанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.

2021 онд 11 төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд төлөвлөгөөт системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн дүнгээр 1.2 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, баталгаажуулсан дүнгийн мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх нийт 53 арга хэмжээ, 55 зөвлөмжийг шалгалтад хамрагдсан байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, 35 албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

2020 онд төлөвлөгөөт 35, гүйцэтгэлийн 10 болон төлөвлөгөөт бус шалгалтыг тухай бүр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс төлөвлөгөөт 19, гүйцэтгэлийн 10, төлөвлөгөөт бус 7 хяналт шалгалтыг гүйцэтгэсэн бөгөөд төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр 21,290.74 сая төгрөгийн зөрчил илэрч цаашид авч хэрэгжүүлэх 84 арга хэмжээ, холбогдон гарсан тогтоол шийдвэрийн 104 арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг, даалгаврыг холбогдох хуулийн этгээдэд өгсөн байна.

2020 онд 7 төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд төлөвлөгөөт системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн дүнгээр 370.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд төсвийн хөрөнгөөр бий болж байгаа эд хөрөнгөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хуулийн дагуу бүртгэх, олж авах зөвшөөрөл авдаггүй, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажилладаггүй байдал нийтлэг тогтоогдсон. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан шалгалтын дүнгээр цаашид авч хэрэгжүүлэх 33 арга хэмжээ, тогтоол шийдвэрийн 36 арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг тус тус өгсөн байна.

4.2.5.Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

Биелэлт: Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд төрийн албан хаагч нэгжийн даргаар, нэгжийн дарга төсвийн шууд захирагчаар, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хагас, бүтэн жилээр үнэлж дүгнэхээр зааж өгсөн. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгжийн даргаас гадна байгууллагын үнэлгээний баг байгууллагын бүхий л түвшинд жигд, бодитой, шударга хийгдэж байгаа эсэхэд давхар хянах юм. Байгууллагын үнэлгээний багийн бүрэлдэхүүнд тухайн байгууллагын хүний нөөцийн ажилтан болон ёс зүйн хорооны төлөөллийг оруулж үнэлгээний субъектив байдлыг бууруулах ил тод, нээлттэй, шударга байх зарчмыг баримталсан. Төрийн үйлчилгээ үзүүлдэг албан хаагчийн ажлыг үнэлэхдээ үйлчлүүлэгчийн үнэлгээ оруулж өгсөн болно.

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Мөнхбат, Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан

гишүүн нар төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг нэгдмэл байдлаар зохицуулсан ерөнхий хуулийг батлан гаргах, түүнд төрийн албан хаагчдын сахин мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг тогтоож, зөрчсөн бол хүлээлгэх хариуцлагын төрөл, түүнчлэн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны журмыг тогтоох зорилгоор Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд 2022 оны 5 дугаар сарын 26-нд өргөн мэдүүлсэн.

4.2.6.Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.

Биелэлт: Төрийн албаны тухай хууль болон холбогдох эрх зүйн баримт бичигт заасны дагуу төрийн албан хаагчдад зориулсан дараах төрлийн сургалтыг зохион байгуулж байна. Үүнд:

1. *Мэргэшүүлэх дунд хугацааны сургалт*
2. *Мэргэшүүлэх багц сургалт*
3. *Богино хугацааны сургалт*

Төрийн шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан 10 хичээлийн агуулга, хөтөлбөрийг бүрэн шинэчилсэн бөгөөд мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтын нийт хичээлийн 50 хувийн агуулга, хөтөлбөрийг шинэчилж Удирдлагын академийн Хөтөлбөрийн хороогоор хэлэлцэн зөвшөөрч сургалтад ашиглаж байна. Богино хугацааны сургалтын хувьд төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулсан 40 цаг сургалтын агуулга, хөтөлбөрийг нийт 9 сэдвээр шинээр боловсруулж гаргасан. Цаг үеийн эрэлт шаардлага, төрийн байгууллага, албан хаагчдын сургалтын хэрэгцээнд тулгуурлан богино хугацааны зорилтот сургалтын агуулгын шинэчлэлийг хийж дараах чиглэлээр шинэ сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулан гаргасан. “Алсын хараа-2050”, “Систем сэтгэлгээ”, “Дизайн сэтгэлгээ”, “Зан үйлийн нөлөөлөл”, “Төрийн байгууллагын удирдах ажилтанд зориулсан жендэрийн сургалт” гэсэн богино хугацааны зорилтот сургалтад зориулсан сургалтын агуулга, хөтөлбөрийг шинээр боловсруулж гаргасан.

Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийн сургалтад 2020 онд 473, 2021 онд 608 төрийн албан хаагчийг, Төрийн албан хаагчдын давтан сургалтад 2020 онд 570, 2021 онд 622 төрийн албан хаагчийг тус тус сургалтад хамруулав. Нийт мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2020 онд 1043, 2021 онд 1230 төрийн албан хаагч хамрагдсан. Тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад нийт дүнгээрээ 2020 онд 446, 2021 онд 617 төрийн албан хаагчийг тус тус сургалтад хамруулав.

Төрийн албан хаагчдад зориулсан мэргэшүүлэх дунд хугацааны болон багц сургалт, богино хугацааны сургалтуудад 2020 онд нийт 3545 албан хаагчийг суралцуулахаар төлөвлөж 3190 албан хаагчийг сургаж Ковид-19 цар тахлын улмаас танхимын сургалтыг хязгаарласантай холбоотойгоор төлөвлөснөөс 10 хувиар цөөн албан хаагчийг элсүүлэн сургасан бол 2021 онд 6149 албан хаагчийг суралцуулахаар төлөвлөж 7295 албан хаагчийг сургаж төлөвлөснөөс 16 хувиар илүү элсүүлэн сургасан нь сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж онлайн хэлбэрээр зохион байгуулсны үр дүн юм. Төрийн албан хаагчдын дээрх сургалтуудыг 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өнөөг хүртэл Ковид-19 цар тахлын улмаас сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэн хэрэгжүүлж байна.

2022 онд Удирдлагын академи улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, судалгааны ажлын төлөвлөөгөөгөөр богино хугацааны сургалтад нийт 4340 төрийн албан хаагчийг сургахаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар 1688 сургаж **38.8%**-ийн гүйцэтгэлтэй байна. Мөн богино хугацааны сургалтад байгууллагын захиалгаар 1806

төрийн албан хаагч хамрагдсан. Ингэснээр нийт 3494 төрийн албан хаагчийг тус сургалтад хамруулсан байна.

Удирдлагын академийн сонсогчдын дотуур байр, дэмжих үйлчилгээний төвийн шинэ барилга баригдаж эхэлсэн бөгөөд 2021 онд 500 сая, 2022 онд 2.4 тэрбум төгрөг батлагдсан. Тус барилга нь сургалт, мэдээллийн төвийн байр, сонсогчийн дотуур байр, спорт заал бүхий 3 корпустай байхаар зураг, төсөв хийгдсэн ба нийт талбайн хэмжээ 11,621.1 м.кв, төсөвт өртөг нь 18,827.2 сая төгрөг юм.

4.2.7.Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.

Биелэлт: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18.4-т заасны дагуу Хороо нь төрийн захиргааны төв байгууллагад Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан салбар зөвлөл, орон нутагт Засаг даргаар ахлуулсан салбар хороотой бөгөөд одоогоор улсын хэмжээнд 14 яамны жендэрийн салбар зөвлөл, 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт салбар хороо нийт 45 салбар зөвлөл, хороо үйл ажиллагаа явуулж байна. Жендэрийн үндэсний хороо 2020 оноос хойш төрийн албан хаагчдын мэдлэг ойголтыг нэмэгдүүлэх хүрээнд 130 танхимын болон цахим сургалтад 16000 төрийн албан хаагчдыг хамруулаад байна. Үүнээс 2022 онд 42 сургалтаар 2600 төрийн албан хаагчдыг жендэрийн чиглэлээр чадавхжуулаад байна. 2022 оны байдлаар 14 яамдын салбар зөвлөлөөс нийт 12 яам жендэрийн талаар салбарт баримтлах бодлого батлагдсан байна. Жендэрийн салбар хороо 21 аймаг, нийслэл, 8 дүүрэг жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг батлуулан ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн хуралдааныг 2022.1.25-нд зохион байгуулж, Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. БХБЯ-ны дэргэдэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд 12 ажилтан ажиллаж байгаагийн 5 иргэний нийгмийн байгууллагуудаас тус бүр 1 ажилтан ажиллаж байна. Харьяа байгууллагуудад дэд салбар зөвлөлийг байгуулан, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг 1 дүгээр сарын 31-ний өдрийн 3/419 тоот албан бичгээр хүргүүлснээр БХТ, ТОСК байгууллагадаа орон тооны бус Жендэрийн дэд салбар зөвлөл, түүний ажиллах журмыг батлан хэрэгжүүлж байна.

4.2.8.Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана.

Биелэлт: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 21 зүйлд заасан Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийн хүрээнд Төрийн албанд жендэрийн тэгш байдлыг хангах 2021 оноос 2023 хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулагдлаа. Төрийн албаны зөвлөл нь Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөлийг байлгах үүднээс дээрх баримт бичгийг боловсрууллаа. Төрийн албан дахь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө нь Төрийн албаны зөвлөлийн стратеги төлөвлөгөөний стратеги зорилтуудын нэг бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх баримт бичиг юм. Төрийн албанд жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд:

-Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх зорилтын хүрээнд Хүний нөөцийн чиг үүрэгт жендэрийн үзэл баримтлалыг суулгах буюу Хүний нөөцийн чиг үүрэгт жендэрийн үзэл баримтлал

тусгах арга зүйн зөвлөмж, Төрийн албаны хүний нөөцийн аудитын өгөгдлийг жендэрийн үзүүлэлттэй болгох;

-Төрийн албан дахь удирдах албан тушаал дахь хүйсийн харьцааг тэнцвэртэй байлгах ажлын хүүрээнд Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааны хэрэгжилтийг судлан дүн шинжилгээ хийх, бодлогын санал боловсруулах;

-Төрийн албаны Удирдах албан тушаалтан, хүний нөөцийн болон жендэрийн мэргэжилтэн, албан хаагчдыг чадавхжуулах;

-Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотын хэрэгжилтийг хангах.

4.2.9.Үндэсний стандартуудыг олон улсын түвшинд нийцүүлж шинэчилнэ.

Биелэлт: Монгол Улсад 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 6528 улсын стандарт мөрдөгдөж байгаагаас олон улс, бүс нутаг, гадаад орны 2815 стандартыг үндэсний стандартаар мөрдөхөөр баталсан ба нийт стандартын 43 хувь нь олон улсын түвшинд хүрсэн байна. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар СХЗГ-ын дэргэдэх салбарын стандартчиллын техникийн хороод үндэсний 20 стандарт, олон улсын 50 стандартыг үндэсний стандартаар тус тус шинээр баталсан ба 25 стандартыг дахин хянаж, 5 стандартад нэмэлт, өөрчлөлт оруулан, хүнс, хөдөө аж ахуйн зарим салбарын стандартыг хянан үзэж ач холбогдлоо алдаж бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулж байгаа нийт 292 стандартыг хүчингүй болгоод байна.

2021 онд хүнс, эрүүл мэнд, аялал жуулчлал, эрчим хүч, уул уурхай ашигт малтмалын салбарт MNS ISO Guide 21 олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн 45 стандартыг шинээр, 13 стандартыг дахин хянаж, 59 стандартыг нэгийг харьцах нь нэгээр орчуулсан ба нийт 117 олон улсын стандартыг үндэсний стандартаар батлуулсан. Мөн шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогоор байнгын дэмжлэг туслалцаа үзүүлэх, худалдаан дахь техникийн саад тотгорыг бууруулах зорилгоор 31 олон улс, бүс нутаг, гадаад орны стандартыг бүртгэсэн. Үүнд: MNS ISO 11133:2021, Ус, хүнс, малын тэжээлийн микробиологи. Тэжээлт орчин бэлтгэх, үйлдвэрлэх, хадгалах, гүйцэтгэлийг шалгах MNS ISO 13485:2021, Эмнэлгийн хэрэгсэл. Чанарын удирдлагын тогтолцоо. Зохицуулалтын зорилгоор тавих шаардлага г.м. Мөн цах тахлын нөхцөл байдалтай уялдуулан эрүүл мэндийн салбарт 8 стандарт, COVID-19 цар тахалын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгааны стандартыг үндэсний болгон баталж УОК, ЭМЯ болон бусад оролцогч талуудад хүргүүллээ. Бүтээн байгуулалттай холбоотой олон улсын 1006 стандартыг оролцогч талуудад хүргүүлсэн бөгөөд үндэсний болгох, байгууллагын стандартаар бүртгүүлэх ажил хийгдэж байна.

4.2.10.Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

Биелэлт: "Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн төсөл"-ийг 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-ын 2022 оны намрын чуулган, холбогдох байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэгдэж байна. Тус хуулийн төсөлд түншлэлийн төсөл хөгжүүлэх болон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хараат бус гишүүд буюу тухайн салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулах талаар холбогдох зохицуулалтууд тусгагдсан. Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд Цар тахлын үеийн эдийн засгийг эрчимжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох

үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх Үндэсний хороог байгуулан 2021 оны 8 дугаар сарын 24-ний өдөр анхдугаар хурал хийв. Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгамдаж буй асуудлууд, сайжруулах санал, шийдлийг тодорхой зорилгоор бизнесийн салбарын төлөөллүүд, хуулийн фирмийн төлөөллүүдтэй 3 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг хийж санал боловсруулав. Төр хувийн хэвшлийн яриа хэлэлцээрийн хүрээнд АБНЕУ, ХБНАБУ, ИБНПУ, БНБАУ, БНФУ, БНМУ, МНУ, БННУ, БНАЛАУ, БНРУ, Өмнөд Африк, БНПУ, ОХУ, ХБНУлсын сайн туршлагыг судалж, төр хувийн хэвшлийн яриа хэлэлцээрийн хэрэгжилтийн явц, гарсан үр дүн, дэвшил хөгжлийн талаар судалгаа хийв.

Барилгын салбарын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ болон сургалт эрхлэгч байгууллагууд, сургалтын үйл ажиллагаа, орчин, байртай танилцах ажлыг хуваарийн дагуу зохион байгуулж, тайлагнасан. 12 төрийн бус байгууллагын сургалтын үйл ажиллагаатай танилцсан. 2020 онд 85 удаагийн сургалт зохион байгуулагдаж, 1939 инженер, техникийн ажилтанд мэргэшсэн, зөвлөх инженер, архитектор, төсөвчин, эдийн засагч, тэргүүлэх төсөвчин мэргэшлийн зэрэг шинээр олгох, сунгах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажилласан. Эдгээрийн 1106 ИТА-д мэргэшлийн зэрэг сунгаж, 833 ИТА-д шинээр зэрэг олгуулах ажлыг зохион байгуулсан. Барилгын салбарын болон орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээрийн төслийг хянан боловсруулж, 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр гэрээ байгуулсан.

Тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээний хүрээнд 2021.4.13-ны өдөр НҮБ, ОУ-ын Валютын Сан, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн банк тэргүүтэй 10 гаруй ОУ-ын байгууллагын 40 гаруй төлөөлөлд, 4 дүгээр сарын 15-ны өдөр Монголын томоохон бизнес группийн төлөөллүүд, шинээр гарч ирж буй гарааны бизнесүүд, бизнесийн холбоо зөвлөлүүд, мэргэжлийн холбоодоос бүрдсэн 80 гаруй төлөөлөлд, 4 дүгээр сарын 19-ний өдөр 21 аймаг болон нийслэлийн удирдлагуудын төлөөлөлд 100 төслийн эрэмбэлэл, арга зүй ба эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хэлэлцэх зорилготойгоор цуврал зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулав.

4.2.11.Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах, хилийн чанадаас улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт: Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит чуулганаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлд “Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх” тухай тусгасан.

“Халамжаас хөдөлмөрт” “Цар тахлын эсрэг хамтдаа-Хөдөлмөрийн цахим яармаг-2021” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд ажил хайгч иргэд, оюутан залуучууд, гадаадад их дээд сургууль төгссөн болон ажиллаж, амьдарч байгаад эх орондоо ирсэн иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээ, цахим хурлууд, 183 ажил олгогч байгууллагын 2129 сул чөлөөтэй ажлын байрны мэдээ, мэдээллүүдийг нэг доороос хүргэсэн. Энэхүү цахим платформоор дамжуулан 273 ажил хайгч иргэд болон ажил олгогчид цахимаар цаг товлон, ажлын шууд ярилцлагад 150 ажил хайгч иргэн хамрагдсан байна.

Амар тайван, аюулгүй нийгэм

4.3.Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.

4.3.1.Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглана. Хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хүний нөөцийг нэмэгдүүлнэ. Хилийн анги, салбаруудын автомашины парк шинэчлэлийг үе шаттайгаар хийнэ.

Биелэлт: Хилийн хэсэгт 330 км торон саад байгуулах материалыг татан авах ажил 40 хувьтай, 187,6 км газарт түймрээс хамгаалах шороон зурвас шинээр байгуулах, 782.2 км газрын шороон зурвасыг сэргээх ажлуудыг хийж гүйцэтгэв. Дорнод аймгийн Чулуун хороот сум дахь хилийн цэргийн ангийн “Эрээнцав” шалган нэвтрүүлэх салбарыг өргөтгөх барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьтай, ХХЕГ-ын өргөтгөл, Шуурхай удирдлагын төв, Хилийн цэргийн төв архивын барилгын 5 давхарын угсралтын ажил явагдаж байна. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суман дахь хилийн цэргийн анги шинээр байгуулах ажлын штаб, соёлын төв, спорт заалны барилгын суурийн газар шорооны ажил хийгдэж, тэнд хүчжүүлсэн застав барих барилгын ажлын материал татах ажил хийгдсэн ба Дорнод аймгийн Чулуунхороот суман дахь хилийн цэргийн ангийн “Авдархараат” салбарын орон сууц, мөн аймгийн Матад суман дахь хилийн цэргийн ангийн “Бага хүрээ”-гийн салбарын их засвар, Хэнтий аймгийн Дадал суман дахь хилийн цэргийн дугаар ангийн “Цагаанчулуут”-ын салбарын барилгын их засварын ажлууд эхэлсэн. Хилийн цэргийн ангиудын хилийн салбаруудад нийт 74 айлын орон сууц засварлах, гэрээт цэргийн байранд урсгал засвар хийх, ангиудын штаб, цэргийн байр, агуулахын барилгын дээврийг засварласан. Дорноговь аймаг дахь хилийн цэргийн ангид 1 хянах цамхагийг шинээр байгуулж, Дорнод аймаг дахь хилийн цэргийн ангид 1 хянах цамхагийг засварлах ажил 70 хувьтай, аймаг дахь хариуцсан хэсэгт шинээр гүүр барих ажил дууссан, мөн ангийн “Ямлах”-ын салбарын хариуцсан хэсэгт гүүр барих ажил 50 хувьтай, 1 хянах цамхагийг засварлах бэлтгэл ажлыг хангасан. Увс аймаг дахь хилийн цэргийн дугаар ангийн “Давст”-ын салбарыг төвлөрсөн эрчим хүчний системд холбохоор 17 км шугамын төмөр бетон тулгуур суурилуулсан. Булган, Хэнтий аймаг дахь хилийн цэргийн дугаар ангиудын хилийн салбаруудыг 5-10 кВт-ын сэргээгдэх эрчим хүчний системд холбох ажлын явц 35 хувьтай хэрэгжиж байна.

Хилийн “Чингис хаан” боомтод 2021 оны 07 дугаар сараас гадаадын иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийг бүртгэж эхэлсэн, хилийн 17 боомт шилэн кабелд холбож, Хилийн “Цагааннуур”, “Боршоо”, “Шивээхүрэн” боомтуудад зорчигч, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, боомтод мөрдөх журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах зөөврийн хамгаалалтын хаалт хашаа 300 ширхэг, агаарын замын “Чингис хаан”, Төмөр замын “Сүхбаатар”, “Замын-Үүд” боомтуудад гадаадын иргэнийг биометрик өгөгдлөөр бүртгэх (хурууны хээ унших, нүүрний зураг авах, паспорт унших) зориулалт бүхий 30 ширхэг таблетыг худалдан авч, албанд ашиглаж байна.

4.3.2.Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.

Биелэлт: Цагдаагийн ерөнхий газрын төсвийн хөрөнгөөс 821 сая төгрөгөөр Checkpoint 6000 техник тоног төхөөрөмж /багц1/, Firewall лиценз, техник хэрэгсэл /багц2/, K2 платформ системийн лиценз /багц3/, техник хэрэгсэл, Мэдээлэл, шуурхай удирдлагын

төвийн 2022 оны төсвийн зардлаас 43.7 сая төгрөгөөр сервер, сүлжээ, телехяналтын камерын системийн тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардагдах багаж, сэлбэг хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж худалдан авч, суурилуулан, үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Мөн Улсын төсвийн 2022 оны урсгал зардлын 1,5 тэрбум төгрөгөөр 546 суурин компьютер, зөөврийн 46 компьютер, 73 ширхэг 3 үйлдэлтэй хэвлэгч төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Бүгд Найрамдах Чех Улсын галт зэвсэг үйлдвэрлэгч “Ceska zbrojovka” байгууллагаас цагдаагийн байгууллагад шинэ загварын 6 ширхэг галт зэвсэг олгосныг хүлээн авсан. Тайлант хугацаанд гэмт хэргийн нөхцөл байдлын талаар 9, техник, технологийн талаар 3, ажлын ачааллын талаар 2, нийт 14 дүн шинжилгээ, судалгаа хийж, гарсан дүгнэлт, саналыг хэрэгжүүлэх зөвлөмж, чиглэлийг холбогдох нэгжид хүргүүлсэн. Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын 190 сургуулийн 90.137 сурагч, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн 20 төвийн 3325 оюутан нийт 93.462 сурагч, оюутан, 14310 багш ажилтан, 31200 иргэнд 1234 удаа сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил зохион байгуулсан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмд 422 удаа, “School police” эргүүлийн үйл ажиллагаанд 3539 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн Дамбадаржаагийн усан сан, Толгойтын усны эх үүсвэр, Алтай хотын ус хангамжийн эх үүсвэр буюу 3 ундны усны эх үүсвэр, Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК буюу 1 цахилгаан станц, Тайширын УЦС, Дарханы “Үндэсний дата төвийн нөөц төв” буюу 2 стратегийн орд, нийт 6 объектыг Дотоодын цэргийн хамгаалалтад авсан.

2022 онд олон улс, улсын чанартай авто замын 62 цэгт камерын хяналтын систем суурилуулахаар төлөвлөснөөс улсын төсөв болон орон нутгийн төсвийн 448 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Говьсүмбэр, Дорноговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь, Завхан, Баянхонгор аймгийн 9 сумдын 13 постод 68 ширхэг хяналтын камерыг суурилуулсан. Шүүх, прокурор, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 32 байгууллагын дундын зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем, программ хангамжийг урьдчилсан байдлаар боловсруулж, цахим системийн эхний хувилбарыг цагдаа, прокурорын байгууллагын хэмжээнд туршилтын журмаар ашиглан сайжруулалт, хөгжүүлэлт хийх замаар 2023 оны 01 дүгээр сараас үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад 568, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/251 дүгээр тушаалаар 90, нийт 658 алба хаагчийн орон тоо нэмэгдүүлэн хуваарилснаар нэг алба хаагчид оногдох ачаалал буурахад эерэг нөлөө үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. Бүртгэгдсэн гэмт хэрэг 35.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 9.9 мянга буюу 39 хувиар өссөн байна. Үүнээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 7.9 мянга буюу 57.7 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1.7 мянга буюу 22.1 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 305 буюу 33.3 хувиар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 138 буюу 25.6 хувиар өсжээ.

4.3.3.Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.

Биелэлт: 2022 онд тайлант хугацаанд 255 хамгаалалтын арга хэмжээг гэрч 12, хохирогч 230, хамаарал бүхий этгээд 4, бусад 1, нийт 247 иргэний аюулгүй байдлыг эрсдэлгүй ханган ажилласан Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хамгаалуулагч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт хамгаалалтын арга хэмжээ 150 нэгж буюу 1.5 дахин, нийт хамгаалуулагч 137 нэгж буюу 1.37 дахин өссөн үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд 36 түр

хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгаа ба тайлант хугацаанд нийт 1853 иргэн /Үүнээс насанд хүрсэн эрэгтэй 20, эмэгтэй 576, хүүхэд 1257/ үйлчлүүлсэн. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс нийт үйлчлүүлсэн иргэн 372-оор буурсан /Үүнд эрэгтэй 61 буюу 75.3 хувиар, эмэгтэй 115 буюу 16.6 хувиар, хүүхэд 196 буюу 13.5 хувиар буурсан/ байна.

4.3.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын 13-25 насны өсвөр насны хүүхэд, залуучуудын дунд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршиг, үр дагаврын тухай ойлголт, мэдлэг, хандлага, хэрэглээний тархалтын талаарх судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийх, шаардлагыг тодорхойлох зорилгоор “Хасах 25” төслийг хэрэгжүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдох эрсдэлтэй зорилтот бүлгийн хүүхэд, залуучуудын дунд хэрэглээний тархалт, ойлголт, мэдлэг, хандлагыг тодорхойлох 10,000 респонденттой 6 модуль бүхий суурь судалгааны ажлыг 2020-2021 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн.

“Устгал” арга хэмжээг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрийн хооронд мансууруулах үйлчилгээтэй олсны ургамал /каннабис/-ын тархац тогтоогдсон 11 аймгийн 38 сум, нийслэл хотын 1934.66 га талбайд химийн хор цацах, хөрсөнд булах, гараар түүх, хадаж шатаах зэрэг аргаар устгах ажлыг зохион байгуулж, аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 85.414.280 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Арга хэмжээний үр дүнд нийслэл хотод 2 жил дараалан устгал хийсэн 2 цэгт олсны ургамал ургаагүй.

Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байгуулах ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт албадан эмчлэх эмнэлэг барих зориулалтаар 150 га газар, ШШГЕГ-ын хэрэгцээнд ашиглагдах 10 га газрын нэгж талбарын хил заагийг тодотгон, кадастрын зургийг үйлдүүлж баталгаажуулсан, барилгын зураг төслийг боловсруулав.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах, хараа хяналтыг сайжруулах чиглэлээр тэдний эцэг, эх, багш, нийгмийн ажилтнуудад чиглэсэн сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах “Сургагч багш” бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 31 алба хаагчийг хамруулан гэрчилгээ олгосон. 2022 онд 57 төрийн байгууллагын 2772 алба хаагч, 30 төрийн бус байгууллагын 3998 ажилтан, 16 их, дээд сургуулийн 317 багш, 2635 оюутан, ерөнхий боловсролын 57 сургуулийн 1250 багш, нийгмийн ажилтан, ахлах ангийн сурагчдын 5230 эцэг, эх асран хамгаалагч, нийт 16202 хүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулж, 16000 ширхэг гарын авлага тараан тэдний мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршиг, үр дагаврын тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, эрэлт нийлүүлэлтийг хязгаарлах, борлуулалт нийлүүлэлтийн сүлжээг таслан зогсоох, сэжигтэй этгээд бүлэг бөөгнөрөл, тэдгээрийн хууль бус үйлдлийг илрүүлэх, эмзэг цэгүүдэд чиглэсэн удаа дараагийн арга хэмжээг үе шаттай зохион явуулсны үр дүнд 2022 оны эхний 10 сарын байдлаар 5 хүүхэд гэмт хэрэг холбогдон шалгагдаж байсныг өмнөх онтой харьцуулахад 6 болж 1 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. Цагдаагийн байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт

бодистой холбоотой нийт 148 гэмт хэрэг, 148 сэжигтэн бүртгэгдэж, эд мөрийн баримтаар 49,820 хүн/тун хэмжээ бодисыг хурааж авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 21 буюу 16.5 хувиар өссөн бол суурь он болох 2019 оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 46 буюу 23.7 хувиар буурсан байна.

4.3.5.Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.

Биелэлт: 2022 оны 11 дүгээр сарын хүн худалдаалах 9 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 5 нэгжээр буюу 1.2 хувиар өсч, уг гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон 27 /насанд хүрээгүй 22/ хүн байна. Хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага /IDLO/, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүйсийн тэгш эрхийн төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж “Охидоо сонсьё”, “Хүүхэд хамгаалал”, “Илрүүлэлт”, “Хүүхэд нэгдүгээрт”, “Хяналт”, “Хүүхэд бидний амьдралын үргэлжлэл”, “Хүүхэд хохирох ёсгүй”, “Анхаар хүүхэд”, “Намайг анхаараарай”, “Сонсьё -Хамгаалъя” зэрэг 15 төрлийн тусгай арга хэмжээг зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцсон. Улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулагдсан хөршийн хяналтын бүлэг 1689, өсвөрийн сэргийлэгчдийн бүлгэм 282, эцэг эхийн эргүүл ажилласан 511 сургууль, хамтарсан баг 442 үйл ажиллагаа явуулж байна. Үүнд 52177 иргэн хамрагдсан ба цагдаагийн байгууллагаас дээрх бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд 2677 удаа зөвлөмж өгч хамтран ажиллаж байна.

2021 онд 41 хохирогч, 2022 оны 11 сарын байдлаар 45 хохирогч хандаж анхан шатны (хамгаалах байрны үйлчилгээ, гадаад оронд хүний найманы хохирогч болсон Монгол улсын иргэдийг эх нутаг нь эгүүлэн авчрах, эрүүл мэнд, хоол хүнс, нэг удаагийн хувцас, ахуйн хэрэглээний үйлчилгээ, хууль зүйн туслалцаа болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх гэх) болон нөхөн сэргээх (сэтгэл засал, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, өмгөөллийн туслалцаа, гэр бүлд нэгтгэх, ажил зуучлах, гэх) үйлчилгээнд хамрагдсан байна. Төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд “Хүйсийн тэгш эрхийн төв”-д 3, “Талита Ази” ТББ-д 4, нийт 7 бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болсон иргэнийг, хүүхэд хамгаалах /107/ төв /108/-ийн хамгаалах байранд 5 иргэнийг тус тус байрлуулж, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлж, хууль эрх зүйн туслалцаа үзүүлсэн.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Сүүдэр бүү тусга” ухуулга нөлөөллийн аяныг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Олон улсын байгууллагын санхүүжилт бусад аж ахуйн нэгж, байгууллагуудын дэмжлэгтэйгээр энэ оны 9, 10 дугаар саруудад улсын хэмжээнд зохион байгуулсан. Тус аяныг олон нийтэд сурталчлах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн 156, төрийн бус 122 байгууллага, 1135 аж ахуйн нэгжтэй хамтран сургалт сурталчилгаа 675, зөвлөгөөн 58, хэлэлцүүлэг 44, өдөрлөг 53 удаа зохион байгуулж, нийт 949 байгууллага, 90545 иргэнийг хамруулсан.

2021 онд оршин суугаа газраасаа сураггүй алга болж цагдаагийн байгууллагын “АСАП” санд эрэн сурвалжлагдаж байсан 12 өсвөр насны охид, эмэгтэйчүүдийг олж тогтоон, ар гэрийхэнд нь хүлээлгэж өгсөн. 2021 онд хүн худалдаалах 9 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнө оны мөн үеэс 1 нэгжээр буюу 11.1 хувиар буурсан байна.

4.3.6.Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд шаардлагатай цахим бугуйвч, тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, суурилуулсан. Мөн Цахим хяналт, удирдлагын төвийг байгуулж, “Цахим хяналт, удирдлагын төв”-ийн хяналтын дэлгэц, алба хаагчдын компьютер техник хэрэгсэл, серверийн нөөц тэжээлийг суурилуулан үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 2022 оны байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн 1317 ялтанд хяналт тавин ажиллаж байна.

Аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, техник хяналтын ажилтны нийт 36 орон тоог шинээр нэмсэн. Шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 21 хорих ангийг бүсчилсэн хэлбэрээр нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх шаардлагатай болсонтой холбогдуулан аймгуудыг баруун, зүүн, хангайн, говь, төвийн гэсэн 5 бүсэд хувааж, Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хорих ялын хугацаа дуусахаас өмнө хоригдлыг нийгэмд гаргахад бэлтгэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, суралцах, ажил хөдөлмөр эрхлэх дадал хэвшүүлэх, гэр бүлийн харилцаанд бэлтгэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022.08.30-ны өдрийн А/167, А/233 дугаар хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Хоригдлыг суллагдахад бэлтгэх зорилгоор 417, 419, 439 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиуд нь тусгайлсан нийгэмшүүлэх байр болон өрөөг бэлтгэн тохижуулж, нийгмийн харилцаа, амьдралд гарахад бэлтгэх, дадлага олгох сургалтыг зохион байгуулж байна.

4.3.7.Шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангана.

Биелэлт: БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд төслийн хүрээнд хүрээлэнгийн шинжилгээний лабораториудыг Олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн тоноглож, метохондр, бактериологийн шинжилгээний лабораториудыг шинээр байгуулж шинжээчдийг урт, богино хугацааны сургалтад үе шаттайгаар хамруулж, БНСУ-ын шинжээч, мэргэжилтнүүдийг урьж сургалт зохион байгуулан ажиллаж байна. Төслийн хүрээнд тус хүрээлэнгийн 10 удирдах албан тушаалтан 2022 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 03-ны өдрүүдэд Сөүл хотод зохион байгуулсан эхний ээлжийн сургалтад хамрагдсан. Мөн БНСУ-д зохион байгуулагдсан гүйцэтгэх албан тушаалтны эхний ээлжийн сургалтад тус хүрээлэнгийн ДНХ, Хими, Дижитал шинжилгээний 6 албан хаагч 2022 оны 08 дугаар сарын 01-нээс 09 дүгээр сарын 16-ны өдрүүдэд, хоёрдугаар ээлжийн сургалт 10 дугаар сарын 02-ноос 11 дүгээр сарын 16-ны хооронд зохион байгуулагдаж ДНХ, Бичиг баримт, Химийн шинжилгээний лабораторийн 6 албан хаагч хамрагдсан.

“Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах 18.5 сая ам.доллар өртөгтэй төсөл”-ийн ерөнхий хэлэлцээрийн гэрээг МУ-ын Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Монгол дахь Эксим банкны төлөөлөгчид 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд БНСУ-ын Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 121/19 тоот албан бичгээр санхүүжилт олгох тухай Батламж ирүүлсэн. Төслийн хүрээнд шүүх эмнэлгийн

шинжилгээний лабораторийн болон цогцос хадгалах барилгыг Нийслэлийн баруун талд барихаар Техник эдийн засгийн үзүүлэлтийг хийж дуусгасан. Барилга барих 1 га газрыг Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Архивын ерөнхий газрын баруун урд талд шийдвэрлүүлж, холбогдох техникийн нөхцөл, зөвшөөрлүүдийг авсан бөгөөд барилгын зургийг “Зуун найм” ХХК-аар, барилга угсралтын төсвийг “Өрх” ХХК-аар хийлгүүлсэн болно.

Гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлж гэмт хэрэгтнийг нотлон тогтоох болон санг бүрдүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ДНХ-ийн мэдээллийн сангийн “Mondis” хайлтын системийг хийсэн бөгөөд уг хайлтын систем нь “Иргэн”, “Ялтан”, “Гэмт хэрэг”, “Илрээгүй гэмт хэрэг” гэсэн үндсэн 4 ангилалтай бөгөөд ангилал тус бүрээр хайлт хийх, мэдээлэл оруулах, цаашид хөгжүүлэлт хийх боломжтой бөгөөд тус хайлтын системд нийт 8000 гаруй ДНХ-ийн мэдээллийг оруулж бүртгэсэн байна. Мөн Цагдаагийн ерөнхий газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран хорих ангид ял эдэлж байсан хоригдол, өршөөлийн хуулиар суллагдсан ялтан, орон гэргүй тэнэмэл хүн, захиргааны хяналтад байгаа зэрэг нийт 10000 орчим хүнээс генетикийн дээж авч хадгалсан.

4.3.8.Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг эх нутагт нь байршуулж, үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын баримтыг эдийн засгийн эргэлтэд оруулна.

Биелэлт: “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний төслийг боловсруулсан бөгөөд энэ хүрээнд ирэх жилүүдэд гадаадын улсуудад хадгалагдаж байгаа манай түүх, соёлд холбогдох үзмэр, дурсгалын зүйлсийг худалдан авахаар төлөвлөж буй бөгөөд энэхүү арга хэмжээний төсөвт (9 тэрбум 350 сая төгрөг) батлагдсан болно. Гадаад улсад хадгалагдаж байгаа баримтаар Үндэсний архивын сан хөмрөгийг 351 баримтаар бүрдүүлсэн. Үүнд: ОХУ-ын Кино, гэрэл зураг, дуу авианы баримтын архиваас болон Данийн Хааны музейн сан хөмрөгт буй баримтаас гэрэл зураг, дүрс бичлэгийн баримтын хуулбарыг хүлээн авсан. Нийт 12 орноос 78 дан болон иж бүрдэл үзмэрийн хуулбарыг авахаар ажиллаж байна. 2022 онд ОХУ-ын Шинжлэх ухааны архиваас олон улсын сансрын нислэгийн түүхэнд холбогдох 147 хуудас бүхий 87 баримтыг хуулбараар авсан. Оросын Шинжлэх ухааны академийн архиваас Д.Г.Мессершмидтийн баримт бичгийн өв дэх толь зүйн материал: “Монгол, төвд толь бичгийн тойм” 458 хуудас зохиолыг цахимаар авч хэвлэн товч оршил бичиж, Үндэсний төв архивын сан хөмрөгт авсан. БНСУ-ын Солонгос судлалын академид хадгалагдаж байгаа XIII зууны Юань улсын хууль цаазын түүхэнд холбогдох “Чжичжэн-гийн хуулийн бичиг хэмээх хууль цаазын бичгийн дурсгалын тухай танилцуулгыг гаргасан.

21 аймгийн төрийн архивын байр, хадгаламжийн сан, өрөө тасалгааны хэмжээ, зай талбайн хүрэлцээ, нөхцөл байдлын судалгааг шинэчлэн гаргасан. Архивын байр барих газрын асуудлаа шийдвэрлэсэн, зураг төсөл хийлгэх боломжтой болсон аймгуудын судалгааг нэгтгэн гаргасан. Улсын бүртгэлийн архив, үйлчилгээний цогцолбор төвийн барилга Сүхбаатар дүүрэгт 2020-2021 онд баригдаж ашиглалтанд орсон. 6 аймагт /Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий/ Архивын байр барих газрын асуудлыг тухайн аймгуудын Засаг даргын захирамжаар шийдвэрлэв. 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймгийн архивын барилга баригдаж байна, 75 хувийн гүйцэтгэлтэй, Увс аймгийн архивын тасгийн баригдаж эхэлсэн, 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын төрийн зүтгэлтэн, Ерөнхий сайд асан Д.Содномын хувийн хөмрөг үүсгэх арга хэмжээг 2022.06.09-ний өдөр зохион байгуулж, түүний амьдрал үйл ажиллагаанд холбогдох 1970-2022 оны 147 хадгаламжийн нэгж хувийн гаралтай баримтаар Үндэсний төв архивын сан хөмрөгийг баяжуулсан.

4.3.9.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.

Биелэлт: ХЗДХЯ, ГХЯ, ХХЕГ, ТЕГ, ГИХГ, ДТГ-уудын мэдээллийн нэгдсэн санг бий болгохоор холбогдох журмыг боловсруулж, уг ажлыг гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулаад байна. Цахим визийн системийг нэвтрүүлсэн. Мэдээллийн нэгдсэн сангийн эхний хувилбарыг 2021.11.01-нээс туршилтын журмаар нэвтрүүлж, хөгжүүлэлтийг хийж байна. Уг системээр нэн тэргүүнд Европын 32 улс, Монгол Улсад ирэх жуулчдын тоогоор тэргүүлдэг Австрали, Шинэ Зеланд, БНСУ нийт 35 улсын иргэдэд цахим виз олгож байна.

Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор Нэгдсэн үндэстний байгууллагын “Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр /goTravel/-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэн систем (APP, PNR)-ийг Чингис хаан боомтод нэвтрүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем /RNSF/-ийг 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглалтад оруулж, 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нийт 111,716 гадаадын иргэнд регистрийн дугаар олгосон.

4.3.10.Ачаа болон нийтийн зорчигч тээвэрлэлтийн зориулалттай тээврийн хэрэгсэл автомашины камертай байх стандартыг тогтоож, баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг үе шаттайгаар хязгаарлах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна.

Биелэлт: Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн бариад байна. Энэхүү хуулийн төслийн шинэчилсэн найруулгын хүрээнд баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг хориглох, 7-оос дээш жилийн насжилттай тээврийн хэрэгслийн импортыг бууруулах УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан хүргүүлээд байна. Мөн ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс GPS системийг нэвтрүүлсэн бөгөөд цаашид RFID цахим технологийг нэвтрүүлэх “Зам, тээврийн салбарын зарим үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулаад байна.

“Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага. MNS 4598:2003” стандартад “Ачаа болон нийтийн зорчигч тээвэрлэлтийн зориулалттай тээврийн хэрэгсэл автомашины камертай байх” талаар холбогдох заалтыг тусгаж батлуулсан. 2021 онд МУ-д 128016 автомашин бүртгэлтэй, зам, тээврийн осол 22482 гарсан. 1 машинд ногдох ЗТО-0,0182 байна. 2022 оны 9 дүгээр сарын байдлаар МУ-д 1280216 автомашин бүртгэлтэй, зам, тээврийн осол 15006 гарсан. 1 автомашинд ногдох ЗТО-0,0117 болж буусан байна

4.3.11.Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлж, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл өндөртэй бүсүүдэд байгуулна.

Биелэлт: Монгол Улсын хэмжээнд байгуулах гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн системийн шийдэл, техник, эдийн засгийн үндэслэлийн баримт бичгийг

боловсруулах талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан зөвлөлдөх уулзалтыг 2021 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулж, гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн харилцаа холбооны сүлжээнд холбох, өргөтгөн сайжруулах асуудал хариуцсан ажлын хэсгийн гишүүд болон дотоод, гадаадын харилцаа, холбоо мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нийт 20 аж ахуйн нэгж, байгууллагын давхардсан тоогоор 93 төлөөлүүд оролцож, гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийг харилцаа холбооны сүлжээнд холбох, өргөтгөн сайжруулах оновчтой шийдлийг тодорхойлсон. Онцгой байдлын ерөнхий газраас техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэгч Францын “Консейл Сантэ” компанитай хамтран Зарлан мэдээллийн системийн өнөөгийн нөхцөл байдлын нарийвчилсан судалгааг хийсэн. Тус судалгаанд үндэслэн Зарлан мэдээллийн системийн төслийн ерөнхий загвар, дотоод зарлан мэдээллийн системийн техникийн шийдэл, сансрын холбооны зарлан мэдээллийн системийн техникийн шийдэл; үүрэн холбооны хэрэглэгчдэд гамшгийн аюулын зарлан мэдээллийг шуурхай хүргэх техникийн шийдэл болон төслийн удирдлагын баримт бичиг, ТЭЗҮ-ийг боловсруулсан.

4.3.12. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон санхүүгийн системийг хөгжүүлнэ.

Биелэлт: Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжийн дагуу Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад холбогдох байгууллагууд хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг судалсны үндсэн дээр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл болон дагалдах хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтүүдийг Хууль, тогтоомжийн тухай хууль болон бусад олон улсын туршлага, стандартад нийцүүлэн боловсруулсан. Хуулийн төслийг УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, баталсан.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2022 оны 7 дугаар сарын 27-нд Монгол Улсын Явцын тайланг гишүүн орнуудаар хэлэлцүүлж, батлуулсан. Хуралдаанаар “хагас хэрэгжүүлсэн” үнэлгээтэй байсан ФАТФ-ын Зөвлөмж 15-ыг “дийлэнхийг хэрэгжүүлсэн” болгож үнэлгээг амжилттай ахиулсан байна. “Зөвлөмж 15”-ын үнэлгээ баталгаажсанаар Монгол Улс ФАТФ-ын нийт 40 Зөвлөмжөөс 39 Зөвлөмжийг техник зөвлөмжийн хувьд бүрэн болон дийлэнхийг хэрэгжүүлсэн үнэлгээтэй болгож, ахиц гаргав.

Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийж гүйцэтгэх ажлыг Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан 2020 оны 01 дүгээр сард эхлүүлж, Сангийн сайдын тушаалаар ажлын хэсгүүд байгуулагдаж ажилласан. Энэ хүрээнд банк, үнэт цаас, даатгал, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид болон ашгийн бус байгууллага зэрэг нийт 15 салбарын эрсдэлийн үнэлгээг дэд ажлын хэсгүүд хийж гүйцэтгэсэн. Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх нөөц бололцоог зөв хуваарилах, болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломж нөхцөл бүрдэх юм.

Терроризмтой тэмцэх зөвлөлийн гишүүд, холбогдох албан тушаалтнууд, Терроризмтой тэмцэх 22 салбар зөвлөл, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлж болзошгүй үйлдлийг мэдээллэх үүрэгтэй 4 салбарын 30 байгууллагад сургалт, мэдээллийн ажил хийгдсэн. Дээр дурдагдсан мэдээллэх үүрэгтэй 4 салбарын 30 байгууллагад шалгалтыг зохион байгуулсан нь терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн үр дүнтэй ажил болсон.

4.3.13.Иргэдийн эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтүүдийг өндөр нарийвчлалтай тодорхойлж, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрсдэлд суурилсан хяналтаар чанд мөрдүүлнэ.

Биелэлт: Хилийн хорио цээрийн хяналтын чадавхыг бэхжүүлэх зорилгоор Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл (МОН-3313)-ийн хүрээнд Замын-Үүд, Сүхбаатар боомт дахь ХМХА, Дархан-Уул аймгийн МХГ-ын ХМХХ-ийн улсын байцаагчдыг түргэвчилсэн шинжилгээний 150,000 ам.долларын 15250 ширхэг багаж хэрэгслээр хангасан.

Мэргэжлийн хяналтын төв, орон нутгийн байгууллагын лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд 2021 онд нийт 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, лабораторийн барилгыг барих, шаардлагатай шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийг худалдан авч нийлүүлсэн. 2022 онд хяналтын итгэмжлэгдсэн сүлжээ лабораториудаас 3 аймгийн МХГ-ын лабораторид тоног төхөөрөмж, 1 аймагт лабораторийн байр болон тоног төхөөрөмж шинэчлэх ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр батлан хэрэгжүүлэв. Баян-Өлгий, Завхан, Говьсүмбэр аймгийн мэргэжлийн хяналтын газарт орон нутгийн хөрөнгө оруулалтаар лабораторийн тоног төхөөрөмж худалдан авав.

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл (МОН-3313)-ийн хүрээнд нийт 69 төрлийн лабораторийн тоног төхөөрөмж, 43 төрлийн урвалж бодис, 19 төрлийн зөөврийн хяналтын багаж, 19 төрлийн тавилга эд зүйлийг 2020 онд лабораториудад хүлээлгэн өгөхөөс Лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх компанийг сонгон шалгаруулан 244 300\$ үнэ бүхий нийт 19 төрлийн 519 ширхэг тавилга хэрэгслийг Замын-Үүд, Сүхбаатар боомт дахь ХМХА, Дархан-Уул аймгийн мэргэжлийн хяналтын газрын лабораториудад хүлээлгэн өгсөн. Realtime PCR багажийг ашиглан махны төрөл болон бактерийн төрөл зүйл тодорхойлох, арга аргачлалыг бүрэн нэвтрүүлэв.

4.3.14.Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна.

Биелэлт: Улаанбаатар хотод хүнсний агуулах барихтай холбоотойгоор Онцгой байдлын ерөнхий газар, “Капитал хүнс” ХХК-ийн хооронд 2022 оны 3 дугаар сарын 07-ны өдөр “Ажил гүйцэтгэх” 8 дугаар гэрээ байгуулан улсын нөөцийн хүнсний бараа, материал хадгалах механикжуулсан агуулахын техник-эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулаад байна. Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулахын зураг төсөл техник эдийн засгийн үндэслэл, салбар зам барих зураг төсөл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг тус тус хийлгэхээр ОБЕГ “Эм Пи Ай консалтонс” ХХК, “Өндөр хаан трейд” ХХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн “Зураг төслийн төв”-тэй 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдөр “Ажил гүйцэтгэх” гэрээг тус тус байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

4.3.15.Салбар дунд ашиглах “Агаарын аврах хүчин” байгуулна.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд Францын төрийн сангийн зээлийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газраас БНФУ-ын Иргэний аюулгүй байдал, гамшгийн удирдлагын газартай хамтран агаараас аврах ажиллагааны анги нэгж байгуулах төслийг хэрэгжүүлж

байна. Төслийн хүрээнд Онцгой байдлын байгууллагад нисэх хүчний нэгж шинээр байгуулан, нисдэг тэрэгний 12 нисгэгч, 12 механик, авианик, ослын үеийн яаралтай тусламж үзүүлэх 3 эмчийг сургаж дадлагажуулж байна. Мөн Агаараас эрэн хайх, аврах, эмнэлгийн тусламж үзүүлэх үйл ажиллагаанд зориулан тоноглогдсон Airbus EC-145 T-1 загварын 3 нисдэг тэрэг, нисэгч нарыг сургах бага оврын 1 нисдэг тэрэг, симулятор нийлүүлж, нисдэг тэрэг байрлах ангарт байгуулаад байна. Агаараас эрэн хайх, аврах ажиллагааны нэгжид нисгэгч, инженер, техникийн ажилтан бэлтгэх зорилгоор БНФУ-ын Хэли-Юнион компанийн сургагч багш “Нисгэгч бэлтгэх онолын сургалт”-ын эхний шатыг 2021 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс 3 дугаар сарын 26-ны өдрүүдэд, 2 дахь шатыг 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс хойш, инженер-техникчдийн сургалтыг 6 дугаар сарын 07-ны өдрөөс хойш тус тус зохион байгуулж байна. Эхний ээлжинд нийлүүлэгдсэн 2 нисдэг тэрэг нь угсралт, засварын үйлчилгээ хийгдэж 2022 оны 6 дугаар сараас эрэн хайх, аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж, өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор 15 аймаг, сумын нутаг дэвсгэрт 37 удаагийн ослын дуудлагаар нислэг үйлдэж, 50 хүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж, тэдний амь нас, эрүүл мэндийг авран хамгаалаад байна.

4.3.16. Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, хүрээлэн байгаа орчны эрүүл, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хэмжил зүйн эталоныг хөгжүүлнэ.

Биелэлт: Герман Улсын Физик техникийн хүрээлэн /РТВ/-гээс “Даяаршлын чанарын дэд бүтцийн сан 95276-01-B58” төслийн хүрээнд Зайнаас хэмжих хэт улаан туяаны эмнэлгийн термометр шалгах эталон тоног төхөөрөмжийг авсан бөгөөд 2021 оны 12 дугаар сард хүний биеийн халууныг зайнаас хэмжих хэт улаан туяаны термометрийг шалгаж тохируулах лабораторийн байрыг засварлан ашиглалтад оруулсан. 2021 оны 12 дугаар сард 20 хэт улаан туяаны термометрт шалгалт тохируулга хийсэн.

Монгол Улсын болон БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн сангийн дэмжлэгээр тус газарт хамтран хэрэгжиж буй төслийн хүрээнд шингэний нягтын эталон болох аерометрүүд БНХАУ-ын хэмжил зүйн хүрээлэнгээс нийлүүлэгдэж нягтын эталоны чадавхи, нарийвчлалыг нэмэгдүүллээ. Цахилгааны эталоны нарийвчлалыг дээшлүүлэх зорилтын хүрээнд ХБНГУ-ын Физик техникийн хүрээлэнгээс хэрэгжүүлж байгаа төслөөр Тогтмол гүйдлийн эсэргүүцлийн 6 эталон, өндөр нарийвчлалын жин, согтуурлын түвшин хэмжих эталон, ажлын эталон манометр СХЗГ-т нийлүүлэгдэхээр худалдан авалт хийгдэж, цахилгааны хэмжлийн дээрх эталон тоног төхөөрөмжүүд тус газарт 2022 онд нийлүүлэгдснээр нарийвчлалын түвшинг 10 хувиар нэмэгдүүлж чадсан. Булган аймгийн СХЗХ нь 55 сая төгрөгөөр 18 нэр төрлийн эталон, Орхон аймгийн СХЗХ нь 45.1 сая төгрөгөөр 52ш эталон, Дундговь аймгийн СХЗХ нь 30 сая төгрөгний эталон туухайг орон нутгийн болон улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлэн, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтад ашиглаж байна.

4.3.17. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.

Биелэлт: Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж батлав. Газрын тосны хайгуул, олборлолтын чиглэлээр ашиглах тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг

импортлох, ашиглах тусгай зөвшөөрөл олгох асуудлыг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байна.

4.3.18.Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлнэ. Архидан согтуурахтай тэмцэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна.

Биелэлт: Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж, хуулийн төслийг 2021 оны 03 дугаар сарын 19-нд Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар эцэслэн баталсан.

Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл

4.4.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.

4.4.1.Орон тооны гишүүдээс бүрдсэн Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороог байгуулах замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлж, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах хууль, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авна.

Биелэлт: Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон бусад хуулийн төслийг Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн чуулганаар баталсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/72 дугаар тушаалаар Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан бөгөөд хуулийн төслийг боловсруулж байна.

4.4.2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно.

Биелэлт: Монгол Улсын цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ болон гадаад орны харьцуулсан судалгааг хийлгүүлж, хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Мөн 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр салбарын холбогдох судлаач, эрдэмтэдтэй уулзалт хийж, хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан бөгөөд хуулийн төслийг боловсруулж байна.

4.4.3.Хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэнэ.

Биелэлт: Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Эрх зүйч, хууль сахиулагч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд тус хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа хийж хуулийн төслийг боловсруулж байна.

4.4.4.Эх газрын эрх зүйн бүлийн хэв шинж, философид суурилсан Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн, хүний эрхийг дээдэлсэн, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн урт хугацааны “Эрх зүйн шинэтгэл II” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Биелэлт: 2050 он хүртэлх Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулж, хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж байна.

4.4.5.Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, хуулийн төслийг 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар баталсан. 2021 оны байдлаар нийт 52 улсын өмгөөлөгч ажиллаж байгаа ба тайлант хугацаанд 2292 эрүүгийн хэргийн 2293 төлбөрийн чадваргүй холбогдогчид үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн байна. Хууль зүйн туслалцааны төв нь 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 31 салбарт 48 улсын өмгөөлөгчийн орон тоотойгоор ажиллаж байна.

4.4.6.Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, цахим гэрээ, хэлцлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулан цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Биелэлт: Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлуулсан.

Засгийн газрын 2020 оны 12 сарын 16-ны өдрийн хуралдаанаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж, хуулийн төслийг 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хууль боловсруулах ажлын хэсгийг байгуулан төслийг боловсруулан холбогдох байгууллагаас саналыг авч, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Уг хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нарын нэр бүхий гишүүдээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Дампуурлын /Төлбөрийн чадваргүйдлийн/ тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж дуусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Арилжааны тухай хууль төслийн боловсруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, Шүүхээр шийдвэрлэгдсэн арилжааны хэрэг маргаанд дүн шинжилгээ хийх арилжааны гэрээний судалгаа, гадаад улсын арилжааны хуулийн харьцуулсан судалгаа, Монгол Улсын бизнес эрхлэгчдийн дунд тогтсон бизнесийн практик/зан заншлын хэм хэмжээний тухай зэрэг нэмэлт судалгааг тус тус хийлгэсэн бөгөөд хуулийн төслийг боловсруулж байна. Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн ойлголт, нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн эрх зүйн харилцааг зохицуулсан бусад орны хуулийг судалж, Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн бөгөөд нэгж хувьцаа эзэмшигчтэй компанийн харилцааны зохицуулалтыг хуулийн төсөлд тусган боловсруулж байна.

4.4.7.Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.

Биелэлт: Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялыг чангатгах хуулийн төслийг 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тус хуулийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн.

Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, мансуурахтай тэмцэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг эцэслэн боловсруулж байна. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг эцэслэн боловсруулж Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

4.4.8.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.

Биелэлт: Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хүрээнд хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээг хийсэн бөгөөд хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулж, холбогдох байгууллагаас санал авахаар ажиллаж байна.

4.4.9.Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ, хязгаарыг тодорхойлж, хуулийн төслийн боловсруулалтын чанарын үр нөлөөг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах байнгын механизмыг бүрдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

Биелэлт: Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газар хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг тогтоох, хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтийн үр дагавар болон боловсруулсан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх, зардал тооцох зэрэг аргачлалыг оновчтойгоор томъёолох, хуулийн төслийн боловсруулалтын чанарын үр нөлөөг дээшлүүлж, хуулийн төслийн төрлийг

тогтоох, хуулийн албан бус орчуулга хийх зэрэг харилцааг нарийвчлан тусгаж эхний хувилбарыг боловсруулж, холбогдох яамд, байгууллагуудаас санал авав. Хуулийн төслийг эцэслэн боловсруулсан бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

2022 оны 11 дүгээр сард Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулж хөрөнгө оруулалт, бизнесийн эрх зүйн холбогдох 18 хуулийн англи орчуулгыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn сайтад байршуулсан бөгөөд одоогоор нийт Монгол Улсын 100 хуулийн албан бус орчуулгыг байршуулсан.

4.4.10.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.

Биелэлт: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд холбогдох саналыг цахимаар авч тусган хуулийн төслийг эцэслэн боловсруулж, 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн.

Төрийн өмчийн удирдлага, менежмент болон олон улсуудын төрийн өмчийн талаарх бодлого, баримталж буй чиглэл, компанийн засаглал, санхүү, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх OECD, PWC, ADB (АХБ), World Bank, IDB, IMF (ОУБС), EBRD зэрэг олон улсын байгууллагуудаас эрхлэн гаргасан судалгаа, тайлантай танилцан судалж, боловсруулалт хийв.

Төрийн өмчийн хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, олон нийтийн хяналтад оруулах зорилгоор 2022-2023 онд биржээр төрийн мэдлийн 34 хувийг нээлттэй худалдах жагсаалтыг баталлаа. Үүнд: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ болон авто зам арчлалтын компаниуд багтсан. “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК нь нийт хувьцааныхаа 34 хувь буюу 119,157,603 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 100 төгрөгөөр тогтоосон үнийн аргаар олон нийтэд санал болгож, 11.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр анхдагч зах зээлийн арилжааг 2022 оны 12 дугаар сарын 26-нд эхлүүллээ.

2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр дээр дурдсан 46 төрийн өмчит хуулийн этгээдүүдийн орлого 4.0 их наяд төгрөг болж 30.0 хувиар, зардал 2.6 их наяд төгрөг буюу 6.6 хувиар, цэвэр ашиг 940.0 тэрбум болж 146.7 хувиар тус тус өссөн байна. Мөн 1.1 их наяд төгрөгийн татвар хураамж, төсвийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь төлөвлөснөөс 39.3 хувиар өссөн үр дүнтэй байна. 2021 оны төлөвлөгөөнд өглөгийг 3.6 их наяд төгрөг байхаар төлөвлөсөн бөгөөд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 3.2 их наяд төгрөг болж 9.6 хувиар, авлагыг 1.4 их наяд төгрөг байхаар төлөвлөсөн нь 506.0 тэрбум төгрөг болж 64.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн 6813 хуулийн этгээдийн улсын үзлэг, тооллогын дүн мэдээг хянан баталгаажуулах ажлыг хийж дууссан бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг, тооллогын дүнг Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу 2022 онд 45.5 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашиг, Ирээдүйн өв санд 535.1 тэрбум төгрөгийн хувьцааны ногдол ашгийг тус тус төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж байна. ТӨБЗГ-ын 2022 оны 307 дугаар тогтоолоор тогтоосон хувь хэмжээ, хуваарилалтын дагуу төрийн өмчит

болон төрийн өмчийн оролцоотой 44 хуулийн этгээдээс төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байна. 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар төрийн өмчийн ногдол ашгийн нийт 156.1 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Санхүү, эдийн засгийн их сургууль, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажиллаж, “Монгол шуудан” ХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Амгалан дулааны станц” ТӨХК, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК зэрэг компаниудад засаглалын үнэлгээг хийв. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 53.9 хувь байсан бол 64.8 хувьд хүрсэн үр дүнтэй байна.

4.4.11.Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна.

Биелэлт: Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хуулийн төслийг Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл болгон 3 салган боловсруулсан бөгөөд Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж Засгийн газрын гишүүд, төрийн байгууллага, төрийн бус байгууллагаас хуулийн төсөлд саналыг авч нэгтгэв. Хуулийн төслийг Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд, хуулийн төслүүдийг 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралданаар эцэслэн баталсан. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас саналыг авч хуулийн төслийг эцэслэн боловсруулж байна.

4.4.12.Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

Биелэлт: Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/321 дүгээр тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого

4.5.Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.

4.5.1.Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, цахимаар үзүүлэх үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ.

Биелэлт: www.e-notary.mn системийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс Австрали, Австри, Швед, АНУ (Чикаго), БНТУ (Истанбул) дахь ДТГ-уудад, 9 дүгээр сарын 15-наас нийт 35 ДТГ-т туршилтаар нэвтрүүлж, хөгжүүлэлтийг хийж байна. Цахим нотариатын системийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс нийт ДТГ-д бүрэн нэвтрүүлэх бэлтгэл хангасан. Уг систем нэвтэрснээр иргэд өөрт ойр байрлах нотариатчаас итгэмжлэл, баримт бичгийг хүлээн авах боломж бүрдэнэ. “E-mongolia” цахим хуудасны нүүр хуудаст байгаа “Гадаадад байгаа монгол иргэн” гэсэн хэсэгт шинээр хуудас нээж, 40 төрлийн үйлчилгээний холбоосыг 2021.03.19-нөөс байршуулав.

Хилийн чанадад 90-ээс дээш хоног оршин суугаа иргэдийг бүртгэх программыг ГХЯ, УБЕГ, ҮСХ хамтран боловсруулж, 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс нэвтрүүлэв. Хилийн чанадад 90-ээс дээш хоног оршин сууж буй монгол иргэд www.citizen.gov.mn цахим хуудсанд хандан сайн дурын үндсэн дээр бүртгүүлж байна. 2022 оны байдлаар нийт 32,000 мянга орчим иргэн бүртгүүлээд байна.

Гадаад харилцааны яамнаас иргэдийн эрх ашгийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, гадаад худалдааны эргэлтийг сайжруулах зорилгоор консулын төлөөлөл шинээр байгуулах, консулын албыг бэхжүүлэх асуудлаар судалгаа, статистикт тулгуурлан БНХАУ-ын Манжуур хотод Консулын газрыг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. 2021 оны 12 дугаар сард Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод суух Консулын газрын 3 дипломат, 1 үйлчилгээ техникийн ажилтныг томилон явуулж, 2022 оны 3 дугаар сард албан ёсоор КГ-ыг нээж үйл ажиллагаагаа эхлүүлэв. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 70 дугаар тогтоолоор Монгол Улсаас Австралийн Холбооны Улс, Монгол Улсаас Шведийн Хаант Улс, Бүгд Найрамдах Чех Улсад суугаа ЭСЯ-ны бүтцэд Консулын хэлтэс байгуулахаар шийдвэрлүүлж, 2022.09.01-ний өдрөөс үйл ажиллагааг нь эхлүүлэв.

Гадаадад оршин суугаа иргэдийн иргэний бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа, мэдээллийг ДТГ-ууд УБЕГ-аас цахим шуудангаар авдаг тогтолцоог 2020 онд бүрдүүлж, 1000 орчим хүнд үйлчилгээ үзүүлээд байна.

2021 онд хилийн чанадад 49 иргэн гэмт хэрэг зөрчилд холбогдсон нь 2020 оноос 40,8 хувиар буурсан үзүүлэлт юм. 2020 онд хар тамхи зөөвөрлөсөн, хэрэглэсэн, орон байраар хангасан зэрэг гэмт хэрэгт манай улсын 3 иргэн саатуулагдан шалгагдсан нь 2019 онтой харьцуулахад 84.2 хувиар буурсан. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 99 иргэн гэмт хэрэг зөрчилд холбогдсон нь өмнөх оны мөн үеэс 8 хувиар буурсан байна.

2022 онд Монгол Улсын Засгийн газар, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар, 2020 онд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Словени Улс, Бүгд Найрамдах Эквадор Улсын Засгийн газар хооронд дипломат болон албан/сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай хэлэлцээр байгуулав. Монгол Улсын энгийн паспорттай иргэд визгүй зорчих улсын тоог хоёроор нэмэгдүүлж, Парагвай, Перу улстай энэ төрлийн хэлэлцээрийг тус тус байгуулах нөхцөлийг бүрдүүлэв. Бүх төрлийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Засгийн газрын 2022.08.03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж, ойрын хугацаанд цахимаар гарын үсэг зурах саналыг холбогдох талуудад тавиад байна. Мөн Мальдив, Доминикан, АНЭУ-тай бүх төрлийн паспортыг визийн шаардлагаас чөлөөлөх тухай хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, уг хэлэлцээрийг байгуулах дотоодын процедураа эхлүүлээд байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-нд өөрчлөлт оруулав. Энэ хуулиар Монгол Улсын цахим виз, хилийн боомтод олгох виз, виз мэдүүлгийн төвийг нээх зэрэг виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх эрх зүйн зохицуулалт тусгагдсан. Засгийн газраас “Монгол Улсын виз олгох журам”-ыг шинэчлэн баталж, 2021 оны 8 дугаар сарын 16-наас шинэчилсэн журмыг мөрдөж эхлэхээр боллоо. Тус журам шинэчлэгдсэнээр Монгол Улсын визийн ангиллууд нэмэгдэж, дипломат, албан, хөрөнгө

оруулах, хөдөлмөр эрхлэх, суралцах, гэр бүл, цагаач, хувийн, шашны болон түр ирэх зорилгоор гэж төрөлжүүлж, 64 ангиллын виз олгохоор болж байна. Монгол Улсын визийг цахимаар олгох зохицуулалтыг шинээр тусгаж, эхний ээлжид жуулчин /K2/, соёл, урлаг, спортын тэмцээн уралдаанд оролцох, кино, контент бүтээх /K4/ болон дамжин өнгөрөх /K6/ визийн ангиллыг цахимаар авах боломжтой боллоо. Цахим визээр анхны гадаад зорчигч 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсад зорчин ирсэн бөгөөд 2021.12.30-ны өдрийн байдлаар тус системээр гадаадын 94 иргэн цахим виз мэдүүлснээс 88 иргэнд зохих журмын дагуу виз олгов. Монгол Улсын цахим визийн www.evisa.mn системээр 2022 оны 1-11 дүгээр сард нийт 36 улсын 7281 иргэнд виз олгосон.

4.5.2.Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.

Биелэлт: Олон талт гадаад худалдааг нээлттэй, чөлөөтэй байх явдлыг дэмжих, экспортын гол бүтээгдэхүүний зах зээлийг нээлттэй байлгах үүднээс хоёр болон олон талт чөлөөт худалдааны хэлэлцээрийг үндэсний ашиг сонирхолд нийцүүлэн байгуулах, гадаадын өрсөлдөөнд бэлэн бус байгаа болон өөрийн давуу тал болсон эдийн засгийн зарим салбар, дотоодын үйлдвэрлэлийг гадаад худалдааны хамгаалалтын арга хэрэгслээр хамгаалах зэрэг үндсэн зохицуулалтыг тусгасан “Гадаад худалдааны хууль” боловсруулаад байна.

Евразийн эдийн засгийн комиссын зөвлөлөөс Монгол Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны Ажлын хэсгийг байгуулах шийдвэр 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр гарсан. Хамтарсан судалгааны анхны хуралдааныг 2020 оны 10 дугаар сарын 5-нд цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааг хийж байна.

“Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг УИХ 2022.04.28-нд баталж, батламж жуух бичгийг зохих журмын дагуу хэлэлцээрийн эх хадгалагчид хүргүүлж, улмаар тус хэлэлцээр 2022.07.27-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт 2020 оны 9 дүгээр сард нэгдэн орж, 2021 оны 1 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэв. Хөнгөлөлтийн жагсаалтад багтсан бараа бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэгчдэд сурталчлан таниулах үүднээс АНДХХ-ийн мэдээлэл, дотоодын ААН-үүдэд үүссэн боломжийн талаар богино хэмжээний видео шторкийг ТРАМ төслийн дэмжлэгтэйгээр боловсруулан ДТГ-уудад хүргүүлж, олон нийтийн сүлжээ болон томоохон мэдээллийн агентлагуудаар цацаж, ГХЯ болон ДТГ-уудын цахим хуудаст байршуулсан.

ЕХ-ны улсууд руу экспортыг өргөжүүлэх зорилготой “Монголын мэдээлэл, худалдааг дэмжих төв”-ийг байгуулах бэлтгэл үйл ажиллагааг 2020 оны 12-р сараас эхлүүлсэн бөгөөд ЕХ-ны улсууд дахь цар тахлын хөл хорионы улмаас тус төвийн үйл ажиллагааны албан ёсны нээлтийг ХБНГУ-ын Берлин хотноо 2021.06.24-ний өдөр зохион байгуулав.

4.5.3.Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Хөрөнгө оруулалтын тухай шинэчилсэн найруулгын төсөлд хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг хамгаалах асуудал хариуцсан зөвлөлийн эрх үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон төрийн

байгууллагуудаас хөрөнгө оруулагчдын гомдол, маргааныг шуурхай шийдвэрлэх талаар тусгах арга хэмжээний зохицуулалтыг шинээр тусгасан.

Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулан Монгол Улсын бизнес, хөрөнгө оруулалтын орчны мэдээлэл, хөгжлийн төслүүдийн жагсаалт, танилцуулга, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах цахим систем болон төрийн цахим үйлчилгээнүүдийг нэг цонхоор үзүүлэхийн тулд доорх цахим систем, цахим хуудсыг нэгтгэн, сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж байна.

1.e-invest.mn (Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан төрийн бүх үйлчилгээний цахим систем)

2.investmongolia.gov.mn (Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга цахим хуудас)

3.ipc.gov.mn (Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, гомдол шийдвэрлүүлэх цахим систем).

E-invest.mn цахим системээр 2022 оны 05 дугар сарын 18-ны өдрөөс эхлэн хөрөнгө оруулагчийн тодорхойлолтыг олгож эхлээд байна. Систем ашиглалтад орсноос хойш нийт 1,300 орчим хэрэглэгчтэй болж, цахим системээр хөрөнгө оруулагчийн 2,900 орчим тодорхойлолт олгосон.

Засгийн газрын 2022 оны 11 сарын 23-ны өдрийн хуралдаанд гадаадын хөрөнгө оруулагчдаас гаргасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор "Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол гаргуулсан. "Хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг цахим хэлбэрээр бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих SIRM" системийг Дэлхийн банк группын Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран хөгжүүлж, 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдөр ашиглалтад оруулсан бөгөөд системийн үйл ажиллагааг идэвхжүүлэхээр Үндэсний хөгжлийн газар, Дэлхийн банк группын Олон улсын санхүүгийн корпораци, Монгол дахь Америкийн худалдааны танхим, Монголын бизнесийн зөвлөлтэй хамтран 2020 оны 12 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд цахим хурлыг зохион байгуулсан. 2020 онд 4 гомдол, 2021 онд 20 гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Хөрөнгө оруулагчдад зориулсан Төслийн ном "Project Pitchbook 2020"-ыг 2020 оны байдлаар шинэчлэн боловсруулж, тус байгууллагын цахим хуудаснаас үнэ төлбөргүйгээр татан авахаар байршуулаад байна. Төслийн ном 2020-д уул уурхай, хүнд үйлдвэр 6, эрүүл мэнд 3, байгаль орчин, аялал жуулчлал 1, эрчим хүч 10, зам, тээвэр 5, ХАА, хөнгөн үйлдвэрийн 6 төсөл буюу нийт 31 төсөл, мөн дээрх салбаруудад хөрөнгө оруулах боломж, давуу талуудын талаар мэдээлэл оруулж нэгтгэн гаргасан. Хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг байгуулан 2019.2.25-ны өдөр нээлтээ хийсэн ба ҮХГ, УБЕГ, ТЕГ, НДЕГ, ГИХГ гэсэн төрийн 5 агентлаг, инновацийн сан, банк, нотариат, үл хөдлөх хөрөнгийн зөвлөгөө зэрэг төрийн болон хувийн байгууллагуудын нийт 62 төрлийн үйлчилгээг хөрөнгө оруулагчдад зориулан нэг цэгээс үзүүлж байна.

Хөрөнгө оруулагчийн оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг уламжлалт хэлбэрийн цаасаар ажлын 3 хоногт гаргадаг байсан бол invest-assist.gov.mn веб сайтыг 2020.3 дугаар сараас ашиглалтад оруулснаар "ХУР" мэдээлэл солилцох төрийн системээр дамжуулан УБЕГ, НДЕГ, ТЕГ, Гадаадын иргэн, харьяатын газруудын системтэй холбогдож, ажлын 8 цагт хүсэлтийг шийдвэрлэн хариу өгдөг болсон. Систем ашиглалтад орсноос хойш 2784 хүсэлтийг хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлэсэн болно.

Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай гэрээний загварыг Засгийн газрын хуралдаанаар батлуулсан. Гэрээний загварыг БНСУ, Энэтхэг, Вьетнам, Тайландын Хаант улсад тус тус хүргүүлж, хөрөнгө оруулалтын хэлэлцээрийг шинэчлэн байгуулахаар хэлэлцээг эхлүүлээд байна.

Монгол-Оросын бизнесийг дэмжих болон хөрөнгө оруулалт татах” боломж сэдэвт уулзалтыг 2021.08.28-ны өдөр хийв. “Invest in Mongolia - Tokyo 2021” Монгол-Японы бизнес форумыг 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулав. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам)-ын 2021 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн цахим уулзалтад Зочин илтгэгчээр оролцож, Монгол Улсын эдийн засаг, худалдаа, гуравдагч хөршийн бодлого, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграц, хамтын ажиллагаа, Монгол-Америкийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэл хийв.

АНУ-д 2022 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс 9 дүгээр сарын 5-ны өдрүүдэд “Монголын худалдаа, хөрөнгө оруулалт, өв соёлын чуулган”-нд оролцож, Шинэ сэргэлтийн бодлогын хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслүүдийг сурталчлах ажлыг эхлүүлсэн. Монгол дахь Америкийн худалдааны танхимаас 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдөр гишүүн байгууллагууд, хөрөнгө оруулагч нартай цаг үеийн асуудлаар хийсэн уулзалтад “Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт ба санхүүжилт” сэдвээр илтгэл танилцуулж, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн шатны 61 төсөл болон эх үүсвэр шаардлагатай 33 төслийн талаар мэдээлэл хүргэсэн. БНСУ-ын Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг (KOTRA)-тай хамтран “Global Project Plaza 2022” ногоон, тогтвортой бизнесийг дэмжсэн 2022 оны 5 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулсан арга хэмжээнд Шинэ Сэргэлтийн Бодлогын төслүүдийг танилцуулсан.

4.5.4.Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны хүрээнд улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, худалдаа, соёл, хүмүүнлэг зэрэг бүх салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлнэ.

Биелэлт: ОХУ-ын Гадаад харилцааны сайд С.Лавров манай улсад 2022 оны 7 дугаар сарын 5-нд айлчилж, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгтэй хэлэлцээ хийж, Монгол Улсын удирдлагатай уулзав. ОХУ-ын Төрийн Думын орлогч дарга Ш.В.Кара-Оол манай улсад 7 сард айлчилж, УИХ-ын дэд дарга С.Одонтуяатай уулзав. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Дорнын эдийн засгийн VII уулзалтад оролцох үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтэй уулзаж, “Газпром”, “Роснефть”, “Оросын төмөр замууд”, “Газпромбанк”, “Роскосмос” компанийн тэргүүн нартай уулзав. Үүний дүнгээр АИ-92 бензинийг ОХУ-аас 2027 он хүртэл хөнгөлөлттэй үнээр авахаар тохиролцов. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 2.03-08-нд БНХАУ-д айлчилж, БНХАУ-ын Дарга Ши Жиньпин, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кэчян, ХКН-ын Төв хорооны Гадаад харилцааны газрын дарга Сун Тао нартай уулзав. Айлчлалын үеэр Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг БНХАУ-ын Гадаад харилцааны сайд Ван И-тэй уулзав. Айлчлалын хүрээнд эдийн засгийн чухал ач холбогдолтой 5 баримт бичигт гарын үсэг зурж, “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталсан тухай БЖБ-ийг солилцов. БНХАУ-ын Гадаад харилцааны сайд Ван И-гийн Монгол Улсад 2022.08.07-08-нд хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд 3 баримт байгуулав.

Самарканд хотноо 2022.09.15-16-нд болсон ШХАБ-ын дээд түвшний уулзалтын үеэр МУ, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын ээлжит VI уулзалт болж, тус уулзалтаар ЭЗ-ийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар хэлэлцэв. Уулзалтаар “Монгол, Орос, Хятадын ЭЗ-ийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг 5 жилээр сунгасныг зарлав. Мөн ойрын үед ЭЗ-ийн коридорын төмөр замын Төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх ТЭЗҮ-ийн ажлыг эхлүүлэхээр болсныг мэдэгдэв. Мөн төмөр замын зүүн болон баруун коридорын байгуулах ажлыг хэрэгжүүлж эхлэх нь чухал гэдэгт талууд санал нэгдэв.

Монгол-Оросын худалдааны хэмжээ 2022 оны эхний 10 сарын байдлаар 2.1 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 46 хувиар өссөн. Эдийн засгийн стратегийн ач

холбогдол бүхий газрын тосны бүтээгдэхүүнийг ОХУ-аас авч байгаа одоогийн нөхцөл байдалд худалдааны алдагдлыг бууруулах боломж хомс байна. Монгол-Хятадын худалдааны хэмжээ 2022 оны эхний 10 сарын байдлаар 10.96 тэрбум ам.долларт хүрч энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 63.9 хувийг эзэлж байна.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОХУ-д 2021 оны 12-р сард албан ёсны айлчлал хийв. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавровтой 2021 оны 2, 11-р сард, Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 7-р сард Ерөнхийлөгч В.Путинтай, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ОХУ-ын Ерөнхий сайд М.Мишустинтэй 11-р сард тус тус утсаар ярих. ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга А.Оверчук 10-р сард, Холбооны Зөвлөлийн орлогч дарга К.Косачёв 11-р сард тус тус манай улсад айлчилсан. Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2021 оны 6 дугаар сарын 1-5-ны өдрүүдэд ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хүрээнд 6 дугаар сарын 1-ний өдөр сайд Б.Батцэцэг ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавровтой албан ёсны хэлэлцээ хийв. Гадаад харилцааны сайд Н.Энхтайван ОХУ-ын Гадаад хэргийн сайдын урилгаар 2020 оны 9 дүгээр сарын 3-5-ны өдрүүдэд тус улсад албан ёсны айлчлал хийж, “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай” Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ”-г соёрхон баталсан батламж жуух бичгийг солилцов. Монгол, Оросын худалдааны хэмжээ 2021 оны байдлаар 2 тэрбум ам.долларт хүрч 42.2 хувиар өссөн, үүнээс импорт – 1,9 тэрбум ам.доллар (+40%), экспорт –112 сая ам. доллар (+ 96.9 %) байна. ОХУ-тай хийж буй худалдаа нь Монголын нийт худалдааны 12.8 хувьтай тэнцэж байна. Сүүлийн 3 жилийн экспортын байдал сая ам.доллараар: 2019 онд 68,0; 2020 онд 57,3; 2021 онд 112,8.

2021 оны 4-р сард УИХ-ын дарга Г.Занданшатар БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жэньшутай цахимаар уулзав. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй 7-р сард утсаар ярьж, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кэчянтай 4-р сард утсаар ярьж, 10-р сард цахим уулзалт хийж, БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд Вэй Фэнхэ 7-р сард Монголд, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг БНХАУ-д 7-р сард албан ёсны айлчлал хийв. Монгол, Хятадын ЗГХК-ын хоёр талын дарга нарын цахим уулзалт 9-р сард болов. Шадар сайд С.Амарсайхан БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И-тэй 2021 оны 9-р сард ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн уулзалтад оролцох үеэрээ уулзав.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И 2020 оны 9 дүгээр сарын 15-16 –ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсоор айлчилж, “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-г нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ноот бичиг” солилцож, Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, Гадаад харилцааны яам хоорондын 2021-2022 оны хамтран ажиллах төлөвлөгөө, Монгол Улсаас БНХАУ-д гурил экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээрийн шаардлагын тухай Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын Протокол гэсэн баримт бичгүүдийг байгуулав. Монгол-Хятадын хамтын ажиллагааны механизмыг байгуулж, Монгол, Хятадын хилийн боомтын “Ногоон гарц” түр журмыг хэлэлцэн тохиролцож, 2020 оны 8 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж эхлэв. Ингэснээр Монгол Улсын худалдаа, эдийн засгийн харилцааг сэргээж 2020 онд БНХАУ-тай 7.4 тэрбум ам.долларын худалдаа хийсэн байна. 2021 оны байдлаар 10,1 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 37 хувиар өссөн байна. Үүнээс импорт–2,47 тэрбум ам.доллар /Монгол Улсын импортын 41.8%/ , байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 23.4 хувиар өссөн экспорт–7.63 тэрбум ам. доллар /Монгол Улсын экспортын 82.5%/ хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 28 хувиар өссөн байна. БНХАУ-д хөх тариа, улаан буудайн гурил экспортлох 13 аж ахуйн нэгжийг 2021 оны 12

дугаар сарын 16-ны өдөр БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт бүртгүүлснээр хөх тариа, улаан буудайн гурил экспортлох нөхцөл бүрдээд байна.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын XVI хуралдааныг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, талууд “Бүс ба Зам” болон “Талын зам” санаачилгын бүтээн байгуулалтыг урагшлуулах тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны төлөвлөгөөний агуулгыг шинэ төсөл, арга хэмжээгээр баяжуулж үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тохиролцов.

Монгол Улсын газар нутгаар дамжуулан ОХУ, БНХАУ-ыг холбосон байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийн ажлыг судлах хамтарсан ажлын хэсгийн оросын талын дарга "Газпром" НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов 2021 оны 3 дугаар сард Монгол Улсад ирж, хийн хоолойн маршрутын талаар урьдчилсан тандалт хийв. Оросын талаас төслийн ТЭЗҮ-ийн төслийг эцэслэн гаргасныг мэдэгдсэн бөгөөд 2021.11.12-нд цахим хэлбэрээр болсон хөтөлбөрийн хэрэгжилтийг урагшлуулах шинжээчдийн түвшний V уулзалтаар талууд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу хийн хоолой барих төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох төрийн өмчит аж ахуй нэгжүүдэд 3 улсын Засгийн газрын зүгээс үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэхээр тохиролцож, хуралдааны протоколд тусгав.

4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.

Биелэлт: АНУ-ын Төрийн департамент Монголын асуудлыг Хятад, Тайваний нэгжээс шилжүүлж, БНСУ-ын нэгжтэй нэгтгэсэн. Монгол Улсын ГХЯ, АНУ-ын Төрийн департамент хоорондын XV Улс төрийн зөвлөлдөх уулзалт, анхдугаар Стратегийн яриа хэлэлцээ 2022.08.24-нд болов. Уулзалтын үеэр талууд харилцаагаа Стратегийн түншлэлдээ түшиглэн харилцан сонирхсон бүхий л салбарт өргөжүүлэх, хоёр улсын хооронд хуваарьт шууд нислэг үйлдэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх “Агаарын харилцааны хэлэлцээр” байгуулах, Монголын соёлын өмчийг АНУ руу хууль бусаар гаргах явдлаас хамгаалах хамтарсан зохицуулалттай болох зэргийг тохиролцож, Хамтарсан мэдэгдэл гаргав. АНУ-ын дэлхийн хүнсний аюулгүй байдлын хямралыг шийдвэрлэх хүч чармайлын хүрээнд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг 2 сая ам.долларын санхүүжилтийг Монгол Улсад хэрэгжүүлж буй Жижиг, дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх (BEST) хөтөлбөрөөрөө дамжуулан олгохоор шийдвэрлэснээ 2022.09.09-нд мэдэгдсэн.

Америкийн Нэгдсэн Улсын Төрийн нарийн бичгийн даргын орлогч хатагтай Уэнди Шерман 2021 оны 7 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны боломжийг нэмэгдүүлэх, МСК-ын II компакт гэрээ, Ил тод байдлын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахын төлөө байгаагаа илэрхийлэв. ГХЯ, Төрийн департамент хоорондын XIV зөвлөлдөх уулзалт 2020 оны 9 дүгээр сарын 14-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Монгол Улс, АНУ-ын Эдийн засгийн бодлогын III дугаар зөвлөлдөх уулзалтыг 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр цахимаар зохион байгуулав. Уулзалтад хоёр талаас нийт 24 байгууллагын 50 гаруй төлөөлөгч оролцож, хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааны талаар хэлэлцэв. АНУ-тай тохиролцсон Эдийн засгийн өргөтгөсөн түншлэлийн тухай замын зураглалыг хэрэгжүүлэх хүрээнд хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын ашиг сонирхолд нийцсэн тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход чиглэсэн Эдийн засгийн хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулахаар тохиролцов. АНУ-ын шинэ 117 дугаар Конгрессын нэр бүхий гишүүд

“Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хууль”-ийн төслийг 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр дахин өргөн барьсан. АНУ-ын зүгээс КОВАКС-ын шугамаар 2021 оны 9 дүгээр сард 188,370 тун, 10 дугаар сард нэмэлт 899,730 тун “Файзер”компанийн вакциныг тусламжаар хандивласан. АНУ-ын Засаг захиргаа цар тахалтай тэмцэх манай улсын хүч чармайлтыг тууштай дэмжиж, хамгаалалтын хэрэгсэл, 50 ширхэг амьсгалын аппарат, амьсгалын аппаратыг ашиглах сургалтын зориулалт бүхий 50 уушги орлуулагч зэрэг нийт 7 сая гаруй ам.долларын тусламж үзүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Япон Улсын Ерөнхий сайд Ф.Кишида нар 11 дүгээр сарын 29-ний өдөр албан ёсны хэлэлцээ хийж, хэлэлцээний дүнгээр энэхүү Хамтарсан мэдэгдлийг гаргав. Хоёр улсын төр, засгийн тэргүүн нар Монгол Улс, Япон Улс хоорондын харилцааг цаашид улам бэхжүүлэхийн зэрэгцээ цаашдын хамтын ажиллагааны хүрээнд бүс нутаг, олон улсын тавцанд хоёр улс тус тусдаа “Чөлөөт, нээлттэй, Энэтхэг, Номхон далай”-н үзэл санааны хүрээнд дэлхий нийтийг хамарсан нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг бэхжүүлэхийг зорилго болгон “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийг байгуулахаар санал нэгдэв. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021.07.21-25-нд Япон Улсад ажлын айлчлал хийж, Олон улсын Олимпын хороо, “Токио-2020” Олимпын наадмыг зохион байгуулах хорооны урилгаар Токиогийн зуны XXXII Олимпын наадмын нээлтийн ажиллагаанд оролцов. Энэхүү айлчлал нь манай улсын гуравдагч хөрш, Стратегийн түнш Япон Улстай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болохыг нотолж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлоход ач холбогдолтой болов. Япон Улсын Гадаад хэргийн сайд Т.Мотэги 2020 оны 10 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр буюу 0,01 хувийн хүүтэй 25 тэрбум иенийн (230 гаруй сая ам.доллар) “КОВИД-19” цар тахлын эсрэг хариу арга хэмжээний яаралтай зээл”-ийн солилцох ноот бичигт гарын үсэг зурж, санхүүжилтийг манай тал хүлээн аваад байна. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 21.5 сая ам.долларын буцалтгүй тусламжаар 1.3 сая хүнд хүрэлцэх 2.35 сая орчим тун шаардлагатай вакциныг Япон Улсын Засгийн газар НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF)-аар дамжуулан нийлүүлэх болсон. Уг тусламжийн хүрээнд 2021.06.16-ны өдөр эхний 84240 тун Pfizer вакциныг манай тал хүлээн авлаа. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийг Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд албан ёсоор бүртгүүлж, тус хоёр лабораторийн шинжилгээний үнэлгээний дүнг японы тал шууд хүлээн зөвшөөрөхөөр болсон нь худалдаан дахь саад тотгорыг багасгах чухал ач холбогдолтой болов.

Монгол Улс, Европын холбоотой Ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн асуудлаарх яриа хэлэлцээг 2021.06.21, Бодлогын анхдугаар яриа хэлэлцээг 2021.03.10-нд цахимаар зохион байгуулснаар ЕХ-той яриа хэлэлцээний 2 шинэ механизмтай болов. Монгол Улс, ЕХ-ны Хамтарсан хорооны ХХ хуралдааныг 2020.12.03-ны өдөр цахимаар зохион байгуулав. Монгол Улсаас Европын Холбоонд экспортлохоор төлөвлөж буй 18 нэр төрлийн 70 гаруй бүтээгдэхүүний жагсаалтыг эцэслэн хүргүүлэхээр тохиролцсон. Монгол Улс, ЕХ-ны хөгжлийн тусламжийн хүрээнд 50.8 сая еврогийн төсвийн дэмжлэг олгохоор болж, 2020 оны 11 дүгээр сард эхний санхүүжилт болох 16 сая еврог аваад байна. ИБУИНХУ ЕХ-ноос гарсантай холбогдуулан Британийн худалдааны хөнгөлөлтийн ерөнхий систем болох “Сайжруулсан нөхцөл”-д Монгол Улс 2021.01.01-нээс хамрагдсанаар ЕХ-ны Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP+)-тэй ижил тарифын хөнгөлөлт эдлэх болов. Монгол Улс, ХБНГУ-ын ГХЯ хоорондын улс төрийн зөвлөлдөх уулзалтын үеэр ХБНГУ-ын Засгийн газар Монгол Улсыг хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны тусламжид дахин оруулж буйг мэдээлэв. МУ-ын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022.10.12-15-ний өдрүүдэд ХБНГУ-д албан ёсны айлчлал хийв.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин-тэй 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр хийсэн дээд түвшний цахим уулзалтаар хоёр улсын төрийн тэргүүн нар Монгол Улс, БНСУ-ын “Иж бүрэн түншлэл”-ийн харилцааг шат ахиулан “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хүргэж, энэ тухай Хамтарсан тунхаглал гаргав. Монгол Улсын Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, БНСУ-аас Монгол Улсад суугаа бүрэн эрхт Элчин сайд Ли Ё Хун нар 2021 оны 12 дугаар сарын 27-нд 10 аймагт хэрэгжүүлэх төслийн багц 1 (Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай) 52,378 ам.доллар, багц 3 (Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий) 33,642 ам.доллар зэрэг 7 аймгийн төвд хэрэгжих төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр гэрээнд гарын үсэг зурсан. БНСУ-тай харилцааг шат ахиулах хүрээнд эдийн засгийн агуулгыг баяжуулах, эрхзүйн орчныг бэхжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хэлэлцээрийг шинэчлэн байгуулах зэрэг ажлыг урагшлуулахаар чиглэлд БНСУ-тай хамтран ажиллаж байна. БНСУ-ын Гадаад хэргийн сайд Пак Жин-ийн 2022 оны 8 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалаар “Газрын ховор металлын хамтарсан төв” байгуулахаар тохиролцож, монголын талын ажлын хэсгийг УУХҮ-ийн сайдаар ахлуулан байгуулахаар ажиллаж байна. Хоёр улсын худалдааны нийт эргэлт 2021 онд 532,1 сая ам.доллар болж, 2020 оны 257,18 сая. ам.доллартой харьцуулахад 2.06 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2018 онд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2021.03.01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн нь Турк Улсад ажиллаж амьдарч буй 5000 орчим иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой болов. Эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны IX хуралдааныг 2021.11.15-16-ны өдрүүдэд Анкара хотноо зохион байгуулав. Хуралдаанаар хамтын ажиллагааны 24 чиглэлийн асуудлыг хэлэлцэн тохирч, протокол үйлдэв. Тухайлбал, Худалдааны ажлын хороо болон Хөдөө аж ахуйн хамтарсан ажлын хэсэг байгуулах, Хөрөнгө оруулалтыг харилцан дэмжих, хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэх, бизнес форум зохион байгуулах, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор хорио цээр, эрүүл ахуйн нөхцөлийг тохирохоор болов. “Нэг тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хамтран ажиллах, агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах зорилгоор зөвлөлдөх уулзалт хийх, аялал жуулчлал, залуус, спорт, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрүүд байгуулах, Орхоны хөндийд аялал жуулчлалын цогцолбор байгуулах төсөлд хамтран ажиллахаар тохиров.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022.07.6-9-нд Сингапурт албан ёсны айлчлал хийж “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд эдийн засгийн тэргүүлэх чиглэлд Сингапурын хөрөнгө оруулалт, ноу-хау, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, авто замын түгжрэлийн асуудлыг шийдвэрлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд Сингапурын туршлагыг Монголд нутагшуулах талаар хамтран ажиллахаар тохиролцов. 2021 оны байдлаар манай улс Зүүн Өмнөд Азийн 9 улстай худалдаа хийсэн ба худалдааны эргэлт 157.6 сая ам.долларт хүрсэн нь КОВИД-19 цар тахлын үед хэдий ч худалдаа, эдийн засгийн харилцаа өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад харьцангуй тогтвортой байна. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт тус бүс нутгийн улс орнуудаас хөрөнгө оруулалт татах замаар хамтарсан үйлдвэр байгуулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гуравдагч зах зээлд гаргах, АСЕАН-ы стандарт, чанарын баталгаажилтын стандартуудыг нэвтрүүлэх замаар тус бүс нутагт чиглэсэн экспортыг нэмэгдүүлэх бодит боломж байгаа тухай бизнес эрхлэгч нарт мэдээллээр хангах чиглэлээр ажиллаж байна.

Франц Улстай агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх, нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслүүдийг санхүүжүүлэх Засгийн газар хоорондын

хэлэлцээрийг байгуулан хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд ЕС-145 маркын 4 нисдэг тэрэг авахаас 3, гал унтраах тусгай автомашин 42-г хүлээн авахаас 21 автомашин тус тус хүлээн авсан.

Монгол, Канадын Засгийн газар хоорондын дугуй ширээний уулзалтын IX хуралдааныг 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, энэ үеэр талууд “Иж бүрэн түншлэлийн төлөөх Монгол, Канадын хамтын ажиллагааны Замын зураглал”-ыг тохиролцов. 2021 оны урьдчилсан мэдээгээр Монгол Улсаас Канадад 759.9 сая ам.долларын бараа экспортолж, 24.2 сая ам.долларын бараа импортолж, нийт худалдааны эргэлт 784.1 сая ам.доллар байна.

4.5.6.Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2022 оны 9 дүгээр сарын 20-26-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын ЕА-н 77 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэл, Шарм Эль-Шейх хотноо 2022 оны 11 дүгээр сарын 7-8-ны өдрүүдэд болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалт, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид тус чуулганы үндсэн хэсгийн хуралдаанд оролцсон. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021.9.19-23-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо ажиллаж, НҮБ-ын ЕА-н 76-р чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд 2021.9.22-ны өдөр дэлхий дахины энх тайван, аюулгүй байдал, тогтвортой хөгжил, сайн засаглал, эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд, КОВИД-19 цар тахлын хор уршиг, түүнийг даван туулах талаарх Монгол Улсын байр суурийг илэрхийлж, үг хэлсэн. “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал болон цөмийн зэвсгээс ангид статусын тухай”, “Бичиг үсгийн боловсролын тухай”, “Ардчиллын боловсролын тухай” тогтоолыг тус тус шинэчлэн холбогдох хороо, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар хэлэлцүүлж батлуулав.

Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг ОХУ-ын Гадаад хэргийн сайд Лавровын урилгаар 2021.05.31-06.04-ний өдрийн хооронд ОХУ-д албан ёсны айлчлалын хийх үеэр талууд хилийн гэрээг НҮБ-д бүртгүүлэх асуудлаар санал солилцсон. Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамж, орон тоог баталсан. Удирдамжид Монгол Улс, ОХУ хоорондын 1958, 1976 оны хилийн гэрээг НҮБ-д бүртгүүлэх бэлтгэлийг хангах талаар тусгасан. Удирдамжийн дагуу ажиллаж байна.

4.5.7.Монгол Улсын гадаад бодлого, харилцааны нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах, төр, засгийн байгууллагын гадаад харилцааг нэгдсэн байдлаар зохицуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Биелэлт: “Монгол Улсын гадаад бодлого, харилцааны нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах, төр засгийн байгууллагын гадаад харилцааг нэгдмэл байдлаар зохицуулах тухай” хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан бөгөөд холбогдох судалгааг хийж байна.

4.5.8.Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно.

Биелэлт: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Манжуур хотод 2020 оны 10 дугаар сарын 15-нд Консулын газрын үйл ажиллагааг нээв. Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод Консулын газар нээх асуудлыг Засгийн газрын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн бөгөөд УИХ-ын 2021 оны 64 дүгээр тогтоолоор Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод Консулын газрыг нээн ажиллуулах тухай шийдвэр гаргуулсан. Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод суух Консулын газрын 3 дипломат, 1 үйлчилгээ техникийн ажилтныг 2021 оны 12 дугаар сард томилж, КГ-ын үйл ажиллагааг 3 дугаар сард албан ёсоор эхлүүлэв. Засгийн газрын 2022 оны 70 дугаар тогтоолоор Монгол Улсаас Австрали, Швед, Чех Улсад суугаа ЭСЯ-дын бүтцэд Консулын хэлтэс байгуулахаар шийдвэрлэв. Мөн гадаад улс оронтой хөгжүүлж буй улс төр, эдийн засаг болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэдэд консулын үйлчилгээг хүртээмжтэй түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2022 оны 71 дүгээр тогтоолоор хилийн чанад дахь 16 ДТГ тус бүр 1-2, нийт 22 орон тоог нэмэгдүүлж, батлав.

4.5.9. Дипломат албанд сахилга, хариуцлагыг эрс нэмэгдүүлж, хар тамхи тээвэрлэх болон хууль бус бусад аливаа үйлдлийг таслан зогсооно.

Биелэлт: “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-ээр дараахь хариуцлагын тогтолцоог бий болгосон. Үүнд: Яамны газар, нэгжийн дарга, ДТГ-ын тэргүүн ёс зүйн болон сахилгын хэм хэмжээг манлайлан мөрдөж, ажилтан, албан хаагчдаас мөрдөж ажиллахыг шаардах, хяналт тавих, дүрэм хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс удирдлагад нь ажилладаг албан хаагч ёс зүйн болон сахилгын зөрчил гаргасан тохиолдолд зөрчил гаргасан албан хаагчийн зэрэгцээ тухайн газар, нэгжийн дарга, ДТГ-ын тэргүүнд мөн ёс зүйн болон сахилгын хариуцлага хүлээлгэх зохицуулалттай болсон. “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-д заасан ёс зүй, сахилгын хэм хэмжээг зөрчсөн албан хаагчдад тухай бүр хариуцлага тооцсон. Тухайлбал, 2020 онд хөрөнгө, орлогын мэдүүлгээ дутуу мэдүүлсэн 1 албан хаагч, албан үүргээ гүйцэтгэж байхдаа согтууруулах ундаа хэрэглэсэн ДТГ-т ажиллаж буй төрийн үйлчилгээний 2 албан хаагч, төвөөс өгсөн удирдамж, чиглэлийг зөрчсөн, хэрэгжүүлээгүй ДТГ-т ажиллаж буй 3 дипломат ажилтан, ажлын цагаас хоцорч Хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн 10 албан хаагч буюу нийт 16 албан хаагчид ёс зүйн болон сахилгын шийтгэл ногдуулж, хариуцлага тооцсон.

Хилийн чанад дахь ДТГ-уудад ажиллахаар томилогдсон 63 албан хаагчийг 2021 оны 6 дугаар сарын 07-ны өдөр “Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж буй албан хаагчдын эрх үүрэг, хариуцлагын тухай” сургалтад хамруулав. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон 1 албан хаагчийг төрийн албанаас халж, албан үүрэг, сахилга, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн 4 албан хаагчид сануулах, 1 албан хаагчид 1 сар, 1 албан хаагчид 3 сарын хугацаагаар цалин 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл тус тус ногдуулж, хариуцлага хүлээлгэв.

4.5.10. Монгол Улсын түүх, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ олон улсад сурталчлах, таниулах “Монгол Үндэстний үнэлэмж” арга хэмжээ, хилийн чанадад байгаа иргэд монгол хэл, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ хадгалан тээх “Дэлхийн монголчууд II” арга хэмжээг төлөвлөн боловсруулж хэрэгжүүлнэ.

Биелэлт: “Монгол Үндэстний үнэлэмж” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг сайдын зөвлөлөөр батлав. Түүх, хэл бичиг, өв уламжлал, соёл урлаг, спорт, оюуны хөгжлийн ололт амжилтыг хилийн чанадад сурталчлах чиглэлээр 34, дипломат харилцааны тэгш ойн хүрээнд 6, үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг сурталчлах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 7, монгол судлалын чиглэлээр 16,

хэвлэл мэдээллийн чиглэлээр 5, нийт 70 орчим арга хэмжээг зохион байгуулав. Тухайлбал, Берлинд Berlinale, Каннын кино наадам, “НордАрт”, Венецийн дүрслэх урлагийн үзэсгэлэнд оролцож, Цагаан сарыг тохиолдуулан Монгол хувцасны нууц товчоо 2 ботийг Улаанбаатар дахь гадаадын ДТГ-дад хүргүүлж, баримтат киног 46 ДТГ-аараа дамжуулан олон улсад түгээв. “Монголын нууц товчоо”-г болгар, румын, грек, вьетнам хэл дээр хэвлүүлж, Чехийн Карлын ИС-тай хамтран “Mongolica Pragensia” сэтгүүлийн 2 дугаар эрхлэн гаргаж, ЮНЕСКО-ийн “World Heritage Review” сэтгүүлд монголын тухай нийтлэл хэвлүүлсний зэрэгцээ “Google Arts and Culture Platform”-д 5 өвийн газар нутгийг сурталчлах болон 210 орчим монгол судлалын ном, бүтээлийг Монгол судлалын 12 төвд хүргүүлсэн. Бээжинд “Монголын соёл, мэдээллийн төв”-ийн барилгыг 2022 оны 10 дугаар сард хүлээн авч, төвийн нээлтийн үеэр Монголын соёлын өдрүүдийг 2022.10.24-28-нд зохион байгуулав. “Чингис хааны ертөнц ба Монгол судлал” ОУ-ын эрдэм шинжилгээний бага хурлын “Монголчууд ба гадаад ертөнц” салбар хуралдааныг 2022.08.6-8-нд ГХЯ-нд зохион байгуулав.

“Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг ГХ-ны сайдын 2021 оны А/51 дугаар тушаалаар баталсан. Хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй 11 улсын 25 хотод нийт 44 монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төвийн судалгааг гаргав. ГХЯ-наас ХБҮЗ-тэй хамтран багшийн мэргэжил, заах арга зүйн 16 сургалтыг зохион байгуулав. 90 орчим багш тус сургалтад хамрагдаад байна. БСҮХ-тэй хамтран 3 цахим сургалтын материал бэлтгэн ДТГ-уудаар дамжуулан сургуулиудад хүргүүлэв. ХБҮЗ-тэй хамтран “Үндэсний бичиг эхлэн хялбар хурдан сурах дэвтэр”-ийн эхний хэсгийг ДТГ-уудаар дамжуулан сургуулиудад хүргүүлэв. ХБҮЗ, ШУА-тай хамтран 44 сургуульд Хүүхдийн эх хэлний боловсролд эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Мал аж ахуйн соёл, Би Монгол хүн, Монгол ярианы сурах бичиг, Монгол хэлний дүрмийн заах арга зүйн эмхэтгэл зэрэг 350 гаруй номыг ДТГ-уудад хүргүүлэв.

Батлан хамгаалах

4.6.Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.

4.6.1.Хугацаат цэргийн алба хаасан иргэдэд төрийн албанд орох, шатлан дэвших, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж хүртэх давуу эрх олгох хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

Биелэлт: Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Хууль батлагдсанаар Цэргийн тагнуулын байгууллага ЗХЖШ-ын бүтцэд шилжиж, Зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх нэмэгдэж, тагнуулын байгууллагын тогтолцоо шинэчлэгдэж, цэргийн тагнуулын байгууллагын эрх зүйн зохицуулалт тодорхой болно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д 2022 оны 3 дугаар сард өргөн мэдүүлсэн. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байна.

“Цэргийн албаны тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэн хугацаат цэргийн албыг хаах хугацааг 24 сар болгох, цэргийн албыг сайн дурын алба болгон хөгжүүлэх, иргэнийг хугацаат цэргийн албанаас түр чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хугацаат цэргийн албыг хаасан иргэнийг “эрүүл

мэндийн даатгал"-аас алба хаасны дараах жилд нэг удаа чөлөөлөх, хугацаат цэргийн алба хаагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц төгрөгийн цалин олгох зэрэг зохицуулалтыг шинээр тусгахаар санал боловсруулсан.

Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар баталсан Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд "улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална" гэсэн эрх зүйн зохицуулалтыг нэмж тусгаснаар Зэвсэгт хүчинд цэргийн алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагч сайн дурын үндсэн дээр мэргэжил үйлдвэрлэлийн сургалтын төвөөр дамжуулан нарийн мэргэжил эзэмшиж, улмаар улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцож тодорхой мөнгөн хуримтлалтайгаар цэргийн албанаас халагдаж байна.

"Иргэдийн цэргийн алба хаах хүсэл, сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г сайдын 2020 оны А/205 дугаар тушаалаар баталгаажуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн шалтгаантай иргэдийн бүртгэл, мэдээллийг цахим системд бүрэн оруулсан. Ингэснээр 2020 оны хугацаат цэргийн албаны цэрэг татлагаар эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй иргэдийн тоо өмнөх оныхоос 9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

4.6.2.Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг зэвсэгт хүчнийг бэхжүүлнэ.

Биелэлт: Зэвсэгт хүчний бүтцэд Кибер аюулгүй байдлын цэрэг, Тусгай хүчний цэрэг, "Барилга-инженерийн цэргийг бий болгох асуудлыг тусгаж, УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 14-ны өдрийн чуулганаар, Зэвсэгт хүчний хөгжлийн санг тусгай хуулиар зохицуулах хэрэгцээ, шаардлагыг үндэслэлийг тусгаж, Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар тус тус шийдвэрлэсэн. Цэргийн тагнуулыг Зэвсэгт хүчний бүтцэд оруулах хэрэгцээ, шаардлагыг судлан, Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд 2020 оны 12 дугаар сард өргөн мэдүүлсэн болно.

"Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулан Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. "Зэвсэгт хүчинд орон зайн тандалт, судалгааг 2030 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/170 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийг 4 жилийн цэргийн сургалтын тогтолцоонд 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс шилжүүлэхээр Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/190 дүгээр тушаалаар баталгаажуулсан. Цэргийн мэргэжлийн 4 жилийн боловсрол олгох элсэлтийг зохион байгуулж, сонгон шалгаруулалтад тэнцсэн бүрэлдэхүүнийг цэргийн анхан шатны бэлтгэлд хамруулж, батлагдсан хөтөлбөрийн дагуу ерөнхий суурь хичээлд хамруулж байна.

4.6.3.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.

Биелэлт: Батлан хамгаалахын сайд 21 аймаг, нийслэлийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г 2019 онд, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 331 сум, 9 дүүргийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г 2020 онд баталснаар орон нутгийн хамгаалалтыг нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулах эрх зүйн орчин бүрдсэн. 2022 оны 05, 10 дугаар саруудад 331 сум, нийслэлийн 9 дүүргийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-нд тодотгол хийж, холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн.

2021 оны 5 дугаар сард Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар: “Аймаг, нийслэлд орон нутгийн цэргийг байгуулах, ашиглах төлөвлөгөө”, “Орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөө”-г тус тус батлуулсан. Аймаг, нийслэлийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г тодотгож, тайван цагт хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг хангаж ажиллав.

Батлан хамгаалах сайдын 2020 оны А/133 дугаар тушаал, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын 2021 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын бүрэлдэхүүнтэй сургалтыг 2021 оны 3, 4 дүгээр улиралд зохион байгуулсан. “Орон нутгийн хамгаалалтын сургалт зохион байгуулах журам”-ыг Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/133 дугаар тушаалаар баталж, сургалт зохион байгуулах эрх зүйн орчин бий болсон. Дайчилгаа зарласан үеийн хүн амын хэрэгцээ, түүнийг хангах тооцооллыг боловсруулах зорилгоор мэдээлэл гаргах хүснэгтийг бэлтгэж 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 1в/2560 албан тоот бичгээр яамдад хүргүүлсэн. “Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө”-ний төслийг боловсруулсан. 2022 онд батлуулахаар ажиллаж байна.

4.6.4.Зэвсэгт хүчний бүтцэд барилга-инженерийн, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний цэргийг байгуулна.

Биелэлтийг нууцын журмаар танилцуулна.

4.6.5.Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр хангах бодлогыг дэд дараатайгаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг боловсруулан Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/250 дугаар тушаалаар батлан, хэрэгжүүлж байна.

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын хээрийн холбооны зангилгааны техник хэрэгслийг шинэчлэх, тактикийн түвшний салбарыг холбоожуулах “Хээрийн хөдөлгөөнт радио холбоо” төслийг сайдын 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн нууц тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4.6.6.Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, зэвсэгт хүчний олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

Биелэлт: Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын “Цэргийн салбарт хамтарч ажиллах тухай” хэлэлцээрийг Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн, батлав. Мөн Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн чуулганаар хэлэлцүүлэн, батлуулав.

Монгол Улс, Бүгд Найрамдах Сингапур Улстай Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж байгуулах чиглэлээр ажиллаж байна. Монгол Улсын

Батлан хамгаалах яам, Бүгд Найрамдах Филиппин Улсын Үндэсний батлан хамгаалах яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт хоёр улсын Батлан хамгаалахын сайд нар Сингапур Улсад 2022 оны 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 19 дэх удаагийн “Шангри-Ла яриа хэлэлцээ” дээд хэмжээний уулзалтын үеэр гарын үсэг зурж баталгаажуулсан.

Олон улсын болон хоёр талын хамтарсан сургалт, дадлагад 2020 онд Зэвсэгт хүчнээс давхардсан тоогоор 1342, гадаадын 2 орны Зэвсэгт хүчний 112, нийт 1454 цэргийн алба хаагчийг оролцуулсан.

4.6.7.Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.

Биелэлтийг нууцын журмаар танилцуулна.

4.6.8.“Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ”-г хэрэгжүүлж, “Оюутан-цэрэг” сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлнэ.

Биелэлт “Оюутан-цэрэг” сургалтын бүртгэлийг төрийн нэгдсэн цахим үйлчилгээний “E-Mongolia систем”-ээр 2022 оны 03 дугаар сарын 01-10-ны өдрүүдэд явуулж, Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох журмын шаардлагыг хангасан 1668 оюутан, суралцагчдыг эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалгалтад тус тус хамруулсан. Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/91 дүгээр тушаалаар шалгаруулалтад тэнцсэн 493 оюутан, суралцагчдыг 2022 оны 06 дугаар сарын 15-наас 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд “Цэргийн мэргэжлийн бэлтгэл” сургалтыг Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Шар хад дахь Хээрийн сургалтын төвд зохион байгуулсан.

ЗХЖШ-ын даргын 2019 оны А/553 дугаар тушаалаар 2020 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Говьсүмбэр аймаг дахь Политехникийн коллеж, Налайх дүүргийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг түшиглэн хүнд машин механизмын оператор 118, хүнд машин механизмын засварчин 10, гагнуурчин 15, тогооч 16, авто зам гүүр угсралтын ажилтан 28, нийт 187 цэргийн алба хаагчид мэргэжил олгох сургалтыг 2 үе шаттай зохион байгуулсан. Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх ажлыг 2020 оны 9 дүгээр сарын 03-07-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт суманд зохион байгуулж, Цэргийн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт орон нутгийн 958 иргэнийг хамруулж, Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчдийн тоглолтыг толилуулсан.

4.6.9.Цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулна.

Биелэлт: Улсын төсөв болон Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/16, А/27, Батлан хамгаалахын Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/16, А/38, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны А/82 дугаар тушаалын дагуу Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад 7,3 тэрбум төгрөгийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралт, засвар шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэж байна.

Батлан хамгаалахын сайдын “Барилга-инженерийн цэргийн удирдах газрын барилга барих тухай” 2021 оны А/66, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын “Барилга угсралтын ажил гүйцэтгүүлэх тухай” 2021 оны А/152 дугаар тушаалын дагуу Зэвсэгт хүчний хүчний ...

дугаар ангийн байрлалд Барилга-инженерийн цэргийн удирдах газрын барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/20, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны А/64 дүгээр тушаалын дагуу Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн 200 цэргийн байрны барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/405 дугаар тушаалаар “2020 онд Зэвсэгт хүчний анги, салбаруудын зарим барилга байгууламжийн тохижилт, их засварын ажилд шаардагдах хөрөнгө”-ийг, 2020 оны А/128 дугаар тушаалаар “Барилгын ажлын жагсаалт”-ыг тус тус баталж, хэрэгжилтийг нь зохион байгуулан, гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулсан. Хуурай замын цэргийн командлалын алба хаагчдын албан тушаалын 30 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулсан. ХБНГУ-ын Холбооны Батлан хамгаалах яамны буцалтгүй тусламжаар 3,1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 4 нэр төрлийн 131 нэгж эмнэлгийн тоног төхөөрөмж, 172 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн амьсгалын аппаратыг хүлээн авч, Цэргийн төв эмнэлгийн чадавхыг нэмэгдүүлсэн. Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийг “ЖИШИГ ЦЭРГИЙН ХОТХОН” болгохоор төлөвлөн зураг, төслийг боловсруулсан. Зэвсэгт хүчний 015 дугаар ангийг “ЖИШИГ НОГООН БАЙГУУЛАМЖТАЙ АНГИ” болгохоор шийдвэрлэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, тус ангийн 30000 м2 талбайг зүлэгжүүлэх, 8000 орчим төрөл бүрийн мод, бутыг тарих, спорт тоглоомын талбай тохижуулах зэрэг ажлыг хийгдэж байна.

ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Ногоон хөгжил

5.1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.1.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

Биелэлт: “Суудлын автомашины онцгой албан татварын тухай” Засгийн газрын 2017 оны 164 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, байгальд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй, цахилгаан тэжээлт болон хийгээр ажилладаг автомашины хэрэглээ, тоог нэмэгдүүлэх зорилгоор цахилгаан тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг насжилтаас хамааруулан үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа 0-3 жил “0” хувь, 4-6 жил “10” хувь, 7-9 жил “25” хувь, 10 ба түүнээс дээш жил “50” хувь болгохоор тогтоолын төсөл боловсруулан яамдаас санал авч нэгтгэсэн.

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2022 оны 22/05 дугаар тогтоолоор агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 14 арга хэмжээнд 23.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: Аймгуудын нам даралтын усан халаалтын зуухны янданд утаа шүүгч суурилуулахад 3.3 тэрбум, “Таван толгой түлш” ХХК-ий сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэхэд 2.1 тэрбум, 6 аймгийн зорилтод бүлгийн 6600 айл өрхөд угаарын хий мэдрэгч суурилуулахад 988.7 сая, нийслэлийн авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисыг бууруулахад 237.9 сая, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд орших зарим цэцэрлэг, сургуулийн түүхий нүүрсээр ажилдаг нам даралтын усан халаалтын зууханд технологийн шинэчлэл хийж, цахилгаан халаагуур, хийн түлшинд шилжүүлэхэд 2.7 тэрбум, Дундговь, Завхан, Өвөрхангай, Дархан-Уул аймагт байгуулах сайжруулсан түлшний

үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэхэд 8.0 тэрбум, Улаанбаатар хотын агаарын чанарын мэдээллийг иргэд олон нийтэд түгээхэд 404.9 сая, агаарын чанарын автомат суурин харуулд шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахад 695.0 сая, стандартын шаардлагад нийцээгүй шатахууны импортод хяналт тавихад 200.0 сая, түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавих хяналтын постууд ажиллуулахад 974.0 сая, судалгаа шинжилгээний ажилд 30.8 сая төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

2020 онд гэр хорооллын айл өрхөд шөнийн цахилгааны үнийн урамшуулалд 15.8 тэрбум, сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлж, хэрэглээнд хяналт тавьхад 29.7 тэрбум, нам даралтын усан халаалтын зууханд технологийн шинэчлэл хийх, зуухны янданд утааны шүүлтүүр суурилуулахад 4.5 тэрбум зэрэг нийт 27 төсөл, арга хэмжээнд 77.3 тэрбум төгрөг зарцуулахаар Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2020 оны 20/05 дугаар тогтоолоор батлан хэрэгжилтийг ханган ажилласан. Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын 2020 оны жилийн дундаж агууламжийг өмнөх дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 34мкг/м3-ээр буюу 27 хувиар, PM2.5 тоосонцор 11мкг/м3-ээр буюу 18 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Агаарын чанарын хяналт, шинжилгээний бүрэн автомат харуулыг Сүхбаатар дүүргийн 13-р хороо 5 буудал 248 дугаар цэцэрлэгийн хашаанд суурилуулж агаарын чанарын мэдээллийн төв сервертэй холбосноор Улаанбаатар хотын агаарын чанарын 15 харуулыг автомат ажиллагаатай болгож иргэдэд Улаанбаатар хотын агаарын чанарын индексийн мэдээллийг дэлгэцээр байнга хүргэх нөхцлийг бүрдүүлсэн. Агаарын чанарыг хянах автомат суурин харуулыг нэмж Шархад, Налайхад байгуулж, агаарын чанарыг 30 минут тутам хянадаг болсон. Байгаль орчны шинжилгээний төв лаборатори болон 5 аймгийн байгаль орчны лабораторид Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр агаар дахь PM10, PM2.5 тоосонцор хэмжигч Dustruck багажийг худалдан авч, агаарын чанарын явуулын судалгаа хийх чадавхыг нэмэгдүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улс /БНСУ/-ын Засгийн газар хоорондын Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих “Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн чадавхыг сайжруулах” төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох Техник, эдийн засгийн үндэслэлийг батлуулсан. Тус төсөлд шаардлагатай 14.8 сая ам.долларын зээлийн санхүүжилтийг БНСУ-ын Засгийн газар 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдөр албан ёсоор зөвшөөрсөн. Хоёр улсын Засгийн газрын хооронд зээлийн гэрээг байгуулсан бөгөөд төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна.

2021 онд Улсын төсвийн 3.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гэр хорооллын 36 халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаанд холбох барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

5.1.2.Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Биелэлт: Хөвсгөл нуурыг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор нуурт живсэн машин, техникийг илрүүлэх суурь судалгаа хийж, татаж гаргах ажлыг эрсдэлгүй зохион байгуулах талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах чиг үүрэг бүхий ажлыг хэсгийн хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 14, 5 дугаар сарын 30-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Хурлын шийдвэрийн дагуу Япон улстай уг асуудлаар хамтарч ажиллах төлөвлөгөөг боловсруулж, БОАЖЯ нь Япон улсын “Ниппон салвайж” компанийн удирдлагуудтай тохиролцон тус компани судалгааны ажлын төлөөлөгч Араки Ватару Монгол улсад 5 дугаар сарын 27-оос 06 дугаар сарын 01-ны өдрүүдэд ажиллаж урьдчилсан

тандан судалгааг хийсэн. Живсэн тээврийн хэрэгслийг эрэн хайх, илрүүлэх туршилтын ажиллагааг 2022 оны 02 дугаар сарын 21-27-ны өдрийн хооронд зохион байгуулсан.

Хөвсгөл нуурыг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор нуурт живсэн машин, техникийг илрүүлэх суурь судалгаа хийж, татаж гаргах ажлыг эрсдэлгүй зохион байгуулах талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 117 дугаар захирамжаар байгуулсан. Хөвсгөл нуурын ёроолд живсэн 50м хүртэлх гүнээс тээврийн хэрэгслийг татаж гаргах ажил 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлж нуурт 1985 онд живсэн Сүхбаатар хөлөг онгоцыг 11-р сарын 05-ны өдөр татаж гарган нуурын эрэгт байрлуулсан. 50м-ээс илүү гүнд живсэн тээврийн хэрэгслийг татаж гаргах ажлыг 2022 оноос эхлүүлнэ.

5.1.3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, нийслэлийн цэвэр усны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.

Биелэлт: Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж “Таширын хүрээ” ХХК гүйцэтгэгчээр шалгарч 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр дугаар гэрээг байгуулсан. Өмнөговь аймгийн Манлай сумын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Дорноговь аймгийн Дэлгэрэх, Өргөн сум, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Халзан, Түвшинширээ, Уулбаян, Асгат, Онгон сумдад Гидрогеологийн дунд масштабтай зураглалын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр “Дунар-од” ХХК шалгарч гэрээ байгуулахаар ажиллаж байна. Газрын доорх усны түвшин, температур, цахилгаан дамжуулах чанар, агаарын даралтыг 6 цаг тутам хянаж, бүртгэдэг мониторингийн хяналт шинжилгээний цэгийг 2022 онд Өмнөговь аймгийн Ноён суманд 2, Баяндалай суманд 1, Дорноговь аймгийн Сайхандулаан суманд 2, Мандах суманд 2, Өргөн суманд 2 цооног, Айраг суманд 1 цооног нийт 10 мониторингийн цооногоор сүлжээг өргөтгөж 319-д хүргэсэн.

2020 онд “Майдар хот төсөл”-ийн ус хангамжийн эх үүсвэрийг илрүүлэн тогтоох газрын доорх усны ордын хайгуулын ажил, Өвөрхангай аймгийн Хужирт сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлуудыг хийлээ. 2021 онд Нийслэлийн Багануур дүүрэг, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл хайгуулын ажлыг хийлгэхээр холбогдох ажлыг зохион байгуулж Усны нөөцийн зөвлөлөөр тайланг хэлэлцэж усны нөөцийг Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/262 дугаар тушаалаар баталсан.

5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.

Биелэлт: Улсын хэмжээнд он дамжин хэрэгжиж байгаа болон 2022 онд хэрэгжиж байгаа нийт 3230 нүхэн жорлон шинэчлэхээс, 2022 онд 1760 нүхэн жорлонг стандартын шаардлагад нийцүүлэв. Ажлын явц 88 хувьтай хэрэгжиж байна. Гол мөрний сав газар дагуух хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 2022 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 11 дүгээр "Арга хэмжээ авч ажиллах тухай" албан даалгавар баталж, аймаг, нийслэлийн Засаг дарга болон усны сав газрын дарга нарт Усан сан бүхий газрын бохирын цооног, нүхэн жорлонг булж устгах арга хэмжээг яаралтай авах үүрэг өгсний дагуу 2022 онд нийт 600 орчим нүхэн жорлонг буулгасан.

2021 онд Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдийн нийт 2810 өрхийн нүхэн жорлонг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлээд байна. Мөн Туул

голын эрэг дагуух амралт зугаалгын бүсэд зөөвөрлөн байрлуулах боломжтой 2 хаалга бүхий, 1.5м3 бохирын танктай 6ш зөөврийн жорлон, 120.0 сая төгрөгөөр Сонгинохайрхан дүүргийн Драгон авто зогсоол, Хан-Уул дүүргийн Ажилчдын соёлын ордны автобусны буудлын орчимд нийт 2 ширхэг Эко нийтийн бие засах газрыг ашиглалтад оруулсан.

2020 онд 1350, 2018-2020 онд нийт 6260 өрхийн бие засах газрыг стандарт шаардлагад нийцсэн байгууламжтай болгосон. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2019 онд 600 нүхэн жорлон, 2020 онд улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 350, БОАЖЯ-с 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2000 өрхийн нүхэн жорлонг шинэчлэх ажлыг эхлүүлж, 1000 нүхэн жорлонг шинэчилсэн.

Булган аймгийн төвд 200 айл өрхөд сайжруулсан нүхэн жорлон шинээр барих ажлын гэрээ байгуулагдсан. Ковид-19 цар тахал гарч хөл хориог тогтоосны улмаас хугацаат ажил хойшлогдож, 2021 оны 7 дугаар сар хүртэл гэрээ сунгагдсан. Бараа татан авалт 100 хувь хийгдсэн. "Ахуйн бохир усны лагийг ашиглахад тавигдах ерөнхий шаардлага", "Өтгөн лагийг суллах, тээвэрлэх, боловсруулах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага" стандартын төслүүдийг боловсруулаад байна.

"Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн тогтвортой менежментийг хангах стратеги төлөвлөгөө"-г боловсруулж, 2021.10.20-нд батлан, хэрэгжүүлж эхэлсэн.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны баазуудын ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдлын талаар нөхцөл байдлын судалгаа хийгдэж байна.

5.1.5.Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэж, мод тарьж ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгжид мөнгөн урамшуулал олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: 2022 онд Улсын хэмжээнд 3148.2 га талбайд ойжуулалт, 168 га талбайд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил, 608.4 га талбайд хамгаалалтын ойн зурвас, 445.4 га талбайд ногоон байгууламж, нийт 4370 га талбайд ойжуулалт нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн ажлыг хэрэгжүүлсэн. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 532 га талбайд, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 1000.1 га талбайд, төсөл, хөтөлбөр, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 1989.8 га талбайд тус тус хэрэгжүүлсэн. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд мрод тарих ажилд 355923 иргэн, 16104 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, нийт 10129.0 мян.ширхэг мод, сөөгийг тарьсан.

Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох судалгааны ажлыг 16 аймаг, 109 сум, Улаанбаатар хотын ногоон бүс, Богдхан уулын ДЦГ-ын ойн сангийн 2.2 сая га талбайг хамруулан гүйцэтгэж навч, шилмүүсний 5 зүйлийн хөнөөлт шавжийн голомт 737.1 мян.га талбайд үүсээд байгааг тогтоосон. 2022 онд Улсын хэмжээнд 15 аймгийн 58 суманд 130 удаагийн ой, хээрийн түймэр бүртгэгдсэн байна. Дээрх түймэрт урьдчилсан байдлаар ойн 9917 га талбай, хээрийн 1290910 га талбай, нийт 1300827 га талбай өртөж, 2022 оныг 2021 онтой харьцуулахад нийт шатсан талбай 29,4 хувиар өссөн бөгөөд үүнд ойн талбай 10 дахин, хээрийн талбай 3,3 дахин тус тус өссөн. 5 аймгийн хилийн бүс зурваст нийт 187.6 км урт түймрээс хамгаалах шороон зурвас байгуулж, 782.2 км шороон зурвасыг сэргээсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/166 дугаар тушаалаар ой зохион байгуулалтын ажлыг Говь-Алтай аймгийн заган ойн бүхий сумдын 1664.8 мян.га талбайд хийж гүйцэтгэсэн.

Ойн төлөв байдлыг сайжруулах, доройтлыг бууруулах зорилгоор арчилгааны сийрэгжүүлэх, завсрын хэлбэрийн огтлолыг 3.0 мянган га, ойн цэвэрлэгээний огтлолыг 28.5 мянган га талбайд, нийт 31.5 мянган га талбайд хэрэгжүүлэх ажлууд холбогдох хууль, журмын дагуу орон нутагт зохион байгуулагдаж байна.

Цөлжилтөд нэн хүчтэй, дунд зэрэг өртсөн Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Баянхонгор аймагт цөлжилт, газрын доройтлыг бууруулах, элсний нүүлтийг сааруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/233 дугаар тушаалаар нийт 32 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулахад зориулан 370.1 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Дундговь 8 га, Дорноговь 6 га, Өвөрхангай 8 га, Баянхонгор 5 га талбайд цөлжилтийг сааруулах, хамгааллын арга хэмжээ авах ажлын хүрээнд нийт 27 га талбайд хамгаалалтын зурвас, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/166 дугаар тушаалаар Дорноговь аймаг Мандах сум 9 га, Дорноговь аймаг Хатанбулаг сум 8 га, Завхан аймаг 50 га, Сүхбаатар аймаг 20 га нийт 87 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авч санхүүжилтийг олгосон.

2021 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Завхан, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Хөвсгөл, Улаанбаатар хотын ойн санд, нийт 1549 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлт хийхээр аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан, ажиллав. "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд "Нэг өрх-нэг мод" аяныг улсын хэмжээнд зохион байгуулж, 30000 иргэн, 2000 аж ахуйн нэгж, байгууллага нийт 450.0 мян.ширхэг мод, сөөгийг өөрийн эзэмшлийн хашаанд, шинээр 8.0 га талбайд нийт 15 бичил цэцэрлэгийг байгуулж, 8500 ширхэг мод, сөөгийг тарьсан.

"2021 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар"-т багтаан түймэр, хөнөөлт шавжид нэрвэгдсэн ойн төлөв байдлыг сайжруулах зорилгоор арчилгааны сийрэгжүүлэх, завсрын хэлбэрийн огтлолыг 3.058 га, доройтсон ойд цэвэрлэгээ хийх ажлыг 5 аймгийн 7 суманд 533 га талбайд, ойн цэвэрлэгээний огтлолыг 28.573 га-д явуулах ажлууд холбогдох хууль, журмын дагуу орон нутагт зохион байгуулагдан, улсын төсвийн хөрөнгөөр 60 га, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 29.073 га, нийт 32.604 га талбайд ойн арчилгаа, цэвэрлэгээний ажил явагдаж байна.

2020 онд Улсын төсвийн хөрөнгөөр 1255 га-д ойжуулалт, ойг нөхөн сэргээх, 1118 га талбайд хомсдол, доройтолд өртсөн ойд ойн цэвэрлэгээ хийж, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 725 га, олон улсын төслийн хөрөнгөөр 3000 га, нийт 6098 га ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн.

Ойн хөнөөлт шавжийн хөнөөлийн голомтыг хязгаарлах тэмцлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд 6 аймгийн 9 сумын 65874 га ойд хийж хөнөөлийн голомтыг хязгаарлав.

2021 оны эхний хагас жил буюу хаврын улирлын түймрийн аюултай байх хугацаанд гарсан ой, хээрийн түймрийн тоо, өртсөн талбайн хэмжээг 2020 оны мөн үетэй харьцуулахад түймрийн тоо 67 хувь, түймэрт өртсөн талбайн хэмжээ 33,5 хувиар тус тус буурсан байна. Улсын хэмжээнд 2020 онд 9549,3 га ой, 234882 га бэлчээр шатаж, 2020 онд ойн талбай 18,9 хувь, бэлчээрийн талбай 10,2 хувиар, байгаль экологид учруулсан хохирлын хэмжээ 95 хувь, түймрийг унтраахад зарцуулсан зардал 21,9 хувиар тус тус буурсан. 2020 онд хууль бус бэлтгэгдэж хураагдсан мод 2020 байдлаар 72 шоометр болж 2019 оны мөн үеэс 70 хувиар буурсан.

Ойн төлөв байдлыг сайжруулах, доройтлыг бууруулах зорилгоор 14 аймаг, нийслэлийн болон сумын ИТХурлаас тогтоосон хэмжээнд багтаан, мод бэлтгэлийн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 23,5 мянган га талбайд ойн арчилгаа, цэвэрлэгээний ажил гүйцэтгэв.

5.1.6.Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна.

Биелэлт: Нийт газар нутгийн хэмжээг 21 хувийг Улсын тусгай хамгаалалтад авч, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 49.9 хувийг эзэлж байна. 6 аймгийн 25 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 2,1 сая га талбай бүхий 14 газар нутгийг

улсын тусгай хамгаалалтад авахаар "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай" УИХ-ын тогтоолын төсөл боловсруулж Засгийн газрын гишүүдээс санал авч байна. 2021 онд Улсын тусгай хамгаалалттай газрын 30 хувь буюу 11 хамгаалалтын захиргаанд улсын төсөв болон төсөл хөтөлбөрөөс 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, материаллаг баазыг сайжруулсан. 2022 онд Ховд аймгийн 17 сум, аймгийн ИТХ-4 нэр төрлийн 52 ш, Говь-Алтай аймгийн 5 сум, аймгийн ИТХ-4 нэр төрлийн 24 ш, Увс аймгийн ЗДТГ-4 нэр төрлийн 4 ш, Баянхонгор аймгийн 2 сум-3 нэр төрлийн 6 ш, Баян-Өлгий аймгийн 6 сум-3 нэр төрлийн 18 ш, зэрэг нийт 7 нэрийн 119 ш хэрэгслийг 38 байгууллагад нийлүүлэх ажлыг зохион байгуулсан.

5.1.7.Ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлж, ашиглалтын нөөц бий болгоно.

Биелэлт: Генетик нөөцийн тухай хуулийг УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлуулав. "Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчийг тогтоох, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах урьдчилсан зөвшөөрөл авах журам"-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/324, "Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, ашиглах, хадгалах, хамгаалах журам"-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/325, "Генийн сан байгуулах, сан хөмрөгийг баяжуулж бүртгэх, хадгалж хамгаалах, түгээх солилцох журам"-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар батлуулсан.

"Халиун бугын тархац, нөөц, зохистой ашиглах хэмжээг тогтоох, хамгааллын статусыг тодорхойлох" судалгааг МУИС-ийн багш нар 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгэн, судалгааны тайлан мэдээг энэ онд ирүүлсэн. Уг судалгааны дүнгээр сүүлийн жилүүдэд манай орны 15 аймгийн 192150.7 км², голомт нутгийн хэмжээ 77596.7 км² талбайд тархсан бугын нийт тоо толгойг 55215 гэж тогтоосон нь 2010 оны хамгийн сүүлд хийсэн судалгааны дүнтэй харьцуулахад халиун бугын ерөнхий нутаг 70000 орчим км²-ээр, тоо толгой 3 дахин өссөн.

Монгол Алтай болон Ховдын ургамал газарзүйн 2 тойргийн уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг нэн ховор, ховор, мэдрэг зүйлийн суурь судалгааны ажлыг хийлээ. Судалгаагаар 4 зүйл урагмлыг ургамлын аймагт шинээр бүртгэж, 2 тойргийн нэн ховор, ховор, мэдрэг 200 зүйлийг олон улсын улаан дасны үнэлгээгээр үнэлж 15 зүйл устаж байгаа, 68 зүйл устаж болзошгүйг нэн ховор ургамлын жагсаалтад, 116 зүйл эмзэг ургамлыг ховор ургамлын жагсаалтын төсөлд орууллаа. 2 тойргийн ургамлын зүйлийн жагсаалтыг шинэчлэн гаргаж, 200 зүйл ургамлын хамгааллын төлөвлөгөө боловсруулсан.

Говийн Их ДЦГ-ын Хавтгай тэмээ хамгаалах төвөөс 6-8 бодгалийг Баянхонгор, Өмнөговь аймгийн сонгогдсон газруудад шилжүүлэн байршуулах ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажлыг хийж байна. Халиун бугын 25 толгой илийг шилжүүлэн нутагшуулах ажлыг Хустайн БЦГ-ын захиргаа, Эрдэнэт үйлдвэрийн Сэлэнгэ амралт, Төв аймгийн Эрдэнэ сум, Сонгино хайрхан дүүргийн Санзай буга үржүүлгийн төв зэрэг газруудад хийж байна. "Сая загас" төслийн хүрээнд Туул гол Баруун Баян голын бэлчирт зэвэг загасны 110 мянга орчим түрсийг зориудын орчинд бойжуулан өсгөж, эх байгальд нь тавих ажлыг зохион байгуулж байна. 2021 онд Улаан гоёоны байгалийн сэргээн ургалтыг дэмжих, эх ургамлын плантацыг Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой багийн нутагт байгуулсан, 2022 онд улаан гоёог In vitro орчинд өсгөвөрлөх ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Сармисан сонгино, цагаан дэгд, хангайн шиваантиг, хурган мэхээр, нарийн навчит цахилдаг, падгар бадаана 6 зүйл ургамлыг тарималжуулах эх ургамлын плантаци байгуулж, эх ургамлын суулгацын нөөц, үрийн нөөцийг бий болгосон. Нэн ховор хавтгай тэмээг хамгаалах зорилгоор хавтгай тэмээг үржүүлэх, судлах төвийн үйл ажиллагааг

өргөжүүлж 2020 онд 2 аймгийн 2 газарт нутагшуулах газрыг сонгож суурь судалгааг хийсэн. Хавтгай тэмээг үржүүлэх, судлах төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, гаршуулсан хавтгайн шинэ сүрэг үүсгэх, тархац нутгийг тэлэх зорилгоор 2 дахь үржүүлгийн төвийг Говийн их Дархан цаазат газрын “А” хэсгийн орчны бүсийн хэсэг, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 2 дугаар баг “Толь булаг” гэх газарт байгуулж, 10 хүртэл бодгаль хавтгай тэмээг зөөвөрлөж, сэргээн нутагшуулав. 2020 онд 10 бодгаль халиун бугыг Богд хан ууланд, 10 бодгалийг Сэлэнгэ баазын орчимд тус тус нутагшуулсан. 2020 онд аргаль хонь, янгир ямаа, хулан адууны тоо толгой, тархац, нөөцийн судалгааг 14 аймагт хийсэн.

2021 онд Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг буюу Бөхөн шарын нуруунд монгол орны нэн ховор амьтан болох 10 бодгаль баданга хүдэр /*moschus moschiferus*/ сэргээн нутагшуулав.

5.1.8.Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.

Биелэлт: 2022 онд улсын хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд өртсөн 2057 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 769 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийсэн байна. 2021 онд нийт 2070.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 682.91 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийлгэсэн байна.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн Байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд нийт 17 тэрбум төгрөгийг байршуулсан байна. 2020 онд “Эм жи эйч” ХХК-ийн Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт эзэмшиж байгаад цуцлагдсан ашиглалтын тусгай зөвшөөрлийн нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон 40.65 га талбайгаас 10 га талбайд хийх техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэсэн байна. Мөн Улсын хэмжээнд 2019 онд уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас нийт 7078.9 га талбай уулын ажилд хамрагдсанаас техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай нь 1927.6 га, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 704.8 га, нөхөн сэргээлтэнд зарцуулсан зардал 28.7 тэрбум төгрөг, байгаль орчинг хамгаалахад зарцуулсан зардал 15.8 тэрбум төгрөг байна.

Нөхөн сэргээлт-2024 нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах байнгын ажиллагаатай салбар дундын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн төлөвлөгөөг Монгол Улсын Шадар сайд, БОАЖ-ын сайд, УУХҮ-ийн сайд, ХЗДХ-ийн сайд нарын 2020.12.30-ны өдрийн №169, А/698, А/336, А/242 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. Шаардлагатай машин, техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, үүнээс автомашин, дроны асуудлыг шийдвэрлэв.

5.1.9.Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх, аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулна.

Биелэлт: Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 12-ний өдрийн хуралдаанаар Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар хэлэлцэж, 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 377 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын зориулалтаар 20 газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 41-т туссан “Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-д тусгагдаж батлагдсан. Химийн бодисын мэдээллийн систем бий болгох ажлыг эхлүүлж, Азийн хөгжлийн банкны төлөөлөл, Испанийн IDOM, Монголын Интерактив ХХК компанитай хамтран хэрэгжүүлж эхэлсэн. 2021 онд төслийн багаас Химийн хорт болон

аюултай бодисын мэдээллийн прогресс загварчлал, систем хөгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэв.

5.1.10.Туул голын сав газраас түгээмэл тархацтай ашигт малтмал олборлохыг таслан зогсоож, нөхөн сэргээлт хийж, усны түвшинг нэмэгдүүлнэ.

Биелэлт: Туул голын хамгаалалтын бүсэд 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 10.5 га техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 21 түгээмэл тархацтай ашигт малтмалын тус зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээр хийлгүүлж, хяналт шалгалтын явцад зөрчил гаргасан 22 иргэн, 7 аж ахуйн нэгжид нийт 42.0 сая төгрөгийн торгууль 33.1 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулан барагдуулж, байнгын хяналтыг тавин ажиллаж байна.

2021 онд Хан-Уул дүүрэг болон Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 62 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар 8 аж ахуйн нэгжид улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, Зөрчлийн тухай хуулийн дагуу 29.3 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, техникийн нөхөн сэргээлтийг 39.3 га, биологийн нөхөн сэргээлтийг 5.3 га талбайд хийж гүйцэтгүүлсэн.

2020 онд Туул голын энгийн хамгаалалтын бүсэд орсон, нөхөн сэргээлт хийгээгүй түгээмэл тархацтай ашигт малтмал хайх эрх бүхий 3, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 93, нийт 96 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцалсан. Үүнээс голын энгийн хамгаалалтын бүстэй давхцалтай 46 аж ахуйн нэгжийн 1913.18 га талбайг 2020 онд усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсээс бүрэн чөлөөлсөн.

5.1.11.“Хөх морь” төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.

Биелэлт: "Орхон Онги" төслийг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хурлын 18 дугаар тэмдэглэл гарсан. Гадаргын усны хуримтлал бий болгон говийн усан хангамжийг нэмэгдүүлэх “Хөх морь” төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, шийдвэр гаргах түвшний бэлтгэл ажлыг хангуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг БОАЖС-ын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/196 дугаар тушаалаар байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Онги-Цагаанбургастай” төслийн ажлын зураг, төсөв, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардагдах 6.8 тэрбум.төгрөгийг, "Хөх морь" төслийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх Сэлэнгийн сав газрын хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэх 7.8 тэрбум.төгрөгийг Эдийн Засаг Хөгжлийн Сайдын 2023 оны төсвийн багцад тусгасан.

Сайншандын ажүйлдвэрийн парк болон говийн бүсийн усны хэрэгцээг Хэрлэн голын усаар хангах ТЭЗҮ судалгааны хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын зүүн урд зүгт 22 км зайд Тооно уулын дэргэд 2400м урттай, 30 мөндөртэй боомт байгуулж, Хэрлэн голын үерийн усыг нөөцөлснөөр Тайшир сумын Гэгээннуураас 2 дахин том хэмжээтэй цэнгэг устай хиймэл нуур 5-6 жилийн хугацаанд үүсэх Хэрлэн Тооно усан цогцолбор байгуулах байршлыг тодорхойлсон. Хэрлэн Тооно төслийн хүрээнд жилдээ 120-130 сая м³ усыг хуримтлуулан говийн бүсийн үйлдвэрлэлийн ус хангамжийг шийдвэрлэх боломжийг тогтоосон.

2021 онд Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Хөлийн голын дагуу батлагдсан зураг төсвийн дагуу 10695м³ талбайтай, 18790,9м³ усан мандлын талбайтай хуримтлуулах хүчин чадалтай хөвийг байгуулав. Нийслэлийн хэмжээнд 2019-2021 онд 3

байршилд хөв, цөөрөм байгуулж бороо, цасны усыг хуримтлуулж, гадаргын усны нөөцийг хамгаалах, ашиглах нөхцөл бүрдэв.

5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.

Биелэлт: НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж байгаа “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох эрх зүйн орчны суурь судалгааг хийж гүйцэтгэв.

Барилга, хот байгуулалтын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж байна. Барилгын хүлэмжийн хийн ялгарлын стандарт суурь түвшин болон холбогдох тооцоолол, Чанарын хяналтын тайлан, Монгол Улсын барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг тооцоход тохирох аргачлалыг тодорхойлсон ажлын тайлан, Хүлэмжийн хийн ялгарлын суурь түвшинг тооцсон тооцоо, холбогдох мэдээллийг НҮБ-ын Суурь Конвенцын байгууллага хянан үзэж, 2020.09.02-ны өдөр албан ёсоор бүртгэн авсан болно. ХХААХҮ-ийн салбар өөрийн үйл ажиллагаанд малаас ялгарах хүлэмжийн хийг бууруулах стратеги баримтлан ажиллаж арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд 2021 оны жилийн эцсийн мал тооллогоор нийт 67.1 сая толгой мал тоологдож, өмнөх оноос 3.9 сая /5.5%/ толгойгоор буурлаа. 2020-2021 онд нийт 24.8 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан. Өөрөөр хэлбэл 2020 онд 21943.48 мянган тонн CO_2 экв хүлэмжийн хийг бууруулж чадлаа. Энэ нь зорилтот түвшинтэй харьцуулахад 307.78 мянган тонн CO_2 экв-р их байлаа. Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд өчүүхэн (0.09%) хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их байгааг тогтоосон.

Монголын ногоон санхүүгийн корпораци /МНСК/ байгуулахаар хөрөнгө оруулалтын төслийн саналыг Уур амьсгалын ногоон сангийн Удирдах зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. МНСК байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. МНСК-ийн хувьцаа захиалгын гэрээ болон хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг холбогдох талуудтай хамтран боловсруулсан. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 309 иргэн, 11 аж ахуй нэгжид 854,6 сая төгрөгийн зээлийн хүүний санхүүжилт олгосон байна. Ногоон зээлийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна.

Цаг уурын автомат станцгүй өртөө харуулын судалгааг гаргаж, 2022 оноос автомат станц суурилуулахад зориулж 30 өртөө, харуулын цаг уурын талбайг томсгон хашаалж, цахилгааны эх үүсвэрийг тус талбай руу татах ажлыг хийж эхлээд байна. 2021 онд 50 харуулын бэлтгэл ажлыг бүрэн хангахаар төлөвлөсөн.

Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байр /Улаанбаатар хот/-ын нээлттэй тендер шалгаруулалтын 1-р багц Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхагийн байр төслийн барилга угсралтын ажил хийгдсэн. 2021 онд “Цаг уурын радарын систем худалдан авах, суурилуулах” ажил хийгдэж байна.

ЗУРГАА.НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Улаанбаатар хот

6.1. Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.

6.1.1.Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөг “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн 20 жилээр төлөвлөнө.

Биелэлт: Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний “Эцсийн шатны тайлан”-г хүлээн авч Мэргэжлийн зөвлөл /комисс/-ийн 2021 оны 16 , 21 дүгээр хурлаар тус тус хэлэлцүүлэв. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит бус IV хурлаар “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний төслийг хэлэлцэн дэмжсэн бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

6.1.2.Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг эрчимжүүлж, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад, Дарь-Эх дэд төвүүдийг шинээр байгуулна.

Биелэлт: Төслийн 1-р үе шатны дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлын явц 90 хувьтай байна. Үүнд:

- Сэлбэ дэд төвийн авто зам, дулаан хангамж, цахилгаан холбоо, ус хангамж, ариутгах татуурга, 28 Мвт-ын дулааны станц, мэдээлэл холбооны төв, тохижилтын ажлын бүтээн байгуулалтын явц 90 хувьтай, 1000 м3 усан сан, гүүрэн байгууламж, 2*16/35/10Мва цахилгааны дэд станцын бүтээн байгуулалт бүрэн хийгдсэн. 240 хүүхдийн хоёр цэцэрлэг, Бизнес инкубатор, сургалтын төв шинээр баригдаж ашиглалтад орсон.

- Баянхошуу дэд төвийн авто зам, дулаан хангамж, цахилгаан холбоо, ус хангамж, ариутгах татуурга, дулааны салбар шугам, мэдээлэл холбооны төв, 1000 м3 усан сан, гүүрэн байгууламж, 2*16/35/10Мва цахилгааны дэд станц, тохижилтын ажлын бүтээн байгуулалтын явц 90 хувьтай, Үерийн хамгааллын далан, Дулааны шугамын өргөтгөлийн бүтээн байгуулалт бүрэн хийгдсэн. 240 хүүхдийн хоёр цэцэрлэг, Бизнес инкубатор, сургалтын төв шинээр баригдаж ашиглалтад орсон. 20 айлын орлогод нийцсэн орон сууцны бүтээн байгуулалтын ажил 35 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төслийн 2-р үе шатны хүрээнд Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүдийн барилгын ажлуудын /зарим ажлууд Баянхошуу дэд төвийн нийгмийн барилга байгууламжуудын ажлыг үргэлжлүүлэн хийхтэй холбоотой өөрчлөгдсөн/ зураг төсөл боловсруулах, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлуудыг эхлүүлсэн, хэрэгжилтийн явц 30.7 хувьтай байна.

Засгийн газрын 2020.12.30-ны өдрийн хуралдаанаар 3 дугаар үе шатны бүтээн байгуулалтын санхүүжилтийн зээлийн хэлэлцээрийг хэлэлцүүлсэн.

6.1.3.Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, ногоон орон сууц, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

Биелэлт: 2022 онд 63 айлын 4 орон сууцыг буулган, 377 айл өрхийн орон сууц ашиглалтад орсон. 2021 онд 211 айлын 11 орон сууцыг буулган, 266 айлын 2 орон сууцыг ашиглалтад оруулсан. Төсвийн хөрөнгөөр 10 барилга, хувийн хэвшлийн хөрөнгөөр 18 барилгыг буулган дахин барилгажуулахаар төлөвлөж байна.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 16 байршилд 41604 өрхийн хүчин чадалтай барилгажилтын төсөл, 20 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар, 9 байршилд 3216 өрхийн хүчин чадалтай загвар зураг, 10 байршилд ажлын зургийн даалгавар боловсруулан баталгаажуулсан. Гэр хорооллын дахин барилгажуулах төслийн 13 байршилд гадна

инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл, 6 байршилд ажлын зураг төсөл зөвшилцсөн. Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 12 байршилд барилгын ажлын зөвшөөрөл олгосон.

Баянзүрх дүүргийн 10,12 дугаар хороонд 858 м дулааны шугам, Баянгол дүүргийн 16 хороо, Гандантэгчлэн хийд орчмын инженерийн дэд бүтцийн ажлыг хийсэн. 2052 айлын орон сууцыг шинээр ашиглалтад оруулахаар төлөвлөсөн боловч хөл хорио тогтоосонтой холбогдуулан бүтээн байгуулалтын ажил зогсож, 2020 оны жилийн эцсийн байдлаар 492 орон сууцыг ашиглалтад оруулсан. Налайх дүүрэгт 201 өрхийг гадна инженерийн шугам сүлжээнд холбосон.

2020 онд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинэчлэн төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг зарласнаар 6 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, 97 айлын 2 орон сууцыг буулган 360 айлын 2 орон сууц ашиглалтад оруулж, 97 айл эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл хангагдсан.

Улаанбаатар хотын гэр хорооллын зургаан дэд төвүүдэд түшиглэн орлогод нийцсэн ногоон орон сууцны төслийг төлөвлөн ажиллаж байна. Төслийн нэгдүгээр үе шатанд Баянхошуу, Сэлбэ, Шархад дэд төвүүдэд дараах байдлаар орлогод нийцсэн ногоон орон сууцны эко хорооллыг төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна.

Агаар орчны бохирдлыг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах “Хөгжлийн үүд” төслийн хөрөнгөөр Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийн дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ батлагдаж, дулааны эх үүсвэрийн эхний ээлжийн ажлын гэрээг “Рино инженеринг” ХХК-тай байгуулсан. Гадна дулаан, цэвэр ус, бохир усны шугамын угсралт хийгдэж дууссан. Гадна дулааны ил шугамын төмөрлөгөөний ажил хийгдсэн. Шинэ суурьшлын бүсийн усан хангамж, цахилгаан хангамж болон мэдээлэл технологийн гадна шугам сүлжээний ажлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан дулааны шугам сүлжээний ажил нийт 6,9 тэрбум төгрөг төсөвлөснөөс ажлын талбай дээр эхлүүлээд байсан газар шорооны ажил болон бусад шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэлийг, гэрээний дагуу 2021-2022 онд 90 хувийн гүйцэтгэлтэй хийгдээд байна. Баянзүрх дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Хан-Уул дүүрэгт “Дэд бүтцийн төв”-ийн иж бүрэн зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.

6.1.4.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодлогын арга хэмжээний хүрээнд сайжруулсан түлшний 2 дахь үйлдвэрийг байгуулна.

Биелэлт: Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 35 дугаар тогтоолоор Нийслэлийн зүүн бүсэд жилд 600 мянган тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахаар шийдвэрлэж, уурын хатаалгатай тоног төхөөрөмж бүхий үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг 2020 оны 5 дугаар сараас эхлүүлэн 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ашиглалтад оруулсан. 2021 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар 7 шугам ажиллаж хоногт 1500-1800 тн сайжруулсан түлш үйлдвэрлэж байна. “Таван толгой түлш” ХХК-ийн баруун болон зүүн бүсийн үйлдвэр нь 666,815 тонн сайжруулсан түлшийг 686 борлуулалттын цэг, 28 хангамж, 35 нөөцийн агуулахад тээвэрлэн 198,000 айл өрхийг сайжруулсан түлшээр тасралтгүй ханган ажиллаж байна.

6.1.5.Нийтийн тээврийн үйлчилгээнд зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангасан ухаалаг, эко, цахилгаан хөдөлгүүрт дан болон давхар автобус, цахилгаан соронзон болон дүүжин замын тээврийн хэрэгслийг хэрэглээнд үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Франц улсын Засгийн газар "Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд агаарын дүүжин тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийн санхүүгийн хэлэлцээрийг 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдөр байгуулж, Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн чуулганаар хэлэлцэж, соёрхон баталсан. Ашиглалтын өмнөх захиргааны үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий "Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Төслийн нэгдүгээр шугам буюу Баянхошуу-Ханын материал-3, 4-р хорооллын эцэс чиглэлд 3 зогсоолтой 2.6 км шугам бүхий дүүжин тээврийн төслийн техник эдийн засгийн судалгаа болон төслийн барилгын ажлын бэлтгэл болох топо судалгааг тус тусхийж төслийн нэгдүгээр шатны ажлын бэлтгэлийг бүрэн хангасан.

Нийтийн тээврийн парк шинэчлэлийн төсөл, арга хэмжээний хүрээнд НЗДТГ, Сүлдэрхан минералс ХХК болон "Xia men golden dragon bus" Co.,Ltd түншлэлтэй Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл (Улаанбаатар) "Нийтийн тээврийн парк шинэчлэлт"-ийн хүрээнд 60 ширхэг их багтаамжийн автобус, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь БНХАУ-аас Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 10 ширхэг давхар автобус, 1 ширхэг цахилгаан автобус, НЗДТГ, "Моннис Моторс" ХХК -тай байгуулсан гэрээний дагуу сургуулийн 20 ширхэг автобус нийт 91 автобусыг хүлээн авч, 2022 оны 06-р сарын 03-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар үйлчилгээнд ажиллуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 09-р сарын 19-ний өдрийн "Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх тухай" А/1216 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд худалдаж авах автобус, дагалдах хэрэгслийн жагсаалтыг баталж, урьдчилгаа төлбөр 60,560.4 сая төгрөгийг шийдвэрлэсэн. "Xiamen Golden Dragon" ХХК-тай эхний ээлжийн их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 224 ш автобусыг худалдан авах гэрээ байгуулсан.

6.1.6.Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулна.

Биелэлт: Нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх дунд, урт хугацааны мастер төлөвлөгөө нь 2018 оны 11-р сарын 30-ны өдөр эцэслэн дуусгавар болсон. Мастер төлөвлөгөөнд 2025, 2030 онуудад Нийслэлийн авто замын сүлжээ, замын байгууламжийн төлөвлөлтийг тооцоолсны дагуу 2022 онд холбогдох авто замын ажлууд хийгдэж байна. Үүнд:

- Гүйцэтгэгч байгууллага шалгарч ажил эхлүүлсэн 10 төсөл арга хэмжээнээс өнөөдрийн байдлаар 3 ажил бүрэн дууссан.

- Гүйцэтгэгч байгууллага шалгараагүй тендерийн шатанд байгаа 3 авто зам байна.

- БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 4 нүхэн гарц барих бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнд:

- Таван шар, төмөр замын 396-р гарам, Таван шарын 5-р авто баазын баруун талд, төмөр замын дагуу хөндлөн гарна.

- Геологийн төв лабораторийн уулзвар, Төмөр замын 398-р км, Москвагийн гудамж, үйлдвэрчний эвлэлийн гудамжны уулзвараас Нөхөрлөлийн гудамжтай холбох

- Төмөр замын 401-р км-т /Гермес төвөөс урагш Төмөр замын зоорь, Нарны замын баруун тал, төмөр замын зоориноос урагш Тээвэрчдийн гудамжтай холбох

- Нарны зам болон Их хүрээний гудамжны уулзвар /Нарантуул ОУХТ, Нарны зам, төмөр замын уулзвар 407км ПК5-18/.

6.1.7.Олон улсын стандартад нийцсэн явган хүний болон унадаг дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж барьж байгуулан, тоосжилтыг 50 хувь бууруулна.

Биелэлт: 2020-2021 онд 50,2 км дугуйн замын барилгын ажлыг гүйцэтгэхээр нийт 15,248.4 сая төгрөг батлагдсан. 2020 онд 33.9 км дугуйн зам, 2021 онд 9 байршилд 19.5 км дугуйн зам, 2022 онд 20.4 км дугуйн зам тус тус барьсан. 2022 онд Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 112690.84 м² явган хүний замыг байгууллаа.

2021 онд Нийслэл хотод 787.8 сая төгрөгөөр 5 байршилд 7385м² явган зам, 3.052,6 сая төгрөгөөр 6 байршилд хийгдсэн эмнэлэг сургууль, цэцэрлэгийн гадна талбайн тохижилт, спорт талбайд нийт 3665м² явган зам нийт 11,050м² шинээр хийж, 70.5 сая төгрөгөөр 40 байршилд 1170,7м² явган замыг засварласан. Нийслэлийн төсвийн 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Багахангай, Хан-Уул дүүргүүдэд явган хүний зам тавих 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж нийт 12,926.7м² талбайд явган зам тавьсан. Авто зам, барилга, өргөтгөл шинэчлэлтийн нийт 169 төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр 64 байршилд 87,176 м² явган зам тавьсан байна.

6.1.8.Улаанбаатар хотын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулна. Туул, Сэлбэ, Дунд голын урсацын тохируулга хийж, голуудын орчинд олон нийтийн соёл, амралтын тохилог орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/259 дүгээр захирамжаар Баянзүрх дүүргийн 11-р хороо, Асем вилла хотхоны баруун хойд талд Туул голын эрэг дагуух 3,6 га талбайд 1-р ээлжийн тохижилтын ажлыг 70 хувьтай гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд 350м² явган зам, 510м² эко хавтан, 2 байршилд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зорчих шат, 466,4м² хайрган хучилттай зам, 424у/м чулуун хашлага, 624,5м² асфальт бетон хучилт бүхий 30ш авто зогсоол байгуулах ажил, 1ш харуулын байр барих, 900 у/м цахилгаан кабел, 13ш явган замын гэрэлтүүлэг, 2ш явган гүүр, 1260у/м явган замын хашлага, 4ш камер, 2ш суваг, 600м² чулуун эргийн бэхэлгээ зэрэг ажлууд хийгдсэн.

Сонгинохайрхан дүүргийн 22-р хороо, Цагдаа толгойд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг 1,997.0 сая төгрөгөөр 2019-2021 онд он дамжин хэрэгжүүлж, байнгын ашиглалтад оруулсан. Тохижилтын ажлын хүрээнд 750м дугуйн болон гүйлтийн зам, 8000м² явган зам, 1740м² авто зогсоол, хүүхдийн спорт тоглоомын талбай байгуулах, 200ш улиас, 1500 орчим нарс, хайлаас, 22000м² талбайг зүлэг тарьж худаг гаргах, ногоон байгууламжийн усалгааны систем суурилуулах, 9ш био 00 хийх, усан толио байгуулах, 18ш чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдсэн.

Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнг тохижуулах ажлыг эхлүүлж 1-р ээлжийн ажлын хүрээнд 18га талбайн ажлын зургийг боловсруулан батлуулж, нийт 4000м² явган замын ажлыг гүйцэтгэсэн. Мөн Хан-Уул дүүргийн 11-р хороо, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнд 179.5 сая төгрөгөөр том оврын нарс мод 280ш тарьж, 630м² явган замын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Туул, Сэлбэ, Дунд голын эргийн дагуу эрүүл мэнд, соёл, амралт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж бий болгох төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. ХУД-ийн Сонсголонгийн гүүрнээс Яармагийн гүүр хүртэл эргийн дагуу тохижилтын ажлыг 149 га газарт хийхээр газрын асуудлыг шийдвэрлэж, төсөл хамтран хэрэгжүүлэхээр шалгарсан “Дорнын Их гэгээ” ХХК-тай 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгө хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулсан. Сэлбэ голын дагуу тохижилтын ажлыг 9 га газарт хийхээр газрын асуудлыг шийдвэрлэж, төсөл хамтран хэрэгжүүлэхээр шалгарсан “Жи Өү Энд Ти Эс” ХХК-тай 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан.

6.1.9.Хог хаягдлын менежментийг сайжруулж, гэр хорооллын айл өрхийг үнс хадгалах зориулалтын савтай болгож, дахин боловсруулах бүх төрлийн үйлдвэрийг байгуулна.

Биелэлт: Швейцарын холбооны улсын санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежмент төсөл”-н хүрээнд Иргэдэд хог хаягдлын хууль, эрх зүйн мэдлэг олгох сургагч багш бэлтгэх, хог хаягдлын олон нийтийн байцаагч болон хороодын хэсгийн ахлагч нарын чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Иргэдэд хог хаягдлын эрх зүйн мэдлэг олгох сургагч багш бэлтгэх” сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулсан. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний чанар, үр ашиг сайжруулах үр дүнгийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн “ТЦҮ” ОНӨААТҮГ болон “ТҮТ” ОНӨААТҮГ-д ангилан ялгах хогийн сав суурилуулсан 500 айл өрхийн ангилсан дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг тээвэрлэхэд зориулж Бүгд Найрамдах Солонгос улсын “HYUNDAI” брэндийн хог тээврийн автомашинуудыг гардууллаа. Мөн хог ихээр үүсдэг 33 байршилд зөөврийн камерыг суурилуулсан нь хууль бусаар хог хаягдал ихээр үүсдэг байсан 18 цэгт хог хаягдал дахин үүсэхээ больсон. Стандартчилал хэмжил зүйн газрын Барилгын стандартчиллын техникийн хорооны 2021 оны 08-р сарын 03-ны өдрийн хурлаар “Сайжруулсан нүүрсэн шахмал түлшний үнс. Техникийн шаардлага, турших арга” стандартын бичиг баримтыг хэлэлцэн дэмжиж Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 9-р сарын 16-ны өдрийн тушаалаар үндэсний стандарт MNS 6927:2021 шинээр баталж, 2021 оны 10-р сарын 18-ны өдрөөс нийтээр дагаж мөрдөж эхэлсэн. Гэр хорооллын айл өрхөөс гардаг үнсийг дахин боловсруулах туршилтын төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 2, 3-р хороо, Чингэлтэй дүүргийн 7, 12-р хороонд үнсийг ангилан ялгах ажлыг эхлүүлээд ажиллаж байна. Монгол улсын хэмжээнд 33 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагийн 14 нь аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр, 19 үйлдвэр нь энгийн хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр үйл ажиллагааг явуулж буй судалгааг хийсэн.

НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн газар /UNIDO/-аас хэрэгжиж байгаа “Хог хаягдлын ил шаталтыг бууруулах төсөл”-ийн хүрээнд Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт үнс хүлээн авч дарж булах зориулалтын ландфилын байгууламжийг барих ажлыг 2019 оны 5-р сараас эхлүүлж, 2020 оны 9 дүгээр сард ашиглалтад оруулсан. СХД-ийн 3, 4, Чингэлтэй дүүргийн 7, 12 дугаар хороодод үнс ангилах төслийг эхлүүлж 7,684 хашааны 11,845 өрхийг сонгон туршилтаар үнс ангилан тээвэрлэх ажлыг эхлүүлсэн. Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгийн бэлдсэн талбайд 4875 шуудай ангилсан үнсийг тээвэрлэж, СХД-ийн 3 хорооны үнсээ сайн ангилан ялгасан өрхүүдэд 120 шуудай сайжруулсан түлшийг урамшуулал болгон олгосон.

Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хот хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлж байгаа аймгуудаас хяналттай хогийн цэг, хог нягтруулах үйлдвэр, дахивар хүлээн авах цэг, сайжруулсан нүхэн жорлон зэргийг байгуулах ажлын зураг, дэвсгэр зураг, нарийвчилсан зураг төсөл, гадна шугам хоолойн зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан бөгөөд 2022 оны байдлаар барилга угсралтын ажил хийгдэж дууссан. Сүхбаатар аймгийн ландфиллийг 2021.12.09-нд, Говь-Алтай аймгийн ландфиллийг 2021.12.15-нд Улсын комисс ажиллан ашиглалтад оруулсан. Дархан-Уул аймгийн төвд дахивар нөөцийн цэг барих ажил, хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүү ба дахивар нөөцийн цэг барих ажил Говь-Алтай, Сүхбаатар, Өвөрхангай аймагт хийгдэж байна.

6.1.10.Улаанбаатар хотын цэвэр усны шинэ эх үүсвэрийг бий болгож, “Төв цэвэрлэх байгууламж”-ийг шинээр барьж ашиглалтад оруулан, тус цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн усыг дулааны III, IV цахилгаан станцын технологийн хэрэгцээнд ашиглана. Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартад нийцсэн бие даасан цэвэрлэх байгууламж

бүхий ноолуурын үйлдвэрүүдээс бусдыг хотоос гаргаж, Ус сувгийн удирдах газрын харьяа урьдчилсан цэвэрлэх байгууламж Харгиаг татан буулгана.

Биелэлт: АНУ-ын МСК-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр барих” төслийн гүйцэтгэл явц 20 хувьтай 2022 хүрэх түвшиндээ хүрээд байна. Үүнд:

1.Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын нийт ажлын явц 26 хувьтай. Үүнд: үйлдвэрийн газар шорооны ажил-65 хувь, гадна талбайн ажлын нийт гүйцэтгэл 31,8 хувь, цэвэршүүлэх барилгын угсралтын ажил 21 хувь, урвуу осмосын барилгын ажил 22 хувь, цэвэршүүлсэн усны сан болон насосн станцын барилгын ажил 47 хувь, багана болон хучилтын барилгын ажил 85 хувь, шугам хоолойн угсралт 23 хувь, цахилгааны газардуулга 45 хувьтай байна.

2.Шувуун фабрик орчмын газрын доорх усны эх үүсвэрийн талбайд-16, Биокомбинатын эх үүсвэрийн талбайд-14 цооногийн өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн.

3.Усны эх үүсвэрийн талбайн газар чөлөөлөлт 100 хувь, цэвэршүүлсэн ус дамжуулах шугам хоолойн трассын дагуух газар чөлөөлөлт 95 хувьтай. Төслийн дулаан хангамжийн зураг төслийг “Анготранс” ХХК боловсруулж магадлал хийсэн.

Төв цэвэрлэх байгууламжийн 35 объектын зураг төслийн ажлын гүйцэтгэл 100 хувьтай, бараа материал татан авалт 40 хувь, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт 33 хувь, барилга угсралтын ажил 65 хувьтай, төслийн нийт гүйцэтгэл 68,3 хувьтай явагдаж байна. 2024 онд цэвэрлэх байгууламжийг барьж дуусгана.

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төслийн зөвлөхөөр ХБНГУ-ын “Фихтнер Ватер энд Транспортэйшн” компани шалгарч, 2021.08.04-нд гэрээ байгуулсан. Зөвлөх нь ХУДБТөслийн Байгаль орчны нарийвчилсан байдлын нөлөөллийн үнэлгээг хийж, БОАЖЯ-аар батлуулсан ба шугамын дагуух нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө 100 хувь, зөвлөхийн нийт ажлын гүйцэтгэл 90 хувьтай. Ус дахин боловсруулах үйлдвэрийн Зураг төсөл-Барилга угсралтын ажил гүйцэтгэх гүйцэтгэгчээр М-Си-Эс Проперти ХХК, туслан гүйцэтгэгчээр Францын Egis болон Veolia Water Technologies компаниуд шалгарч, гэрээг 2022.05.10-нд байгуулж, төслийн барилгын ажил эхэлсэн. Түр кемпийн барилга угсралтын ажил 70 хувьтай. Инженер геологийн судалгаа 100 хувь хийгдсэн. Үйлдвэрийн шав тавих ёслолыг 2022.08.25-нд хийсэн. Үйлдвэрийн техникийн зураг төслийг 2022.09.19-нд хүлээн авсан. Төслийн хэрэгжилт 20 хувьтай. 2022 оны 10-р сарын байдлаар ДЦС 4-д техникийн ус хүлээн авах сүлжээний зураг төсөл 90 хувьтай, ДЦС 3-ын схемийн өөрчлөлтийн зураг төсөл 60 хувьтай, ус дамжуулах системийн зураг төсөл 90 хувьтай хийгдсэн байна.

6.1.11.Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Биелэлт: "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн 14 дэд бүтцийг бүтээн байгуулалтыг байгуулахаас ундны усан хангамж, технологийн усан хангамжийн бүтээн байгуулалтын ажил нийслэлийн 2021 оны концессын жагсаалтад орсон.Засгийн газрын 2020 оны 178-р тогтоолоор паркийн ТЭЗҮ боловсруулах, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх шийдвэр гарсан. Паркийн “Төслийн магадлан шинжилгээ, байгаль орчны үнэлгээ”-г боловсруулах ажил хийгдсэн.

"Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн 110 кв-ын үндсэн цахилгаан хангамжийн 30 хувийн гүйцэтгэлтэй, Налайх-Чойрын чиглэлийн төв замд холбох 4,64 км авто замын хучилтын ажил болон явган хүний замыг ашиглалтад оруулсан, 1.4 км үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барьж байгуулсан. Дэд бүтцийн бүтээн байгуулалт 35 хувьтай байна. Үйлдвэрлэл технологийн парк байгуулахад

шаардлагатай төмөр зам, авто замын сүлжээ, дулаан цахилгаан станц, цэвэрлэх байгууламж, 110 кв цахилгааны шугам сүлжээ, усан хангамж, инженер, холбоо мэдээлэл, үерийн байгууламжийн 8 дэд бүтцийн зураг, төсвийг боловсруулсан. Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэгч “Вилл вест” ХХК нь 10 кВ-ын хуваарилах байгууламжийн тоноглолын угсралт, суурилуулалтын ажлыг бүрэн дуусгаж, хүчдэлд холбон, туршилт тохируулгын ажлыг хийсэн ба 1,000.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалын захиалга хийн татан авалтын ажлуудыг хийж байна.

"Багануур үйлдвэрлэл технологийн парк"-ийн ХЕТ, гадна инженерийн шугам сүлжээ, дулаан хангамж, мэдээлэл холбоо, ус хангамж ариутгах татуурга, цахилгааны техникийн нөхцөл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зураг төслийн ажлууд хийгдсэн. 2021 онд тус паркийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугам болон үндсэн дэд станц болох 110/35кВ-ын зураг төслийг гүйцэтгэж дууссан.

"Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк" байгуулах 56 га газрын асуудлыг шийдвэрлэсэн. Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 192.6 сая төгрөгийн санхүүжилтийг нийслэлийн төсөвт тусгаж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах ажил хийгдэж дууссан.

6.1.12.Богдхан төмөр замын төслийг түшиглэн “Хөгжлийн алтан тойрог” байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

Биелэлт: Богдхан төмөр замтай “Хөгжлийн алтан тойрог” буюу Улаанбаатар хотын дагуул хотуудыг холбосон замын ТЭЗҮ-ийг уялдуулах замын шугамын чигийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан. Мөн Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д Засгийн газрын 2021.08.04-ний өдрийн 230 дугаар тогтоолоор олгосон бөгөөд төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулан ажиллаж байна. “Хот төлөвлөлтийн судалгааны институт” ХХК-ний зүгээс судалгааны ажлыг эхлүүлж эхлэлийн тайланг 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдөр танилцуулсан.

6.1.13.Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын аюулгүй, найдвартай зорчих “Сургуулийн автобус” төслийг үргэлжлүүлнэ.

Биелэлт: “Сургуулийн автобус” төслийн хүрээнд 2020-2021 оны хичээлийн жилд замын хөдөлгөөний нягтаршил ихтэй нийт 29 сургуулийн 35 чиглэлд 40 автобусыг үйлчилгээнд гаргаж өдөрт дунджаар давхардсан тоогоор 5,600 хүүхдэд үйлчилсэн бөгөөд шинээр “Хүүхэд зохицуулагч”-ийн 40 ажлын байр бий болгосон. Стандартын шаардлага хангасан тусгай зориулалт бүхий 75 автобус /нийт 23 тэрбум төгрөг/ хүлээн авахаар гэрээ байгуулж, эхний ээлжийн 5 автобусыг хүлээн авсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 3, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1, нийт 6 автобус олгосон. 2020 онд 11 хүүхдийн автобус олгогдсон.

Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил

6.2.Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

6.2.1.Төвлөрлийг сааруулах бодлогыг Улаанбаатар хотын удирдлагатай хамтарч үндэсний хэмжээнд цогц байдлаар хэрэгжүүлнэ.

Биелэлт: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн чуулганаар

баталсан. Хуульд орон нутгийн чиг үүрэг бүлгийг шинээр нэмж өмчийн захиран зарцуулах эрхийг сум, дүүрэгт шилжүүлж, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж төсвийн төвлөрсөн байдлыг багасгах арга хэмжээг авсан.

Улсын Их хурлын 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн чуулганаар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын баталсан. Тус хуульд Нийслэл хотын эдийн засгийн үндэс, нийслэлийн өмч, түүний харилцаа, нийслэлийн үнэт цаас гаргах, концесс олгох, нийслэл хотын албан татвар, түүнчлэн нийслэлийг хөгжүүлэх сантай байж болохоор, сангийн хөрөнгийн эх үүсвэр болон зарцуулах үйл ажиллагааны талаар тусгасан.

6.2.2.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

Биелэлт: Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд 2018-2020 онд эдийн засаг, нийгэм, байгаль орчны нийт 17 салбарын хөгжил байршлын судалгаа болон “Бүсчилсэн хөгжлийн бодлогын төсөл” зэрэг суурь судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. 2019 оноос Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага “ЖАЙКА”-ын төслийн багийн боловсруулж буй “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”, “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн зарим үр дүнг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах ажилтай уялдуулан хамтарч ажиллаж байна. Эдгээр судалгааны ажлын үр дүнд үндэслэн Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийн хувилбарыг шинэчлэн боловсруулсан. Тус үзэл баримтлалын төслийг 2021 оны 3-4 дүгээр улиралд төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагууд, олон нийтээр хэлэлцүүлсэн. 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

“Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр”-н хүрээнд 21 аймагт керамик эдлэхүүний лаборатори, бетон дүүргэгч материалын лабораториуд, БХБЯ-аас БМСШЛабораторид Метал хийц эдлэхүүний, Холбогч материалын, Бетон дүүргэгч материалын гэсэн 3 лабораторийн хүчин чадлыг 28 иж бүрдэл дэвшилтэд техник тоног төхөөрөмжөөр өргөтгөн сорилт шинжилгээний тоо хэмжээг нэмэгдүүлсэнээс 2021 оны байдлаар 48 нэр төрлийн 13014 ширхэг дээж хүлээн авч сорилт шинжилгээ хийж үр дүнг гаргасан болно. 2021 оны байдлаар 17 аймгийн төвд 3 нэр төрлийн лаборатори: Үүнд – Архангай, Ховд, Дорноговь, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Өвөрхангай, Орхон, Баянхонгор, Дорнод, Говьсүмбэр, Сүхбаатар, Өмнөговь, Завхан, Хэнтий, Дундговь аймгуудад -Бетон дүүргэгч материалын, Керамик эдлэхүүний, Холбогч материалын лаборатори ажиллаж байна. Өмнөговь, Говьсүмбэр аймагт цонх, арматур, цемент, керамик эзлэхүүний лабораторийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулж ажиллаж байна. Мөн 2021 оны 12 дугаар сарын 03-нд Баян-өлгий аймаг Металл эдлэхүүний лаборатори, Вакум цонх, Бетон дүүргэгч, Цементийн, Арматурын лабораторын тоног төхөөрөмжүүдийг суурилуулж үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

6.2.3.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу аймгийн төвийн статусын асуудлыг тодорхой болгоно.

Биелэлт: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Уг хууль батлагдсаны дараа 19 аймгийн төвийн сумыг орон нутгийн зэрэглэлтэй хот болгох асуудал тодорхой болно. Орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгон байгуулах асуудлаар үзэл баримтлалыг бэлтгэх зорилгоор Хатгал тосгонд Хөвсгөл аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын удирдлага, Мөрөн сумын болон Хатгал удирдлагыг

оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгийг, Хялганат тосгонд Булган аймгийн удирдлага, Булган сумын удирдлага, Хялганат тосгоны үе үеийн удирдлагуудыг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулж, тэдний саналыг авах ажлыг зохион байгуулсан.

6.2.4.Дархан, Эрдэнэт зэрэг улсын зэрэглэлтэй хот байгуулах болон аймгийн төвүүдийг хот болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Биелэлт: Дархан-Уул, Орхон аймагт Улсын зэрэглэлтэй Дархан, Эрдэнэт хотын статус тогтоох асуудлаар 4 хувилбар боловсруулж, бодлогын зэрэг болон сөрөг талыг хэлэлцэн дүгнэснээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн статусыг алдагдуулахгүй байх хувилбарыг баримтлах зарчмыг сонгоод байна.

6.2.5.Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.

Биелэлт: Ховд аймаг татварын шинэчилсэн багц хуулийн хэрэгжилт, үүнээс алслагдсан бүс нутгийн хөнгөлөлтөнд хэрхэн хамрагдах талаарх мэдээллийг цахимаар сурталчилж байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн 12 аж ахуйн нэгжийн 6,2 сая төгрөгийн илүү төлсөн татварыг буцаан олгож, мөн хуулийн 22.1 /300 саяас 1.5 тэрбум хүртэл борлуулалтын орлого/ дэх хэсгийг үндэслэн 12,1 сая төгрөг, мөн хуулийн 22.5.1 /алслагдсан бүсийн хөнгөлөлт/ дэхийг үндэслэн 4 аж ахуйн нэгжид 88,3 сая төгрөгийн хөнгөлөлтийг тус тус олгосон байна.

6.2.6.Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тус сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ.

Биелэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 21 аймгийн 330 суманд хийж, болзол хангасан 215 суманд нийт 7 тэрбум төгрөгийн "урамшуулал" олгохоор төлөвлөж, 2022 оны 5-р сард сумдад урамшууллыг бүрэн шилжүүлсэн. ОНХС-ийн удирдлага мэдээллийн систем (www.onhs.mof.gov.mn)-ийг шинэчлэн хөгжүүлж, ашиглалтад оруулсан ба тус мэдээллийн системээс иргэд ОНХС-ийн төсөв, иргэдээс гарсан саналаас батлагдах хүртлэх үе шат бүрийн мэдээлэл, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тоон болон зураг, файл, текст байдлаар авах боломжтой.

2020 онд нийт 330 суманд "ерөнхий дэмжлэг" 3.5 тэрбум төгрөг, болзол хангасан 248 сумдад "урамшуулал" 6.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд 2021 онд 330 суманд 2.5 тэрбум төгрөгийн "ерөнхий дэмжлэг", 2020 оны ЖГҮ-ээр урамшуулал авах үнэлгээний болзол хангасан 225 сумдад 6.5 тэрбум төгрөгийн "урамшуулал" олгохоор 2021 оны Улсын төсөвт батлуулуулсан. ОНХС-ийн "Удирдлагын мэдээллийн систем" болон Олон нийтэд зориулсан портал сайтыг шинэчлэн боловсруулж ашиглалтад оруулсан. Үүнтэй уялдуулан системийг хэрхэн ашиглах, мэдээллийг оруулах талаар холбогдох мэргэжилтнүүдэд цахим сургалт зохион байгуулж, аймаг, сумдын ОНХС-ийн 2018-2020 оны шаардлагатай мэдээллийг системд оруулж ажиллаа.

6.2.7.Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биелэлт: "Сумын хөгжил-Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээний хүрээнд 2022 онд 9 аймгийн 18 сумын төвийн инженерийн шугам сүлжээ, барилга

байгууламжийн барилга угсралтын ажил, 5 аймгийн 15 суманд сумын инженерийн дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгэж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн хүрээнд 2019-2020 он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээнд 98.8 тэрбум төгрөг батлагдсанаас 2020 онд 30 төсөл, арга хэмжээнд 48.3 тэрбум төгрөг санхүүжигдэхээр, шинээр барьж байгуулах 33 төсөл, арга хэмжээнд нийтдээ 16.7 тэрбум төгрөг батлагдсан. 2020 онд 10.9 тэрбум.төгрөг санхүүжихээр тусгагдсан. 2019-2020 онд 17 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжиж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дулааны 26.9 км, цэвэр усны 104.8 км, бохир усны 60.2 км, цахилгааны 34.8 км, үерийн хамгаалалтын 16.2 км далан суваг, шугамын сүлжээний барилга угсралтын ажил хийгдсэн байна.

Ховд аймгийн Булган сумын инженерийн нэгдсэн шугам сүлжээ, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын шугам сүлжээний шинэтгэл, өргөтгөлийн ажил, Дархан-Уул аймгийн Дархан сумын Тосгон чиглэлийн гадна дулаан хангамжийн ажлууд хийгдэж байна.

Сумын хөгжил арга хэмжээний хүрээнд 2021 онд: 1.Баянхонгор, Өлзийт суманд цэвэр усны 0,8 км, бохир усны 2,1 км, дулааны 0,8 км шугам сүлжээ, усан сан 2х50м³, 50м³/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг 2021.10.04-ний өдөр комисс ажиллаж ашиглалтад оруулсан. 2.Өвөрхангай, Хайрхандулаан суманд гүний худаг-2, дулааны 0,8 км, цэвэр усны 6,7 км, бохир усны 3,1 км шугам, усан сан 100 м³, ухаалаг ус түгээх байр 2, 50 м³/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг 2021.10.06-ны өдөр комисс ажиллаж ашиглалтад оруулсан. 3.Хэнтий, Галшар суманд гүний худаг 2, усан сан 2х50м³, цэвэр усны 2,3 км, бохир усны 1,6 км, дулааны 0,6 км шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж 50м³/хон хүчин чадалтай байхаар төлөвлөсөн. 2021 оны жилийн эцсийн байдлаар бохир усны 1,68 км, дулааны 0,6 км шугам, 400 кВа-ын цахилгааны ажил дууссан. Цэвэрлэх байгууламжийн 12 бетон худгийн ажил хийсэн. 4.Баянхонгор, Эрдэнэцогт суманд усан сан 25м³, бохир усны 2,5 км шугам, 60м³/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, 2,5 км автозамын барилгын ажил төлөвлөгдсөн. 2021.10.05-нд автозамын зураг төслийг боловсруулж баталгаажуулан 1,4 км автозамын ажил бүрэн хийгдсэн. 5.Баянхонгор, Галуут суманд гүний худаг, 2 км дулаан, цэвэр усны шугам, 60м³ усан сан, бохир ус зайлуулах 2км урттай шугам, 60м³/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, 2 км автозам барина. БУА нь 2021.09.10-нд эхэлж гадна дулаан, цэвэр усны 2 км шугам сүлжээний ажлаас 1.3 км хийсэн.

6.2.8.Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Биелэлт: Дорноговь аймгийн Сайншанд суманд 1, 4, 8 дугаар багийн нутаг дэвсгэрт 1655 м цэвэр усны, 740 м бохир ус зайлуулах шугамыг ашиглалтад оруулж 180 өрхийг, Замын-Үүд суманд 730 м бохир ус зайлуулах шугам ашиглалтад оруулж 34 өрхийг инженерийн шугам сүлжээнд холбож нийт 214 өрхийн орон сууцны нөхцөлийг сайжруулсан. Айраг суманд 3 айл, 4 аж ахуйн нэгж, Дэлгэрэх суманд 3 айл, Өргөн суманд 5 айл, Хатанбулаг суманд 20 айл 3 аж ахуйн нэгж, Хөвсгөл суманд 5 аж ахуйн нэгж тус тус төвлөрсөн шугам сүлжээнд холбогдлоо.

Ховд аймагт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд гэр хорооллын цэвэр бохир усны шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/-ийн 9,3 тэрбум төгрөгийн ажлын даалгаврыг боловсруулан батлуулж худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн ба одоо тендер шалгаруулалтын шатандаа явагдаж байна.

Сэлэнгэ аймаг 2021 онд дараах ажлыг хийхээр ажиллаж байна.Үүнд: Алтанбулаг сумын гэр хорооллыг инженерийн шугам, дэд бүтцэд холбоход 100,0 сая төгрөг, Орхон сумын дулааны шугам сүлжээ тавихад 100,0 сая төгрөг, Сүхбаатар сумын 4, 6, 8-р

багуудын дулаан шугам сүлжээ татахад 200,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж, инженерийн шугам сүлжээний ашиглалт, байшин барилгын дулааны алдагдлыг бууруулахаар ажиллаж байна.

Орхон аймаг 2022 онд орон нутгийн төсвийн 2,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээний төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг төлөвлөсөн. Баян-Өндөр сумын Цагаанчулуут, Булаг, Баянбулаг, Наран, Дэнж багуудад инженерийн шугам сүлжээний төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажил хийгдэж дууссан. Баянцагаан, Рашаант багуудын инженерийн шугам сүлжээ татах ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Дээрх ажил хийгдсэнээр гэр хорооллын 972 айл өрх инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээнд холбогдох нөхцөл бүрдэнэ.

Өвөрхангай аймгийн Хужирт суманд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж байгаа инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй, Төгрөг суманд хийгдэж байгаа цэвэр усны байгууламж, шугам сүлжээний ажил 50 хувийн гүйцэтгэлтэй, Арвайхээр сумын 10, 11-р багийн гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний холболтын ажил хийгдэж 95 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна. Дээрх инженерийн шугам сүлжээ хийгдснээр 1000 орчим айл өрхийн 4500 иргэн ая тухтай амьдрах орчин бүрдэнэ.

Төв аймгийн хэмжээнд амины орон сууц болон инженерийн төвлөрсөн инженерийн хангамжийн сүлжээнд холбогдсон 584 айл, өрх амьдарч байна. Зуунмод суманд 430 айл өрх, Бусад сумд 154 айл өрх холбогдсон “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг Төв аймгийн 14 суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2022 онд бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр Сэргэлэн, Эрдэнэ, Баянчандмань, Борнуур, Дэлгэрхаан сумдад нийт 6,2 тэрбум төгрөг төсөвлөн, гүйцэтгэх компани шалгарч ажлаа эхлүүлсэн. Батсүмбэр, Жаргалант, Угтаал-Цайдам, Эрдэнсант, Алтанбулаг, Баян, Архуст, Бүрэн, Лүн зэрэг сумдад зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.

6.2.9.Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулна. Аймгийн төвүүдийн гэр хорооллын айл өрхүүдийг ухаалаг тоолуурт шилжүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна.

Биелэлт: Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах ажлын хүрээнд 2021 оны Улсын төсөвт 6,2 тэрбум төгрөг тусгагдсан. Ховд аймгийн Хөшөөтийн нүүрсний уурхайн чулуун нүүрсийг ашиглан жилд 30.000 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх Техник эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн дэмжсэн бөгөөд тус ТЭЗҮ-ийг үндэслэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зарлаж, 2021.10.29-ний өдөр гүйцэтгэгчийг шалгаруулан, төслийн ажлыг эхлүүлсэн. 2022 оны байдлаар төслийн гүйцэтгэгч барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Барилгын ажил 50 хувьтай, тоног төхөөрөмжийн угсралтын ажил 90 хувьтай үргэлжилж байна.

“Бүс нутгийн нүүрсний томоохон уурхайнуудыг түшиглэн сайжруулсан түлшний үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэл /5 газар/ төсөл арга хэмжээнд 350 сая төгрөг батлагдсан ба зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж зураг төсөл боловсруулав.

6.2.10.Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.

Биелэлт: Дархан-Уул аймгийн хог хаягдлын нөөцөд суурилсан органик хог хаягдал боловсруулах, пластик боловсруулах, барилгын хог хаягдал боловсруулах үйлдвэрүүдийн Техник эдийн засгийн үндэслэл хийгдэж байна.

Өвөрхангай аймагт хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах ажлын суурь судалгааны ажлууд хийгдэж байна. Аймгийн хэмжээнд жилдээ нийт 25324 тн хатуу хаягдлыг 25 орчим га талбайд булшилж байна. Хог хаягдлын бүтцийн судалгаагаар нийт гарч буй хог хаягдлын 40 хувь нь дахин ашиглах боломжтой хуванцар, төмөр, шил, лааз, үнс гэх мэт хоёрдогч түүхий эд байна.

Архангай аймагт Хуванцар хог хаягдал, сүү тарагны тетрапак савлагааг нунтаглан бүтээгдэхүүний бэлтгэц болгох үйлдвэрийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан бөгөөд “ЭБЦТС” ТӨХК 1.5 км цахилгаан түгээх шугам татаж, тоног төхөөрөмжийг байрлуулах 8х8 хэмжээтэй агуулахын барилгыг 2020 оны 10-р сарын 07-нд ажил хүлээлцэх комисс байнгын ашиглалтад хүлээн авсан.

6.2.11.Хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих замаар сумдын халуун усны болон нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулна.

Биелэлт: 2022 онд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3 ахуйн үйлчилгээ, 15 халуун усны барилга, нийт 18 байгууламжаас 4 байгууламж ашиглалтанд орсон, ажлын нийт гүйцэтгэл 65 хувьтай хэрэгжиж байна.

2021 онд Булган аймгийн Хишиг-Өндөр, Баяннуур сумдын нийтийн халуун усны барилгын зураг төсөл, Увс аймгийн Зүүнхангай сумын Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилгын зураг төсөл, Хөвсгөл аймгийн Тариалан, Баянзүрх, Алаг-Эрдэнэ зэрэг сумдын халуун усны барилгын барилга угсралтын ажлын тендер зарлагдсан.

6.2.12.Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.

Биелэлт: Өмнөговь аймаг нь бага, дунд орлоготой иргэн, төрийн албан хаагч болон зорилтот бүлгийн иргэдийг инженерийн бүрэн хангамж бүхий хямд өртөгтэй, чанартай амины болон нийтийн орон сууцаар хангах, түрээсийн орон сууцаар хангах, хүн амын худалдан авах чадварт тохирсон орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилго бүхий "Шинэ мянган айл" орон сууцны хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2021 оны 49 дүгээр тогтоолоор баталсан. Хөтөлбөрийн хүрээнд Ханхонгор суманд 8, Даланзадгад суманд 140, Баяндалай суманд 10, Номгон суманд 10, Сэврэй суманд 10, Булган суманд 10, Цогтцэций суманд 10 айлын орон сууцны барилга баригдаж байна. Эдгээр орон сууцыг 7, 8 сард ашиглалтад хүлээн авахаар гэрээ байгуулсан байна. Мөн Гашуун Сухайт хилийн боомтод 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил бүрэн дуусаж улсын комисс ажиллаж хүлээж авсан. Тус цэцэрлэг ашиглалтад орсноор хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын хүүхдүүд цэцэрлэгт хамрагдах боломж бүрдээд байна.

Сүхбаатар аймаг нь Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд 8 эмч, эмнэлгийн ажилтныг орон сууцны 6 хувийн зээлд хамруулсан. 2020 -2021 оны хичээлийн жилд Баяндэлгэр, Дарьганга, Наран, Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан сумдад Физик 2, Нийгмийн ухаан 1, Хөгжим 1, Монгол хэл уран зохиол 2, Гадаад хэл 1, Физик-Мэдээллийн технологи 1, Биеийн тамир 1, Математик 2, Хими 2 нийт 15 багшийг ажиллуулж орон байрны асуудлыг шийдвэрлэсэн.

6.2.13.Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

Биелэлт: Өвөрхангай аймаг “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх” цогц төлөвлөгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 44.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1407 иргэн, аж ахуйн нэгжид олгосон байна. Мөн Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлд 1365 малчин өрхөд 10.5 тэрбум төгрөг, газар тариалан эрхлэгч 6 иргэн, аж ахуй нэгжид 175.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл хүссэн 3 аж ахуйн нэгжийн 353.0 сая төгрөгийн төслийн зээлийн хүсэлт дэмжигдсэн. “Сум хөгжүүлэх сан”-гаас 15 суманд нийт 223 иргэн, аж ахуйн нэгжид 1.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Мөн Зээлийн батлан даалтын сангаас 5 аж ахуйн нэгжид 1.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, 562.3 сая төгрөгийн батлан даалтад хамруулсан байна.

Ховд аймагт жилдээ 300 мянган тонн цемент үйлдвэрлэж, баруун бүсийн аймгуудын цементийн хэрэглээг бүрэн хангах “Ховд эко цементийн үйлдвэр”, “Үйлдвэр технологийн парк” ашиглалтад орсноор дагалдах үйлдвэрүүд хөгжиж 2000 гаруй ажлын байр бий болох юм.

Сүхбаатар аймаг “Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГазрын “Хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах” бүсэд “Их нутаг эко хүнс трейд” ХХК нь нийт 9,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий мах, дайвар бүтээгдэхүүн, өлөн боловсруулах цогцолбор төв байгуулахаар төлөвлөсөн ба тус аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулж байна.

Дархан-Уул аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, 64 аж ахуйн нэгжийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгэж, ажлын байр дэмжих зээлд 102 аж ахуйн нэгж 19,5 тэрбум төгрөг, Репо санхүүжилттэй зээлд 47 аж ахуйн нэгж 5.1 тэрбум төгрөг авч, 1100 гаруй ажлын байр хадгалагдлаа.

6.2.14.Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.

Биелэлт: "Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн систем"-ийг хөгжүүлэх ажлын хүрээнд боловсруулах үйлдвэрүүд болон жижиг дунд үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээ, мөшгөх тогтолцоог бий болгохоор хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлж байна. Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах цахим систем"-ийг хийсэн. Туршилтыг мах, махан бүтээгдэхүүн дээр хийхээр бэлтгэл ажлыг хангасан.

Булган аймаг шинэ хөдөө төслийн хөрөнгө оруулалтаар Бугат сумын Төлүүгийн даваа, Булган сумын улсын чанартай авто зам дагуу орон нутгийн бүтээгдэхүүний худалдааны цэгийг байгуулснаар аялал жуулчлалын улиралд эрэлт нийлүүлэлтийн төвлөрсөн цэг болж, орон нутгийн иргэд түр ажлын байраар хангагдаж байна. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын тогтвортой үйл ажиллагааг хангах, ажлын байрыг хадгалж үлдэх, санхүүгийн эрсдэлээс сэргийлэхэд төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх чиглэлийн дагуу төр, төсвийн байгууллагууд хэрэгцээт бараа ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулж, 2022 оны жилийн эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 1.6 тэрбум орчим төгрөгийн худалдан авалт хийхээр байна.

Орхон аймаг Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих зорилгоор “Баян”, “Төгөл”, “Хангайн бүсийн худалдааны төв” зэрэгт төвүүдэд тус бүр 3 лангуу түрээслэн, түрээсийн төлбөрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах

цэг бий болгон ажиллаж байна. Засгийн газраас жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжин, бага хүүтэй хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож байна. 15 салбар чиглэлийн 165,3 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 1285 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлт ирүүлснээс 396 иргэн, аж ахуйн нэгжид 26,5 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

Ховд аймаг 2021 онд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа банкуудаар дамжуулан 494 иргэн, аж ахуйн нэгжид 25 тэрбум 570 сая төгрөгийн 3 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатай зээл олгож, бизнес эрхлэх, ажлын байр бий болгоход нь дэмжлэг үзүүлсэн байна.

Дорнод аймаг орон нутгийн төсвийн хөрөнгө, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хамтарсан хөрөнгөөр жижиг, дунд үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг хадгалах, худалдан борлуулахад дэмжих зорилготой Баян-Уул суманд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, хүнсний ногооны зоорь барих, Булган, Гурванзагал, Цагаан-Овоо сумдад борлуулалтын цэг барих, Хэрлэн суманд борлуулатын цэгийн хашаа барих, Баянтүмэн, Гурванзагал суманд газар тариалангийн услалтын систем засварлах ажлууд 100 хувь хийгдэж, хүлээн авсан. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашигт малтмал, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/264 дүгээр захирамжаар байгуулж, аймгийн Зөгийчдийн холбоо 1,3 тн зөгийн бал, Халхгол сумын малчид 25,5 тн хонь, үхрийн махыг "Петрочайна дачин тамсаг" ХХК-д, Баяндун сумын "Дун хас эрдэнэ" ХХК 30 хос гутлыг "Эйс жи эй" ХХК -д, Дашбалбар сумын "Улзын тулга" ХХК 30 тн хонь, үхрийн махыг "Шинь шинь" ХХК-д тус тус нийлүүлж, нийт 1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Өмнөговь аймаг орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд борлуулах "Өмнөговьд үйлдвэрлэв" худалдааны төвийг Даланзадгад суманд байгуулахаар төлөвлөн тус худалдааны төвийн зураг төсвийн дагуу засвар, тохижилтын ажлыг эхлүүлээд байна. Мөн Улаанбаатар хотод "Өмнөговьд үйлдвэрлэв" борлуулалтын цэгийг UB MART худалдааны төвд ажиллуулж буй "Говь афор" ХХК-нд 1 жилийн түрээсийн төлбөр болох 18,6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ Улаанбаатар хотод борлуулах боломжоор хангагдсан. Даланзадгад сумын төвд байгуулагдах "Худалдааны төв"-ийн зураг төсвийг боловсруулагдсаны дагуу тус худалдааны төвийг барьж байгуулах ажлыг эхлүүлээд байна.

Төв аймаг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, борлуулалт зах зээлийг нэмэгдүүлэх зорилгоор "Хөдөлмөрийн амт", "Төв түмний цэнгэл", "Төв түмний сүүн соёл - 2022", "Төв нутгийн алтан намар", " Намрын ногоон өдрүүдэд -Үндэсний үйлдвэрлэл", "Нэг сум нэг бүтээгдэхүүн" үзэсгэлэн арга хэмжээг 6 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 600 гаруй иргэн, ААН 322 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 4160,0 сая төгрөгийн борлуулалтаар дэмжигдлээ.

-----oOo-----

